

**Гарчиг:**

Оршил.....	4
1. Судлагдсан байдал.....	7
1.1. Дундговь аймагт явуулсан археологийн хээрийн судалгааны тойм.....	7
1.2. Монголын археологийн үечлэл.....	15
2. Судалгааны ажлын тухай.....	28
2.1. Хээрийн судалгаа хийх хууль, эрх зүйн үндэслэл.....	28
2.2. Хээрийн судалгааны ажлын зорилго бүтэц, зохион байгуулалт.....	31
3. Адаацаг сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	39
4. Баянжаргалан сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	47
5. Говь-Угтаал сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	64
6. Гурвансайхан сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	78
7. Дэлгэрхангай сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	102
8. Дэлгэрцогт сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	118
9. Дэрэн сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	127
10. Луус сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	142
11. Сайнцагаан сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	152
12. Сайхан-Овоо сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	168
13. Өлзийт сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	180
14. Өндөршил сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	201
15. Хулд сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	214
16. Цагаандэлгэр сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	237
17. Эрдэнэдалай сумын нутаг дахь түүх, соёлын дурсгалууд.....	244
18. Төслийн хэрэгжилтийн явц, төслийн үр дүнгийн даалгаврын биелэлт.....	264
Дүгнэлт.....	267
Ашигласан материалын жагсаалт.....	272
Хавсралт.....	276

## **Оршил**

Энэхүү суурь судалгааны тайлан нь 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдөр ШУСС-2020/33 тоот гэрээний дагуу ШУТИС-ийн БүХС дээр 2021-2022 онуудад хэрэгжүүлсэн “Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгал” хэмээх нэртэй суурь судалгааны төслийн хэрэгжилт, үйл ажиллагаа, баталгаажуулалтыг дэлгэрэнгүй хамруулсан тайлан юм.

Дундговь аймгийн нутаг дэвсгэр нь нэн эрт цагаас хүн оршин амьдарч ирсэн уугуул нутгийн нэг төдийгүй нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн голомт нутгийн нэг билээ. Манай улсад тэртээ 100 гаруй жилийн тэртээгээс эдүгээ хүртэл хийсэн эртний судлалын судалгааны үр дүнд тус аймгийн нутаг дэвсгэрээс олон мянган түүх, археологийн дурсгалууд болох эртний хүмүүсийн чулуун зэвсгийн бууц суурин, эртний хот суурины үлдэгдэл, булш бунхан, хиргисүүр, буган хөшөө, бичиг соёлын дурсгалууд илрэн олдсон билээ. Манай ахмад эрдэмтдийн үндэс суурийг нь тавьсан судалгааг орчин үеийн дэвшилтэт арга хэрэглэн судалгааны шинэ түвшинд үргэлжлүүлэх, орчин үеийн мэдээлэл технологийн шаардлагад нийцүүлэн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан хөмрөг бий болгох шаардлагатай юм.

Манай улсын нийгмийн шинжлэх ухаан түүний дотор соёлын өв судлалын асуудал бол монгол угсаатны түүхэн хөгжлийн явцыг судлах, тодруулах чухал асуудал билээ. Энэ асуудлын хүрээнд Монгол улсын нийт 21 аймаг, тэдгээрийн сумдын нутаг дахь түүх, археологийн дурсгалуудыг судлан нэгдсэн бүртгэл мэдээллийн сан бий болгох нь чухал.

Орчин үеийн хотжилт, хүн амын нягтрал, нийгэм эдийн засгийн хөгжлийн эрчимтэй явагдаж буй хурдацтай уялдан өнөө үед Монголын түүх, соёлын дурсгалууд устах, эвдэгдэх, санаатай болон санамсаргүйгээр аж ахуйн үйл ажиллагааны явцад үгүй болох, түүх, ахуй соёлын асуудал улам бүдгэрэн гээгдсээр байна. Ийнхүү устан үгүй болж бүдгэрэн буй дурсгалуудыг нэгтгэн нэгдмэл бүртгэл мэдээллийн сан бий болгох шаардлагатай бүс нутгийн нэг бол Дундговь аймгийн нутаг дэвсгэр билээ. Иймээс Монгол улсын Дундговь аймгийн нутаг дахь түүх, археологийн дурсгалуудыг

орчин үеийн эртний судлалын шинжлэх ухааны арга зүйн дагуу, судлан тодруулах, бүртгэн баримтжуулах нь ихээхэн чухал ач холбогдолтой болно.

Энэхүү судалгааны ажил нь Монгол улсын төр засгийн үйл ажиллагааны нийгмийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх цогц арга хэмжээний нэгэн хэсэг “Монголын эртний түүх соёлын дурсгалуудыг судлан шинжилж, эх түүхээ нөхөн сэргээнэ” гэсэн зорилттой, нөгөөтээгүүр Шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт “ардын уламжлалт болон үндэсний дэвшилт үйлдвэрлэлийг гол чиглэл болгон Монголын археологи, угсаатны зүй өв уламжлал, монголчуудын угсаа гарлыг судална” гэсэн заалтуудтай тус тус нийцэж байгаа билээ.

Монгол улсын Дундговь аймаг нь 15 сум, 66 багтай бөгөөд өргөн уудам газар нутагтай, эртний чулуун зэвсгийн үеэс хожуу ХХ зууны эхэн үе хүртэлх түүх, археологийн асар их дурсгалуудтай билээ. Өдгөө тус аймгийн нийт сумдын нутагт оршин амьдарч буй угсаатны бүлгүүдийн угсаа гарал, аж ахуй соёлын төвшин, ертөнцийг үзэх үзэл, шашин мөргөлийн талаар багагүй судалгаа хийгдсэн хэдий ч эдгээр асуудал бүрэн хэмжээгээр шийдэгдээгүй байна. Нөгөө талаар сүүлийн үед эрчимтэй өрнөж байгаа шинэ үйлдвэр, уурхай байгуулах зэрэг эдийн засгийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөр эртний дурсгал өртөгдөн эвдэрч устах аюул гарч байна. Иймд Дундговь аймгийн нутаг дэвсгэрт буй түүх, археологийн дурсгалуудын судалгааны ажлыг цаг алдалгүй явуулж бүртгэн тэмдэглэх, судлах, аварч хамгаалах анхны дүр төрхөөр нь хадгалах ажлуудыг хамтаар гүйцэтгэх нь тулгамдсан асуудал болжээ. Тиймээс энэхүү суурь судалгааны төслийн зорилго нь Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалыг бүртгэж баримтжуулах, судалгааны эргэлтэд оруулах, цаашдын суурь судалгааны бааз хэрэглэгдэхүүн бий болгоход оршино.

Сүүлийн жилүүдэд Монгол орны эртний түүх, археологийн дурсгалыг судлах гадаадын эрдэмтдийн сонирхол эрс нэмэгдэж байна. Тухайлбал, 1990-ээд оноос хойш Монгол улстай хамтран түүх, археологийн салбарт давхардсан тоогоор 20 гаруй орны 100 шахам эрдэм шинжилгээ судалгааны экспедицүүд үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа билээ. Ийм нөхцөлд бид өөрийн болон гадны эрдэмтдийн хүчээр улс орныхоо түүх, соёлын дурсгалуудыг судлан шинжлэх хөрс суурийг тавихын тулд

нэгдсэн бүртгэл мэдээллийн сантай болох явдал билээ. Тиймээс төслийг хэрэгжүүлснээр манай улсын шинжлэх ухааны салбарт, тэр тусмаа Дундговь аймгийн нутагт дэвсгэрт эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулах гадаад орны эрдэмтдийн оролцоо, ирж буй хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж, харилцан хариуцлага хүлээж эрх тэгш хамтран ажиллах нөхцөлийг бодитой бүрдүүлнэ.

Төсөл хэрэгжсэнээр Монголын түүхийн шинжлэх ухааныг шинэ олдвор баримтаар баяжуулж, түүхэн мэдлэгийг арвижуулан шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр оруулна. Эртний түүхийн дурсгалуудыг шинэ дэвшилтэт аргаар судалж, эрдэм шинжилгээ, сурталчилгааны эргэлтэд оруулснаар эдгээр дурсгалыг үзэж сонирхох гадаад дотоодын жуулчдын тоо өсөж нэмэгдэхэд нөлөө үзүүлж, улс орны эдийн засагт зохих хувь нэмэр оруулна.

Шинээр хот суурин, үйлдвэр аж ахуйн газар байгуулах зэрэг эдийн засгийн үйл ажиллагааг, түүх соёлын дурсгалыг судлах, аварч хамгаалах ажилтай зөв зохистой уялдуулах боломжийг бий болгоно. Энэ нь цаашид Дундговь аймгийн нутаг дэвсгэрт аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй гадны болон дотоодын компани аж ахуйн нэгжүүдийн сонирхлыг нааш татаж, эрдэмтэд, шинжлэх ухааны байгууллагатай хамтран ажиллах боломж бололцоог бүрдүүлнэ хэмээн үзэж байна.

Түүнчлэн өвөг дээдсийн бүтээсэн түүх соёлын дурсгалаа хайрлан хамгаалах, түүгээрээ бахархах эх оронч үзэл бүрэлдэн тогтоход түлхэц өгөх болно.

Энэхүү суурь судалгааны тайлан нь үндсэн 18 бүлгээс бүрдэнэ. Нэгдүгээр бүлэгт Дундговь аймгийн судлагдсан байдал болон тайлангийн агуулгыг илүү ойлгомжтой болгох үүднээс Монголын археологийн үечлэл, дурсгалын төрөл зүйлийн талаарх шинжлэх ухааны ойлголтыг оруулж өгсөн. Хоёрдугаар бүлэгт уг суурь судалгааны ажлыг хийх хууль, эрх зүйн үндэслэл болон суурь судалгааны хүрээнд хийгдсэн хээрийн шинжилгээний ажлын бүтэц, зохион байгуулалт, зорилго, арга зүй, үйл ажиллагаа процессын тухай дурьдсан болно. 3-18-р бүлэгт Дундговь аймгийн нутгаас бүртгэн баримтжуулсан дурсгалыг сум тус бүрээр нь цагаан толгойн дарааллаар оруулсан. Мөн дүгнэлт, хавсралт, ном зүйн хэсгээс бүрдэнэ.



## 1. СУДЛАГДСАН БАЙДАЛ

### 1.1. Дундговь аймагт явуулсан археологийн хээрийн судалгааны тойм

Дундговь аймаг нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт зүүн талаараа Говьсүмбэр, Дорноговь аймагтай, урд талаараа Өмнөговь аймагтай, баруун талаараа Өвөрхангай аймагтай, хойд талаараа Төв аймагтай тус тус хиллэн 74.7 мян.км<sup>2</sup> газар нутаг эзлэн оршдог.

Дундговь аймгийн нутаг дэвсгэр дээрх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эрдэм шинжилгээний үүднээс бүртгэн баримтжуулж судлах ажил бусад аймгийг бодвол харьцангуй хожуу эхэлжээ. Үнэ ажлын эхлэлийг Монголын ууган археологич Х.Пэрлээ Дэрэн сумын нутаг Тахилын усны сайрын орчимд байх эртний гар урчуудын сууринд хийсэн судалгааны ажлаараа тавьсан байна. Мөн тэрээр уг суурингийн ойролцоо байх хэдэн булшийг бүртгэн, заримыг нь малтан судалж эрдэм шинжилгээний хувьд сонирхолтой эд өлгийн зүйлсийг илрүүлсэн байна. Х.Пэрлээ 1951 онд “Краткое сообщение о древностях около Их-Газарын чулуу” гэдэг бүтээлдээ Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дахь Тахилын усны сууринд хийсэн судалгааны талаар анх нийтлүүлсэн байна (Пэрлээ, 1951). Үүний дараа “Монгол Ард Улсын хот суурины товчоон” (1963) бүтээлдээ дээрх хотод хийсэн малтлага судалгаа болон он цагийн талаар дэлгэрэнгүй оруулжээ (Пэрлээ, 1963).

1951 онд Х.Пэрлээ Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг Зүүн Бүрэн ууланд буй тоногдсон 2 булшны үлдцийг малтан судалж тоосго, зээ бадын хээтэй нүүр ваар, тосгуур, нөмрөг ваарны үлдэгдлүүд, ширмэн хонх, улаан шавар савны хагархай, 8 ширхэг зоос зэрэг зүйлсийг олжээ. Эндээс олдсон зоосны эртнийх нь 713-740 оны үед цутгасан Тан улсынх, хожмынх нь 1068-1077 оны үед цутгасан Сүн улсын үеийн зоос байжээ.

1957 онд археологич Х.Пэрлээ Дундговь аймгийн Зүүнбүрэн, Сайхан сумын нутагт малтсан хоёр булшны хэрэглэгдэхүүн болон түүнд тулгуурласан он цагийн талаар өгүүлэл хэвлүүлсэн байна (Пэрлээ, 1956:40-48). Мөн онд тэрээр дундад зууны монголчуудын хот сууринг шинжлэх явцдаа, Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын

Тахилын усны суурингийн хойно орших зарим булшийг малтан шинжилжээ (Пэрлээ, 1961:94).

1959 онд В.В.Волков Дундговь аймгийн нутгаар хайгуул судалгааны ажил хийж Хаан хэмээх ууланд монголын үеийн булш малтан шинжилсэн байна (Волков, 1963:43-55). Энэхүү малтлага судалгаагаар дүгрэг үзүүртэй төмөр зэв зэрэг эд өлгийн дурсгалт зүйлс илрүүлжээ. Мөн тэрээр Өндөршил сумын Тас уулын орчим, Мандалговь хотын дэргэдэх болон Дэлгэрхангай сумын нутагт өөр малтлага судалгааны ажил гүйцэтгэсэн байна (Волков, 1957:37-38).

Дундговь аймгийн нутагт хадны зургийн судалгаа харьцангуй сайн хийгдсэн хэмээн үзэж болно. Хамгийн анх 1960 онд Өлзийт сумын Тагт багийн нутагт орших Дэл уулын хадны зургийн дурсгалыг анх 1960 онд А.П.Окладников, Д.Дорж нарын удирдсан Монгол-Зөвлөлтийн шинжилгээний анги илрүүлэн олжээ (Дорж, Новгородова, 1975).

Мөн А.П.Окладников Дэл уулын хадны зургийн зарим дүрслэлийн талаар өөрийн номондоо нийтэлсэн байна (Окладников, 1981). Мөн тэрээр Өлзийт сумын хуучин төвийн орчмын нутаг нэгэн хавцлын хаданд дүрсэлсэн шовх чихтэй, өргөн дөрвөлжин хоншоортой, нүд болон хүзүүн дээр нь хоёр дугуй хонхрыг товгороор хүрээлж “алим” мэт дүрсэлсэн бүдүүн хөлтэй, урт сүүлтэй, сэлдийг нь зориуд цохон дүрсэлсэн азарганы зургийг их эртний шинжтэй өвөрмөц зураг хэмээн шинэ чулуун зэвсгийн үед холбогдуулан, янгир, чоно зэрэг бусад зургийг түүний хажуу завсар зайд хожим дүрсэлсэн гэж үзжээ (Окладников, 1981).

1964 онд Б.Базылхан Дундговь аймгийн нутгаас олдсон нэгэн тамганы бичээсийг тайлан уншиж нийтлүүлсэн байна (Базылхан, 1964:74-75). Мөн онд Н.Сэр-Оджав нар Дундговь аймгийн орон нутгийг судлах музейн үзмэрт байгаа 400 гаруй хүрэл түүвэр олдворыг судлан тэдгээрийг зэвсгийн зүйл, аж ахуйн хэрэгцээний зүйл, гоёл чимэглэлийн зүйл, тодорхой хэрэгцээний зүйл хэмээн дөрвөн хэсэгт хувааж ангилан он цагийг тогтоосон байна (Сэр-Оджав нар, 1964).

1969 онд Д.Дорж, Э.А.Новгородова нар Дэл уулын хадны зургийг дахин нягтлан үзэж улмаар “Петроглифы Монголии” (УБ.,1975) бүтээлдээ харьцангуй баялаг зурагтай гурван уулыг Дэлийн Зүүн Билүү I, II, III хэмээн дугаарлаж янгир, чоно, адуу, морь тэмээ унасан хүмүүс зэрэг 50 орчим зургийг, мөн Өлзийт сумын хуучин төвийн хажуугийн хоёр хавцлаас янгир, чоно, адуу, тэмээ, хүн зэрэг 20 орчим зургийг нийтэлсний дотор хоёр гэрийн зураг буй нь нэн сонирхолтой хэмээн тодорхойлжээ (Дорж, Новгородова, 1975).

1969 оноос тус бүс нутагт чулуун зэвсгийн судалгаа эхэлсэн хэмээн үзэж болох бөгөөд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн дурсгал судлах анги Өндөршил, Гурвансайхан сумын заагт орших Ярх уулнаас олдсон дугариг, гурвалжин хэлбэрийн зэвсэг, хусуур, болхи хийцтэй нарийн тал нь хавтгай мэс зэргээр хуучин чулуун зэвсгийн доод үед холбогдоно хэмээн үзжээ (МЗТСХЭ, 1969)

1970 онд тус шинжилгээний анги [МЗТСХЭ, 1970] Дундговь аймгийн Ярх уулын чулуун зэвсгийн сууринд дахин нарийвчилсан судалгаа явуулсан байна. Ярх уулын чулуун зэвсгийн дурсгал нь доод палеолитын ашеллийн үед буюу 300.000–500.000 жилийн тэртээд холбогдох чулуун зэвсгийн дарханы газар юм. Энэхүү дарханы газар Африк, Европын ашеллийнхтэй ижил сонгодог хэлбэрийн “гилбэр” зэвсэг хийдэг байжээ. Энэ нь өрнө дахинд (Африк, Европ) сонгодог “гилбэр” зэвсгийн соёл, дорно дахинд (Ази) “хугадас” зэвсгийн соёл өөрөөр хэлбэл, доод палеолитын үед хүн төрөлхтөн эрс тэс хоёр өөр соёлтой байсан, түүнтэй уялдан хүн төрөлхтний хөгжил нь өөр байсан мэт үзэж ирсэн хуучин чулуун зэвсэг судлалд ноёрхож байсан онолд няцаалт өгсөн юм [Окладников, 1986; Дорж, Цэвээндорж, 1978].

1971 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах анги Дундговь аймгийн Хулд, Дэрэн сумдын нутгаар хайгуулын ажил гүйцэтгэж үлдэц, хусуур, ялтас, залтас зэрэг чулуун зэвсгийн олдворууд илрүүлж (МЗТСХЭ, 1971),

1972 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах анги Дундговь аймгийн төв Мандалговь хотоос 60 км зайд орших Ёроол говь хэмээх хотгороос цахиур зэвсэг үйлдэж байсан дарханы газар шинээр илрүүлэн олсон байна (МЗТСХЭ, 1972).

Дээрх онуудын судалгааны үр дүнг нэгтгэн А.П.Окладников, Д.Дорж нар эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна [Окладников, 1977:3-13].

1973 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн дурсгал судлах анги Дундговь аймгийн Цахиур толгой, Цагаан худаг, Цагаан Өндөр зэрэг газруудад хайгуул хийж чулуун зэвсгийн үеийн бууц сууринг шинээр илрүүлжээ [МЗТСХЭ, 1973].

Харин 1979 онд МЗТСХЭ-ийн бичээс судлалын анги Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Бичигт хадны руни, перс, монгол, хятад бичээс, тамгануудыг нягтлан шинжилсэн байна (МЗТСХЭ, 1979).

1981 онд Т.Санжмятав Дэлгэрцогт сумын нутаг Бага газрын чулуунд дөрвөлжин булш малтаж шавар савны хагархай, алтан бөгж, улаан будагтай малын яс, оюу сувс зэрэг зүйлс олсон бол Д.Наваан хүннү булш малтан судалж хүн судлалын материал, эд өлгийн зүйлс илрүүлэн олжээ (Наваан, Санжмятав, 1981). 1985 онд Д.Наваан мөн Бага газрын чулуунд хоёр хадны оршуулга малтсан талаар мэдээ бий (Наваан, 1985).

1984 онд Монгол орны дорно болон өмнө хэсэгт ажилласан хээрийн шинжилгээний ангийнхан Дундговь аймгийн ОНС музейд хадгалагдаж буй 2 хүн хөшөөг судлан эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан байна (Мэнэс, 1995:73-86). Мөн судлаач Д.Баяр “Монголчуудын чулуун хөрөг” (1995) нэгэн сэдэвт бүтээлдээ дээрх хоёр хөшөөний талаар дахин нягтлан хэвлүүлсэн байна (Баяр, 1995).

1987 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Санжмятав, МУИС-ийн багш Д.Хүүхэнбаатар нар Дэл уулын Өлзийтийн хуудас хэмээх газар буй “32 хөшөөт булш”-ийг илрүүлж, улмаар түүний ойр орчимд буй хадны зургийг судалжээ. Уг булш нь 3.6 х 4.7 метрийн хэмжээтэй дөрвөлжин булш байсан бөгөөд энэ булшны хашлага чулуун дээр бүжиглэж буй хүмүүс, буга, согоо, шувуу, нум сумтай хүн, хөтлөлцөж яваа эрэгтэй, эмэгтэй хоёр хүн, ан амьтан зэргийг сийлж дүрсэлсэн байжээ (Санжмятав, 1988).

1987 онд МЗТСХЭ-ийн Хүрэл, төмрийн түрүү үе судлах ангийнхан Дэл уулын Баруун Билүүний хадны зургийг судлах явцдаа эртний түрэг бичээс буйг олж илрүүлж (Санжмятав, 1987), 1988 онд МЗТСХЭ-ийн хүрэл, төмрийн түрүү үе судлах ангийнхан

Дэл уулын Баруун Билүүний хадны зургийг судлах явцдаа 32 хүний дүрс бүхий хөшөө чулуутай булшийг малтан судалсан байна (Санжмятав, 1988).

1989 онд МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангийнхан Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багийн нутаг Билүүт уулын хадны зураг, Өлзийт сумын Тариат багийн нутаг Отготын амны гурван хэсэг газар хаданд бичигдсэн түрэг бичээс, Билүүт уулын түрэг бичээсийг хуулж авсан байна (Баяр, Эрдэнэбаатар, 1989).

1990 онд Д.Наваан Дундговь аймгийн Сайхан Овоо сумын нутаг Хайрханд нэг, Замбага хайрхан ууланд хоёр, монголын үед холбогдох гурван булш малтжээ (Лхагвасүрэн, 1994:53-54; Наваан, 1999:23). Мөн онд Д. Наваан, Дундговь аймгийн ОНС Музейн эрхлэгч Мөнхбаяр, ажилтан Цэрэндорж нар хамтран Сайхан Овоо сумын Хаалган хадны Хангинах гэдэг газар байсан хадны оршуулгыг малтсан байна (Наваан, 1999:23).

1990 онд Монгол-Унгар-Зөвлөлтийн хамтарсан “Хүннүгийн дурсгал судлах анги” Бага газрын чулууны Дунд Шандын аманд нэг хүннү булш малтан судалж нумын гичрийн ясан наалт, чагтан тээгтэй бүсний хүрэл арал, хүрэл товруу, хүрэл үзүүрийн чимэг, авсны төмөр чимэглэл, шавар савны хагархай зэрэг эд өлгийн зүйлс илрүүлэн олжээ (Цэвээндорж, 1990, Цэвээндорж, 2000:35-60).

Т.Санжмятав 1995 онд хэвлүүлсэн “Монголын хадны зураг” номондоо Өлзийт сумын Тагт багийн нутаг Дэл уулын Баруун Билүүн, Хамар ус, Гучин хоёр хүн хөшөөт зэрэг газрын хадны зургаас товч тодорхойлолт, тайлбарын хамт хэсэгчлэн нийтэлсэн байна [Санжмятав, 1995].

Мөн “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал” номын зураг бэлдэх шинжилгээний ангийнхан Дэл уулын зүүн Билүүний хадны зургаас хөтлөлцөн зогссон олон хүн, барилдаж буй хоёр бөхийн зургийг авч уг номонд нийтэлсэн байна [Монгол нутаг, 1999:38-39].

1960-аад оноос хойш МУИС-ийн Түүхийн тэнхимээс жил бүр зохион явуулсан оюутны хээрийн дадлагын ажлын хүрээнд профессор Д.Хүүхэнбаатарын удирдлагаар Дундговь аймгийн нэлээд хэдэн сумдын нутагт түүхийн олон үед хамаарах хөшөө

дурсгал, булш хиргисүүр, хадны сүг зураг, бичээсийг илрүүлэн заримаас нь нийтлүүлсэн байна [Хүүхэнбаатар, 2008:11-31].

1997 онд судлаач Ц.Баттулга Дэл уулын Баруун Билүүний амны эхэнд орших Булаг Билүүтэйн хурал турийн арын сархинаг мэт дэл хаданд буй 4 бичээсийг нягтлан хуулбарлаж 2, 3 дугаар бичээсийг тайлан уншиж нийтэлжээ (Баттулга, 1998:109-115).

2003 онд судлаач Д.Батсүх Дундговь аймгийн нутгаас түүвэрлэсэн зарим хүрэл олдворын цуглуулгыг ангилан боловсруулжээ (Батсүх, 2004).

2004 онд Бага газрын чулууны Ханангийн бууц хэмээх газраас шинээр илрүүлсэн түрэг бичээсийг судлаач Ц.Баттулга тайлан уншиж нийтлүүлжээ (Амартүвшин нар, 2004).

2005 онд Д.Цэвээндорж, Н.Батболд нар Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг дахь Дэл уулын Зүүн болон Баруун Билүүний дөрвөн хэсэг газрын хадны зургийг оролцуулан “Дундговь аймгийн Дэл уулын Билүүний хадны зураг” нэгэн сэдэвт зохиол нийтлүүлсэн байна (Цэвээндорж нар, 2005).

2005 онд Ц.Амгалантөгс, Ч.Амартүвшин нар Бага газрын чулууны Алаг толгойн хүннү булшнаас нумын наалт дээрх сараачмал дүрсний талаар тусгайлан хэвлүүлсэн байна (Амгалантөгс нар, 2005).

2007 онд Ж.Врайт, Ч.Амартүвшин нар Бага газрын чулуунаас олдсон түрэгийн үед холбогдох тамга тэмдгийн байршил зүй, зүй тогтлын талаар туршиц судалгааны ажлаа эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлжээ (Wright, 2007: 349-365).

2007 онд П.Хатанбаатар нарын судлаачид Бага газрын чулууны Ихэрийн аманд малтан судалсан хүннү булшнаас гарсан харь гаралтай ховор олдворын талаар өгүүлэл нийтлүүлжээ (Хатанбаатар нар, 2007). Мөн онд Б.Эрдэнэ, Ц.Амгалантөгс, Р.Нельсон нар 2004 онд Бага газрын чулуунд малтан шинжилсэн Алаг толгой, Дагвын даваа, Монголын ар зэрэг газарт малтан шинжилсэн хүрэл, хүннү, дундад зууны үеийн булшны хэрэглэгдэхүүнийг хэвлүүлсэн байна (Эрдэнэ нар, 2007).

2007 онд Р.Нельсон, В.Ханичёрч, Ч.Амартүвшин нар Бага газрын чулууны Бага Монгол хэмээх цогцолбор дурсгалын малтлага судалгааны үр дүнгийн талаар илтгэл хэлэлцүүлжээ (Nelson et al., 2007). Мөн онд В.Ханичёрч, Р.Нельсон, Ч.Амартүвшин нар БНСУ-ын Сөүл хотноо болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд Бага газрын чулуунд хийсэн хүннү булшны судалгааны талаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна (Honeychurch et al., 2007).

2008 онд Ч.Амартүвшин, Б.Жаргалан нар Бага газрын чулуунд хийсэн хүрэл зэвсгийн түрүү үеийн үеийн булшны судалгаагаар нэг өгүүлэл (Амартүвшин нар, 2008а), Ч.Амартүвшин, П.Хатанбаатар нар Бага газрын чулууны Хүрэн хондын хүннү булшны судалгааны хэрэглэгдэхүүнээр нэг өгүүлэл (Амартүвшин нар, 2008б) тус тус хэвлүүлэн гаргажээ.

2008 онд Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил, Баянжаргалан сумдын нутаг, дахь “Хараат”, “Хайрхан” хэмээх уул уурхайн ашиглалтын талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэж олон тооны дурсгалыг илрүүлэн олсон байна (Гүнчинсүрэн нар, 2009).

2010 онд судлаач Р.Мөнхтулга, С.Хүрэлсүх нар Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутаг Оюут Овоо дахь “Гольден Погада” ХХК-ны ашиглалтын талбайд авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэж нийт 100 гаруй дурсгал илрүүлэн олсон байна (Мөнхтулга нар, 2010).

2010 онд Г.Галдан, Б.Жаргалан нар Бага газрын чулууны хадны зурагт дүрсэлсэн тамга тэмдгийн зүйлсийн талаар тусгайлан өгүүлэл хэвлүүлсэн байна (Галдан нар, 2010).

2012 онд ШУТИС-ийн БуХС-ийн Археологийн судалгааны баг Баянжаргалан сумын нутагт орших “Нутгийн Оюу орд” ХХК-ийн уул уурхайн ашиглалтын талбай дээр Монголын эзэнт гүрний үед холбогдох нийт 30 дурсгалыг илрүүлжээ (Эрдэнэболд нар, 2012).

2016 онд ШУТИС-ийн БуХС-ийн Археологийн судалгааны баг “Очир ундраа” ХХК-ийн Гурвансайхан сумын нутагт орших уул уурхайн талбай дээр олон үеийн

түүхэнд холбогдох 44 булш оршуулгын дурсгалыг илрүүлсэн байдаг. Түүнчлэн тус онд судалгааны багийнхан Өлзийт сумын Дэл уулын хадны зургийн дурсгалт газартай танилцаж, өмнө нь бүртгэгдэж байгаагүй цөөн тооны дурсгалыг баримтжуулан бүртгэж байв (Эрдэнэболд нар, 2016).

2016 онд ШУТИС-ийн БУХС-ийн Археологийн судалгааны баг Гурвансайхан сумын нутагт орших “Шинэ Жес Гранд” ХХК-ийн уул уурхайн ашиглалтын талбай дээр Монголын эзэнт гүрний үед холбогдох нийт 20 тооны дурсгалыг илрүүлжээ (Эрдэнэболд нар, 2016)

2017 онд ШУТИС-ийн БУХС-ийн Археологийн судалгааны баг Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар болон Музейтэй хамтран Өлзийт сумын Гоожинхойн амны хадны оршуулгын дурсгалыг малтан судлах ажлыг хийж оршуулгаас илэрсэн холбогдох эд өлгийн зүйлийг Дундговь аймгийн Музейд хүлээлгэн өгсөн болно (Болдбаатар нар, 2017).

2021 онд ШУТИС-ийн БУХС-ийн Археологийн судалгааны баг Баянжаргалан сумын нутагт Шохойн тал ХХК, Эм жи би ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайд хайгуул судалгаа хийж Түрэгийн үеийн зэл чулуун дурсгал-1, Монголын үеийн булш-1, Хүннүгийн үеийн булш-1, Дөрвөлжин булшны дурсгал-1 зэргийг бүртгэн баримтжуулжээ (Бямба-Очир нар, 2021).



## 1.2. Монголын археологийн үечлэл<sup>1</sup>

### 1.2.а Чулуун зэвсгийн үе

Чулуун зэвсгийн үе нь хүн төрөлхтний түүхийн хамгийн эртний бөгөөд хамгийн удаан үргэлжилсэн үе юм. Чулуун зэвсгийн үеийг палеолит буюу хуучин чулуун зэвсгийн үе, неолит буюу шинэ чулуун зэвсгийн үе хэмээх гурван үед хуваан судалдаг. Түүхэн хөгжлийн урт удаан хугацааны туршид эртний хүмүүс чулуун зэвсэг үйлдвэрлэх арга барил, хүрээлэн буй орчин, амьд байгальтай харьцах харьцаа, байгалийн хатуу ширүүнд дасан зохицох, шинэ газар нутгийг эзэмших зэрэгт томоохон өөрчлөлт дэвшилт гаргасаар иржээ.

Энэ үед хүний эрт үеийн өвөг бүрэлдэн бий болж, орчин үеийн арьстнууд үүсэн, дэлхийн бөмбөрцгийн өнцөг булан бүрийн байгаль цаг уурын таатай нөхцөл бүхий газар нутгийг эзэмших үйл явц явагджээ.

**Хуучин чулуун зэвсгийн үе (800.000-12.000 жил).** Палеолитын үеийг доод, дунд, дээд гэсэн гурван том үед хуваан авч үздэг.

***Доод палеолитын үе (800.000-100.000 жил):*** Монгол орны палеолитын үеийн хамгийн эртний үед холбогдох олдворууд бүхий бууц суурин Баянхонгор аймгийн Өлзийт сумын Нарийн гол, Баянлиг сумын Цагаан агуй, Жаргалант сумын Байдрагийн гол, Шинэжинст сумын Босго, Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий, Ханбогд сумын Оцон Мааньт, Ховд аймгийн Манхан сум Хойт Цэнхэрийн гол, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц зэрэг олон газраас олджээ.

Доод палеолитын үед Монгол нутагт оршин амьдарч байсан хүний хөдөлмөрийн гол зэвсэг нь хугадас, гилбэр ба мэсэн зэвсэг байсан бөгөөд тэдгээр нь цохих, цавчих, хэрчих, хусах зэрэг олон үйлд хэрэглэгдэж байжээ. Тэр үеийн хүн эдгээр үндсэн зэвсгээс гадна бүхэл чулуунаас хэлтэлж авсан хурц ирмэгтэй зузаан нимгэн залтас, ялтас, мөн арслан заан, савгат хирс зэрэг аварга том амьтны яс, модон бороохой, шийдэм зэргийг ашиглаж байжээ.

---

<sup>1</sup> Д.Цэвээндорж, Д.Баяр, Я.Цэрэндагва, Ц.Очирхуяг. Монголын археологи. Улаанбаатар, 2002

**Дунд палеолитын үе (100.000-40.000 жил):** Дунд палеолитын үндсэн зэвсэг нь таргил үлдэцнээс өргөн залтас цуулан авч түүний ир ирмэгийг дахин засаж хийсэн гурвалжин мэс хянгар юм. Хурц ирмэгтэй гурвалжин мэсийг хутганы зориулалтаар, нимгэн мэсийг мод, ясанд суулгаж жад маягаар хэрэглэж байснаас гадна хянгарыг арьс шир янзлах, мод, ясан эдлэл хийхэд голчлон ашиглаж байсан.

Монгол орны нутгаас дунд палеолитын буюу Мустье үед холбогдох бууц суурингууд олон тоогоор олдсон бөгөөд харьцангуй сайтар судлагдсан нь Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Орхон I, Орхон VII (9, 10 дугаар давхарга), Богд сумын нутагт орших Арц Богд, Баянхонгор аймгийн Богд сумын нутаг Аргалант I, Орог нуур I, II, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших Оцон мааньт зэргийг дурдаж болно.

Дунд палеолитын үед чулуун зэвсгээс гадна түүнтэй холбогдсон өдөр тутмын үйл ажиллагаанд том амьтдын ясыг бага зэрэг засаж зэвсэг хийх, модон савааны үзүүрийг галд түлж хатууруулан жадны оронд хэрэглэх, том бөөрөнхий чулууг дүүгүүр болгон ашиглах явдал байжээ. Дунд палеолитын үед гал гаргаж хэрэглэж сурсан явдал нь энэ үеийн хүний хөгжилд хамгийн чухал түлхэц болсон.

**Дээд палеолитын үе (40.000-12.000 жил):** Дунд палеолитоос дээд палеолитод шилжих үед орчин үеийн хүн (*homo sapiens sapiens*) бий болсон нь юуны өмнө чулуун зэвсгийг шинэ арга барилаар хийдэг болсноор илрэх бөгөөд энэ үед гонзгой хэлбэрийн үлдцээс нимгэн урт хутган ялтас тал бүрээс нь уртааш нь цуулж түүнийхээ ирмэгийг нэг ба хоёр талаас нь дахин холтчин засаж хурц ир гаргадаг болжээ. Чулууг цуулах ба сэлтлэн ирлэх болсон нь тэр үед чулуун зэвсэг хийх үйл ажиллагаанд гарсан нэг ёсны шинэ оньсон арга байжээ. Энэ үеийн хүний амьдралын ул мөр болох чулуун зэвсгийн зүйлс манай орны нутгаас түгээмэл байдлаар олддог. Жишээлбэл, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Мойлтын ам, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад, Булган аймгийн ХутагӨндөр сумын нутагт Төлбөрийн голын суурин зэргийг нэрлэж болох юм.

**Дундад чулуун зэвсгийн үе (12.000-7.000 жил).** Мезолитын үед газар тариалан, мал аж ахуй үүсэх эхлэл тавигдаж, эртний хүмүүс нум сумыг зохион

бүтээжээ. Энэ үед Умард Ази, Өрнөд ба Дорнод Европод түрж орсон их мөстлөгийн үе нэгэнт дуусч цаг агаар эрс зөөлөрч Умард Ази (Сибирь) их ойт бүс, Төв Азийн байгал газар зүйн байдал, амьтан ургамлын аймаг орчин үеийн төрхийг олсон байна.

Манай орны Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Чихэн агуй, Дорнод аймгийн Халх гол сумын Хэрээ уул, Чойбалсан хотын орчим Хэрлэн голын баруун эрэг, Өвөрхангай аймгийн Мойлтын ам (I үе), Хэнтий аймгийн Рашаан хад (II-III үе), Дорноговь аймгийн Дулааны говь, Өмнөговь аймгийн Булган сумын Баруун, Зүүн хайрхан уул болон БаянӨлгий, Ховд, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн зарим газраас мезолитын үеийн дурсгалыг илрүүлэн судалжээ.

**Шинэ чулуун зэвсгийн үе (8.000-3.000 жил).** Неолитын үеийн хүний аж ахуйн гол шинж нь ан гөрөө хийх, ургамлын үр үндэс түүх зэрэг байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг шууд хэрэглэх нь хязгаарлагдаж мезолитын үед эхлэлийн төдий байсан үйлдвэрлэхүй аж ахуй ба өөрөөр хэлбэл газар тариалан, мал аж ахуй эрхлэх ажилд шилжсэн явдал юм.

Неолитын үед чулуугаар зэвсэг хийх дадлага туршлага, арга ухаан өмнөх үеэс улам илүү хөгжиж ахуй амьдралын аливаа хэрэгцээнд олон төрөл эдлэлийг маш нарийн хийцтэй үйлдэх болжээ. Ялтсыг шовгор үлдцийн бүх талаас уртааш нь цуулах болсон тул тэр нь зөв талт урт хутган хэлбэртэй болсон байна.

Чулуун эдлэл хийхэд гарсан энэ үеийн нэг гол онцлог нь чулууг сайтар зүлгэж билүүдэх, өнгөлөх, хөрөөдөж ховил гаргах, өрөмдөж цоолох аргыг сэдэж олсонд оршино.

Неолитын үед Монгол оронд оршин суугчид чулуун зэвсгээс гадна ясаар хийсэн эдлэл өргөн хэрэглэж байжээ. Неолитын үеийн хүний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний бас нэг чухал шинэ ололт нь шавар ваар, сав бүтээн хийж хэрэглэх болсон явдал юм.

Дээр дурдсан төрөл бүрийн зэвсэг, ваар сав бүхий тэр үеийн хүний бууц суурин Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хэнтий зэрэг тус орны ихэнх нутгаас олджээ.

### **1.2.b. Хүрэл зэвсгийн үе**

МЭӨ II мянган жилийн тэртээгээс Евразийн хээр тал нутагт хүрлээр хийсэн эдлэл өргөн тархаж эхэлжээ. Ойролцоогоор МЭӨ II мянган жилийн тэртээ зэсийг цагаан тугалга, хар тугалгатай хольж хайлуулан хүрэл гэдэг шинэ холимог төмөрлөгийг гарган авч үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүрэл зэвсгийн үе эхэлсэн гэж үздэг. Хүрэл зэвсэгт шилжсэн үе нь эдийн соёлд гарсан хувьсгал байгаад зогсоогүй аж ахуй, нийгмийн харилцаанд ч үндсэн өөрчлөлт гаргасан юм. Хүрэл зэвсгийн үед амьдарч байсан хүмүүс, эртний хүрэл зэвсгийн үйлдвэрлэл явуулж байсан дурсгалууд, түүвэр олдвор, дөрвөлжин булш, хиргисүүр, буган хөшөө, хадны зосон зураг, хадны сийлмэл зураг зэрэг олон төрлийн дурсгалыг үлдээсэн байна.

**Төмөр зэвсгийн түрүү үе:** Төмөр зэвсгийн түрүү үе нь хүй нэгдлийн нийгмийн төгсгөлийн шат бөгөөд тэр үед эртний овог аймгууд төмрийн хүдрийг хайлуулах аргыг эзэмшиж, төмрөөр хөдөлмөрийн багаж, байлдааны зэр зэвсэг үйлдвэрлэх болжээ.

Хүн төрөлхтний урьд өмнө туулж ирсэн чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеийг бодоход төмөр зэвсгийн үе богино юм. Үнэн хэрэгтээ төмөр одоо хүртэл үйлдвэрлэлийн чухал үндсэн түүхий эд хэвээрээ байна. Гэвч энеолит /зэс чулуу/ ба хүрэл зэвсгийн үед эртний боолын нийгмийн соёл иргэншил үүссэн /Месопотами, Египет, Грек, Энэтхэг зэрэг/ орнуудаас бусад нутагт амьдарч байсан хүй нэгдлийн үеийн овог аймгуудын түүхийг ангилан судлахад “төмөр зэвсгийн түрүү үе” гэдэг нэр томъёо хэрэглэдэг. Төмөр зэвсгийн үйлдвэрлэл дэлхийн орон бүрт харилцан адилгүй өөр өөр үед тархсан байна.

**Дөрвөлжин булш:** Дөрвөлжин булш нь Монголын хүрэл зэвсгийн үеийн археологийн томоохон дурсгалын нэг юм. Дөрвөлжин булш жижиг толгодын орой шил, даваа хөтөл дээр ганц нэг, хоёр гурваараа тохиолдохоос гадна тэднийг гол төлөв уулын энгэр, бэл, аманд мөн тэгш талын дунд нэг дор арваас хэдэн арав хүртэл тоотой хэсэг бүлгээр нь барьж байгуулсан байдаг.

Дөрвөлжин булш дорнод Монголын талаас Алтайн уулс, Байгал нуураас Говь хүртэл өргөн тархсан археологийн томоохон дурсгал юм. Дөрвөлжин булшны зохион

байгуулалтыг авч үзвэл, хайрцаглан хийсэн нимгэн хавтгай чулуун авсанд хүнээ оршуулж, том зузаан хавтгай чулуунуудаар дарж таглан шороогоор булаад дээр нь хавтгай чулууг босгон эгнүүлэн дөрвөлжлөн зоож, дотор гадна хаяаг нь арай багавтар чулуугаар дарж бэхэлсэн байдаг.

**Хиргисүүр:** Хиргисүүр нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн өвөрмөц дурсгал юм. Хиргисүүрийг үйлдэгчид нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн нүүдэлчид байсан гэдэг нь түүний дөрвөлжин булш, буган хөшөөтэй нэг дор нэгэн цогцолбор болон оршин байдгаас илэрхий. Манай орны нутаг дэвсгэр дээр байгаа хиргисүүрүүд нь гаднах хэлбэр төрх зохион байгуулалтын хувьд гуч орчим төрөлд хуваагдана. Хиргисүүр нь том хэмжээний дугуй овгор чулуун дараас, түүнийг тойруулан чулуу эгнүүлэн зоож дугуй, дөрвөлжин хүрээ татсан байдаг. Судлаачид хиргисүүрийг МЭӨ II мянган жилийн төгсгөл МЭӨ I мянган жилийн эхэн үед холбогдуулан авч үздэг.

**Буган хөшөө:** Гонзгой урт чулууг засаж, гурав зааглан, оройн хэсэгт нар сар, доогуур нь олон эгнээ хонхор, эх биеийг ороолгон төв хэсэгт сүрэг бугыг загварчилсан байдалтайгаар ихэд сүрлэг сийлж, бас доогуур нь бүс татан зэр зэвсгийг зүүсэн байдалтай дүрсэлсэн хөшөө чулууг буган хөшөө хэмээн нэрлэдэг. Хөшөөнөө дайчин эрийн зэвсэг болох чинжаал хутга, билүү, байлдааны алх, нум, хоромсого, жад, бамбай, толь дүрслэхээс гадна хөшөөний бүсийг олон төрлийн хээгээр чимсэн байдаг. Буган хөшөөг эрдэмтэд 100 орчим жилийн тэртээгээс судалж энэ завсар 700 орчим буган чулуун хөшөөг олж илрүүлжээ. Эдгээрээс хамгийн их буюу 550 орчим нь Монгол улсын нутгаас олджээ.

**Хадны зураг:** Монгол орны нутаг дэвсгэр дээр оршин амьдарч байсан хүрэл зэвсгийн үеийн хүмүүсийн үлдээсэн өөр нэгэн хосгүй дурсгал бол хадны зураг юм. Энэ үед холбогдох хадны зургийг улаан зосон, сийлмэл хэмээн ангилан авч үздэг. Монгол орны хүрэл зэвсгийн үед холбогдох улаан зосон зургийн гол төлөөлөгч нь “Сэлэнгэ”-ийн төрлийн зосон зураг юм. Монгол нутагт амьдарч байсан хүрлийн үеийн овог аймгийн гишүүдийн оюун санааны хөгжилтийг харуулах өөр нэгэн томоохон дурсгал бол хадны сийлмэл дурсгал юм. Энэ төрлийн дурсгал монгол нутгийн хад чулуунд

харьцангуй олон тоотой байдаг төдийгүй нэгэн хаднаа өөр өөр үеийн дурсгалууд ч давхарлагдан зурагдаж холилдсон байдаг.

**Чандманы соёл:** Монгол оронд төмөр зэвсгийн эхэн үед амьдарч байсан хүмүүсийн аж ахуй, соёлын олон талт асуудлыг улируулан тодруулан судлахад Увс аймгийн Улаангом хотын ойролцоох Чандмань уулнаа малтан шинжилсэн өвөрмөц хэлбэрийн булшнууд онцгой ач холбогдолтой юм. Эдгээр булш нь тодорхой нэгэн овог аймгийн дурсгал болох тул Монголын археологийн судалгаанд тусгай соёл болгон авч үздэг. Чандмань уулын булш гадаад хэлбэр төрх, үхэгсдийг оршуулсан зан үйлээрээ том дөрвөлжин чулуун далантай, чулуун далантай авсгүй, жижиг чулуун австай, дүнзэн бунхантай шороон булш гэсэн үндсэн дөрвөн төрөлд хамаарах ажээ.

### **1.2.с. Эртний улсуудын үе**

**Хүннү гүрний үе:** МЭӨ III зууны үед хүннүчүүд бусад нүүдэлч аймгуудаасаа хүчирхэгжин аймгийн байгууллын хувьд шинэ шатанд орох эхлэлээ тавьжээ. Хүннүгийн аймгийн холбоог шаньюй нэртэй хаан захирдаг байсан бөгөөд МЭӨ III зууны үе хүртэл аймаг буюу зонхилогчийн зөвлөлөөр сонгодог байсан боловч дараагаар нь үе залгамжлуулах хэлбэрт шилжсэн байна. Хүннүчүүд Модунг хаан болсны дараагаар хөрш зэргэлдээ аймаг улсуудыг цэрэглэн эзэлж газар нутгаа тэлэн өргөсгөх бодлого баримталсан байна.

Хүннү нарын дотоодын зөрчил болон овог аймгуудын хоорондын тэмцлээс шалтгаалан Хүннү гүрэн нь МЭӨ 57-55 оны хооронд умард, өмнөд гэсэн хоёр хэсэг болон хуваагдаж Хуханье шаньюйгаар толгойлуулсан өмнөд хүннүчүүд Хан улсын харьяанд орж, Хуханьейн ах Чжичжи умард Хүннүг захирах болжээ.

МЭӨ III - МЭ II зуун хүртэлх хугацаанд Төв Азийн өргөн уудам нутагт Хүннү нар нүүдэллэн амьдарч, төр улсаа цогцлон байгуулж, мандан бадарч байсны бодит нотолгоо болох археологийн дурсгалууд Монгол орны нутаг дэвсгэрээс олон тоотойгоор олддог.

Хүннүгийн археологийн дурсгалыг дотор нь булш бунхан, хот суурин, хадны зураг гэж ерөнхийлөн ангилан авч үзнэ.

**Хүннүгийн булш бунхан:** Хүннүгийн үед холбогдох булш бунхныг оршуулгын зан үйл, гаднах хэлбэр төрх, дагалдуулсан эд зүйл зэргээр нь язгууртны болон жирийн иргэдийн гэж хуваан авч үздэг. Энэ хоёр булш нь гаднах төрх байдал, зохион байгуулалтаараа эрс ялгаатай байдаг төдийгүй булшнаас гарч байгаа эд өлгийн зүйлсийн хувьд ч ялгагдана.

Язгууртны булш нь хэмжээний хувьд харьцангуй том, дөрвөлжин чулуун өрлөг далантай, үүдэвчтэй байдаг. Хүннүгийн язгууртны ийм булш манай орны Төв аймгийн Борнуур сумын нутаг Ноён уулын Сүжигт, Зурамт, Хужиртын ам, Ховд аймгийн Манхан сумын Тахилтын хотгор, Архангай аймгийн Хайрхан сумын Хүнүй голын Гол мод, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Борбулаг, Дуурлиг нарс зэрэг газруудад олон тоогоор байна. Мөн Буриадын нутаг Ильмийн ам, Дэрст зэрэг газруудад хүннүгийн язгууртны бүлэг булшууд байдаг.

Хүннүгийн жирийн иргэдийн булшийг Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Булган аймгийн Бүрэгхангай сумын Өвгөнт, Үүдэнт, Хөвсгөл аймгийн Галт сумын Нүхтийн ам, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Наймаа толгой, Батцэнгэл сумын Худгийн ам, Солби уул, Хөвсгөл аймгийн их-Уул сумын нутаг Сул толгой, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Бурхан толгой, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Морин толгой, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Дуулга уул, Дундговь аймгийн Бага газрын чулуу зэрэг олон газруудад малтан шинжилжээ.

Хүннүгийн жирийн иргэдийн булш нь дугуй чулуун далантай байх ба далангийн доор нүх ухаж дотор нь банзан авс болон мод чулуугаар хийсэн хашлаганд хүнээ толгойгоор нь хойд зүг хандуулан тэнэгэр байдлаар хэвтүүлэн оршуулсан байдаг. Хүннүгийн жирийн иргэдийн булшийг малтан судалсан хэрэглэгдэхүүнээс үзэхэд сонгосон газар зүйн байршилт, булшны гадаад байдал, бүтэц зохион байгуулалт, булшинд үхэгсдийг оршуулах зан үйл, дагалдуулан тавьсан эд өлгийн зүйл зэрэг бүхий л талаараа дундад зууны төдийгүй өнөөгийн монголчуудын үхэгсдээ оршуулдаг заншилтай ижил төстэй байгаа нь хүннү монголчууд хоёр нэгэн угсаатан болохыг археологийн талаас нь харуулж буй чухал үндсэн баримт гэж үзэж болно.

**Хот суурин:** Хүннүгийн археологийн судалгааны чухал хэрэглэгдэхүүний нэг бол тэр үеийн хот суурин юм. Хүннү нар нүүдлийн мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ тодорхой хэмжээгээр газар тариалан эрхлэн хот суурин байгуулан сууж байсан байна.

Төв аймгийн Борнуур сумын Бороогийн суурин, Мөнгөнморьт сумын Хүрээн дов, Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин, Эрдэнэ сумын Өндөр дов, Баянжаргалан сумын нутаг Хэрлэн голын Цагаан арлын Гуа дов, Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын Баруун Дөрөөгийн хэрэм, Барс хот II, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Дэлгэрхаан сумын зааг нутагт орших Цэнхэрийн голын хэрэм, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Шувуутайн голын хэрэм, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Баянбулагийн турь, Ханбогд сумын Мангасын хүрээ зэрэг Хүннүгийн үед холбогдох хот суурины үлдцийг археологийн хайгуул шинжилгээний ажлын явцад олж илрүүлэн заримыг малтан судалжээ.

**Хадны зураг:** Хүннү нарын үлдээсэн археологийн дурсгалын өөр нэг төрөл бол хадны зураг юм. Манай орны нутаг дэвсгэрээс олдсон хэдэн мянган хадны зургаас судлаачид Ховд аймгийн Үенч, Алтай сумын зааг нутаг Ямаан усны хавцлын Ханан хаданд дүрслэгдсэн гурвалсан морь хөллөсөн сүйх тэрэг, тамган дүрс, Баян-Өлгий аймгийн Улаан хус сумын нутаг Цагаан салаагийн хаднаа буй нохойд хөөгдсөн аргалийг угтан харваж буй анчныг дүрсэлсэн зургуудыг хүннүгийн үед холбогдуулан авч үздэг. Гэвч Хүннүгийн үед холбогдох зургууд нэлээд байх боловч тэдгээрийг одоо хир нарийвчлан судлаагүй байгаа билээ.

**Түрэгийн үе:** Түрэгүүд нь Төв Азид эрт цагаас оршин нутагласаар ирсэн, түүх соёл, угсаа гарлаараа монголчууд, тэдний өвөг дээдэстэй туйлын ойрын холбоотой нүүдэлчин ард түмэн юм. Монгол болон зөрчид угсаатны нэгэн адил алтай язгуурын хэлний бүлэгт хамаарах түрэгүүд VI-YIII зууны үед нийт Төв Ази түүний дотор одоогийн Монгол нутгийг харьяандаа багтаасан хүчирхэг хаант улсыг байгуулж энэ бүс нутаг дахь түрэг угсаатны 400 орчим жилийн ноёрхлын эх үндсийг тавьжээ.

Түрэг угсаатанд холбогдох археологийн эд өлгийн дурсгалт зүйлийн дотор хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах хүн чулуу, адгуус амьтны дүрс, руни бичээст пайлуур хөшөө, уран барилгын



холбогдолт дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, их бага бичээсийн зүйлс, нас барагсдыг оршуулсан булш хиргисүүр зэрэг зүйлс орж байна.

**Тахил тайлгын онгон:** Түрэгийн тухайт эд өлгийн дурсгал, нэн ялангуяа тэдний хамгийн их нийтлэг бөгөөд өргөн тархсан дурсгал болох тахил тайлгын онгоны цогцолборууд нь түрэг угсаатан оршин суусан Евразийн уудам нутгаар өргөн тархсан бөгөөд манай орны Хэнтийн уулсаас Алтайн их уулсыг хүртэлх нутагт элбэг олддог. Эдгээр нь уг нас барсан хүний язгуур угсаа, зэрэг дэвээс шалтгаалан их бага, янз бүрийн хэмжээтэйгээс гадна бүтэц зохион байгуулалтаараа ч эрс ялгаатай байв.

Жирийн иргэдийн онгон нь хавтан чулууг газарт хайрцаглан суулгаж хийсэн дөрвөлжин хашлага, түүний өмнө (зүүн талд) байрлуулсан хүн дүрст чулуун хөшөө, уг хөшөөний өмнөөс наран ургах зүгийг чиглүүлж цувруулан зоож тавьсан балбал хэмээх зэл чулуун эгнээ зэрэг үндсэн хэсгээс бүрдэнэ.

Язгууртны онгоныг үйлдэхдээ, өнгөлж засаад хээ угалз гарган чимэглэсэн дөрвөн хавтангаар хашлага босгож өмнө нь нэлээд бодитой уран хийцтэй хүн чулуу тавьж олон тооны зэл чулуу цувуулсан байна.

**Хүн чулуу:** Түрэгийн тайлгын онгоны нэг бүрэлдэхүүн хэсэг болох хүн чулуун хөшөө нь тухайн үеийн хүмүүсийн төрх байдал, хувцас өмсгөл, эд хэрэглэл, гоёл чимэг, зэр зэвсгийн төрөл зүйл, тэдгээрийн онцлог зэргийг сэргээн тодруулж судлахад онцгой ач холбогдолтой эх сурвалж баримт төдийгүй тэр үеийн дүрслэх урлагийн хөгжил, гоо сайхны үзлийн хэмжээ түвшинг илтгэн харуулдаг байна. Монгол нутагт эдүгээ нийт 500 гаруй хүн чулуу илрүүлэн олж бүртгээд байгаагийн 400 гаруй нь түрэгийн үед холбогдох ба цаашид ч шинээр нэмэн олдох боломжтой юм. Хүн чулуу хэмээх нь боржин, гантиг, хүрмэн чулуу, элсэн чулуу занар зэрэг чулуугаар хүний дүрс оруулан хийж тахил тайлгын онгоны бүрэлдэхүүнд оруулан босгодог хөшөө юм.

**Уйгурын үе:** Түрэгийн хаант улс мөхсөний дараа түүний ор суурийг Уйгур улс эзэлж VIII-IX зууны үед Монгол нутагт ноёрхлоо тогтоожээ. Уйгур нь мөн алтайн хэлний бүлэгт багтах түрэг угсаатан байв.

Уйгурчууд хот балгад барьж суурьшин суух талаар бусад нүүдэлчдээс нэлээд онцлогтой байлаа. Тэд манихейн шашныг дэлгэрүүлж согдын гар урчуудын туслалцаатайгаар энэхүү шашны сүм дуган барьдаг байжээ. Уйгурууд дөрвөлжин шавар хэрэмт бэхлэлт хотуудыг их барьдаг ба хил хязгаарыг сэргийлэн хамгаалах бэхлэлт хотын бүхэл бүтэн сүлжээ бүрэлдэн тогтсон байжээ. Манай улсын нутагт Уйгур улсын сүр жавхлантай нийслэл Ордубалык буюу Хар балгас, шашин номын томхон төв болж байсан Сэлэнгэ мөрний хөвөөн дэх Бийбулагийн балгас зэрэг хотууд байдгийг археологийн талаар бага сага шинжин судалж байжээ. Уйгурууд, Монгол нутагт оршин тогтнож байсан олон аймаг, улсын дотор нэлээд дээгүүр соёлтой байжээ. Тэр үеийн дурсгалын тоонд, “Сэлэнгийн бичээс” хэмээн алдаршсан Могойн шинэ усны гэрэлт хөшөө, Архангай аймгийн Тариат сумын нутаг дахь Тэрхийн бичээс зэрэг бичиг үсгийн томхон дурсгалууд орно.

**Кидан улсын үе:** Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын нэг нь Кидан улс юм. 901 онд Киданы хаанаар Елюй овгийн Амбагянь тодрон гарч эрх мэдлээ бэхжүүлэн хуучин найман аймгийг үндэс болгон Кидан улсыг байгуулжээ. Кидан гүрэнд 55 аймаг улс багтсан ба тэдгээрийг өмнөд замын 16 аймаг, умарт замын 28 аймаг, гадаад 8 аймаг гэж хуваадаг. 5 нийслэлтэй, газар нутаг нь дорнод далайгаас Алтайн уулс, Хэрлэн голоос Хятадын цагаан суваг хүртэл өргөжсөн байна.

Монгол нутгаас Киданы үед холбогдох археологийн дурсгалууд бусад үеийнхийг бодвол харьцангуй цөөн тоогоор олддог. Монгол нутагт буй Кидан нарын холбогдолт археологийн дурсгалаас хамгийн олон тоотой хийгээд харьцангуй сайн судлагдсан нь хот балгадын үлдэц юм. Монголд олддог Киданы холбогдолт археологийн дурсгалын дотор хот суурины дурсгал зонхилж байдаг. Түүхийн сурвалж бичиг, археологийн мэдээгээр манай улсын нутагт киданы үеийн арваад хот мэдэгдэж байна. Киданы булш оршуулгын дурсгалыг малтан шинжилсэн байдлаас үзэхэд эл төрлийн дурсгал, тэдний уугуул нутаг Шар мөрөн, Урчи мөрөн зэрэг нутгаас их олддог байна. Киданы булшийг зохион байгуулалтынх нь хувьд нүх ухаж оршуулсан булш, газар дор хонгил хийж оршуулсан хаад ноёдын булш гэсэн үндсэн хоёр хэсэгт хувааж үздэг.

#### **1.2.d. Дундад зууны үе**

**Монгол гүрний үе:** Төв Азид ноёрхон байсан Кидан гүрэн XII зууны үед мөхсөний дараа монгол угсааны овог аймгууд Хятадын цагаан хэрмээс Сэлэнгийн эх хүртэлх нутгийг эзлэн оршиж байв.

XIII зууны эхээр эдгээрийн дотроос Хамаг Монголын ханлиг нэн хүчирхэгжин нийт монгол угсаатныг нэгтгэн 1206 онд Онон мөрний эхэнд их хуралдай хийж Тэмүжинг Чингис хаан цолоор өргөмжлөн Их Монгол улсыг байгуулжээ. Ингээд Чингис хаан засаг захиргаа шинэчлэн тогтоож цэргээ зохион байгуулж, хил хязгаараа өргөтгөн тохинуулжээ. Чингис хааны зарлигаар Хар Хорумд улсын нийслэлийг байгуулж, дараах хаадын үед өргөтгөн барих ажлыг гүйцэтгэсээр иржээ. Харин 1260 онд Хубилай хаан улсын нийслэлийг өмнө зүг шилжүүлж Хятад газар төвлөрөн сууж улсын нэрийг Их Юан болгон өөрчилжээ. 1368 онд Монголчуудын байгуулсан Их Юан улс Хятадын босогчдод цохигдон мөхсөнөөр монголчууд уугуул нутагтаа төвлөрөх болсон ч өмнөх сүр хүч нь доройтон суларч өөр хоорондоо тэмцэн хямарсан бутралын үе эхэлжээ. Энэ байдал удтал үргэлжилсээр 17-18-р зууны үед монголчууд бүхэлдээ Манж Чин гүрний мэдэлд орж улс төрийн тусгаар тогтнолоо алдахад хүргэсэн юм.

**Хот суурин:** Монголчуудын байгуулсан хот суурингаас хамгийн сайн судлагдсан нь XIII зууны Монголын Эзэнт гүрний нийслэл Хар Хорум хот юм. Хот нь эргэн тойрон хүрээлсэн шавар хэрэмтэй, дөрвөн талдаа хаалгатай, төв хэсэгтээ огтлолцсон хоёр их гудамжаар гар урлал, худалдаа арилжаа, орд харш, сүм хийдийн гэх хэдэн үндсэн хэсэгт хуваагдаж байв. Хар Хорум хотын барилга байгууламжийн зохион байгуулалт, гоёл чимэглэлийн хэрэглэгдэхүүнээс IX-XII зууны үеэс уламжлан ирсэн орон нутгийн уран барилгын арга барил харагддаг. Тэр үед монгол оронд Хар Хорумаас гадна хэд хэдэн хот байсныг сурвалж бичгийн мэдээ гэрчлэх бөгөөд, тухайлбал, Саорин, Тосху болон хааны дөрвөн их орд гэж байжээ. Одоо мэдэгдэж байгаагаар монголчуудын барьж байгуулсан хот суурины хамгийн эртнийх нь XII зууны үед холбогдох Аваргын балгас юм. Энэ нь Хэрлэн голын баруун гарын цутгал Аваргын голын хойд эрэгт Рашаан дэрсний ухаа хэмээх уулын өмнө бэлд орших ба 4.5 ам дөрвөлжин км талбайтай.

Археологийн судалгааны явцад Монголын их гүрний үед холбогдох өөр бусад хотуудыг ч илрүүлэн олж ямар нэгэн хэмжээгээр малтан судалж байсны тоонд Хэрлэн Барс, Хар хул хааны балгас, Шаазан хот, Халтарын балгас зэргийг дурдаж болно.

**Монголчуудын булш оршуулга:** Дундад зууны монголчуудын нийгмийн харилцаа, үйлдвэрлэх хүчний хөгжил, зан суртахуун, шашин шүтлэг, ахуй байдлыг бодитойгоор судлан шинжихэд чухал ач холбогдолтой дурсгалын нэг нь тэр үеийн булш оршуулга юм.

Түүхийн сурвалжид тэмдэглэн үлдээснийг үзвээс эртний монголчууд нас барсан хүнээ газрын хөрсөн нүх малтаж булшлан оршуулах ба тэр хүний амьд ахуйдаа хэрэглэж асан эд юмсын зүйлсээс дагалдуулан хийдэг байсныг тодорхой өгүүлжээ. Эртний энэ заншил шарын шашин Монголд дэлгэснээр орхигдож нас барсан хүнээ ил задгай нутаглуулах болжээ.

Эдүгээ манай улс болоод ОХУ-ын нутагт монгол булш малтан шинжилсэн байдлыг үзэхэд эгэл жирийн иргэдийн булш оршуулга голлож байна. Эдгээрийг газар зүйн байрлалыг ажиглахад ямар нэгэн уул, өндөрлөг газрыг сонгон авч уулын өмнөд энгэр, хормой бэл, тэгш дэвсэг газар оршуулдаг нь хаа ч нийтлэг үзэгддэг юм. Дундад зууны монгол булш ихэвчлэн газрын хөрсөн дээр чулуу өрж хийсэн, чулуун дараасны өрлөг нь урт талаараа умар зүг чиглэсэн, цөөвтөр чулуутай, нуугдмал байдалтай байна. Дараасыг хуулж авахад голдуу дан шороогоор булж төдий л гүн биш, австай, авсгүй хоёр янзаар оршуулсан байдаг.

**Хүн чулуу:** Монгол оронд байгаа хүн чулуу нь VI-IX зууны Түрэг овог аймгуудын, XIII-XIV зууны Монгол гүрний үеийн хүн чулуу хэмээх үндсэн хоёр төрөлд хамаарна. Монгол гүрний үеийн хүн чулуу Монгол улсын зүүн өмнөд хэсгээр байрлажээ. Монголын үеийн хүн чулууг баруун гартаа хундага барьж, зүүн гараа сандлын түшлэгт, эсвэл өвдөг дээрээ тавин түшлэгтэй сандалд суугаа байдлаар урладаг. Мөн энэ үеийн хүн чулууг зөв тийш дарсан ташуу энгэртэй, урт хормой, нарийн ханцуйтай дээлтэй, мухар буюу шөвгөрдүү, заримдаа яльгүй ээтийж эргэсэн хоншоортой гутал өмссөнөөр дүрсэлсэн нь түрэг болоод бусад төрлийн хүн чулуунаас их ялгаатай байна.

Монголчуудын хүн чулуун хөрөг нь тухайн үеийн хүмүүсийн бодит дүр төрх, хувцас өмсгөл, гоёл чимэглэл, эдлэл хэрэгслийн онцлогийг тусган харуулах түүхэн чухал сурвалж болохын зэрэгцээ тэр үеийн монголчуудын гоо сайхны мэдрэмж, урлаг уран сайхны төвшин, урчууд дархчуудын ур чадварыг илтгэн харуулах дүрслэх урлагийн үнэт дурсгал болох юм.

## **2. СУДАЛГААНЫ АЖЛЫН ТУХАЙ**

### **2.1. Хээрийн судалгаа хийх хууль эрх зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хууль

Нэгдүгээр бүлэг: Долоодугаар зүйл: Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хууль

27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэнэ.

5.1.4 “Соёлын үнэт зүйлийг элдэв халдлагаас сэрэмжлэн хамгаалах”.

18.1.1 “Түүх, соёлын дурсгалт болон соёлын үнэт зүйлсийг хадгалах, хамгаалах”.

13.1 “Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр, газрын хэвлий нь төрийн хамгаалалтад байх бөгөөд аливаа олдвор нь төрийн өмч мөн”.

17.1 “Түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтад соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн аймаг, нийслэл, баг, сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина”.

17.11.” Иргэн түүх, соёлын дурсгалт зүйлд аюул учирч байгаа, эсхүл учирч болзошгүй байдал олж илрүүлсэн бол энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй”.

17.12.”Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ”.

17.13. “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлгөхийг хориглоно” гэсэн заалтуудыг үндэслэл болгон ажиллаа.

Мөн БСШУ-ны Сайдын 2010 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 222 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Монгол улсын нутагт археологи, палеонтологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 2.4, 2.5 дахь заалтад “Хот суурин, барилга байгууламж, усан цахилгаан станц, уул уурхайн үйлдвэр барьж байгуулах, зам тавих зэрэг үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж нь уг ажлыг эхлэхийн өмнө Мэргэжлийн зөвлөлд хандах бөгөөд зөвлөл нь мэргэжлийн шинжээчдийг томилон тухайн газар нутагт түүх, археологийн дурсгалт зүйл байгаа эсэх талаар тандалтын урьдчилсан малтлага судалгаа хийлгэж дүгнэлт гаргуулна”; “Тандалтын малтлага, судалгаа хийх, олдворыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг энэ журмын 2.4-т заасан үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж хариуцна” хэмээн тус тус заасан байна.

Монгол улс нэгдэн орсон соёлын өвтэй холбоотой ЮНЕСКО-ийн конвенциуд. Олон улсын хамтын нийгэмлэг – ЮНЕСКО 1972 онд Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай Конвенц, 2003 онд Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг тус тус батлан гаргасан нь дэлхий нийтэд түгээмэл ач холбогдолтой, хосгүй гайхамшигт байгалийн болон соёлын өвүүд, улс үндэстэн бүрийн амьдралын хэв шинж, өвөрмөц онцлогийг тусгасан, түүний нэрийн хуудас, таних тэмдэг болсон соёлын биет бус өвүүдийг хадгалж хамгаалах, өвлүүлэх үйл явцад томоохон алхам болсон юм.

Монгол Улс 1964 онд, “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай Гаагийн конвенц”-д нэгдэн орж түүний үзэл санаа, зорилтыг хүлээн зөвшөөрч, тууштай дэмжиж ирлээ. Монгол Улс 1990 оноос хойш хүн төрөлхтний нийтлэг замд нэгдэж, дэлхий дахинд нээлттэй болж эхэлсэн нь олон улсын чанартай гэрээ, конвенцод нэгдэн орж ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Тухайлбал,

1990 онд ЮНЕСКО-гийн “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц”-д, 1991 онд “Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенц”-д, 2005 онд “Биет бус соёлын өвийн конвенц”-д, 2007 онд “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай

конвенц”-д тус тус нэгдэж орсноор тэдгээрийн үзэл санаа, үндсэн зарчмууд болон шаардлагыг соёлын өвийг хамгаалах хууль тогтоомж, бусад баримт бичигт тусган хэрэгжүүлж эхэлсэн байна.

Эдгээр конвенцын хүрээнд ЮНЕСКО өвүүдийг Дэлхийн өвийн жагсаалт, Соёлын биет бус өвийн Төлөөллийн Дэлхийн жагсаалт, Аюулд учирч буй Дэлхийн Өвийн Жагсаалт болон Яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын биет бус өвийн Дэлхийн жагсаалтад бүртгэж, хамгаалах арга хэмжээ авч байна. Түүнчлэн 1990-ээд оноос байгаль, соёлын өвөө ирээдүй хойч үедээ өвлөн үлдээх, залуучуудад ав соёлоо дээдлэн хүндэтгэх хүмүүжил олгох, түүнийг хадгалж хамгаалах талаар мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх зорилгоор Дэлхийн Өвийн боловсролын асуудлыг дэвшүүлэн тавьж хэрэгжүүлж байна. Энэхүү судалгаанд эдгээр эрх зүйн үндсэн баримт бичгүүдийн холбогдох заалтуудыг үндэслэл болгов.



## **2.2. Хээрийн судалгааны ажлын зорилго бүтэц, зохион байгуулалт, арга зүй**

Суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээг “Дундговь аймгийн нутаг дахь, түүх соёлын дурсгал” нэртэйгээр 2020 оны 5 дугаар сарын 19-ны өдөр ШУСС-2020/33 тоот гэрээг/хавсралт-1 үз/ байгуулсан. Энэхүү гэрээний санхүүжилт ШУТСангаас 2021 оны 5 сард хийгдсэнээр уг төсөлд ажил 2021, 2022 онуудад хэрэгжсэн.

*Судалгааны зорилго:* Манай судалгааны төслийн үндсэн зорилго нь Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалыг бүртгэж баримтжуулах, судалгааны бааз бий болгох, сэдэвчилсэн лавлах бүтээл хийх. Хээрийн судалгааны ажлын зорилго нь Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалыг бүртгэн баримтжуулах. Ингэхдээ өмнө нь судлагдаж бүртгэгдсэн дурсгалуудыг дахин очиж байршил солбицолыг дахин тогтоох, дурсгалын зургийг шинэчлэн авах, дурсгалын хадгалалт хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, тэдгээрийн эрсдэлийн үнэлгээг хийх. Түүнчлэн шинэ дурсгалыг илрүүлэн бүртгэж, байршил солбицолыг тогтоох, дурсгалын зургийг авах, дурсгалын хадгалалт хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, тэдгээрийн эрсдэлийн үнэлгээг хийх, дурсгалын хамрах хүрээг тодорхойлох. Хээрийн судалгааны үр дүнд Дундговь аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалын нэгдсэн бааз материал бий болгож судалгааны эргэлтэд оруулах, цаашдын судалгаа шинжилгээний суурь хэрэглэгдэхүүн болгоход оршино.

*Судалгааны объект:* Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Дэрэн, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай, Сайнцагаан, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Хулд, Луус, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдын газар нутаг.

Бид уг төслийн хүрээнд хээрийн судалгааны ажлыг 2021, 2022 онуудад хийсэн бөгөөд хээрийн судалгааны 5 удаагийн шинжилгээний баг ажиллаж гүйцэтгэсэн юм. 2021 онд төлөвлөгөөт ажлын хүрээнд 7 сумын түүх соёлын дурсгалын бүртгэл судалгаа хийх байсан боловч цар тахлын нөхцөл байдлын улмаас Дэрэн, Говь-Угтаал, Адаацаг, Дэлгэрцогт гэсэн 4 сумын нутагт судалгаа хийсэн.

2021 онд ШУТИС-БуХС-ийн Археологи-Этнографийн судалгааны хоёр баг С.Бат-Эрдэнэ, Ц.Бямба-Очир нараар ахлуулан ажилласан. Эхний судалгааны баг С.Бат-Эрдэнэ судлаачаар ахлуулан Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт сумдуудад 2021 оны 6 сарын 10-наас 7 сарын 28-ны өдрүүдэд ажилласан. Хоёрдугаар хээрийн судалгааны баг Ц.Бямба-Очир судлаачаар ахлуулан Дундговь аймгийн Дэрэн, Говь-Угтаал сумдуудад 2021 оны 7 сарын 15-наас 8 сарын 27-ны өдрүүдэд ажиллав.

2022 онд ШУТИС-БуХС-ийн Археологи-Этнографийн судалгааны хээрийн шинжилгээний 3 баг Дундговь аймгийн Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай, Сайнцагаан, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Хулд, Луус, Дэлгэрхангай, Сайхан-Овоо гэсэн 11 сумдад ажилласан.

С.Бат-Эрдэнэ ахлагчтай судалгааны I багийнхан Өлзийт, Сайнцагаан, Луус сумдын нутагт 2022 оны 6 сарын 15-наас 8 сарын 7-ны хооронд хээрийн судалгааг гүйцэтгэсэн.

Д.Очирпүрэв ахлагчтай судалгааны II баг Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Эрдэнэдалай сумдад, 2022 оны 6 сарын 18-наас 8 сарын 13-ны хооронд хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн.

Ц.Бямба-Очир ахлагчтай судалгааны III баг Гурвансайхан, Өндөршил, Баянцагаан, Цагаандэлгэр сумдын нутагт 2022 оны 6 сарын 13-наас 8 сарын 19-ны өдрүүдэд хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. /Хээрийн судалгааны багийн албан томилолтыг Хавсралт-2 хэсгээс үз/

Судалгааны арга зүй, аргачлал: Хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө арга зүйг ШУТИС-БуХС-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж 2020 оны 5-р сарын 29-ны өдрийн эрдмийн зөвлөлийн 09 дугаар тогтоолоор батлуулсан/Хавсралт-3 үз/.

Ямарваа нэгэн зүйлийг зохион байгуулалтайгаар эрэн хайж, олж тогтоох үйлдлийг хайгуул гэдэг билээ. “Хайгуул” гэдэг нь ихэвчлэн шинжлэх ухааны үг хэллэгт өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ нь геологи, палеонтологи, биологи, археологи зэрэг

шинжлэх ухааны салбарт түгээмэл ойлголт билээ. Хайгуул нь археологийн судалгааны хамгийн эхний шатны бөгөөд хариуцлагатай ажил юм.

**Ангилал:** Археологийн хайгуул судалгаа нь эртний түүх соёлын дурсгалыг эрэн хайж, илрүүлэн олох, тодорхойлон, судлан, шинжлэх зорилготой өөрийн гэсэн арга зүйд тулгуурласан судалгааны ажлын нэгэн хэлбэр юм. Археологийн хайгуул судалгааны ажлыг дотор нь нэгдүгээрт, нарийвчлалтай хайгуул, хоёрдугаарт, энгийн, гуравдугаарт хялбаршуулсан гэж гурав хуваан авч үзэж болно.

Нарийвчлалтай хайгуул гэдэг нь хөндий, тэгш тал газар хайгуул судалгаа хийх арга зүй юм. Энэхүү арга зүйг уртраг, өргөргийн дагуу шугаман хайгуулыг гүйцэтгэхэд ашиглах бөгөөд овор хэмжээтэй дурсгалыг хайж олохоос гадна газрын хөрсөн дээр буй хүний нүдэнд тэр бүр ажиглагдахгүй чулуун зэвсэг, шавар савны хагархай, зарим жижиг эд өлгийн зүйлсийг илрүүлэн олоход чиглэгдэнэ [Lightfoot, Kent. 1986].

Ямарваа нэгэн зүйл олсон тохиолдолд түүний байршлын солбицолыг тогтоох, тухайн олсон зүйлийн талаар тодорхойлолт бичих, олдворыг баримтжуулах зэрэг ажлыг гүйцэтгэж дараагийн шатанд өргөтгөсөн малтлага хийх эсэх талаар зөвлөлдөнө. Энэхүү хайгуулын арга зүйг уул уурхайн компанийн ашиглалтын талбай болон хайгуулын талбайд хэрэглэх хэрэгтэй юм. Учир нь ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын талбай нь хэмжээний хувьд том, жижиг янз бүр байх боловч тодорхой хүрээнд хязгаарлагдсан байдгаас гадна цаашид энэ газар нь эвдэгдэх, бүрэн устах магадлалтай учир илүү нарийвчлалтай хийх нь зүйтэй.

Энгийн хайгуул. Энэхүү хайгуулын арга зүйг тачир өвстэй уулын бэл, голын дагуух довцог, хуурай сайранд хайгуул хийхэд ашиглахад тохиромжтой. Хайгуулын энэхүү арга зүй нь ямар нэгэн бүс нутагт хайгуул болон дурсгалын талаар тодорхой хэмжээний туршлага мэдээлэл хуримтлуулсны үндсэн дээр хайгуулыг илүү хурдан, олон хүнийг хамарсан байдалтай хийхэд чиглэгдэнэ. Мөн газрын зургийн хүрэлцээ муу буюу тухайн бүсийн нарийвчлалтай газрын зураг байхгүй тохиолдолд агаарын зургийг ашиглан хайгуулыг хийхэд хэрэглэнэ. Учир нь агаарын зураг тодорхой өндрөөс авсан гэх боловч зарим тохиолдолд зургийн алдаа, чанар зэргээс хамаарч газар орчин сайн харагдахгүй, шугамын талаар нарийн мэдээлэл байхгүй зэрэг дутагдалтай байдаг.

Хайгуулын ажлын хамгийн эхэнд агаарын зургийн тусламжтайгаар сонгосон талбайн дөрвөн захын цэгийг GPS багажаар тодорхойлно. Дараа нь хүн тус бүрийн хоорондын зайг хэлэлцэн тогтоно. Талбайн аль нэгэн захаас тогтсон зайгаар явж нөгөө зах хүрэх зэргээр нааш цааш уртраг, өргөргийн дагуу хайгуулыг хийж гүйцэтгэнэ. Ингэснээр нэг шугамд эгнэн хайгуул гүйцэтгэж байсан хайгуулын хэсэг нь хэд хэдэн хэсэг болон задарч хайгуулын талбайд өөрсдийн сонголтоор хийж гүйцэтгэх боломжтой болно. Хайгуулын хэсэг болгон өөрсдийн хайгуулын мэдээллийн дэвтэр, дурсгалын ерөнхий дэвсгэр зураг үйлдэх дэвтэр, фото аппарат, GPS зэрэг багаж хэрэгслийг хэрэглэнэ.

Хялбаршуулсан хайгуул. Энэ хайгуулын арга зүйг сонгож авсан хайгуул хийх талбай болон түүнээс гадагш харьцангуй хол талбайд хайгуул хийхэд хэрэглэнэ. Гол болон уулсын хоорондох битүү мод бүхий хайгуулын талбайд тухайн хайгуулын хэсэг ямар нэгэн зайд баригдахгүй, хүн явах боломжтой газраар явж шалгаж үзнэ. Ийм уулын бүсэд археологийн дурсгал ховор байдаг боловч хайгуулын гол зорилго бол сонгосон талбайдаа ямар нэгэн газрыг үлдээлгүй, олон янзын арга зүйгээр хайгуулд хамруулах явдал билээ. Мөн өөр нэгэн зүйл бол сонгосон хайгуулын талбайгаас гадагш ойролцоо зарим газрыг үзэж танилцах, өөрсдийн талбайтай харьцуулах зайлшгүй шаардлага урган гарна. Талбай илүү том, зам урт учир үүнийг автомашинаар хийж гүйцэтгэж болдог. Автомашин явах боломжтой ам, хөндийгөөр орж дурсгалтай танилцах, тэдгээрийн баримтжуулалтыг хийнэ.

Манай хээрийн судалгааны анги эдгээр хайгуулын аргуудыг тухайн хайгуул хийж буй газар, талбайн онцлог байдлаас хамааран дангаар нь болон хослуулан хэрэглэсэн. Мөн орон нутгийн соёлын өвийн ажилтан болон орон нутгийн нутаг орно сайн мэдэх иргэдээс тодруулан аван тэднийг хайгуулдаа оролцуулах ажил өргөн хүрээнд хэрэглэгдсэн юм.

*Археологийн дурсгалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс ба эрсдэлийн үнэлгээг тогтоох аргачлал:* ТСҮХД-д сөрөг нөлөөт хүчин зүйлсийн төрөл тус бүрээр нөлөөллийн эрсдэлийн үнэлгээний түвшин, эрэмбийг “А В С” үлгэрчилсэн загварыг ашиглан хийсэн. Энэхүү үлгэрчилсэн загвар нь “А”, “В”, “С” гэсэн 3 хэсгээс бүрдэнэ.

“А” хэсэг нь эрсдэл учруулагч хүчин зүйлсийн тохиолдох цаг хугацааны давтамж эсвэл үргэлжлэх хугацаа юм. Эрсдэл учруулагч хүчин зүйл нь тохиолдлын шинж чанартай бол дахин болох магадлалын цаг хугацааны давтамжийг сонгох, хэрэв эрсдэл учруулагч хүчин зүйл нь үргэлжилсэн шинж чанартай бол хэдэн жилийн дараа ноцтой хэмжээний гэмтэл учруулахыг тооцох зэрэг зарчимд тулгуурласан болно

“В” хэсэг нь эрсдэл учирсан тохиолдолд дурсгалд үүсэж болох эвдрэл гэмтлийн хэмжээг илэрхийлнэ. Эвдрэл гэмтэл нь үргэлжилсэн шинж чанартай бол эрсдэлээс үүдэн гарах эвдрэл гэмтлийн хэмжээг сонгохдоо “А” хэсэгт сонгосон цаг хугацааны дараа дурсгалд ямар гэмтэл үүсэхийг тооцох зарчим юм.

“С” хэсэг нь эрсдэлд орсон тохиолдолд дурсгалын үнэ цэн, үнэлэмжийн түвшин алдагдах хэмжээг илэрхийлэх арга юм.

ТСҮХД-д сөрөг нөлөөт хүчин зүйлсийн нөлөөллийн түвшинг “ABC” үнэлгээний аргаар тогтоосон Соёлын өвийн үндэсний төвийн судлаачдын болон орон нутгийн мэргэжилтнүүд, эрдэмтдийн үнэлгээнүүдийг ТСҮХД-ын төрөл тус бүрээр харьцуулан, “хоёр багийн үнэлгээний дүйцэл” нэрээр илэрхийлсэн билээ.

Соёлын өвийн үндэсний төвөөс хийсэн судалгаагаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтад Монгол орны хувьд сөрөг нөлөөт байгаль 10, нийгмийн дараах 29 хүчин зүйлсийг олон улсын төвшинд зөвшөөрөгдсөн нийтлэг хэрэглэдэг аргазүйн дагуу “устах”, “өгөрших”, “физик гэмтэл”, “ус”, “гал”, “эх төрхөө алдах”, “тоногдох” гэсэн 7 төлөөллөөр (*A Guide to Risk, 2016*) ангилан тогтоосон болно.

Үүнд:

а. Байгалийн хүчин зүйлд:

1. Аянга цахилгаан;
2. Биологийн бохирдол;
3. Газар хөдлөлт;
4. Дэлхийн дулаарал (цэвдэг);
5. Нар;

6. Салхи;
7. Үер;
8. Хур тунадас;
9. Ой, хээр түймэр;
10. Чулуунд нэвчсэн борооны ус хөлдөх тохиолдолд (ЧНБУХТ).

Б. Нийгмийн хүчин зүйлд:

11. Авто болон төмөр замын трасс (АБТЗТ);
12. Агаарын бохирдол, утаа тортог(АБУТ);
13. Аж ахуйн нөлөөлөл (ААН);
14. Ашигт малтмал, газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа (АМГТАҮА);
15. Ашигт малтмал, газрын тосны хайгуулын үйл ажиллагаа (АМГТХҮА);
16. Буруу сэргээн засварлалт (БСЗ);
17. Вандализм;
18. Газар тариалан;
19. Мал шөргөөх (мал сүргийн нөлөөлөл);
20. Орон нутгийн чанартай замтай ойр үед (ОНЧЗОҮ);
21. Соёлын өвийн мэдлэг хомс байдал (СӨМХБ);
22. Суурьшлын бүс газар олголт (СБГО);
23. Сүсэг бишрэл;
24. Объектын түймэр;
25. Улс төрийн нөлөө (УТН);
26. Улсын чанартай замтай ойр үед (УЧЗОҮ);
27. Хууль бус наймаа (ХБН);
28. Эдийн засгийн хомсдол, ядуурал (ЭЗХЯ);
29. Эзэнгүйдэл гэж ангилан үзжээ.

Энэхүү хоёр өөр үнэлгээний аргын хоорондын өндөр түвшний дүйцэл бол Монгол нутагт ТСҮХД-д сөрөг нөлөөт хүчин зүйлсийн төрөл, эрсдэл учруулах түвшний үнэлгээний судалгаанд олон улсын “А В С” аргазүйг ашиглах зайлшгүй хэрэгцээ нэгэнт бий болсныг илтгэж байна.

ТСҮХД-д сөрөг нөлөөт хүчин зүйлсийн эрсдэл учруулах нөлөөллийн үнэлгээгээр:

ТСҮХД-д сөрөг нөлөөт 10 хүчин зүйлс нь тухайн дурсгалын төрлөөс хамаарч харилцан адилгүй эрсдэл учруулж байгаа ба ИХ ЭРСДЭЛ учруулах хүчин зүйлд, ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, суурьшлын бүстэй ойр үед хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, авто болон төмөр замын бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, ДУНД ЭРСДЭЛ учруулах хүчин зүйлд, ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, улсын чанартай замаар зорчиж буй хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэх эрсдэл, БАГА ЭРСДЭЛД орон нутгийн зам, газар хөдлөлт, голын үерийн эрсдэл учруулах тохиолдлууд ажиглагдаж байна.

Энэхүү аргачлалын дагуу бүртгэж баримтжуулсан анкетыг /хавсралт-4 үз/ жишээ болгон оруулав.

Хайгуулд хэрэглэгдэх багаж, хэрэгсэл. Археологийн хайгуулыг хийж гүйцэтгэхэд олон тооны багаж, компьютерын хэрэгслийг өргөн ашигладаг билээ. Үүнд, газрын байршлыг тодорхойлох GPS багаж, GPS багажаар хэмжсэн хэмжилтийг компьютерт оруулан газрын зурагт тэмдэглэх GIS буюу Archview програмууд багтана.

Техник хэрэгслийн хувьд дараах хэрэгслүүдийг ашиглан баримтжуулалт хийлээ. Зургийн Аппарат: Canon EOS 6D, canon EOS 6D mark II, Lens - canon 24-105mm USM II, 24-70mm USM II, 70-200mm USM II, Benro tripod. Drone: AUTEL EVO LITE PLUS BUNDLE, Parrot Anafi, Video: Go pro 6 hero, JVC HD camera Everio 34x zoom, gimbal Osmo mobile 3, gimbal zhiyun smooty X3, Mic: Boya By M1, Boya By MM1.



*Зураг-1: Судалгаанд ашигласан техник хэрэгсэл*



## АДААЦАГ СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Их бөгс уул

**Солбицол:** N 46°42'24.0" E 105°47'47.0" Alt: 1368

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Түрэгийн үе.

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү Булш, Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их бөгс уулын энгэрт 25 тооны Хүннү булш байна. Булшнаас хойш 500 м-т бууцтай. Бууцны хормойд хажуу талдаа зурагтай Тахилын онгон байж мэдэхээр хөшөө чулуу байна. Мөн зэрэгцээд 2 хиргисүүр оршино. Уулын хойд талд том бул хар чулуун дараас бүхий 15м голчтой хиргисүүр байрлана. Мөн хажуу талд нь 15м голчтой 7м овоолготой дөрвөлжин хүрээтэй хиргисүүр байх ажээ.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Ар булаг

**Солбицол:** N 46°41'48.0" E 105°52'11.0" Alt: 1380

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү Булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ар булгийн хойд энгэрт элстэй жижиг хадан цохион өмнө 5м голчтой, том чулуун дараастай хиргисүүр оршино. Урд хэсгийн дараас чулуу шороонд дарагдсан байдалтай. Түүний хажууд 4 тооны хүннүгийн жирийн иргэдийн булш байна.

### Дурсгал-3

**Газрын нэр:** Ар булгийн зэл чулуу

**Баг:** Арвай баг

**Солбицол:** N 46°41'48.8" E 105°52'11.4" Alt: 1380

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ар булгийн усны хойд дээр 13 босоо чулуу баруун урдаас зүүн хойд зүг рүү 45,3 м газарт зоосон байна. Зарим чулууд нь унаад мэдэгдэхгүй болсон.

#### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Эхэн хөвийн булш

**Баг:** Булангаа

**Солбицол:** N 46°35'11.7" E 105°42'52.3" Alt: 1540

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Түрэгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, Хүннү булш, зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс Эхэн хөвийн аманд 20 гаруй км-т 10 орчим хүннү булштай газар байна. Хадтай уулын урд энгэрт 12 тооны хиргисүүр, дөрвөлжин булш хамтдаа орших ба 4 чулууг зүүн зүг чиглүүлэн байрлуулсан зэл чулуун дурсгалтай аж. Уг дурсгалуудыг өмнө нь бүртгээгүй. Мөн Эхэн хөвийн булгийн эхэнд уулынхаа зүүн урд энгэрт 2 том хиргисүүр байх аж.

#### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Ар худаг

**Баг:** Булангаа

**Солбицол:** N 46°35'29.8" E 105°46'08.5" Alt: 1568

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын байгууламж

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ар худаг хэмээх газарт зэргэлдээ 2 тооны Түрэгийн үеийн тахилын байгууламж байна. 1x1м хэмжээтэй, зүүн болон зүүн хойд хашлага чулууд унасан байдалтай. Өмнө нь уг дурсгалыг бүртгээгүй ажээ.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Буруу хавирга

**Баг:** Булангаа

**Солбицол:** N 46°26'08.3" E 105°45'16.1" Alt: 1586

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү Булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Буруу хавиргын аманд хүрээгүй, зүүн талдаа дагуул байгууламжтай 1 хиргисүүр, дөрвөлжин хүрээтэй 1, нийт 9 хиргисүүр байна. Мөн 3 хүннү булш байна.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Саруулын бууц

**Солбицол:** N 46°25'26.7" E 105°45'09.5" Alt: 1552

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү Булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Саруулын бууцны зүүн дор 2, зүүн хажуу дээр 4 хиргисүүр байна. 1 хиргисүүр үүдэвчтэй. 1 хиргисүүр тоногдсон. Саруулын бууцны урд 21ш хүннү булш байх ба дунджаар 6м голчтой. Хүннү булшнуудыг шинээр бүртгэсэн болно.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Хөшөөтийн дэнж

**Солбицол:** N 46°27'12.7" E 105°51'36.2" Alt: 1491

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын байгууламж

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн тийш 8км зайд хөшөөтийн дэнж хэмээх тал дээр Түрэгийн үеийн тахилын онгон байна. Хойд талын хашлага чулуу босоогоороо өндөр нь 50см, урд тал болон зүүн талын хашлага чулуу унасан байдалтай, баруун талын хашлага чулуу намхан газрын хөрсөнд дарагдсан, голдоо 50см орчих хөшөө чулуутай байгууламж ажээ.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Хорин жасын туурь

**Солбицол:** N 46°14'46.0" E 105°37'01.0" Alt: 1490

**Он цаг:** 18-р зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийд

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хорин жасын туурийн үлдэгдэл, түүхий тоосго, хөн цөн, чулуу шар шаврын үлдэгдэл овойж товойж үлдсэн. Одоогийн байдлаар бригадын барилга, чулуун хороо, худаг, склад үлдсэн байна

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Сүм хөх бүрд

**Солбицол:** N 46°14'46.0" E 105°37'01.0" Alt: 1490

**Он цаг:** 17-р зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийд

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Эргэн тойрон усаар хүрээлэгдсэн довцог дээр чулуун хана хэрмийн үлдэгдэл 3 хэсгээс бүтдэг. ХҮII зууны үед бүтээгдсэн барилга ажээ. Байгалийн үзэсгэлэнт газар байрладаг. Улсын хамгаалалтад авсан.

## **Дурсгал-11**

**Газрын нэр:** Зуутын хийд

**Солбицол:** N 46°02'38.0" E 105°40'45.0" Alt: 1436

**Он цаг:** 18-р зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийд

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зуутын хийдийн 2 дуган, 1 суварга, хоёр гурван шавар байшингийн үлдэгдэл байна. Шар өнгөтэй 21, саарал өнгөтэй 1 дуган байна. Аймгийн хамгаалалтад авсан.

## **Дурсгал-12**

**Газрын нэр:** Цагаан овооны булш

**Солбицол:** N 46°21'04.0" E 105°45'54.0" Alt: 1520

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монгол гүрний үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урагш 5 км орчимд Антены баруун хажууд Цагаан-Овооны баруун энгэрээр монгол булш 50 орчим, дөрвөлжин булш 10 орчим байна.

Дундговь аймгийн Адаацаг сумын нутгаас нийт 12 дурсгалт газрын 169 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 28
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 17
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 2
- Монголын үеийн булш оршуулгын дурсгал - 50
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 63
- Зэл чулуу – 2

- Барилга архитектур, Сүм хийдийн дурсгал – 3
- Түрэгийн тахилын онгон - 4

Дундговь аймгийн Адаацаг сумын 12 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 2 дурсгалт газар буюу 18,1%
- Бага эрсдэлтэй – 6 дурсгалт газар буюу 54,5%
- Дунд эрсдэлтэй – 4 дурсгалт газар буюу 36,3%
- Их эрсдэлтэй – 0 дурсгалт газар буюу 0%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Адаацаг сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 12 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 10 буюу 91 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 1 буюу 9%

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл гэсэн нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Адаацаг сумын нутгаас илрүүлэн бүртгэсэн 169 тооны түүх, соёлын дурсгалаас 56 тооны дурсгалыг шинээр бүртгэн баримтуулсан. Үүнд:

- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал - 39
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 5
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал – 9
- Зэл чулуун дурсгал – 1
- Түрэгийн тахилын байгууламж – 2

**Адацаг сумын нутагт байх түүх, соёлын дурсгалт газрын зарим зураг**



1. Их бөгс уулын хүннү булшны цогцолбор



4. Эхэн хөвийн булш



2. Ар булгийн булш



5. Ар худгийн тахилын онгон



3. Ар булгийн зэл чулуу



6. Буруу хавирга уулын булш





7. Саруулын бууц



8. Хөшөөтийн дэнжийн тахилын онгон



9. Хорин жасын туурь



10. Сүм хөх бүрд



11. Зуутын хийдийн туурь



## БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Овоотын тээг

**Солбицол:** N 45°37'01.5" E 108°07'28.6" Alt: 1151

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Овоот уулаас урд зүгт 4 км орчим зайд хар хадан тогтоцтой жижиг толгой бүхий тээгийн зүүн бэлд хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш 3 байх бөгөөд зэрэгцээ байрлана. Эдгээр дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Өндөр улаан

**Солбицол:** N 45°36'08.5" E 108°06'08.3" Alt: 1152

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн чанартай замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс урагш 20-25 орчим км газарт Өндөр улаан хэмээх газрын зэл чулуу 2 эгнээ хойд эгнээ 26 чулуун хөшөөг цувруулан босгосон урд эгнээ нь 10 чулууг цувруулан үйлдсэн.

### Дурсгал-3

**Газрын нэр:** Овоот хайрхан уул

**Солбицол:** N 45°39'01.0" E 108°06'29.8" Alt: 1174

**Он цаг:** Неолит, Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Чулуун зэвсгийн дурсгал, Хиргисүүр, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Сүсэг бишрэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Овоот хайрхан уулын урд энгэрээр орших бүлэг дурсгал.

1. N 45°39'01.0" E 108°06'29.8" Alt: 1174. Овоот хайрхан уулын урд энгэрийн бүлэг дурсгалын хамгийн зүүн талын дурсгал нь дугуй хүрээтэй хиргисүүр, хүрээний зүүн урд талд дөрвөлжин хэлбэрийн битүү чулуун дараастай 5 тооны дагуул байгууламж зэрэгцээ байрлана. Хиргисүүрийн хүрээний гадуур тойроод 11 дагуул байгууламж байна.
2. 1-р хиргисүүрийн баруун тийш уулын энгэрийг дагасан 10 тооны цагариг хэлбэрийн чулуун дараастай монголын үеийн булш байна. Үүний нэг нь тоногдсон. N 45°39'01.6" E 108°06'25.9" Alt: 1179
3. N 45°39'01.7" E 108°06'25.0" Alt: 1182 Монголын үеийн бүлэг дурсгалаас баруун тийш 10 орчим метр зайд хүрэл зэвсгийн үеийн дугуй хүрээтэй хиргисүүр байна.
4. N 45°39'03.5" E 108°06'24.8" Alt: 1189 Овоот уулын зүүн хөтөл дээр байх битүү дугуй чулуун дараастай Монголын үеийн булш 1 байна. Түүнээс дээш уулын орой дээр дөрвөлжин хүрээтэй хиргисүүр 1 байна.
5. Эдгээр дурсгалуудын оршин байх газар буюу Овоот уулын урд бэлээр неолитын үеийн чулуун зэвсгийн үлдэц болон бэлдцүүд олноор илрэх нь энэ газарт чулуун зэвсгийн бууц суурин дарханы газар байсныг илэрхийлнэ. Чулуун зэвсгийн дурсгалт газрыг шинээр илрүүлэв.

#### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Баян Цогт хайрхан

**Солбицол:** N 45°39'58.6" E 108°05'58.9" Alt: 1146

**Он цаг:** Неолит-шинэ чулуун зэвсгийн үе, Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Чулуун зэвсгийн дурсгалууд, Хиргисүүр, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Овоот хайрхан уулын зүүн хойд талын хадтай толгойн эргэн тойронд байх бүлэг цогцолбор дурсгалтай газар. Уг дурсгалт газарт 18 хүннү булш, дөрвөлжин булш 1, дугуй хүрээтэй хиргисүүр 1, дөрвөлжин хүрээтэй хиргисүүр 1 нийт 21 булш оршуулгын дурсгал байна. Мөн уг газарт неолитын үеийн чулуун зэвсгийн үлдэц болон бэлдцүүд олноор илрэх бөгөөд чулуун зэвсгийн дурсгалтай газар байна.

1. N 45°39'58.6" E 108°05'58.9" Alt: 1146 чулуун зэвсгийн дурсгал, неолит буюу шинэ чулуун зэвсгийн үеийн үлдэц бэлдэц зуулга ир зэрэг олноор байх нь чулуун зэвсгийн дарханы газар бууц суурин байсныг илтгэнэ.
2. N 45°39'34.0" E 108°06'30.6" Alt: 1147 Овоот хайрхан уулын зүүн хойд талын хадтай толгойн зүүн хойд талд байрлах бүлэг булштай, нийт 8 тооны Хүннү булш байх бөгөөд хамгийн урд талын хамгийн том нь урд талдаа үүдэвчтэй бөгөөд үүдэвчний залгаа чулуун дараас нь дөрвөлжин хэлбэр сайн ажиглавал мэдэгдэнэ. Уг газарт мөн чулуун зэвсгийн дурсгал газрын хөрсөн дээр олноор байх аж.
3. N 45°39'31.8" E 108°06'31.1" Alt: 1155 2-р дурсгалаас урагш 200 орчим метр зайд 4 тооны Хүннү булш байрлана.
4. N 45°39'26.8" E 108°06'30.6" Alt: 1153 Овоот хайрхан уулын зүүн хойд талын хадтай толгойн урд энгэрийн бүлэг дурсгал. Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр 1, түүний чулууг ашиглаж хожим нь зэрэгцээ дөрвөлжин булш 1-ийг үйлдсэн, Хиргисүүрийн хойд талд цагариг хэлбэрийн чулуун дараастай Хүннү булш 1, түүнээс баруун тийш 5 тооны Хүннү булш байрлана. Хүннү булшнаас баруун тийш дугуй хүрээтэй хиргисүүр 1 байна. Эдгээр 21 тооны булш оршуулгын дурсгал болон шинэ чулуун зэвсгийн үеийн чулуун зэвсгийн дурсгалт газрыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Модот

**Солбицол:** N 45°40'03.8" E 108°04'55.8" Alt: 1175

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн чанартай замд ойр.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Модот хэмээх хадтай толгодын баруун бэлд орших дугуй хүрээтэй хиргисүүр, түүнээс хойш бэлийг даган Монголын үеийн булш 1, дугуй хүрээтэй хиргисүүр 1 байна. Уг дурсгалт газарт нийт 2 хиргисүүр, монголын үеийн 1 булш байна.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Мөрт

**Солбицол:** N 45°42'30.1" E 108°03'59.7" Alt: 1184

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу, хиргисүүр, хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Аж ахуй, Орон нутгийн чанартай замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Мөрт хэмээх газарт, Мөртийн бууц хэмээх айлын өвөлжөө байх бөгөөд уг газарт хадны зураг, тамга тэмдэг болон зэл чулуу, дугуй хүрээтэй хиргисүүр бүхий дурсгалт газар юм. Мөртийн бууцны ойролцоох зэл чулуун дурсгал болон хиргисүүрийн дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэсэн.

1. N 45°42'30.1" E 108°03'59.7" Alt: 1184 Мөртийн бууцны урд талын мөлхөө цагаан хадан тогтоцтой толгодын зүүн урд талын хаднууд дээр тамга тэмдэг бүхий дүрслэл маш бүдгэрсэн байдалтай байна.
2. N 45°42'51.4" E 108°04'04.5" Alt: 1191 Мөртийн бууцнаас зүүн тийш уулын энгэрт баруун урдаас зүүн хойш чиглэсэн зул чулуунууд байна. Тодорхой мэдэгдэж байгаагаар 37 чулууг 800 орчим метр зайд байрлуулсан. Зүүн үзүүртээ тахилгын байгууламжтай.
3. N 45°43'07.3" E 108°04'11.6" Alt: 1190 Мөртийн бууцнаас зүүн хойд зүгт 1,5 км орчим зайд жалгын хойд ирмэг дээр, уулын зүүн урд бэлд дугуй хүрээтэй хиргисүүр байна. Хиргисүүр урдуур орон нутгийн чанартай зам өнгөрнө.

#### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Зараа уулын баруун урд дэнж

**Солбицол:** N 45°44'54.7" E 108°04'57.9" Alt: 1194

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зараа уулаас баруун урд зүгт 2-3 км орчим зайд баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон жижиг дэнжийн урд чулуун өрлөг бүхий барилгын туурь байна. 8м Х 5м хэмжээтэй.

#### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Зараа хайрхан

**Солбицол:** N 45°45'14.3" E 105°05'01.2" Alt: 1210

**Он цаг:** Неолит, Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Чулуун зэвсгийн дурсгал, Хиргисүүр, Дөрвөлжин булш, Хүннү булш, Монголын эзэнт гүрний үеийн булш.

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл, Эзэнгүйдэл, Орон нутгийн чанартай замд ойр байрлана.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зараа уулын эргэн тойрон байх олон үеийн олон тооны булш оршуулгын дурсгалууд байна. Мөн уг газарт нэлээд таруу түүвэр хэлбэрээр чулуун зэвсгийн дурсгал илэрч байна.

1. N 45°45'14.3" E 108°05'01.2" Alt: 1210. Зараа уулын баруун бэлд байх дөрвөлжин булшны бүлэг дурсгал. 10 тооны дөрвөлжин булш хойноос урагш чиглэлтэй зэрэгцээ байрлах бөгөөд мөн 2 тооны дагуул жижиг байгууламж байна.
2. N 45°45'14.5" E 108°05'00.7" Alt: 1210. 1-р дурсгалтай бараг зэрэгцээ байрлах дугуй хүрээтэй хиргисүүр байна. Энэхүү хиргисүүрийн чулуун дараасыг ашиглаж дөрвөлжин булшнуудыг үйлдсэн байх бололтой бөгөөд хиргисүүрийн зохион байгуулалт нийлээд эвдэгдсэн байна.
3. N 45°45'16.1" E 108°05'00.0" Alt: 1211. 1-р дурсгалаас зүүн талд байх дөрвөлжин хашлага бүхий тахилгын байгууламж, түүний голд хөшөө чулуу босгосон байна.
4. N 45°45'23.8" E 108°05'56.8" Alt: 1199. Зараа уулын зүүн урд дэнж дээр байрлах дугуй хүрээтэй зэрэгцээ байрлах 2 тооны хиргисүүр олон тооны дагуултай, тоногдсон. Мөн түүнээс баруун тийш хөтөл дээр дугуй хүрээтэй 1 тооны хиргисүүр байрлах ба түүний хойгуур орон нутгийн зам дайран өгөрнө. Нийт 3 хиргисүүр байна.
5. N 45°46'04.5" E 108°05'36.7" Alt: 1211. Зараа уулын зүүн урд энгэрт 3 тооны дөрвөлжин булш, 1 тооны Монголын үеийн булш, мөн 1 тооны дугуй хүрээтэй хиргисүүр байна. Нийт 5 дурсгал.
6. N 45°45'57.0" E 108°05'40.6" Alt: 1209. Зараа хайрхны зүүн урд бэлд байх бүлэг дурсгалууд. Энд 1 тооны хиргисүүр, 4 тооны дөрвөлжин булш, байна. Нийт 5 дурсгал.
7. N 45°46'13.9" E 108°05'38.4" Alt: 1212. Зараа уулын зүүн энгэрт байрлах дөрвөлжин булш 1 байна.
8. N 45°45'21.8" E 108°04'44.2" Alt: 1215. Зараа уулын баруун хойд бэлд хүрээ тодорхойгүй 1 тооны хиргисүүр байх бөгөөд хойд талдаа 3 дагуултай, түүний зүүн урд талд 1 тооны дөрвөлжин булш байна. Нийт 2 дурсгал.
9. N 45°46'08.4" E 108°04'45.6" Alt: 1218. Зараа уулын хойд бэлд байрлах дугуй хүрээтэй хиргисүүр, голын чулуун овоолго голдоо тоногдсон. Хиргисүүрээс зүүн хойд талд 1 дөрвөлжин булш, зүүн талд 1 Хүннү булш, зүүн урд талд 1

дөрвөлжин булш байна. Хиргисүүрийн хүрээний гадна тойрсон 14 дагуул, урд талд нь зэрэгцээ байрлах 4 дагуул байрлана. Энд нийт 4 булш оршуулгын дурсгал байна.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Эмээлт хар

**Баг:** Баянхошуу

**Солбицол:** N 45°51'02.6" E 108°08'29.5" Alt: 1184

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хэрэм /Барилга архитектурын дурсгал/

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Эмээлт хар хэмээх газар сумын төвөөс зүүн хойш 16 км орчим зайд, сумын төвөөс Чойр явах замын урд, сумын төвөөс Чойрын чиглэлийн өндөр хүчдэлийн шугамын хойд талд байрлана. Уг дурсгалаас баруун хойш Эмээлт хар уул 3 орчим км зайд байна. Хэрмээс урагш задгай тогтоцтой устай хөндий байна. Хэрэм 4 талтай дөрвөлжин хэлбэртэй. Төл бүр нь гадагш нумарсан цүлхгэр хэлбэртэй. Урд талдаа үүдэвчтэй. Хойд болон урд талын урт нь 104 м, баруун болон зүүн талын урт нь 124 м хэмжээтэй.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Уурхай

**Баг:** Баянхошуу

**Солбицол:** N 45°51'59.1" E 108°15'45.5" Alt: 1253

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун тийш 20 гаруй км зайд байх уурхайн хашааны зүүн талын жижиг ухаагийн энгэрт байх цагариг хэлбэрийн чулуун дараастай 10 м

голчтой Хүннү булш 1 байна. Уурхайн хашааны зүүн хойд булангаас 200 орчим метр зайд байрлах нь уг дурсгалыг өндөр эрсдэлд оруулна.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Их Эрээн

**Баг:** Баянхошуу

**Солбицол:** N 45°51'52.7" E 108°19'28.0" Alt: 1256

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их Эрээн хэмээх орой дээрээ овоот уулын арын бэсрэг ухаа толгодын энгэрт байх бүлэг дурсгал уг энгэрт 5 тооны цагариг хэлбэрийн чулуун дараастай булш байна. Түүнээс баруун урагш жалгын эрэг дээр 3 булш оршино. Нийт 8 дурсгалтай.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Дөшийн ус

**Баг:** Шилийн гол

**Солбицол:** N 45°49'05.1" E 108°13'13.3" Alt: 1223

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун тийш 20км зайд байх Дөш хэмээх газрын Дөшийн усны баруун хойд толгодын дунд дугуй хүрээтэй хиргисүүр байна.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Суурингийн бууц

**Баг:** Энгэр ус

**Солбицол:** N 45°56'01.4" E 108°02'11.9" Alt: 1273

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгаль, аж ахуй, орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Аарагийн хадны зүүн урд хэсэгт байх Суурингийн бууцны бүлэг дурсгал энд нийт 5 хиргисүүр, 2 дөрвөлжин булш, 1 монгол булш байна.

1. N 45°56'01.4" E 108°02'11.9" Alt: 1273. Ааргийн хадны зүүн урд хэсэгт байх Суурингийн бууцнаас баруун хойш 1 км орчим зайд дугуй хүрээтэй 1 хиргисүүр, 2 тооны дөрвөлжин булш, цагариг хэлбэрийн чулуун дараастай булш 1 байна.
2. N 45°55'56.3" E 108°01'47.7" Alt: 1280. Суурингийн бууцны энгэрт байх 3 тооны хиргисүүр, нэг хиргисүүр нь дугуй хүрээтэй, хүрээний гадуур 13 тооны дагуул байгууламжтай, голын овоолго 1,5-1,6м өндөртэй. Нөгөө хиргисүүр мөн дугуй хүрээтэй, хүрээний гадуур 3 тооны дагуултай. 3 дахь хиргисүүр хүрээгүй овгор чулуун дараастай голдоо тоногдсон. Нийт 3 хиргисүүр.
3. N 45°55'53.5" E 108°02'18.3" Alt: 1271. 2-р дурсгалаас зүүн урагш том хадтай толгойн энгэрт 1 тооны дөрвөлжин булш байна.
4. N 45°56'04.6" E 108°01'34.0" Alt: 1296. Суурингийн бууцнаас хойд зүгт 500 орчим метр зайд хадны энгэрт дугуй хүрээтэй хиргисүүр байна. зүүн урдаа нэг дагуултай.

#### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Тахилтын булаг

**Баг:** Шилийн гол

**Солбицол:** N 45°56'10.1" E 107°58'57.9" Alt: 1303

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн зам, Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тахилтын булгийн эхэнд орон нутгийн замын хойд талд хөшөө нь унасан Түрэгийн үеийн тахилын онгон байна. 4 тал хашлаганы 3 тал нь газрын хөрсөн дээр ил харагдана. Хөшөө баруун урагш налж унасан. Дөрвөлжин хашлага чулуу



150см X 210см хэмжээтэй. Хөшөө чулууны өндөр нь 170см, өргөн нь 44 см, зузаан нь 24см.

### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Тахилтын булаг

**Баг:** Шилийн гол

**Солбицол:** N 45°56'30.9" E 107°58'40.6" Alt: 1288

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Суваргын үлдэгдэл /Барилга архитектурын дурсгал/

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тахилтын булгийн урд эрэг дээр байх суваргын үлдэгдэл мөн, хийдийн чулуун туурь байна.

### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Тахилтын булгийн урд хөндий

**Баг:** Шилийн гол

**Солбицол:** N 45°56'03.1" E 107°58'16.9" Alt: 1293

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Хэрэм /Барилга архитектурын дурсгал/

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тахилтын булгийн урд хөндийд дэрст хөндийн захад дөрвөлжин хэлбэрийн чулуун хэрэм байна. Он цаг болон үүрэг зориулалт тодорхойгүй. Хэмжээ нь 10м X 10м хэмжээтэй дөрвөлжин хэрэм.

### **Дурсгал-17**

**Газрын нэр:** Ааргийн хад хормойн бууц

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°55'54.3" E 107°57'05.4" Alt: 1317

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе,

**Төрөл:** Дөрвөлжин булш, Хиргисүүр,

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл, тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ааргийн хадны Хормойн бууц хэмээх газарт хүрэл зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булшны бүлэг дурсгал байна. Энд 20 тооны дөрвөлжин булш мөн 1 тооны хиргисүүр байна. Нийт 21 дурсгал байна.

### **Дурсгал-18**

**Газрын нэр:** Нүгнээчийн ам

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°55'37.1" E 107°55'47.6" Alt: 1343

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн чанартай замд ойр.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ааргийн хадны нэг хэсэг болох Нүгнээчийн ам хэмээх газарт байрлах бүлэг дурсгал Нийт 33 хүннү булш байна.

1. N 45°55'37.1" E 107°55'47.6" Alt: 1343. Нүгнээчийн ам руу явах замын эхэнд замын зүүн талд 7м голчтой хүннү булш байна.
2. N 45°56'00.7" E 107°55'31.0" Alt: 1350. Нүгнээчийн ам хэмээх эргэн тойрон хадат уулсаар хүрээлэгдсэн өргөн том ам байх бөгөөд амны томоохон хөндийн дэвсэг газрыг даган Хүннүгийн үеийн цагариг чулуун дараастай 32 тооны булш бүхий бүлэг дурсгал байна.

### **Дурсгал-19**

**Газрын нэр:** Ааргийн хад

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°56'43.5" E 107°55'36.0" Alt: 1404

**Он цаг:** Тодорхойгүй XVII зуунд хамаарах боломжтой

**Төрөл:** Хэрэмт шивээ /Барилга архитектурын дурсгал/

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ааргийн хадны хамгийн өндөр оргил бүхий уулын орой дээр байрлах харуул хамгаалалтын зориулалтай мэт чулуун шивээ байна. Шивээ 34 орчим нүхтэй, харуул шивээ зүүн, зүүн урд зүгт 50-60 км бараатай. Одоо 4-5 нүх үлдсэн.

### **Дурсгал-20**

**Газрын нэр:** Ааргийн хадны урд ус

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°55'05.1" E 107°55'25.7" Alt: 1348

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Булш оршуулгын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн чанартай замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ааргийн хадны урд жижиг гүвээ байх бөгөөд толгодын дунд дэвсэг дээр байрлах Монголын үеийн цагариг хэлбэрийн чулуун дараастай 3 тооны булш байна. Эдгээр дурсгалын хойд ирмэгээр орон нутгийн чанартай зам өнгөрөх аж.

### **Дурсгал-21**

**Газрын нэр:** Дунд гүн Шанд

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°54'19.5" E 107°54'51.4" Alt: 1355

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилгын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дунд гүн Шандын тахилгын онгон 3 босоо чулуутай босоо чулууны хамгийн урд талын чулуун хөшөөн дээр янгир мэт дүрслэл байх бөгөөд янгирын дүрс бүхий Түрэгийн тамганы дүрслэл байх боломжтой.

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Ээдмэгтийн ус

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°55'02.3" E 107°55'07.5" Alt: 1351

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ээдмэгтийн толгой болон Ээдмэгтийн ус хэмээх газарт байх Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр болон Хүннүгийн үеийн булштай дурсгалт газар.

1. N 45°55'02.3" E 107°55'07.5" Alt: 1351 Ээдмэгтийн усны худгаас баруун хойш замын зүүн талд байх цагариг хэлбэрийн чулуун дараастай хүннү булш.
2. N 45°55'07.3" E 107°54'52.4" Alt: 1330. Ээдмэгтийн усны худгаас баруун хойш дэрст хөндийд байх дугуй хүрээтэй хиргисүүр, тодорхой мэдэгдэж байгаа 10 тооны дагуултай.
3. N 45°55'20.7" E 107°55'47.4" Alt: 1329. Ээдмэгтийн толгойн бууцнаас зүүн тийш байрлах 2 тооны Хүннү булш.

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Ээдмэгийн бор толгой

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°55'28.9" E 107°54'21.2" Alt: 1400

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, XVII-XX зуун

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, хадан дээрх бичиг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ээдмэгтийн бор толгойн булшны ам хэмээх газарт 1 тооны хиргисүүр, 1 дөрвөлжин булш байна. Түүнээс зүүн тийш уулын орой дээр хадны урд налуу дээр маанийн үсэг байна.

#### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Саруулын бичигт хад

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°57'34.7" E 107°57'26.1" Alt: 1314

**Он цаг:** XVIII-XIX зуун

**Төрөл:** Бичгийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ааргийн хадны хойд хэсэгт Саруулын бичигт хад хэмээх том хадан тогтоц байх бөгөөд түүний зүүн хэсгийн хавтгай хажуу дээр Монгол бичгийн дурсгал болон Түвд бичиг маанийн үсгийн дурсгал байна.

#### **Дурсгал-25**

**Газрын нэр:** Ааргийн хад

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°58'34.1" E 107°57'18.7" Alt: 1296

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн чанартай замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Саруулын бичигт хаднаас зүүн хойш айлын бууцны баруун хойд энгэрт замын зүүн талд 15 чулууг босгож цувруулан босгосон зэл чулуут байна.

#### **Дурсгал-26**

**Газрын нэр:** Шар Оорцог

**Солбицол:** N 45°43'57.4" E 108°18'34.6" Alt: 1168

**Он цаг:** Неолит, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Чулуун зэвсгийн дурсгал, Монгол булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн нөлөөл, уурхайн бүс талбайд байна.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шар Оорцог хэмээх газарт уурхайн ашиглалтын талбайн бүс нутагт байх Монголын үеийн дугуй чулуун дараастай жижиг булш 3 тооны байна. Мөн энэ газарт хоёр хэсэг газраас чулуун зэвсгийн түүвэр олдвор илэрсэн.

1. N 45°43'57.4" E 108°18'34.6" Alt: 1168. Жижиг толгойн урд энгэрийн налуу дээр байх дугуй хэлбэрийн чулуун дараастай булш. Голч нь 3,2 м.
2. N 45°44'57.9" E 108°18'38.7" Alt: 1186. Жижиг толгойн урд энгэрийн налуу дээр байх цөөн тооны томхон чулуугаар цагариг хэлбэрийн чулуун дараас үйлдсэн булш. Голч нь 2 м.
3. N 45°54'25.8" E 108°43'28.5" Alt: 1233. Уулын энгэрт байх цагариг хэлбэрийн чулуун дараастай жижиг булш. 1,1 м голчтой.
4. N 45°44'29.4" E 108°18'36.8" Alt: 1203. Жижиг толгойн дэвсгэг дээрээс дөрвөн өөр чулуугаар хийсэн үлдэц, бичил ялтас олдсон.
5. N 45°45'03.6" E 108°19'09.9" Alt: 1180. Неолитын үеийн чулуун зэвсэг түүвэр байдлаар олдсон газар

### **Дурсгал-27**

**Газрын нэр:** Хөөт

**Солбицол:** N 45°41'13.9" E 107°40'37.7" Alt: 1301

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Он цаг тодорхойгүй

**Төрөл:** Хиргисүүр, он цаг тодорхойгүй чулуун байгууламж, булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн нөлөөл, уурхайн бүс талбайд байна

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баянжаргалан сумын төвөөс баруун зүгт 26 км-т байх “МАК” ХХК-ийн Хөөт хэмээх газарт хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр 1, он цаг нь тодорхойгүй газрын хөрсөн дээр ил чулуун дараас бүхий булш 20 тоотой байна. эдгээр нь уулын налуу энгэр болон тэгш дэвсгэг газарт хэд хэдээрээ болон ганц нэгээрээ таруу байдалтай оршино. Нийт 21 тооны дурсгалтай газар.

### **Дурсгал-28**

**Газрын нэр:** Элгэн булаг

**Солбилцол:** N 45°45'35.3" E 108°20'43.6" Alt: 1154

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Түрэгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Хүннү булш, Зэл чулуу, Монгол эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн нөлөөл, уурхайн бүс талбайд байна

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт оршино. Баянжаргалан сумын төвөөс баруун зүгт 25 орчим км-т байрлах Элгэн булаг хэмээх газарт байх хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш 1, Хүннү булш 1, Монголын эзэнт гүрний үеийн булш 1, Зэл чулуун дурсгал гэсэн нийт 4 тооны дурсгал байна.

1. N 45°45'29.4" E 108°20'44.4" Alt: 1155. Хар хадан тогтоц бүхий толгойн баруун хойд энгэрт байрлах хүрэл зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булш. Зүүн хойноос баруун урагш чиглэсэн чулуун хашлагатай. Зүүн хойд хэсгийн хоёр буландаа хөшөө чулуутай. 350м X250м хэмжээтэй.
2. N 45°45'35.3" E 108°20'43.6" Alt: 1154. Дөрвөлжин булштай хадан толгойн хойд хэсгийн бэл хормойд жалгын эхэнд байрлана. Цагариг хэлбэрийн чулуун дараастай, жижгэвтэр чулуудаар чулуун дараас үйлдсэн. Гол хэсэгтээ цөөвөр чулуутай Хүннү булш. Голч нь 6 метр хэмжээтэй.
3. N 45°46'31.8" E 108°22'12.4" Alt: 1164. Мөлхөө цагаан хадан тогтоцтой гүвээний баруун бэлд байрлах цагариг хэлбэрийн чулуун дараастай. Зүүн хойд хэсэгтээ чулуун дараас нт тодорхойгүй. Цөөн тооны том том чулуугаар чулуун дараасыг үйлдсэн Монголын үеийн булш. Голч нь 3,6 метр хэмжээтэй.
4. N 45°45'26.69" E 108°20'50.17" Alt: 1156. Жижиг хар хадан тогтоц бүхий толгойн зүүн урт энгэрээс эхлээд баруун урдаас зүүн хойш чиглэлтэйгээр 62-65м зайд цувруулан тавьсан 3 эгнээ бүхий зэл чулуунууд байна. Хойд талын эгнээ нь хамгийн олон чулууг цувруулан тавьсан. Хойд талын эгнээнд газрын хөрсөн дээр ил харагдах нийт 22 чулууг эгнүүлсэн. Хоёр дахь эгнээ нь хойд талын цувраа чулуунаас урагш 2-2,5м зайд 6 чулууг эгнүүлсэн. Гурав дахь эгнээ нь хоёрдугаар эгнээнээс урагш 40-45 м зайд 3 том чулууг цувруулан тавьсан байна.

### **Дурсгал-29**

**Газрын нэр:** Хар толгой

**Солбицол:** N 45°41'961" E 107°56'157" Alt: 1279

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл: Дөрвөлжин булш,** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн нөлөөл, уурхайн бүс талбайд байна

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баянжаргалан сумын төвөөс баруун урагш 6-8 км орчим км-т байрлах Хар толгой хэмээх газарт байх Монголын үеийн булш оршуулгын дурсгал байна. Нийт 18 булш оршуулгын дурсгал байна.

### **Дурсгал-30**

**Газрын нэр:** Цагаан дэл

**Солбицол:** N 45°46'564" E 107°52'396" Alt: 1292

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл: Дөрвөлжин булш,** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн нөлөөл, уурхайн бүс талбайд байна

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баянжаргалан сумын төвөөс баруун зүгт 8 км орчим км-т байрлах Цагаан дэл уулын хойд талаар баруунаас зүүн тийш сунаж тогтсон дэл хадтай толгодын урд бэл болон ар шилээр Монголын үеийн булш оршуулгын бүлэг дурсгал байна. Нийт 12 булш оршуулгын дурсгал байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутгаас нийт 30 дурсгалт газрын 231 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Чулуун зэвсгийн дурсгал илэрсэн газар – 5.
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 25
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 49.
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зургийн дурсгал – 1.
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал - 51
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 65.
- Хадны бичээсийн дурсгал – 2.
- Барилга архитектурын дурсгал – 5.
- Зэл чулууны дурсгал – 5.
- Түрэгийн үеийн тахилгын онгон – 3.



- Түүхэн үе, он цаг нь тодорхойгүй булш оршуулгын төрлийн дурсгал – 20.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын 30 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 9 дурсгалт газар буюу 30%
- Бага эрсдэлтэй – 7 дурсгалт газар буюу 23.3%
- Дунд эрсдэлтэй – 7 дурсгалт газар буюу 23.3%
- Их эрсдэлтэй – 7 дурсгалт газар буюу 23.4%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 30 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 9 буюу 30 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 8 буюу 26.7%
- Аж ахуйн үйл ажиллагааны нөлөөлөл – 7 23.3%
- Байгалийн нөлөөлөл – 6 буюу 20%

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, орон нутгийн замд ойр байх, аж ахуйн нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутгаас илрүүлэн бүртгэсэн 231 тооны түүх, соёлын дурсгалаас 63 тооны дурсгалыг шинээр илрүүлэн бүтгэсэн. Үүнд:

- Чулуун зэвсгийн үеийн дурсгалт газар – 3
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал – 5
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш – 5
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 23
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 4
- Түрэгийн үеийн зэл чулуун дурсгал – 3
- Түүхэн үе, он цаг нь тодорхойгүй булш оршуулгын төрлийн дурсгал – 20.

## ГОВЬ-УГТААЛ СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Эрүү

**Солбицол:** N 45°50'07.1" E 107°16'55.1" Alt: 1432

**Он цаг:** Хүрэлийн үе, Хүннүгийн үе, Түрэгийн үе, XVII-XIX зуун

**Төрөл:** Бичгийн дурсгал, Дөрвөлжин булш, Тахилын байгууламж, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их газрын чулууны зүүн хойд хэсэгт Эрүү хэмээх нэртэй хадан тогтоцтой жижиг уулын дунд хөтөл дээр дөрвөлжин булш байх ба түүнээс зүүн тийш жалгын ирмэгт зэрэгцээ байрлах дөрвөлжин хэлбэрийн 3 тахилын байгууламж байна. Мөн дөрвөлжин булшнаас дээш 20 метр зайд өндөр хадны урд талын хавтгай дээр нар саран дүрс бүхий монгол бичгийн дурсгал байна. Эдгээр дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

1. N 45°50'07.1" E 107°16'55.1" Alt: 1432. Дөрвөлжин булш 310см X 260см хэмжээтэй.
2. N 45°50'07.8" E 107°16'55.7" Alt: 1436. Бичиг болон тамга тэмдгийн дүрслэл
3. N 45°50'13.7" E 107°17'23.6" Alt: 1395. Эрүү хэмээх хадан тогтцын зүүн талын хөндий рүү чиглэх жалгын хойд эрэгт байрлах дөрвөлжин хэлбэрийн тахилгын байгууламж. 130см X 120см хэмжээтэй.
4. N 45°50'13.9" E 107°17'23.2" Alt: 1394. 3-р дурсгалаас баруун тийш 8-10 орчим метр зайд байх тахилын дөрвөлжин хашлага бүхий байгууламж. Хэмжээ нь 290см X 180см.
5. N 45°50'14.0" E 107°17'23.1" Alt: 1394. 4-р дурсгалтай зэрэгцээ байрлах тахилын байгууламж. Хэмжээ нь 270см X 170 см
6. N 45°50'42.6" E 107°18'03.7" Alt: 1370. Намхан цагариг хэлбэрийн чулуун дараастай 490см голчтой хойд талдаа жижиг босоо чулуутай Хүннү булш.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Баянзүрх-1

**Солбицол:** N 45°47'50.8" E 107°16'02.0" Alt: 1440

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баянзүрх хайрхны зүүн талын хадан цохионуудын дунд хэсэгт жижиг хадан товцгийн баруун хойд талын налуу дээр урдаас хойшоо цуварч байрлах бүлэг дурсгал. Нийт 5 булш байна.

1. N 45°47'50.8" E 107°16'02.0" Alt: 1440. 2,60 м голчтой цагариг хэлбэрийн чулуун дараастай булш.
2. N 45°47'51.4" E 107°16'02.0" Alt: 1437. 3,10м голчтой цагариг хэлбэрийн булш.
3. N 45°47'51.5" E 107°16'02.0" Alt: 1437. 2,80м голчтой цагариг хэлбэрийн булш.
4. N 45°47'51.6" E 107°16'02.0" Alt: 1437. 2м голчтой цагариг хэлбэрийн булш.
5. N 45°47'51.7" E 107°16'02.0" Alt: 1437. 1,60м голчтой цагариг хэлбэрийн булш.

### **Дурсгал-3**

**Газрын нэр:** Баянзүрх хайрхан-2

**Солбицол:** N 45°47'39.2" E 107°15'51.5" Alt: 1427

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн чанартай замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баянзүрх хайрханы баруун талд байх 2 тооны хүннү булш.

6. N 45°47'39.2" E 107°15'51.5" Alt: 1427. Баянзүрх хайрхны баруун талын хадан товцогүүд дунд хадтай толгойн урд энэгрт байрлах цагариг хэлбэрийн чулуун дараастай Хүннү булш. 430см голчтой.
7. N 45°47'05.1" E 107°15'42.7" Alt: 1418. 4,50м голчтой цагираг хэлбэрийн хүннү булш Баянзүрх хайрхны баруун бэлд байрлана.

### **Дурсгал-4**

**Газрын нэр:** ...

**Солбицол:** N 45°49'353" E 107°16'518" Alt: 1391

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замын ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дөрвөлжин хэлбэрийн чулуун хашлагатай. Урд талын хоёр буландаа хөшөө чулуутай тоногдсон байна. 4,70м урттай, 4м өргөнтэй.

### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Ар зүлэгт

**Солбицол:** N 45°52'37.0" E 107°21'28.2" Alt: 1360

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Хүн чулуун хөшөө, дөрвөлжин хашлагатай.

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл. Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их газрын чулууны баруун зах Ар зүлэгт хэмээх газарт Түрэгийн үеийн хүн чулуун хөшөө байна. Түүнийг тойруулан 4 чулуугаар дөрвөлжин хашлага үйлдсэн. Хашлага чулуу 170см X 170см хэмжээтэй. Хөшөө чулууны өндөр 123 см, толгойгүй. Зузаан нь 30см, өргөн нь мөр хэсэгтээ 45см, бэлхүүс хэсэгт 35 см, суурь хэсгээрээ 40см хэмжээтэй. Баруун гартаа хундага барьж цээжиндээ барьсан. Зүүн гараа ташаа орчим сэлмэний бариул дээрээс барьсан. Сэлмэний урт 71см, өргөн 6,5см. Худгийн өндөр 17см, амсар хэсгийн өргөн 10см дунд хэсэгтээ 12см. Хөшөө чулуу нүүрэн талаараа урагшаа 45 хэм хазайсан. Бүсэндээ 12см X 10см хэмжээтэй хэт, хавтага мэт зүйл зүйсэн. Бүс 3см өргөн, тойрог нь 106,5см хэмжээтэй байна.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Ар зүлэгт

**Солбицол:** N 45°52'20.0" E 107°20'48.7" Alt: 1358

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их газрын чулууны баруун зах Ар зүлэгт хэмээх газарт байх зэл чулуун дурсгал. 2 эгнээ зэл чулуу байх бөгөөд хойд талын эгнээ нь нийт 25 чулууг баруунаас тийш чиглэлтэй цувуулсан дундаа 210см урттай, 140см өрөгтэй дөрвөлжин чулуун хашлага бүхий тахилын байгууламжтай. Тахилын байгууламжаас зүүн тийш 14 чулуу, баруун тийш 11 чулууг босгосон. Урд талын эгнээ зэл чулуу нь 7 чулууг цувруулан босгосон. Хоёр эгнээ хоорондоо 20-иод метр зайтай.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Булан

**Солбицол:** N 45°51'10.7" E 107°18'48.2" Alt: 1358

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Хэрэм

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дөрвөлжин хэлбэртэй чулуун хэрмийн үлдэгдэл баруун хойд хэсэгтээ хаалгатай, хэрмийн хойд талд хойд зүг рүү чиглэсэн 7 эгнээ 3км орчим үргэлжлэх зэл чулуу мэт зохион байгуулалттай. Хаалга 1 метр орчим урттай, хэрэм баруунаас зүүн тийш 32м хэмжээтэй, Хойноос урагш 40 метр, газрын хөрснөөс дээш 90см өндөр.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Номгон цохио

**Солбицол:** N 45°50'59.6" E 107°23'11.0" Alt: 1313

**Он цаг:** Хүннүгийн үе, Түрэгийн үе

**Төрөл:** Хүннү булш, зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Номгон цохионы салбар хадан толгодын урд энгэрт байрлах бүлэг булшнууд цагариг хэлбэрийн чулуун дараастай. Бүлэг булшнаас баруун тийш 18м зайд өндөр нь 48см зузаан нь 24 см, өргөн нь дээд хэсэгтээ 10см, доод хэсэгтээ 42см хэмжээтэй хөшөө чулуутай.

1. N 45°50'59.6" E 107°23'11.0" Alt: 1313. 9 метр голчтой цагариг хэлбэртэй булш.

2. N 45°50'59.9" E 107°23'10.6" Alt: 1313. 9 метр голчтой цагариг хэлбэртэй булш.
3. N 45°50'59.7" E 107°23'10.4" Alt: 1314. 9 метр голчтой цагариг хэлбэртэй булш.
4. N 45°51'00.1" E 107°23'10.4" Alt: 1314. 8 метр голчтой цагариг хэлбэртэй булш.
5. N 45°50'00.01" E 107°23'11.6" Alt: 1313. Хөшөө чулуу.
6. N 45°51'00.6" E 107°23'18.1" Alt: 1322. Өргөргийн дагуу 32-33 чулууг 120 метр зайд цувруулан босгосон. Номгон цохионы урд энгэрт байх зэл чулуун дурсгал. Эдгээр хүннү булшны дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Номгон цохио

**Солбицол:** N 45°50'42.7" E 107°22'51.8" Alt: 1310

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Номгон цохионы ойролцоо орших хиргисүүр болон дөрвөлжин булшны цогцолбор дурсгал.

1. N 45°50'42.7" E 107°22'51.8" Alt: 1310. Дугуй хүрээтэй голдоо овгор дугуй чулуун дараастай хиргисүүр хүрээний гадна 16 дагуултай. Голын овгор чулуун даарсны гол нь 15 метр, хүрээний голч 32 метр.
2. N 45°50'42.9" E 107°22'51.3" Alt: 1309. 4 буландаа хөшөө чулуутай, хавтгай чулууг хавиргалан босгож үйлдсэн дөрвөлжин хашлагатай өргөн нь 3,2м хэмжээтэй, урт нь 5м хэмжээтэй дөрвөлжин булш.
3. N 45°50'42.71 E 107°22'51.0" Alt: 1310. 4м X 3м хэмжээтэй дөрвөлжин булш. Эдгээр булш оршуулгын дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Баруун Ганжуурын хийдийн туурь

**Солбицол:** N 45°02'40.5" E 104°52'13.4" Alt: 1316

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баруун ганжуурын хийдийн туурь гол барилгын суурин дээр хожим босгосон суваргатай. Суварга тойрон олон тооны дөрвөлжин болон гэрийн буурь хэлбэрийн чулуун туурь олноор байна. Гол хийдийн туурийн урд талын 2 буланд цонж байрлаж байсан бололтой туурийн үлдэгдэл байна. Гол хийдийн туурь нь 22м X 24м хэмжээтэй байна. 2 цонжийн туурь нь 5м X 5м хэмжээтэй байна.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Шар Даравгай

**Солбицол:** N 45°54'06.9" E 107°37'59.9" Alt: 1310

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шар Даравгай нуураас хойд зүгт 1,5-2 км зайд байрлах өргөргийн дагуу 250м газарт цувруулан босгосон 48-50 чулуу байна.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Сайн Шандын ус

**Солбилцол:** N 45°54'23.4" E 107°38'11.6" Alt: 1320

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Түрэгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Дөрвөлжин булш, Хүннү булш, Түрэг булш,

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сайн шандын ус хэмээх газарт байх хиргисүүр, дөрвөлжин булш бүхий цогцолбор дурсгал. Энд хиргисүүр 2, дөрвөлжин булш 1, Түрэг булш 1, Хүннү булш 2 нийт 6 тооны дурсгал байна.

1. N 45°54'23.4" E 107°38'11.6" Alt: 1320. Дугуй хүрээтэй хиргисүүр. Голын овгор чулуун дараасны голч нь 14 метр, хүрээний голч нь 44 метр. Дугуй хэлбэрийн долоон дагуултай, мөн хиргисүүрийн зүүн талд тэгш өнцөгт хэлбэрийн 1 том дагуултай.

2. N 45°54'23.7" E 107°38'11.4" Alt: 1319. Хиргисүүрийн чулууг ашиглаж хиргисүүрийн хүрээн дотор үйлдсэн Түрэгийн үеийн булш. Голч нь 8 метр.
3. N 45°54'23.7" E 107°38'11.9" Alt: 1318. Цагариг хэлбэрийн чулуун дараастай булш
4. N 45°53'22.8" E 107°38'12.4" Alt: 1317. Дөрвөлжин булш 2,5м X 3м хэмжээтэй дөрвөлжин хашлагатай.
5. N 45°54'24.5" E 107°38'19.6" Alt: 1319. Хиргисүүрээс зүүн урд зүгт 400 гаруй метр зайд байрлах цагариг хэлбэрийн чулуун дараастай Хүннү булш. Голч нь 3,5м хэмжээтэй.
6. N 45°55'05.0" E 107°38'06.1" Alt: 1329. 1-р дурсгалаас зүүн хойд зүгт 1,7-2км орчим зайд байх хүрээгүй хиргисүүр, чулуун дараасны голч 23 метр, өндөр нь 130см, голдоо бага зэрэг хонхойсон.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Шар даравгай

**Солбицол:** N 45°55'15.7" E 107°38'06.3" Alt: 1328

**Он цаг:** Түрэгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Түрэгийн тахилын онгон, булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Түрэгийн үеийн тахилын онгон түүнээс нэлээн зайтай орших Хүннүгийн үеийн булш.

1. N 45°55'15.7" E 107°38'06.3" Alt: 1328. Түрэгийн үеийн тахилын онгон, түүний зүүн урд хөшөө чулуутай. Дөрвөлжин хашлага чулууны хэмжээ 120см X 174см. Хөшөө чулуун баруун хойшоо налж унасан. Өндөр нь 115см, өргөн нь 40см, зузаан нь 18 см.
2. N 45°55'15.7" E 107°38'06.3" Alt: 1328. цагариг хэлбэрийн чулуун дараастай 16м голчтой Хүннү булш.

### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Бага бичигт

**Солбицол:** N 45°56'08.9" E 107°39'12.1" Alt: 1361

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу



**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зэл чулуун дурсгал 2 байна.

1. N 45°56'08.9" E 107°39'12.1" Alt: 1361. Зүүн хойноос баруун урагш зэллэж босгосон 4 тооны бал бал чулуу байна.
2. N 45°56'08.3" E 107°39'17.0" Alt: 1361. Өргөргийн дагуу сунаж байрласан, 220 орчим метр зайд 40 тооны чулууг зэллэж босгожээ.

### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Их бичигт

**Солбицол:** N 45°55'43.4" E 107°42'27.9" Alt: 1404

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Түрэгийн тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** 215см X 210см хэмжээтэй дөрвөлжин тахилын онгон голдоо хөшөө чулуутай. Хөшөө чулуу зүүн хойд тал руугаа налж унасан. Хөшөөний урт 220см, өргөн 47см, зузаан 24 см хэмжээтэй.

### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Их бичигт

**Солбицол:** N 45°54'54.2" E 107°41'40.1" Alt: 1402

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Монгол булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Тоногдсон.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их бичигтийн хадан цохионуудын дунд дэвсэг дээр байрлах дөрвөлжин булшны бүлэг дурсгал болон Их бичигтийн хадан цохионы захад байх монгол булштай газар. Нийт 7 булш байна.

1. N 45°54'54.2" E 107°41'40.1" Alt: 1402. 4,5м X 3м хэмжээтэй.

2. N 45°54'54.7" E 107°41'35.9" Alt: 1402. 4м X 5м хэмжээтэй.
3. N 45°54'52.5" E 107°41'35.7" Alt: 1402. 4,5м X 3,2м хэмжээтэй, дөрвөн буландаа хөшөө чулуутай.
4. N 45°54'52.8" E 107°41'35.8" Alt: 1402. 1,6м X 3м хэмжээтэй.
5. N 45°54'52.9" E 107°41'35.7" Alt: 1402. 1,5м X 2м хэмжээтэй.
6. N 45°56'34.9" E 107°38'37.3" Alt: 1356. Их бичигтийн хадан цохионуудын захад байх зуван дугуй хэлбэрийн чулуун дараастай жижиг монгол булш, 3м X 2м хэмжээтэй.
7. N 45°56'38.0" E 107°38'38.4" Alt: 1359. Жижиг хадан толгойн урд энгэрт байх дугуй хэлбэрийн чулуун дараастай монгол булш.

### **Дурсгал-17**

**Газрын нэр:** Их бичигт

**Солбицол:** N 45°09'21.0" E 104°48'07.8" Alt: 1500

**Он цаг:** XVII-XIX зуун

**Төрөл:** Бичгийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их бичигт хэмээх том хадан цохион баруун болон урд талын хавтгайнууд дээр олон тооны маанийн үсэг болон монгол бичгийн дурсгал байна.

### **Дурсгал-18**

**Газрын нэр:** Их бичигтийн зэл чулуу

**Солбицол:** N 45°54'54.8" E 107°38'31.4" Alt: 1363

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их бичигтийн баруун захад орших жижиг хадан толгодын хойд налуу дээр 50 метр гаруй зайд 18 тооны чулууг зэллэж байрлуулсан. Түүний урд талд мөн 6 чулууг цувруулан байрлуулсан 2 эгнээ зэл чулуун дурсгал аж.

### **Дурсгал-19**

**Газрын нэр:** ...

**Солбицол:** N 45°59'13.9" E 107°37'32.3" Alt: 1377

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Морьт багийн нутагт байх ганц нэгээр орших Монгол булшнуудын дурсгал. 3 тооны Монгол булш.

1. N 45°59'13.9" E 107°37'32.3" Alt: 1377. Жижиг толгойн урд энгэрт байрлах 2 метр голчтой дугуй чулуун дараастай булш.
2. N 45°58'46.8" E 107°37'30.7" Alt: 1361. Дэрст хоолойн хойд захад жижиг толгойн урд бэлд байрлах, том том чулуудаар цагариг хэлбэр үйлдсэн чулуун дараастай булш. Голч нь 4 метр.
3. N 45°58'39.0" E 107°37'32.4" Alt: 1361. Дэрст хоолойн урд захад байрлах 3 метр голчтой, дугуй хэлбэрийн чулуун дараастай булш. Шинээр бүртгэв.

### **Дурсгал-20**

**Газрын нэр:** Шар Хужирт

**Солбицол:** N 46°01'11.1" E 107°40'58.3" Alt: 1343

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шар хужирт хэмээх газрын тал дунд байрлах цагариг хэлбэрийн чулуун дараастай 8 метр голчтой Хүннү булш 1 байна. Шинээр бүртгэв.

### **Дурсгал-21**

**Газрын нэр:** Сарын хонд

**Солбицол:** N 46°01'16.8" E 107°39'41.9" Alt: 1351

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон, тамга тэмдгийн дүрслэл

**Эрсдэлийн хүчин зүйл:** Буруу сэргээн засварлалт

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сарын хонд хэмээх Сар хайрхан уулаас зүүн тийш байх жижиг гүвээд толгодыг хэлнэ. Түүний орой дээр 6 том чулуутай, түүний гурван чулууг нь хожим сэргээн босгосон байдалтай. Бусад 3 чулуу нь газарт унасан байдалтай байна. газарт байх чулуун дээр тамга тэмдгийн 3 дүрслэлтэй.

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Сар хайрхан

**Солбицол:** N 46°00'35.9" E 107°18'21.8" Alt: 1556

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун зүг 15 орчим км-т хадтай уулын баруун бэлд байрлах зэргэлдээ орших 3 тооны дөрвөлжин булштай дурсгалт газар. Эдгээр дурсгалыг шинээр бүртгэв.

1. 2м X 3м хэмжээтэй. N 46°00'35.9" E 107°18'21.8" Alt: 1556
2. 3м X 4м хэмжээтэй. N 46°00'36.0" E 107°18'21.9" Alt: 1557
3. 3м X 2м хэмжээтэй. N 46°00'36.2" E 107°18'21.8" Alt: 1558

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Хэрээ хад

**Солбицол:** N 45°56'22.3" E 107°18'03.4" Alt: 1403

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон, Хүн чулуун хөшөө

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн чанартай замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун тийш 20 гаруй км-т Хэрээ хаднаас зүүн хойд зүгт жижиг дэвсэг дээр дөрвөлжин хашлагатай, дөрвөн буландаа хөшөө чулуутай байсан нь зарим нь унаж, баруун урд болон зүүн урд талын булангийн хөшөө чулуу үлдсэн. Тахилын онгоны баруун талд нүүр дүрслэгдсэн Хүн чулуун хөшөө нь газар унаж толгойн хамрын дунд хэсгээрээ хөндлөн хугарсан. Хүн чулуун хөшөөний өндөр 210см, өргөн 55-60см, зузаан 17см хэмжээтэй. Тахилын байгууламжаас зүүн чиглэсэн 6 тооны зэл чулуутай. Зүүн урд талын хашлага чулууны урд тодорхойгүй тамга тэмдэгтэй.

#### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Их Бичигт-Уурхайн талбай

**Солбицол:** N 45°51'52.4" E 107°41'08.4" Alt: 1403

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Түрэгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, Тахилын байгууламж, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн нөлөө-Уурхайн талбайд байна

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Говь-Угтаал сумын нутагт байх Их бичигт нэртэй уурхайн ашиглалтын талбайн бүсэд хамаарах газраас илэрсэн 8 тооны дурсгал байна.

1. N 45°51'52.4" E 107°41'08.4" Alt: 1363. Монгол булш, голч нь 3 метр, дугуй хэлбэрийн чулуун дараастай. Дэл хадтай тогтцын урд талд байна.
2. N 45°51'52.2" E 107°41'09.6" Alt: 1363. 1-р дурсгалаас зүүн тийш 10 м орчим зайд байрлах дөрвөлжин булш. 380см X 260см хэмжээтэй.
3. N 45°51'51.6" E 107°41'10.7" Alt: 1363. Дэл хадтай толгойн захад жижиг чулуугаар зууван дугуй хэлбэрийн чулуун дараас үйлдсэн, 410см хэмжээтэй, Монгол булш.
4. N 45°51'49.1" E 107°41'09.1" Alt: 1363. Дэл хаднаас урагш 500м зайд боржин чулуун хөшөө бүхий тахилын байгууламж. Хөшөө чулуу хойд таруугаа нурсан. Хөшөөний урт 220 см, өргөн 45 см, зузаан 30 см.
5. N 45°52'14.5" E 107°41'37.3" Alt: 1363. Дугуй хүрээтэй хиргисүүр. Хүрээний голч 22 м, голын чулуун овоолго голч 12 м. Баруун ба хойд талаараа 24 тооны дагуултай.
6. N 45°52'40.5" E 107°41'33.0" Alt: 1363. Том чулуудаар зууван дугуй хэлбэрийн битүү чулуун дараас үйлдсэн Монгол булш, хэмжээ нь 210 см голчтой.
7. N 45°52'38.2" E 107°41'30.4" Alt: 1363. 6-р дурсгалын зүүн талд дугуй хэлбэрийн чулуун дараастай монгол булш. 360 см голчтой.

8. N 45°52'36.8" E 107°40'57.4" Alt: 1363. Дугуй чулуун дараастай монгол булш.  
Хэмжээ нь 650 см голчтой.

### **Дурсгал-25**

**Газрын нэр:** Жоншт толгой-Уурхайн талбай

**Солбицол:** N 45°48'40.7" E 107°40'32.4" Alt: 1351

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн нөлөө-Уурхайн талбайд байна

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Говь-Угтаал сумын нутагт байх Жоншт толгой хэмээх нэртэй уурхайн ашиглалтын талбайн бүсэд хамаарах газраас илэрсэн 6 тооны Монголын үеийн булш байна.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутгаас нийт 25 дурсгалт газрын 72 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 4.
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 14.
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 21.
- Хүннүгийн үеийн булш булш – 10.
- Эртний бичээс, тамга тэмдэг – 3.
- Түрэгийн үеийн тахилын онгон – 8.
- Түрэг булш – 1.
- Түрэгийн үеийн хүн чулуун хөшөө – 2.
- Зэл чулуун дурсгал – 6.
- Барилга архитектурын дурсгал – 2.
- Түүхэн он цаг, төрөл нь тодорхойгүй булш оршуулгын төрлийн дурсгал – 1.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 25 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 12 дурсгалт газар буюу 48%

- Бага эрсдэлтэй – 6 дурсгалт газар буюу 24%
- Дунд эрсдэлтэй – 2 дурсгалт газар буюу 8%
- Их эрсдэлтэй – 5 дурсгалт газар буюу 20%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 23 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 14 буюу 56 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 5 буюу 20%
- Мал шөргөөх – 2 буюу 8%
- Аж ахуйн нөлөө-Уурхайн бүс – 2 буюу 8%
- Буруу сэргээн засварлалт – 1 буюу 4%
- Вандализм– 1 буюу 4% байна.

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, орон нутгийн чанартай замд ойр гэсэн нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутгаас 72 тооны түүх, соёлын дурсгалаас шинээр 29 тооны дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 6
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал – 1
- Хадны бичээсийн дурсгал – 1
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 8
- Түрэгийн үеийн булш – 1
- Түрэгийн үеийн тахилын онгон – 5
- Түрэгийн үеийн зэл чулуу – 1
- Сүм хийд, барилга архитектурын дурсгал – 1
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 6.

## ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Сумын төвийн хойд талын цагаан толгой

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°32'20.4" E 107°01'54.0" Alt: 1180

**Он цаг:** Хүннүгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хүннү булш, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс хойд зүгт 1км орчим зайд байх цагаан өнгийн боржин чулуун тогтоцтой хадтай бэсрэг толгодын баруун хойд бэлд байрлах 5м голчтой цагираг хэлбэрийн чулуун дараастай булш.

- N 45°32'22.5" E 107°02'03.0" Alt: 1179. Уг толгойн зүүн талын үерийн том жалганы зүүн эрэг дээр байрлах дугуй хэлбэрийн битүү чулуун дараастай 2м голчтой Монголын эзэнт гүрний үеийн булш 1 тооны байна.
- N 45°33'04.3" E 107°01'20.9" Alt: 1208. Сумын төвөөс баруун хойд зүгт 2-3км орчим зайд байх 6м голчтой 1 тооны Хүннү булш байна. Энд нийт 2 тооны Хүннү булш, Монголын эзэнт гүрний үеийн булш 1 тооны нийт 3 дурсгал байна. Эдгээрийг шинээр илрүүлэн бүртгэв.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Баруун Нарийны Тал булаг

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°43'28.7" E 106°58'12.8" Alt: 1258

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс хойш 20 км орчим зайд байрлах тахилын онгон 4 босоо хөшөө чулуутай, хашлага чулууны баруун тал нь эвдэгдсэн. Урд болон хойд, зүүн



талын хашлага бүтэн. Зүүн талын хашлага чулууны гадна талд ханан хээтэй. Хашлага чулууны урт 275см, өргөн нь 140см, өндөр нь 35 см байна. 4 хөшөө чулууг хамгийн урд талаас нь дугаарлан бүртгэв. 1-р хөшөө 195см өндөр, 50см өргөн, 20см зузаан. 2-р хөшөө 190см өндөр, 40см өргөн, 30см зузаан. 3-р хөшөө 185см өндөр, 37см өргөн, 30см зузаан. 4-р хөшөө 191см өндөр, 48см өргөн, 25см зузаан.

### **Дурсгал-3**

**Газрын нэр:** Үйзэнхэй жасын туурь

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°42'25.0" E 107°06'13.3" Alt: 1250

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Сүм хийд, барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, орон нутгийн замын ойр, тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зүүн Гэр чулуунаас баруун хойш Үйзэнхэй хэмээх газарт айлын өвөлжөөний хойд талын жижиг толгой дээр байрлах хуучин хийдийн чулуун тууриуд олноор байна. Хожим уг хийдийн үлдэгдэл суврага босгож толгойн өндөрлөг дээр овоо босгожээ.

### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Зүүн Асгат

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°43'19.1" E 107°18'45.5" Alt: 1350

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зүүн Асгатын хамгийн хойд талд байрлах 4 буландаа хөшөө чулуутай дөрвөлжин булш. 5м X 4м хэмжээтэй.

- N 45°43'18.9" E 107°18'45.1" Alt: 1351 6м X 4м хэмжээтэй хашлага чулуу нилээд эвдэгдсэн дөрвөлжин булш байна.
- N 45°43'18.4" E 107°18'44.9" Alt: 1349. 5м X 4м хэмжээтэй дөрвөлжин булш. Нийт 3 тооны дөрвөлжин булш байна.

### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Асгат

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°43'15.2" E 107°18'42.2" Alt: 1348

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** - N 45°43'15.2" E 107°18'42.2" Alt: 1348. Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр. Хүрээний урт 18м, өргөн 13м. Голын овгор чулуун дараасны голч 10м, өндөр 1,1м. Хойд талаараа 5, урд талаараа 6 дагуултай.

- N 45°43'14.0" E 107°18'41.3" Alt: 1345. Зэрэгцээ байрлах 3 тооны дурсгал. Хамгийн баруун талынх нь дөрвөлжин хүрээтэй хиргисүүр. Хүрээ 9м X 10м хэмжээтэй. Голын овгор чулуун дараасны голч 5м хэмжээтэй. Хиргисүүрийн зүүн талд 5м X 4м хэмжээтэй дөрвөлжин булш байна. Түүний зүүн талд цагираг хэлбэрийн чулуун дараастай 6м голчтой Хүннү булш байна.
- N 45°43'13.3" E 107°18'40.1" Alt: 1343. Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр. Эргэн тойрон нийт 16 дагуултай.
- N 45°43'12.6" E 107°18'39.8" Alt: 1380. 8м голчтой цагираг хэлбэрийн чулуун дараастай булш.
- N 45°43'11.3" E 107°18'38.6" Alt: 1343. Дөрвөлжин хүрээтэй, тодорхой мэдэгдэж байгаа 9 тооны дагуултай хиргисүүр.
- N 45°43'09.9" E 107°18'36.9" Alt: 1341. Дөрвөлжин булш, 4 буландаа хөшөө чулуутай. Энд нийт 8 тооны дурсгал байх бөгөөд Хүннү булш 2, дөрвөлжин булш 2, Хиргисүүр 4 байна.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Баруун Асгат

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°43'20.3" E 107°18'23.6" Alt: 1352

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дугуй хүрээтэй хиргисүүр. Хүрээний голч 24м, голын чулуун дараасны голч 10м, өндөр нь 1,2 м хэмжээтэй.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Ханан хад

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°42'17.9" E 107°14'25.6" Alt: 1336

**Он цаг:** Түрэгийн үе, XVII-XX зуун

**Төрөл:** Зэл чулуу, бичиг үсгийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ханангийн хадны урд бэлд 14 чулууг зүүнээс баруун тийш цувруулан тавьсан зэл чулуун дурсгал байна. Мөн Ханангийн хадны урд хавтгай дээр 2 хэсэг газарт маанийн үсэг сийлсэн байна.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Хулгарын хад/Сүмийн хад/

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°42'16.2" E 107°14'43.1" Alt: 1336

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Сүм хийд, барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хулгарын хадны урд энгэрт чулуугаар барьсан сүмийн туурь байна. Чулуун өрлөгийн гадуур шавраар өнгөлгөө хийсэн нь зарим газартаа үлдсэн. Барилга зүүн талдаа хаалгатай, урдаа 2 баруун талдаа 1 цонхтой чулуун хана үлдэж хоцорсон. Оточ навааны сүм хэмээн нэрлэх аж.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Буурал толгой

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°43'20.1" E 107°13'30.9" Alt: 1380

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, эртний улсуудын үе

**Төрөл:** Хадны зураг, тамга тэмдгийн дүрслэл

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Буурал толгой зарим иргэд Буур толгой хэмээх газрын урд талын хавтгай хадан дээр хэд хэдэн янгир болон тамга тэмдгийн дүрслэл байна. Тамга тэмдэг нь Хүннү болон Түрэгийн үед хамаарах боломтой.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Монгол овоо

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°44'01.1" E 107°11'14.2" Alt: 1351

**Он цаг:** Эртний төрт улсуудын үе-Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннүгийн үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хайсангийн амны баруун урд талын амны бүлэг дурсгал нутгийнхан Монгол овоо хэмээнэ. Монгол овооны урд энгэрт цагираг хэлбэрийн чулуун дараастай Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал бүлэгээрээ байрлана. Энэ дурсгалт газарт нийт 34 тооны булштай. Уг дурсгалт газрыг шинээр илрүүлэн бүртгэсэн.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Зүүн Хөх овоо

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°44'47.2" E 107°06'59.7" Alt: 1301

**Он цаг:** Эртний төрт улсуудын үе-Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннүгийн үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:**

- N 45°44'47.2" E 107°06'59.7" Alt: 1301. Зүүн Хөх овооны зүүн хойд дэвсэг дээр байрлах 3,5м голчтой цагираг хэлбэрийн чулуун дараастай 1 тооны булш байна.
- N 45°44'41.8" E 107°06'55.6" Alt: 1306. Зүүн Хөх овооны эрд энгэрт байх бүлэг дурсгал. Нийт тодорхой мэдэгдэж байгаар 44 тооны Хүннүгийн жирийн иргэдийн булш байна. Эдгээр дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Тахилын усны суурин

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°45'15.4" E 107°08'43.7" Alt: 1296

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тахилын ус хэмээх газарт олон тооны барилгын чулуун туурь үлдсэн. Айлын хашаа хороонд ихээр зөөж хэрэглэгдсэн.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Баянхошуу

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°47'06.0" E 107°10'16.8" Alt: 1344

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе,

**Төрөл:** Шоргоолжин булш, дөрвөлжин булш, Хүннү булш, зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн хойш 30-аад км зайд Баянхошууны баруун энгэрт олон тооны үе үеийн булш оршуулгын дурсгал болон, 6 чулууг цувруулан тавьсан зэл чулуун дурсгал байна. Энд тодорхой мэдэгдэж байгаар зэл чулуун дурсгал 1, шоргоолжин булш 2, дөрвөлжин булш 3, Хүннү булш 23 байна.

### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Зүлэгтийн урд ар

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°47'18.0" E 107°12'10.9" Alt: 1382

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе,

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зүлэгт хэмээх гарын урд талын хадан толгойн ар бэлд байрлах 4 буландаа хөшөө чулуутай 4м X 3м хэмжээтэй дөрвөлжин хашлагатай, дөрвөлжин булшны дурсгал 1 байна.

### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Тоорой бандийн агуй

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°46'17.5" E 107°13'14.9" Alt: 1421

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тоорой бандийн агуйн урд аманд байрлах Хүннүгийн үеийн бүлэг дурсгал. Энд нийт 12 тооны булш байна.

### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Хайсан

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°43'57.1" E 107°16'12.3" Alt: 1391

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хайсан хэмээх газарт хадан тогтоцтой толгойн урд хормойд дугуй хүрээтэй хиргисүүр байна. Хүрээн дотроо битүү чулуун дараастай 10м голчтой. Түүний ойролцоо 8м голчтой цагираг хэлбэрийн чулуун дараастай Хүннү булш 1 байна.

### **Дурсгал-17**

**Газрын нэр:** Баруун Дундаан /Хайрханы тахилын онгон/

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°43'51.5" E 107°16'25.6" Alt: 1380

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Чулуут багийн төвөөс баруун урагш Хайрханаас зүүн урд зүгт 1 км орчим зайд Баруун Дундаан хэмээх газарт зэрэгцээ байрлах тахилын онгон байна. 1-р тахилын байгууламж 185см X 185см хэмжээтэй хашлагатай. Хөшөө чулуу хугарч унасан. Босоо хөшөөний өндөр 38см, өргөн 30см, зузаан 28см. Унасан хөшөөний урд 85см, өргөн 25см хэмжээтэй. 2-р тахилын байгууламж 185см X 170см хэмжээтэй хашлага чулуутай. Хөшөө чулуу мөн хугарсан. Босоо хөшөөний өндөр 72см, өргөн 27см, зузаан нь 25см. Газарт унасан хөшөөний урт 64 см, өргөн 23 см хэмжээтэй байна.

### **Дурсгал-18**

**Газрын нэр:** Багийн хад

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°45'08.2" E 107°16'21.5" Alt: 1390

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны сийлмэл зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Багийн хад хэмээх газарт хадны энгэр хавтгай дээр янгир болон адууны дүрслэл бүхий хадны зураг байна. Шинээр бүртгэсэн.

### **Дурсгал-19**

**Газрын нэр:** Булангийн хэрэм

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°51'11.2" E 107°18'47.4" Alt: 1364

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Говь-Угтаал болон Гурвансайхан сумын нутагт орших Их газрын чулуунаас зүүн хойд зүгт хөндийд байрлах чулуун хэрэмийн том суурь үлдсэн байна.



## Дурсгал-20

**Газрын нэр:** Лянх хад

**Баг:** Элгэн

**Солбилцол:** N 45°46'29.0" E 107°14'28.3" Alt: 1435

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Шоргоолжин булш, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Сүсэг бишрэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их газрын чулуун нэг хэсэг Лянх хад хэмээх газрын баруун урд бэлд байрлах бүлэг дурсгал. Энд шоргоолжин булш 3, дөрвөлжин булш 2 нийт 5 тооны дурсгал байна.

- N 45°46'29.0" E 107°14'28.3" Alt: 1435. 3м X 2м хэмжээтэй хавтгай чулуугаар хашлага үйлдсэн шоргоолжин булш. 4 булангийн хашлага чулуу бусдаас өндөр байна.
- N 45°46'28.3" E 107°14'27.9" Alt: 1430. 3м X 3м хэмжээтэй том том хавтгай чулуудар хашлага үйлдсэн дөрвөлжин булш. Түүний зүүн талд 6 м зайд хөшөө чулуутай.
- N 45°46'27.9" E 107°14'28.1" Alt: 1432. 4м X 6м хэмжээтэй шоргоолжин булш
- N 45°46'27.2" E 107°14'23.6" Alt: 1429. Лянх хадны баруун бэлд орон нутгийн замд ойр байрлах 5м өргөнтэй, 17,5м урттай, гол хэсэгтээ 2,6м өргөнтэй шоргоолжин булш.
- N 45°46'27.3" E 107°14'24.4" Alt: 1429. Шоргоолжин булштай зэрэгцээ байрлах 5м X 6м хэмжээтэй дөрвөлжин булш.

## Дурсгал-21

**Газрын нэр:** Холбоо улаан /Холбоогийн хонд/

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°46'33.7" E 107°04'07.7" Alt: 1285

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Холбоо улаан хэмээх толгодын дунд хөтөл дээр байрлах хүрээгүй дугуй хэлбэрийн чулуун дараастай хиргисүүр. Чулуун дараасны голч 6,5м хэмжээтэй. Шинээр бүртгэсэн

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Зүүн Гэр чулуу буюу Өндөр улаан/Талын хар цохио/

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°46'33.7" E 107°04'07.7" Alt: 1285

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Чулуут багийн төвөөс зүүн тийш 5км зайд байх Зүүн Гэр чулуу хэмээх газрын Өндөр улаан хэмээх цохио хадтай газрын зүүн урд хөндийд байрлана. Нутгийнхан мөн Талын хар цохио хэмээн ч нэрлэх аж. 4 буландаа хөшөө чулуутай байсан нь 2 нь унаж, баруун хойд болон зүүн хойд булангийн хөшөө чулуу нь үлдсэн. Дөрвөлжин хашлага 2,5м X 2м хэмжээтэй, хашлага чулууны баруун хойд талын хашлага чулуу гадна талдаа ханан хээтэй. Ханан хээтэй хашлага чулууны урт 120см, өндөр нь газрын хөрснөөс дээш 58см, зузаан нь 9см хэмжээтэй. Баруун хойд булангийн хөшөө чулуу 127см өндөр, 35см өргөн, 17см зузаантай, урд талын хавтгай дээрээ тамга тэмгийн дүрслэлтэй. Дүрслэл байгалийн нөлөөгөөр нилээд бүдгэрсэн. Зүүн хойд талын хөшөө чулууны өндөр 158см, өргөн нь 68см, зузаан нь 34см хэмжээтэй. Зүүн урд булангийн хөшөө унасан хөшөөний урт 270см, баруун урд булангийн унасан хөшөө чулууны урд 242см хэмжээтэй байна.

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Өндөр улааны зэл чулуу

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°46'43.8" E 107°03'34.5" Alt: 1282

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл,

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Өнөдөр Улаан овооноос баруун хойш 1 км орчим зайд хадтай толгойдын дунд 18 тооны чулууг баруунаас зүүн тийш цувруулсан зэл чулуун дурсгал. Шинээр илрүүлэн бүртгэсэн.

#### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Чулуут багийн төв, Хөшөөгийн зэл чулуу

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°47'06.0" E 107°01'07.3" Alt: 1298

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн зам,

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хуучин Чулуут багийн төвийн суурингийн зүүн хойд талд 400-500м орчим зайд байрлана. Тодорхой мэдэгдэж байгаар 54 тооны чулууг баруунаас зүүн тийш 600 гаруй м зайд цувруулан тавьсан зэл чулуун дурсгал. Нилээд хэсэг нь орон нутгийн замын нөлөөгөөр үгүй болсон байдалтай. Шинээр бүртгэсэн.

#### **Дурсгал-25**

**Газрын нэр:** Чулуут цохионы Зүүн Харуулт

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°46'40.7" E 107°01'04.9" Alt: 1307

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хуучин Чулуут багийн төвөөс урд зүгт 1км орчим зайд Чулуут цохионы Зүүн Харуулт хэмээх газарт жижиг хадан цохионуудын дунд байрлах дөрвөлжин булш.

1-р булш 5,5м X 3м хэмжээтэй. 2-р булш 4м X3м хэмжээтэй, N 45°46'39.9" E 107°01'04.6" Alt: 1306.

### **Дурсгал-26**

**Газрын нэр:** Чулуут цохионы Туулайтын зэл чулуу

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°46'00.8" E 107°01'02.0" Alt: 1296

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Чулуутын хадан цохионуудын дунд Туулайт хэмээх газарт байх зэл чулуун дурсгал. Баруунаас зүүн тийш чиглэлтэй 23 тооны чулууг зэллэн босгосон. Зэл чулууны хамгийн баруун чулууны урд 5 чулууг зэрэгцүүлэн босгосон. Түүнээс зүүн тийшх цувраа чулууны харалдаа 4, 3, 2, 1 гэх мэтээр чулууг зэрэгцүүлэн босгосон. Түүнээс цааш нэг эгнээ цувруу чулуунууд байрлах аж.

### **Дурсгал-27**

**Газрын нэр:** Цохион усны тал

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°45'41.0" E 106°56'38.7" Alt: 1300

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цохион усны тал хэмээх газарт баруунаас зүүн тийш чиглэсэн 27 тооны чулууг цувруулан босгосон зэл чулуун дурсгал. Сумын төвөөс хойд зүгт 22-23км орчим зайд байна. Шинээр бүртгэсэн.

## Дурсгал-28

**Газрын нэр:** Их Жасын суурин

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°46'40.7" E 107°01'04.9" Alt: 1307

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хуучин хийдийн олон тооны чулуун туурь болон шавар тууриуд байна. Чулуугаар суурь хийгээд шавар цохиж барьсан барилгын үлдэгдэл хэд хэдэн газар тодорхой хананы үлдэгдэлтэй. Мөн гэрийн чулуун буурь ч олон тоогоор байна. сумын төвөөс баруун хойш 20 гаруй км-т байх Улаан овооны энгэрт одоогоор хананы туйр, довцог үлдэж хоцорсон. гадна талыг шар шавраар өнгөлсөн байна

## Дурсгал-29

**Газрын нэр:** Хаалган хадны баруун урд энгэр

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°46'50.1" E 106°50'22.8" Alt: 1390

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Хиргисүүр, зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хаалган хад хэмээх сумын төвөөс баруун баруун хойш 35 орчим км-т байх хадан тогтоцтой том үргэлжлэх уул нуруудын энгэр бэлээр олон тооны дурсгалууд таруу байдлаар ихээр тааралдана.

- N 45°46'50.1" E 106°50'22.8" Alt: 1390. Хаалган хадны баруун урд энгэрт хадны доод хэсэгт байх зэрэгцээ байрлах 3 тооны дөрвөлжин булш. Хавтгай чулууг босгож хашлага үйлдсэн 4 буландаа хөшөө чулуутай байна.

- N 45°46'50.2" E 106°50'31.8" Alt: 1385. Ёлын бууц хэмээх газарт бууцны баруун урд байрлах тоногдсон хиргисүүр байна. Мөн уг бууцны урд энгэрт том хадан цохионы ёроолд 2 тооны дөрвөлжин булш байна.
- N 45°46'49.1" E 106°50'51.0" Alt: 1384. Дугуй хүрээтэй хиргисүүр.
- N 45°46'54.0" E 106°51'16.5" Alt: 1384. Хаалган хадны урд энгэрт байх дугуй хүрээтэй хиргисүүр. Хиргисүүрийн зүүн талаар зэл чулуун дурсгалтай.

### **Дурсгал-30**

**Газрын нэр:** Их Улаан цохио

**Баг:** Чулуут

**Солбилцол:** N 45°46'45.7" E 106°52'57.1" Alt: 1374

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Түрэгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр, тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс хойд зүгт 32 км-т байх Их Улаан овооны урд энгэрт Дундговь аймгийн төвөөс Чойр хүрэх төв замын хойд талд байрлах тахилын онгон байна. Хашлага чулуу нурж тоногдсон, зөвхөн урд талын хашлага чулуу үлдсэн. Хөшөө чулууунууд бүгд унаж хугарсан байдалтай байна.

Мөн N 45°47'08.7" E 106°53'37.5" Alt: 1385. Их Улааны энгэрт байх өвөлжөөний урд талд байх дугуй хүрээтэй хиргисүүр байна. Хүрээ нь нилээд эвдэгдсэн, тодорхой мэдэгдэх 6 дагуултай. Энэ дурсгалыг шинээр илрүүлсэн. Шинээр илрүүлэн бүртгэсэн.

### **Дурсгал-31**

**Газрын нэр:** Хоншоор

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°28'56.5" E 107°10'47.1" Alt: 1098

**Он цаг:** Хүннүгийн үе, Түрэгийн үе

**Төрөл:** Хүннү булш, зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс урд зүгт 12 орчим км зайд байх Хоншоор хэмээх газарт зэл чулуун дурсгал болон Хүннүгийн үеийн булш 1 тооны байна.

- N 45°28'56.5" E 107°10'47.1" Alt: 1098. Хоншоорын зэл чулуунаас хойш 800 орчим метр зайд цагираг хэлбэрийн чулуун дараастай 4м голчтой Хүннү булш байна. Шинээр илрүүлэн бүртгэсэн.
- N 45°28'43.5" E 107°11'09.1" Alt: 1112. Хоншоор хэмээх газарт баруун хойноос зүүн урд зүгт чиглэсэн 12 тооны чулууг цувруулан босгосон зэл чулуу байна.

### **Дурсгал-32**

**Газрын нэр:** Дундадын хүрэн овоо

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°26'08.3" E 107°14'50.2" Alt: 1186

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, XVII-XX зуун

**Төрөл:** Хадны зураг, бичээсийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дундадын хүрээ овооны баруун урд энгэрт зүүн хойноос байруун урд зүгт газрын хэвгий хэсэгрүү зэллэн тогтсон хадны өмнөд элгэн хавтгай дээр хамгийн дээд хэсэгт маанийн үсэг 4 газарт, монгол бичиг 1 газарт сийлсэн. Мөн хас тамганы сийлбэр, мөн хүрэл зэвсгийн үеийн янгирын дүрслэл нэг байна. Хадны доод хэсэгт 2 янгирын дүрслэлийг зүүн тийш хандуулан дүрсэлжээ.

### **Дурсгал-33**

**Газрын нэр:** Хөшөөн Хонд

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°25'29.3" E 107°15'56.8" Alt: 1122

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хөшөөн хондноос баруун урагш хүрэн овооны зүүн талд 800 орчим м зайд дөрвөлжин хашлага чулуутай голдоо зүүн урд зүр рүү налсан хөшөө чулуутай. Хашлага чулууний хэмжээ 3м X 1,2м, хөшөө чулууны өндөр 190 см, өргөн 50 см, зузаан 30 см.

#### **Дурсгал-34**

**Газрын нэр:** Дугуй шар

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°25'29.3" E 107°15'56.8" Alt: 1122

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр, Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дугуй шараас баруун тийш 1 км орчим зайд байрлах 1 тооны цагираг хэлбэрийн чулуун дараастай 5,5 м голчтой Хүннүгийн үеийн булш байна. Шинээр бүртгэн баримтжуулав.

#### **Дурсгал-35**

**Газрын нэр:** Шандны ус

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°20'32.9" E 107°17'39.2" Alt: 1090

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үед холбогдох булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шандны уснаас баруун хойш 500 орчим метр зайд байрлах 1 тооны дурсгал цагираг хэлбэрийн чулуун дараастай, цөөн тооны чулуугаар чулуун дараас үйлдсэн Монголын эзэнт гүрний үед холбогдох булш оршуулгын дурсгал бололтой байна. Шинээр бүртгэн баримтжуулав.



### **Дурсгал-36**

**Газрын нэр:** Баруун сайхан уул

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°20'17.4" E 107°17'10.9" Alt: 1100

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баруун сайхан уулын зүүн хойд талын хадан тогтоцуудын дунд байрлах Хүннүгийн үеийн цагираг хэлбэрийн чулуун дараастай булш байна. Шинээр бүртгэн баримтжуулав.

- N 45°20'17.4" E 107°17'10.9" Alt: 1100. 8м голчтой булш.
- N 45°20'16.8" E 107°17'09.9" Alt: 1105. 7м голчтой булш.

### **Дурсгал-37**

**Газрын нэр:** Баруун сайхан уулын зүүн урд энгэр

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°18'56.9" E 107°17'23.6" Alt: 1075

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баруун сайхан уулын зүүн урд энгэрт байрлах хоёр эгнээ зэл чулуун дурсгал. Хойд эгнээ 6 чулууг баруунаас зүүн тийш цувруулан тавьсан. Уг 6 чулууны зүүн талын 5 болон 6 дахь чулууны харалдаа урд талд нь дахин нэг нэг чулууг зэрэгцүүлэн байрлуулсан. Урд эгнээнд 26 чулууг цувруулан тавьжээ.

### **Дурсгал-38**

**Газрын нэр:** Баруун сайхан уулын Нарийны амны хөтөл

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°20'45.7" E 107°21'14.4" Alt: 1074

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баруун сайхан уулын Нарийны ам хэмээх газарт хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр болон дөрвөлжин булшны цогцолбор байна. Мөн Хүннүгийн үеийн цагираг хэлбэрийн чулуун дараастай булш байх нь тоногдож сүйтсэн байдалтай байна. Энд 4 хиргисүүр, 5 дөрвөлжин булш, 3 тоногдсон булш нийт 12 дурсгал байна.

- N 45°20'45.7" E 107°21'14.4" Alt: 1074. Дугуй хүрээтэй хиргисүүр гол овгор чулуун дараас нь 8м голчтой. Хүрээний голч 20м хэмжээтэй. Хойд болон баруун хойд талаар нь тодорхой мэдэгдэж байгаа 3 тооны дагуул байна. Түүнээс зүүн хойд талд хадны энгэрт тоногдсон цагираг хэлбэрийн чулуун дараастай булш байна. Тоногдож зохион байгуулалт нь эвдэгдсэн.
- N 45°20'48.4" E 107°21'19.8" Alt: 1083. Дөрвөлжин хүрээтэй битүү овгор чулуун дараастай хиргисүүрийн төрлийн байгууламж. Түүний хойд талд 1 дөрвөлжин булш. Урд талд нь мөн нэг дөрвөлжин булш байна.
- N 45°20'48.8" E 107°21'20.4" Alt: 1077. Дугуй хүрээтэй голдоо овгор чулуун дараастай хиргисүүр. Түүний зүүн талд 3 тооны дөрвөлжин булш байна.
- N 45°20'49.7" E 107°21'23.9" Alt: 1071. Нарийны амны хөтөлийн зүүн бэлд чулуугаар 1,6м голчтой тойрог хүрээ үүсгэсэн. Түүний голд жижиг чулуун дараас үйлдсэн хиргисүүрийн төрлийн дурсгал байна.

### **Дурсгал-39**

**Газрын нэр:** Майхан хайрхан

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°20'48.7" E 107°19'03.9" Alt: 1114

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе.

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Майхант хайрханы зүүн хөтөл дээр байрлах дугуй хүрээтэй хиргисүүр. Түүний урд талд хүрээтэй залгаа хожим хиргисүүрийн чулууг ашиглаж байгуулсан бололтой 2 тооны цагираг хэлбэрийн чулуун дараастай булш байрлана. Мөн хиргисүүрийн зүүн урд талд 1 тооны дөрвөлжин булш байна. Хиргисүүрийн хойд болон баруун талд мөн нэг нэг цагираг хэлбэрийн чулуун дараастай булш байна. Энд 1 хиргисүүр, 1 дөрвөлжин булш, 4 цагираг хэлбэрийн чулуун дараастай булш нийт 6 тооны дурсгал байна. Энэ дурсгалт газрыг шинээр илрүүлэн бүртгэв.

#### **Дурсгал-40**

**Газрын нэр:** Үзүүр цагаан

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°23'21.9" E 107°19'16.0" Alt: 1114

**Он цаг:** Хүннүгийн үе.

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Үзүүр цагаан хэмээх газрын ар талын хадан толгойн урд хормойд байрлах цөөн тооны томхон чулуугар чулуун дараасыг үйлдсэн, 2 тооны цагираг хэлбэрийн чулуун дараастай булш байна. Эдгээр дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

#### **Дурсгал-41**

**Газрын нэр:** Халзан хадны зүүн бөөн хайлаас

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°24'25.5" E 107°21'05.6" Alt: 1111

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе.

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Халзан хадны зүүн талын бөөн хайлаас дунд дөрвөлжин хүрээтэй хиргисүүр байна. Хиргисүүрийн хүрээ эвдэгдэж зөвхөн баруун талын хүрээний чулуун өрлөг мэдэгдэнэ. Энэ хиргисүүр шинээр бүртгэв.

### **Дурсгал-42**

**Газрын нэр:** Халзан хад

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°24'15.3" E 107°20'22.0" Alt: 1113

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе.

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Халзан хадны баруун талын дэвсэг дээр байрлах дөрвөлжин булшны бүлэг дурсгал. Энд нийт 4 тооны дөрвөлжин булш байна. Эдгээр дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-43**

**Газрын нэр:** Номын Дов

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°26'16.7" E 107°18'17.6" Alt: 1133

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Хадны бичээс

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Номын Дов хэмээх маанийн үсэгтэй том хад байна. Шинээр бүртгэсэн.

### **Дурсгал-44**

**Газрын нэр:** Бичигт чулуу

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°26'38.2" E 107°18'48.9" Alt: 1114

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Хадны бичээс

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бичигт хад хэмээх том хадан толгойн зүүн болон зүүн урд талын хавтгай дээр хоёр хэсэг газар 6 газар маанийн үсэг сийлсэн байна. Шинээр бүртгэсэн.

#### **Дурсгал-45**

**Газрын нэр:** Бичигт хадны Зүүн Заараг

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°26'24.5" E 107°18'51.2" Alt: 1141

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бичигт хад хэмээх маанийн үсэгтэй хаднаас урд байрлах том хадан толгойн орой хэсгийн урд талын хавтгай дээр 3 хэсэг газарт янгирын сүрэг дүрслэгдсэн нь бүдгэрч 4 тооны янгир тодорхой харагдана. Шинээр бүртгэсэн.

#### **Дурсгал-46**

**Газрын нэр:** Таван Жас

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°32'18.3" E 107°18'40.1" Alt: 1133

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Сүм хийд барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Тонуулчидын нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урд зүгт 25 км зайд байх Таван Жасын туурь 30 орчим барилгын чулуун туурь болон хөх зөн хэмээх хөх тоосго болон улаан тоосгон барилгын материалууд бүхий тууриуд байна.

## Дурсгал-47

**Газрын нэр:** Ярх уул

**Баг:** Гурвансайхан

**Солбилцол:** N 45°30'16.5" E 107°33'06.2" Alt: 1119

**Он цаг:** Чулуун зэвсгийн үе, Хүннү

**Төрөл:** Сүм хийд барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Тонуулчидын нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ярх уул нь чулуун зэвсгийн арвин дурсгалтай газар багаад хуучин чулуун зэвсгийн дунд үеэс неолитын үеийн чулуун зэвсгийн дурсгалтай. Энд Ярх уулын урд талын толгойн энгэрт байрлах цагираг хэлбэрийн чулуун дараастай Хүннүгийн үеийн 2 тооны булшийг шинээр бүртгэсэн.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутгаас нийт 47 дурсгалт газрын 207 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хуучин чулуун зэвсгийн үеийн дурсгал – 1.
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 17
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 28.
- Хүрэл зэвсгийн үеийн шоргоолжин булшны дурсгал – 5.
- Хадны сийлмэл зураг - 3
- Хадны бичээсийн дурсгал – 4.
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал - 8
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 127.
- Түрэгийн үеийн тахилын онгон – 5.
- Сүм хийд, барилга архитектурын төрлийн дурсгал – 6.
- Зэл чулуун дурсгал – 9.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутгаас нийт 47 газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 26 дурсгалт газар буюу 55.3%
- Бага эрсдэлтэй – 13 дурсгалт газар буюу 27.7%
- Дунд эрсдэлтэй – 4 дурсгалт газар буюу 8.5%
- Их эрсдэлтэй – 4 дурсгалт газар буюу 8.5%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 47 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 34 буюу 72.3 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 4 буюу 8.5%
- Байгалийн нөлөөлөл – 3 буюу 6.4%
- Тоногдсон – 5 буюу 10.6%
- Сүсэг бишрэл– 1 буюу 2.2 %

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, тоногдсон гэсэн нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутгаас 207 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн бөгөөд үүний 105 тооны дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал – 5
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 6
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 86
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 3
- Хадны зураг – 1
- Хадны бичээсийн дурсгал – 2.

## ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Номгон уул

**Солбицол:** N 45°22'53.1" E 104°57'03.2" Alt: 1360

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Номгон уулын баруун хойд ард, элстэй өндөр толгойн хормойд, үерийн жалганы урд эрэгт 4 дугуй хэлбэрийн монгол булш байна. Эдгээр дурсгалын том нь 5м голчтой, жижиг 2м голчтой байна.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Номгон

**Солбицол:** N 45°22'44.0" E 104°57'45.0" Alt: 1393

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннүгийн үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Номгон уулын урд энгэрээр нэлээд хэдэн цагариг хэлбэрийн хүннү булш байна. Бид эдгээрийн баруун захаас дугаарлан тодорхойлолт үйлдэв.

1. 2м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
2. 2,60м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
3. 3,50м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
4. 5м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.



5. 3,70м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
6. 2х3,50м хэмжээтэй битүү чулуун дараастай дөрвөлжин булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
7. 6 дугаартай дурсгалын зүүн талд үерийн усанд сүйдсэн нэгэн дөрвөлжин булш байна.
8. 6 дугаартай дурсгалтай зэргэлдээ 3,50х2,40м хэмжээтэй дөрвөлжин булш
9. 3м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.

### **Дурсгал-3**

**Газрын нэр:** Бага баянгийн хяр

**Солбицол:** N 45°13'55.7" E 104°58'0.01" Alt: 1369

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл, Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Нүхтийн бууцны зүүн урд Бага баянгийн хярын урд энгэрт 1 хиргисүүр 2 хүннү булш байна.

1. 27м голчтой дугуй хүрээтэй 16м голчтой хиргисүүр хиргисүүрийг тойроод 15 тахилын байгууламж байна.
2. Хиргисүүрийн баруун талд 6м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.
3. 10м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.

### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Бага баянгийн хяр

**Солбицол:** N 45°14'08.2" E 104°58'07.7" Alt: 1362

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Нүхэнгийн бууц, нутгийн хүмүүс Хадан булуугийн бууц гэж нэрлээд байдаг бууцны баруун урд Бага баянгийн хяраас урагш унжсан хөтөл дээр зэргэлдээ 4 хиргисүүр байна. Эдгээр дурсгал нь толгой дараалан тоногдсон байна.

1. Уг дөрвөн хиргисүүрийн урд захын хиргисүүр нь 20м голчтой дугуй хүрээтэй 10м голч бүхий тахилын байгууламж бүхий хиргисүүр юм.
2. 1 угаартай дурсгалын хойд тал зэрэгцээ 9м голч бүхий хиргисүүр
3. Зэргэлдээ 9,50м голчтой хиргисүүр.
4. Хамгийн хойд захад орших 10м голч бүхий хиргисүүр.

### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Гooжинхой тээгийн агуй

**Солбицол:** N 45°07'57.0" E 105°11'38.9" Alt: 1444

**Он цаг:** Он цаг тодорхойгүй

**Төрөл:** Агуй

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урагш 34 км-т сумын өвөрмөгц тогтоц бүхий газруудын нэг болох Гooжинхой хяр дотор орших Гooжингийн агуй юм. Гүн ойролцоогоор 13м бөгөөд доод суурын тойрог 15м голчтой.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Зосон тээг

**Солбицол:** N 45°06'33.0" E 105°07'22.6" Alt: 1399

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зосон тээгийн салбар Чавганцын овооны энгэрт 2 монгол булш байна.

1. Хоёр дурсгалын баруун талд нь байрлах 6м голчтой монгол булш.
2. Хоёр дурсгалын зүүн талд байрлах 7м голчтой монгол булш.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Гүн усны бичигт хүрэн хад

**Солбицол:** N 45°05'57.9" E 105°06'40.8" Alt: 1409

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Түрэгийн үе

**Төрөл:** Хадны зураг, тамаг, руни бичээс

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Гүн усны бичигт хүрэн хэмээн нэгэн хүрэн уулын оройгоор янгир, зээр, буга зэрэг амьтайд, төрөл бүрийн тамга дүрсэлсэн байдгаас гадна нэгэн жижиг хадан дээр руни бичээс бичсэн байна. Энэхүү руни бичээс өмнө нь шинжлэх ухааны эргэлтэд орж байгаагүй бичээс юм. Зураг болон бичээс нар, салхинаас шалтгаалан нэлээд бүдгэрсэн байна.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Мэргэний хөтөл

**Солбицол:** N 44°58'47.9" E 105°55'47.6" Alt: 1216

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Мэргэний бууцны зүүн хойно Мэргэний хөтлийн энгэрт 20м голч бүхий дугуй хүрээтэй, 15м голчтой хиргисүүр. Хиргисүүрийн зүүн талд 2м голчтой нэг тахилын байгууламж байхаас гадна бусад талуудаар нийтдээ 5 тахилын байгууламж байна. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Хан хүрээ

**Солбицол:** N 44°59'16.4" E 104°56'53.3" Alt: 1341

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хан хүрээ хэмээх байгалийн өвөрмөгц тогтоц бүхий эргэн тойрон тэгш орой бүхий уулаар хүрээлэгдсэн дугуй хөндий юм. Уг хөндийн нь баруунаас зүүн зах хүртлээ 3 км байх бөгөөд урд талаасаа ордог ганц амтай. Тус хөндийн зүүн зах руу 3 дөрвөлжин булш байна. Баруун талаас нь эхлэн дугаарлан тодорхойлолт үйлдэв.

1. 4х4м хэмжээтэй дөрвөлжин булш.
2. 5х3м хэмжээтэй дөрвөлжин булш.
3. 3х2м хэмжээтэй дөрвөлжин булш.
4. 3 дугаартай дурсгалаас зүүн тийш 200м зайд зэрэгцээ 2 дөрвөлжин булш байгаагийн баруун захын дөрвөлжин булш нь 2х4м хэмжээтэй байна.
5. 4 дугаартай дурсгалын зүүн талд байрлах 4х3м хэмжээтэй дөрвөлжин булш.
6. Хан хүрээ рүү ордог ганц амны чанх хойно нэгэн дурсгал байх бөгөөд тонуулчид зохион байгуулалтыг нь эвдэн мэдэгдэхгүй болсон байна.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Мөнх хашаатын хар овоо

**Солбицол:** N 45°02'40.5" E 104°52'13.4" Alt: 1316

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Мөнх хашаатын хар овооны энгэрт 1 хиргисүүр, 1 дөрвөлжин булш, 1 монгол булш байна.

1. 11м голч бүхий хиргисүүр. Хиргисүүр нь баруун талдаа 2х3м үүдэвчтэй, 2 тахилын байгууламжтай байна.
2. 2,50х3м хэмжээтэй дөрвөлжин булш.
3. 6м голчтой монгол булш.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Хөх-Овоо

**Солбицол:** N 45°13'11.7" E 104°49'59.0" Alt: 1536

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урагш 3 км зайд Хөх-Овооны энгэрт нэгэн хиргисүүр бий. 8м голчтой тус хиргисүүрийг тойроод 10 гаруй тахилын байгууламж байна.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Монхор хүрэн

**Солбицол:** N 45°12'10.9" E 104°51'03.6" Alt: 1609

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэлгэрхангай ууланд Монхор хүрэний энгэрт нэгэн хиргисүүр бий. Уг хиргисүүр нь 20x02м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, 7м голчтой, хойно болон урд талдаа 1,5м хэмжээтэй тахилын байгууламж бүхий хиргисүүр юм.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Халзангийн улаан

**Солбицол:** N 45°12'16.5" E 104°52'27.5" Alt: 1583

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урагш 8 км-т Дэлгэрхангай уулын салбар уулс Халзангийн улаан гэх боржин чулуу бүхий уулийн оройгоор гөлгөр хар чулууд дээр

цоолборлох аргаар янгир, буга, зээр, янз бүрийн тамга, зэвсэглэсэн хуяг дуулга бүхий баатар гэх мэт зургуудыг дүрсэлсэн байна. Хүмүүс хадны зурган дээр давхарлаж зурсан тохиолдол цөөнгүй байна.

#### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Үзүүр овоо

**Солбицол:** N 45°12'17.7" E 104°52'13.1" Alt: 1592

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Халзангийн улаан уулаас зүүн урагш 300м зайд Үзүүр-Овоон дээр мөн адил цоолборлох аргаар янгир, буга, зээр, янз бүрийн тамгуудыг дүрсэлсэн байна. Хүмүүс давхарлаж зурсан тохиолдол их байна.

#### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Хүрэн хад

**Солбицол:** N 45°11'19.2" E 104°57'0.75" Alt: 1383

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зэгстэйн тойрмын баруун урд Хүрэн хадны зүүн хойд ард байрлах 23м голчтой дугуй хүрээтэй 10 голч бүхий хиргисүүр бий. Хиргисүүр нь урд талдаа 1,5м голчтой 6 тахилын байгууламжтай. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.

#### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Хүрэн тээг

**Солбицол:** N 45°11'58.7" E 104°54'58.5" Alt: 1442

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хүрэн тээгийг уруудсан жалганы баруун эрэг дээр 6м голч бүхий монгол булш.

### **Дурсгал-17**

**Газрын нэр:** Алаг бураглангийн ам

**Солбицол:** N 45°09'21.0" E 104°48'07.8" Alt: 1500

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл, тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Алаг бургалангийн амны урд амнаас буусан үерийн эргийн буруу эрэг дээр нь 3 цагариг хэлбэрийн булш, 1 хиргисүүр байна.

1. 8м голчтой дугуй хүрээтэй хиргисүүр. Хиргисүүрийг гол хэсгээр тонуулчид орсон ул мөр үлдсэн байна.
2. 5м голчтой цагариг хэлбэрийн булш.
3. 4м голчтой цагариг хэлбэрийн булш.

### **Дурсгал-18**

**Газрын нэр:** Тамганы-Овоо

**Солбицол:** N 45°09'48.9" E 104°46'53.3" Alt: 1524

**Он цаг:** Он цаг тодорхойгүй

**Төрөл:** Тамга

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тамганы-Овоо гэх тамганы зураг бүхий овоо бий.

### **Дурсгал-19**

**Газрын нэр:** Хулгарын хадны зураг

**Солбицол:** N 45°06'33.0" E 105°07'22.6" Alt: 1399

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хулгарын задгайн баруун урд хулгарын хад хэмээх хадан дээр 2 янгирыг дүрсэлсэн байна.

### **Дурсгал-20**

**Газрын нэр:** Муруй ам

**Солбицол:** N 45°10'23.5" E 104°41'56.2" Alt: 1543

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл, Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Муруйн хүрэн амны урд энгэрт 19 дурсгал байна.

1. Хамгийн урд захад нэгэн хиргисүүр байна. Дараас чулууд нэлээд тарсан байдалтай, 8м голч бүхий хиргисүүр юм. Дугуй хүрээтэй байсан нь үл ялиг мэдэгдэж байна. Дөрвөн буландаа тахилын байгууламжтай.
2. Дөрвөлжин хүрээтэй 11м голчтой, дагуул байгууламж бүхий хиргисүүр юм.
3. 2 дугаартай дурсгалын чанх хойд талд 8м голч бүхий 2 дагуул байгууламжтай хиргисүүр.
4. 3 дугаартай дурсгалын баруун талд 1,20м голч цагариг хэлбэрийн булш.
5. 3 дугаартай дурсгалын чанх хойд талд зэрэгцээ 7 ш дөрвөлжин булш байна. Эдгээр дөрвөлжин булшнууд дунджаар 3,60х2,20м хэмжээтэй байна. Эдгээр дурсгал бүгд тоногдсон тул зохион байгуулалт нэлээд эвдэгдсэн байна.
6. Муруй амны хажуу дээр өндөр эгц хадтай хар уулын урд жижиг дэнж дээр 2м өндөр дараас бүхий эргэн тойрон тахилын байгууламжтай, 17м голчтой хиргисүүр. Хиргисүүр тоногдсон байна.
7. 6 дугаартай дурсгалын зүүн талд зэргэлдээ 7ш дөрвөлжин булш байна.



### **Дурсгал-21**

**Газрын нэр:** Солбийн хүрэн

**Солбицол:** N 45°10'38.5" E 104°41'22.1" Alt: 1546

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Муруй амны зүүн талд Солбийн хүрний энгэрт хүрэл зэвсгийн үед холбогдох 9 дурсгал байна. Дөрвөлжин хүрээтэй 4 хиргисүүр, Дугуй хүрээтэй 3 хиргисүүр, дөрвөлжин булш 1, дугуй хүрээтэй булш 1 байна. Хиргисүүрүүд нь дунджаар 9м голчтой, дөрвөлжин булш нь 3х2,5м хэмжээтэй, дугуй булш нь 5м голчтой байна. Эдгээр дурсгал нь толгой дараалан тоногдсон байна.

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Хар хашаатын ам

**Солбицол:** N 45°12'39.0" E 104°39'98.1" Alt: 1566

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун зүг 22 орчим км-т Хар хашаатын аманд дүрслэл нь ихэд бүдгэрсэн хадны зураг байна. Хадны зурагт хүн, янгир, адуу зэрэг амьтадыг дүрсэлсэн байна. Хүмүүс ойр орчмын чулууг нь ихэд зөөсөн байна.

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Хар хашаат

**Солбицол:** N 45°12'39.0" E 104°39'48.3" Alt: 1566

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун зүг 22 орчим км-т Хар хашаатын аманд хадны зураг бүхий хадны ёроолд 11м голчтой хиргисүүр бий. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.

#### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Нурамтын бууц

**Солбицол:** N 45°12'42.1" E 104°38'24.6" Alt: 1527

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Чулуун хороот уулын энгэрт 1 хиргисүүр, 12 дөрвөлжин булш бий.

1. Хиргисүүр нь эдгээр дурсгалын хамгийн урд захад нь байрлалтай 10 тахилын байгууламж бүхий 8м голчтой хиргисүүр.
2. Хиргисүүрийн хажууд 4х3м хэмжээтэй дөрвөлжин булш байна. Зохион байгуулалт ихэд эвдэгдсэн байна.
3. 2 дугаартай дурсгалаас хойш уулын энгэрт 11 тооны дөрвөлжин булш байна. Эдгээр дөрвөлжин булшнуудын хамгийн том нь 4х5, дунд нь 2х2, жижиг нь 1х1м хэмжээтэй байна.

#### **Дурсгал-25**

**Газрын нэр:** Чулуун хороот

**Солбицол:** N 45°13'23.0" E 104°37'33.5" Alt: 1538

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Чулуун хороот уулын урд нэгэн жижиг толгойн орой дээр 5м голчтой хиргисүүр бий. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.

### **Дурсгал-26**

**Газрын нэр:** Хар хадын бууц

**Солбицол:** N 45°13'33.1" E 104°36'28.3" Alt: 1559

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хар хадын бууцны урд 2 хиргисүүр бий.

1. Дугуй хүрээтэй, 11м голчтой хиргисүүр. Хиргисүүр нь тойроод 30 гаруй тахилын байгууламжтай.
2. 1 дугаартай дурсгалын хойд талд зэрэгцээ 5м голч бүхий хүрээгүй хиргисүүр юм.

### **Дурсгал-27**

**Газрын нэр:** Хүрэн зараа

**Солбицол:** N 45°12'52.5" E 104°35'21.3" Alt: 1511

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хүрэн зараа уулын баруун урд 8 дөрвөлжин булш, 1 хиргисүүр байна.

1. Хиргисүүр нь ойролцоогоор 40м хүрээтэй, зүүн урд талдаа 5м голч бүхий тахилын байгууламжтай, эргэн тойрон нийлээд 16 жижиг тахилын байгууламж бүхий хэмжээний хувьд нэлээд том 11м голч бүхий хиргисүүр бий.
2. Хиргисүүрийн чанх урд талд 3х5м хэмжээтэй дөрвөлжин булш байна. Дөрвөлжин булшны баруун талд тахилын байгууламж гэлтэй хэмжээгээр жижиг 1х1м хэмжээтэй байгууламж байна.
3. Хүрэн зараа уулын урд энгэрт зэрэгцээн 7 дөрвөлжин булш байна. Эдгээр нь дунджаар 1,5х2м хэмжээтэй байна. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.

## Дурсгал-28

**Газрын нэр:**

**Солбицол:** N 45°13'47.0" E 104°35'18.5" Alt: 1625

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хятад бичээс

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутгаас нийт 28 дурсгалт газрын 93 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 30
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 33.
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 4.
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал - 9
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 12.
- Эртний бичээс – . 2
- Агуй-1
- Түүхэн үе, он цаг нь тодорхойгүй булш оршуулгын төрлийн дурсгал – 2.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 28 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 2 дурсгалт газар буюу 7.14%
- Бага эрсдэлтэй – 16 дурсгалт газар буюу 57.14%
- Дунд эрсдэлтэй – 1 дурсгалт газар буюу 3.57%
- Их эрсдэлтэй – 9 дурсгалт газар буюу 32.14%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 28 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 4 буюу 14.28 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 1 буюу 3.57%
- Байгалийн нөлөөлөл – 14 буюу 50%
- Тоногдсон – 6 буюу 21.42%
- Вандализм– 3 буюу 10.71

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, байгалийн хүчин зүйл, тоногдсон гэсэн гурван нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутгаас нийт 28 дурсгалт газрын 93 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн бөгөөд үүнээс 11 дурсгалт газрын 29 тооны дурсгал шинээр илрүүлэв. Үүнд: Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал 4, хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр 18, дөрвөлжин булш 5, Хүннү булш- 8, хадны зургийн дурсгалт газар 1-ийг шинээр илрүүлэн бүртгэсэн.

## Дэлгэрхангай сумын нутагт байх түүх, соёлын дурсгалт газрын зарим зураг



1. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум.  
Номгоны булш.



4. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум.  
Гүн усны бичигт хүрээний хадны зураг.



2. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум.  
Гоожинхой тээгийн агуй.



5. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум.  
Тамагт.




3. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум.  
Гүн усны бичигт хүрээний хадны зураг.



6. Дундговь аймгийн Дэлгэрхангай.  
Шарангадын агуй.





7. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум.  
Шарангадын агуйн бичээс.



9. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум. Хар  
хашаатын ам.



8. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум.  
Хар хашаатын ам.



6. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум.  
Хар чулуутын дөрвөлжин булш.

## ДЭЛГЭРЦОГТ СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Хундагын бууцны булш

**Солбицол:** N 46°10'21.8" E 106°01'14.5" Alt: 1567

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Дөрвөлжин булш, Хөшөө чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 26 орчим км, Бага газрын чулууны Хундагын бууцны зүүн толгойн орчимд цөөнгүй булш, хиргисүүр бий. 2 зэргэлдээ 4ш дөрвөлжин булш, түүнээс хойш уулын аманд 10 хиргисүүр, 5 дөрвөлжин булш, 1 хөшөө чулуу байна. Хөшөө чулуунд 3 нуман зураас татсан байна. Өмнө нь байсан дурсгалууд дээр нэмж бүртгэв.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Баян-Уул

**Солбицол:** N 46°11'08.3" E 106°01'08.3" Alt: 1596

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, шоргоолжин булш, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баян-Уулын баруун аманд хойноос урагш чиглэлтэй 110 гаруй булш хиргисүүр байна. Жижиг уулыг тойруулан зэргэлдээ байдлаар үйлдсэн, олон үед хамаарах булш байна. Хиргисүүр-29, дөрвөлжин булш-37, шоргоолжин булш-13, хүннү булш-31 байх ажээ. Сумын хамгаалалтад авсан.

### Дурсгал-3

**Газрын нэр:** Зүүн өвдөгний бууц

**Солбицол:** N 46°10'57.9" E 106°04'20.6" Alt: 1544



**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, шоргоолжин булш, зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зүүн өвдөгний бууцны хажууд хойд болон урдаа том хашлага чулуутай 7 тооны шоргоолжин булш байна. Түүнээс холгүй гурван эгнээ 27 тооны чулууг баруунаас зүүн зүг хандуулан зэллэн зоосон, зэл чулуун дурсгал байна.

#### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Сөдтэйн хийд

**Солбицол:** N 46°12'26.0" E 106°02'37.0" Alt: 1560

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийд

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бага газрын чулууны дунд Сөдтэйн хоолойд хаалган сүм бололтой дундуур нь ордог 2 талдаа чулуун барилгатай хойд талд суурийг тоосгоор хийж, дотор талыг будсан хийдийн туурь. Эрт цагт барилгын голоор ус урсдаг байсан. Сумын хамгаалалтад авсан.

#### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Сөдтэйн хоолой

**Солбицол:** N 46°12'27.8" E 106°01'29.2" Alt: 1561

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, XVII-XX зуун

**Төрөл:** Дөрвөлжин булш, зэл чулуу, бичгийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сөдтэйн хоолойд нэг дөрвөлжин булш, булшнаас баруун тийш 2 эгнээ чулууг зүүнээс баруун тийш хандуулан 41ш чулууг зэллэн зоожээ. Сумын

хамгаалалтад байдаг. Сөдтэйн хоолойн эхэнд зүүн талын хаданд маанийн 6 үсэг, дээд талд нь үл мэдэх дүрс сийлсэн байна.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Сономын хонд

**Солбицол:** N 46°13'03.0" E 106°06'34.0" Alt: 1561

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Хүннү булш, хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 23 орчим км-т, Бага газрын чулууны зүүн урд хэсэг, Сономын хондны хойд талд хэдэн дөрвөлжин булш бий. Мөн ойр хавийн хаданд буга, янгир зэрэг байна. Дөрвөлжин булш 6, хүннү булш 4ш байна. Сономын хондны хойд талын өнцгөөр хаданд бугын дүрс сийлсэн байна. Сумын хамгаалалтад авсан.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Дагийн хад

**Солбицол:** N 46°12'42.7" E 106°05'35.7" Alt: 1565

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дагийн хаданд янгир, тамга тэмдгийн дүрсийг сийлсэн байна.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Гэр хад

**Солбицол:** N 45°44'53.4" E 107°04'24.3" Alt: 1560

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Хадны сийлмэл болон зосон зураг, тамга тэмдгийн дүрслэл

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 20 орчим км, Бага газрын чулууны зүүн захад орших Гэр чулууны зүүн талд дугуй хүрээтэй 2 тооны хиргисүүр оршино. Мөн энд хүрлийн үеийн сийлмэл болон зосон зургийн дурсгал байдаг. Гэр чулууны урд талын хаданд тамга, тэмдэг дүрс байна.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Хөшөөтийн ам.

**Солбицол:** N 46°19'54.0" E 106°03'11.0" Alt: 1545

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 30 орчим км-т, Бага газрын чулууны Хөшөөтийн аманд голдоо хөшөө чулуутай тахилын онгон бий. 1,4м өндөр 40см өргөн, 30см зузаантай аж. Уг онгон саяхан ухагдсан байна. Сумын хамгаалалтад авсан.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Дунд шанд

**Солбицол:** N 46°14'30.0" E 106°02'37.0" Alt: 1530

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 29 орчим км-т, Бага газрын чулууны хойд хэсэг, Дунд шандын аманд олон хүннү булш бий. Нийт бүртгэснээр 68 хүннү булш цогцолбороороо байх ба элс ихтэй тул зарим булшнууд мэдэгдэхгүй болсон байх талтай. Дундаж нь 5,6м хэмжээтэй аж. Сумын хамгаалалтад авсан.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Дэлгэрийн Чойрын хийд

**Солбицол:** N 46°08'40.0" E 106°09'07.0" Alt: 1570

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийд

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун тийш 17 орчим км-т, Дэлгэр уулын энгэрт Дэлгэрийн Чойрын хийдийн туурь, үлдэгдэл бий. Уг хийдийн нурсан сүм, дуганыг 2005 оноос эхлэн засварлаж хурал номын үйл ажиллагааг нь сэргээжээ. Дэлгэрийн чойрын хийд дахин сэргэж, одоо ном хурдаг 1 дуган, шинээр том хийд барьж байгаа. Хуучин 10 орчим хийдийн туур үлдэж хоцорсон. Ихэнх барилга хөх зөн, шатаагүй тоосго, шар шавраар барьсан байна. Сумын хамгаалалтад авсан.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Хүрэн хондны булш

**Солбицол:** N 46°11'31.0" E 106°03'51.0" Alt: 1563

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 26 орчим км, Бага газрын чулууны Хүрэн хондны орчимд 60 гаруй хүннү булш бий. Сумын хамгаалалтад авсан.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Хавчгийн амны булш

**Солбицол:** N 46°14'03.0" E 106°02'13.0" Alt: 1561

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн хойш 30 орчим км-т Бага газрын чулууны ууланд дөрвөлжин булш байна. Хавчгийн гэх аманд 14 дөрвөлжин булш бий. 4 булш нь хөшөө чулуутай, хөшөө чулуу нь дөрвөлжин хүрээтэй. Сумын хамгаалалтад авсан.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутгаас нийт 13 дурсгалт газрын 339 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 92
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал –67
- Хүрэл зэвсгийн үеийн шоргоолжин булш - 20
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 3
- Бичгийн дурсгал – 1
- Зосон зургийн дурсгал – 1
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал - 6
- Хүннү булш – 163
- Хөшөө чулуу – 1
- Зэл чулуу – 2
- Барилга архитектур сүм хийдийн дурсгал – 2
- Түрэгийн үеийн тахилын онгон - 1

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын 13 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 2 дурсгалт газар буюу 15,4%
- Бага эрсдэлтэй – 1 дурсгалт газар буюу 7,7%
- Дунд эрсдэлтэй – 10 дурсгалт газар буюу 76,9%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 13 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 5 буюу 38.4 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 7 буюу 53,8%

- Мал шөргөөх – 1 буюу 7,7%

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, орон нутгийн замтай ойр гэсэн хоёр нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутгаас бүртгэсэн 339 тооны түүх, соёлын дурсгалаас шинээр илрүүлэн бүртгэсэн 20 тооны дурсгал байн. Үүнд:

- Хөшөө чулуун дурсгал – 1
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал – 10
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 9.

**Дэлгэрцогт сумын нутагт байх түүх, соёлын дурсгалт газрын зарим зураг**



1. Хундагын бууцны булш



4. Сөдөтийн хийдийн туурь



2. Баян-Уулын булш



5. Сөдөтийн хоолойн зэл чулуу



3. Зүүн өвдгийн бууцны булш



6. Сономын хондны хадны зураг





7. Дагийн хадны зураг



8. Гэр хадны зосон зураг



9. Хөшөөтийн амны тахилын онгон



10. Дунд шандны хүннү булшны цогцолбор



11. Дэлгэрийн Чойрын хийд



## **ДЭРЭН СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД**

### **Дурсгал-1**

**Газрын нэр:** Бумбат хайрхан-Тэгшийн жас

**Солбицол:** N 46°10'51.7" E 106°58'14.5" Alt: 1286

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урагш 21 орчим км зайд Бумбат хайрхны баруун урд хөндийд байрлах Тэгшийн жасын туурь нь Бумбат багийн төвийн зэргэлдээ байрлана. Хийдийн тууриуд нь чулуун болон хөх саарал тоосгоор үйлдсэн. Тууриудын дунд хожим сэргээн босгосон суваргатай.

### **Дурсгал-2**

**Газрын нэр:** Өвөр Хүрэн дэл

**Солбицол:** N 46°10'46.6" E 107°03'26.3" Alt: 1337

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Өвөр хүрэн дэлийн урд талын жижиг товцог толгойн урд энгэрт байрлах дугуй хэлбэрийн чулуун дараастай 6,5 м голчтой, Хүннү булш. Шинээр бүртгэв.

### **Дурсгал-3**

**Газрын нэр:** Хар дэл

**Солбицол:** N 46°10'15.9" E 107°04'51.2" Alt: 1368

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хар дэлийн хамгийн баруун талын хадтай толгойн урд энгэрт байх баруун тийш чиглэлтэй 17 чулууг босгож 100 гаруй метр зайд цувруулсан. Шинээр илрүүлэн бүртгэв.

#### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Хүрэн дэл

**Солбицол:** N 46°10'26.4" E 107°04'50.4" Alt: 1362

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн чанартай замд ойр, элсэнд тарагдсан.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хүрэн дэл дэлээс Бумбат баргиад руу явах замд жижиг элсэн толгодын зүүн дэвсэг дээр байрлах бүлэг Хүннү булш. Нийт 8 булштай.

#### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Бага тал

**Солбицол:** N 46°08'50.5" E 107°08'49.7" Alt: 1390

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бага талаас урагшаа 5-6 км орчим зайд жижиг толгодын урд энгэрт байрлах цагариг хэлбэрийн чулуун дараастай 7 м голчтой Хүннү булш 1 байна.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Говийн бууц

**Солбицол:** N 46°14'22.0" E 107°10'34.7" Alt: 1352

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бага талаас хойш байрлах Говийн бууц хэмээх газарт жижиг толгойн урд энгэрт байрлах бүлэг Хүннү булштай дурсгалт газар. Нийт 11 булштай. Шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Хүрэн дэлийн зүүн толгод

**Солбицол:** N 46°11'21.1" E 106°59'43.1" Alt: 1300

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хүрэл дэлийн зүүн талын хадан тогтоцтой жижиг толгодын зүүн талын дэвсэг дээр байрлах бүлэг цөөн тооны Хүннү булштай дурсгалт газар. Нийт 4 булштай. Шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Салаатын хар

**Солбицол:** N 46°09'38.1" E 106°55'57.4" Alt: 1291

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Салаат хар хэмээх жижиг уулын урд хэсэгт байрлах 1 монгол булш, Салаат харын зүүн урд довцог дээр 1 тооны хиргисүүр байна байна.

1. N 46°09'38.1" E 106°55'57.4" Alt: 1291. Жижиг чулуун дараастай 3 м голчтой монголын эзэнт гүрний үеийн булш 1. Энэ дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.
2. N 46°09'37.1" E 106°55'27.8" Alt: 1328. Хүрээгүй хиргисүүр чулуун овоолго 15,5м голчтой.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Хөх Ишиг хайрхан

**Солбицол:** N 46°10'55.2" E 106°48'16.0" Alt: 1276

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс урагш Хөх Ишиг хэмээх тэр хавьдаа онцгой харагдах уулын энгэр бэлээр байрлах Монголын үеийн бүлэг булш болон хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр, дөрвөлжин булштай дурсгалт газар. 5 тооны дөрвөлжин булш, 1 тооны хиргисүүр, 24 монгол булштай. Нийт 29 дурсгалтай.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Бурхант хайрхан

**Солбицол:** N 46°10'09.9" E 106°40'58.3" Alt: 1276

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун урагш 5 км гаруй зайд Бурхант уулын урд энгэрийн овоотой толгойн хойд талд байрлах Хиргисүүр, дөрвөлжин булштай

цогцолбор дурсгал. Хиргисүүр нь дугуй хүрээтэй, хүрээ болон голын овоолгын чулууг ашиглан дөрвөлжин булшнуудыг үйлдсэн байх боломжтой. Тодорхой мэдэгдэж байгаа 4 дагуултай. Хиргисүүрийн чулуун овоолго 12 м голчтой. Хиргисүүрийн баруун урд талаар 9 тооны дөрвөлжин булшнууд байрлана. Нийт 10 дурсгалтай.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Бурхант хайрхан зүүн бэлийн Хиргисүүр

**Солбицол:** N 46°10'27.5" E 106°41'33.5" Alt: 1379

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бурхант хайрхны зүүн бэл, амуудыг даган орших хиргисүүр дурсгалт газар.

1. N 46°10'27.5" E 106°41'33.5" Alt: 1379. Дугуй хүрээтэй хиргисүүр голын овоолго голч 16 м, хүрээний голч 40 м. Дагуул байгууламж 49.
2. N 46°10'32.2" E 106°41'36.3" Alt: 1376. Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр. Хүрээ 21м X 20м хэмжээтэй, голын чулуун овоолго голч нь 12 м. 19 дагуултай.
3. N 46°10'50.1" E 106°41'27.2" Alt: 1387. Дөрвөлжин хүрээтэй битүү чулуун дараастай хиргисүүр нийлээд эвдэгдсэн. 7,5 м X 8 м хэмжээтэй.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Бурхант хайрхны Цагаан эргийн бууц

**Солбицол:** N 46°10'48.3" E 106°41'39.2" Alt: 1376

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр, Байгалийн нөлөө.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бурхант хайрхны зүүн суга Цагаан эргийн бууцны дурсгалт газар Хиргисүүр болон монгол булш байна. 5 тооны хиргисүүр, 1 Монгол булш байна.

1. N 46°10'48.3" E 106°41'39.2" Alt: 1376. Цагаан эргийн бууцны баруун урд дэвсэг дээр байрлах дөрвөлжин хүрээтэй хиргисүүр. Хүрээ 17м X 17м, голын чулуун овоолго 13 м голчтой. 22 тооны дагуул байгууламжтай.
2. N 46°10'37.6" E 106°41'41.5" Alt: 1375. Хүрээгүй хиргисүүр 11 м голчтой.
3. N 46°10'46.3" E 106°41'45.2" Alt: 1372. Дугуй хүрээтэй хиргисүүр, голын чулуун овоолго голч нь 11 м, хүрээний голч 17 м хэмжээтэй.
4. N 46°10'58.5" E 106°41'47.4" Alt: 1376. Цагаан эргийн бууцны амны жалгын дээд ирмэг дээр байрлах дугуй хэлбэрийн чулуун дараастай Монгол булш.
5. N 46°10'55.9" E 106°42'08.1" Alt: 1357. Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр. Хүрээ 7м X 8м хэмжээтэй. Голын овоолго 6,5м голчтой.
6. N 46°10'58.3" E 106°42'13.5" Alt: 1350. Дугуй хүрээтэй хиргисүүр. Хүрээний голч 18 м, чулуун овоолго 10 м голчтой. 2 тооны дагуултай.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Бурхант хайрхны зүүн толгод

**Солбицол:** N 46°10'59.1" E 106°42'11.7" Alt: 1354

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Шоргоолжин булш, Дөрөө хэлбэрийн булш,

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн нөлөө.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бурхант хайрхны зүүн талын толгодын дунд сумын төвөөс баруун урагш 4 км орчим зайд байрлах шоргоолжин булш болон дөрөө хэлбэрийн булшны дурсгал. Эдгээр дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

1. N 46°10'59.1" E 106°42'11.7" Alt: 1354. Шоргоолжин булш, баруунаас зүүн тийш 9 м хэмжээтэй, зүүн талын өргөн 6 м, баруун талын өргөн 4 м хэмжээтэй. Гол хэсэгтээ 2,2 м хэмжээтэй, том том хавтан чулуугаар хашлага үйлдсэн.
2. N 46°10'59.5" E 106°42'11.8" Alt: 1355. 1-р дурсгалын зэргэлдээ байрлах дөрөө хэлбэрийн булш. Голч нь 3,2 м.

### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Бурхант хайрхны зүүн хойд ам

**Солбицол:** N 46°11'01.3" E 106°42'19.8" Alt: 1347

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, Дөрвөлжин булш, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Суурьшилын бүсэд ойр.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бурхант хайрхны зүүн хойд амнуудыг даган олон хиргисүүрүүд, дөрвөлжин булш. Цөөн тооны Монголын үеийн булш илэрнэ. 2 тооны дөрвөлжин булш, 1 тооны монгол булш, 11 тооны хиргисүүрийн дурсгалтай. Нийт 14 дурсгалтай. Хиргисүүрүүд олон тооны дагуултай цогцолбор байдлаар оршино. Эдгээр дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Дагданпунцоглин хийд

**Солбицол:** N 46°12'59.5" E 106°42'01.6" Alt: 1314

**Он цаг:** XIX-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сум хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Сүсэг бишрэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвийн хойно байрлах шинээр сэргээн босгосон одоо үйл ажиллагаа явуулдаг хийд. Тойруулаад 108 суврагатай. Гол дуганы хоёр талд суваргатай. Түүнээс баруун хойно Ногоон дахь эх бурхантай цогцолбор байна. Х.Базар хэмээх нутгийн нэртэй Ловон хүний дурсгалд зориулан босгосон сүсэг бишрэлийн цогцолбор.

### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Дугантын бууц

**Солбицол:** N 46°12'52.7" E 106°41'54.2" Alt: 1323

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуй, айлын өвөлжөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дугантын бууцны урд энгэрт байх дөрвөлжин булш болон хиргисүүрийн дурсгал байна. Нийт 3 тооны дурсгал байна.

1. N 46°12'52.7" E 106°41'54.2" Alt: 1323. Дөрвөлжин булш, 3м X 3м хэмжээтэй.
2. N 46°12'52.9" E 106°41'53.8" Alt: 1324 3м X 4м хэмжээтэй. Зүүн хойд талдаа хөшөө чулуутай, дөрвөлжин булш.
3. N 46°12'54.1" E 106°41'51.9" Alt: 1329. Дөрвөлжин хүрээтэй голдоо битүү овгор чулуун дараастай хиргисүүрийн төрлийн байгууламж, 7м X 6м хэмжээтэй.

### **Дурсгал-17**

**Газрын нэр:** Дугантын бууцны хойд толгод

**Солбицол:** N 46°12'38.2" E 106°41'47.3" Alt: 1351

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш,

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуй, айлын өвөлжөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дугантын бууцны хойд талын толгод гүвээний дунд байх дөрвөлжин булшны дурсгалт газар. Нийт 4 тооны дөрвөлжин булш байна.

### **Дурсгал-18**

**Газрын нэр:** Сумын төв

**Солбицол:** N 46°12'16.3" E 106°41'26.0" Alt: 1348

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Суурьшлын бүс

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвийн баруун хаянд айлын өвөлжөөний урд талд залгаа байх хиргисүүрийн дурсгалт газар, сумын төвд ойрхон, айлын өвөлжөө байшинд ойр, малын хөл болон автозамын нөлөөнд нэлээд эвдэгдсэн их эрсдэлтэй газар аж. Энд 3 тооны хиргисүүрийн дурсгал, 1 тооны дөрвөлжин булш байна.

1. N 46°12'16.3" E 106°41'26.0" Alt: 1348. Дөрвөлжин хүрээтэй хиргисүүр, хүрээ 28м X 22м хэмжээтэй. Голын чулуун овоолго 10м голчтой. Хүрээний дөрвөн буланд тахилын байгууламжтай. Тодорхой мэдэгдэж байгаар 16 дагуултай.



2. N 46°12'17.4" E 106°41'23.5" Alt: 1351. Дөрвөлжин хүрээтэй, хүрээ эвдэгдэж хэмжээг тодорхойлох боломжгүй болсон. Голын чулуун овоолго 10 м голчтой. Тодорхой мэдэгдэж байгаа 8 дагуултай.
3. N 46°12'43.2" E 106°41'54.0" Alt: 1321. 4м X 3м хэмжээтэй дөрвөлжин булш.
4. N 46°12'43.6" E 106°41'51.1" Alt: 1323. 3-р дурсгалын баруун талд дөрвөлжин хүрээтэй хиргисүүр нилээд эвдэгдэж зохион байгуулалт алдагдсан. Хүрээний тодорхой мэдэгдэж байгаа хэмжээ нь 15м X 11м хэмжээтэй. Голын чулуун дараас 6 м хэмжээтэй. Хүрээний урд талаар тодорхой мэдэгдэж байгаа 4 тооны дагуултай.

### **Дурсгал-19**

**Газрын нэр:** Дугантын бууцны бичээс

**Солбицол:** N 46°13'03.7" E 106°41'46.1" Alt: 1342

**Он цаг:** XVI-XIX зуун

**Төрөл:** Бичгийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Сүсэг бишрэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дугантын бууцны хойд талын хадан дээр 2 хэсэг газар маанийн 6 үсэг сийлсэн байна.

### **Дурсгал-20**

**Газрын нэр:** Цант хайрхны урд талын хадат толгой

**Солбицол:** N 46°13'07.8" E 106°41'52.6" Alt: 1331

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн, мал амьтны нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цант хайрханы урд талын хадат толгодын дунд орших дөрвөлжин булштай дурсгалт газар. 2 тооны дөрвөлжин булш байна.

1. N 46°13'07.8" E 106°41'52.6" Alt: 1331. 5м X 4м хэмжээтэй дөрвөлжин булш.
2. N 46°13'09.8" E 106°41'52.9" Alt: 1331. 4м X 3м хэмжээтэй дөрвөлжин булш.

### **Дурсгал-21**

**Газрын нэр:** Нүүрэгт хайрхан

**Солбицол:** N 46°13'08.9" E 106°42'07.3" Alt: 1318

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвийн хойд талын Нүүрэгт хайрхан хэмээх газарт зэрэгцээ байрлах 2 тооны хиргисүүр байна. Хүрээний 4 буланд тахилын байгууламжтай, хүрээ нилээд эвдэгдсэн. Хиргисүүрийн эргэн тойронд тодорхой мэдэгдэж байгаагаар нийт 8 дагуултай. Том Хиргисүүрийн хүрээ 17м X 11м, голын овоолго 11м голчтой. 2 дахь хиргисүүрийн хүрээ 14м X 14м, голын чулуун дараасны голч 10м хэмжээтэй байна.

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Нүүрэгт хайрхны баруун бэл

**Солбицол:** N 46°13'09.1" E 106°42'05.7" Alt: 1317

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Нүүрэгт хайрхан баруун бэл, энгэрт байх цагариг хэлбэрийн чулуун дараастай цөөн тооны Хүннү булштай дурсгалт газар. нийт 3 дурсгалтай.

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Цант хайрхан

**Солбицол:** N 46°13'25.5" E 106°41'59.9" Alt: 1322

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, шоргоолжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цант хайрхны урд хормойд байх Хиргисүүрийн төрлийн булш болон шоргоолжин булштай дурсгалт газар. Нийт 3 дурсгалтай.

1. N 46°13'25.5" E 106°41'59.9" Alt: 1322. Зууван дугуй хэлбэрийн овгор чулуун дараастай хиргисүүрийн төрлийн дурсгал 7м X 4м хэмжээтэй.
2. N 46°13'27.4" E 106°41'58.6" Alt: 1322. Зууван дугуй хэлбэрийн овгор чулуун дараастай хиргисүүрийн төрлийн дурсгал 9м X 6м хэмжээтэй.
3. N 46°13'31.7" E 106°42'04.4" Alt: 1320. Шоргоолжин булш. 9м X 6,5м хэмжээтэй.

#### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Нүүрэгт Хайрхан урд энгэрийн Хүннү булш

**Солбицол:** N 46°13'04.8" E 106°42'04.7" Alt: 1306

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуй, Суурьшлын бүсэд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цант хайрхны урд талын Нүүрэгт хайрхан энгэрт орших цөөн тооны Хүннү булштай дурсгалт газар. 3 тооны Хүннү булш байна.

1. N 46°13'04.8" E 106°42'04.7" Alt: 1306. 4,5м голчтой цагариг хэлбэрийн чулуун дараастай хамгийн баруун талын булш.
2. N 46°13'05.4" E 106°42'04.5" Alt: 1305. 7м голчтой цагариг хэлбэрийн чулуун дараастай булш.
3. N 46°13'06.5" E 106°42'04.6" Alt: 1306. 6м голчтой цагариг хэлбэрийн чулуун дараастай булш.

#### **Дурсгал-25**

**Газрын нэр:** Цант хайрхны зүүн ам

**Солбицол:** N 46°12'19.0" E 106°40'38.2" Alt: 1361

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Шоргоолжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цант хайрхнаас хойш үргэлжлэн тогтсон уулын зүүн аманд байх дөрвөлжин булш, шоргоолжин булштай дурсгалт газар. Энд 3 тооны дөрвөлжин булш, 1 тооны шоргоолжин булш байна.

1. N 46°12'19.0" E 106°40'38.2" Alt: 1361. 4м X 3м хэмжээтэй дөрвөлжин булш.
2. N 46°12'19.2" E 106°40'38.7" Alt: 1366. 3,1м X 2,2м хэмжээтэй дөрвөлжин булш.
3. N 46°12'19.6" E 106°40'38.8" Alt: 1367. 1,8м X 1,6м хэмжээтэй дөрвөлжин булш.
4. N 46°12'19.6" E 106°40'38.1" Alt: 1369. 17м урттай, 4,5м өргөнтэй, гол хэсэгтээ 2м өргөнтэй шоргоолжин булш.

### **Дурсгал-26**

**Газрын нэр:** Сүүдэрт овоо

**Солбицол:** N 46°13'44.6" E 106°42'15.4" Alt: 1312

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сүүдэрт хайрхан энгэрт байх хиргисүүр бүлэг дурсгал оршино.

N 46°13'44.6" E 106°42'15.4" Alt: 1312. Дугуй хүрээтэй хиргисүүр. Хүрээний голч 31 м, голын чулуун овоолго 14м голчтой. Чулуун овоолгоос зүүн урагш чиглэсэн цагаан чулуугаар хийсэн үүдэвчтэй. Үүдэвчний урт 9м, өргөн нь 70см хэмжээтэй. Зүүн урдаа тодорхой мэдэгдэж байгаа 5 дагуултай.

N 46°13'49.2" E 106°42'12.2" Alt: 1312. Хүрээгүй хиргисүүр чулуун дараасны голч 9м хэмжээтэй.

N 46°13'51.9" E 106°42'11.8" Alt: 1316. Сүүдэрт овооны зүүн хойд бэлд байрлах 5м голчтой овгор чулуун дараастай хиргисүүрийн төрлийн байгууламж.

N 46°19'57.2" E 106°43'48.4" Alt: 1325. Сумын төвөөс хойш 20 орчим км зайд байрлах хүрээгүй хиргисүүр, урд талаараа 4 дагуултай.

### **Дурсгал-27**

**Газрын нэр:** Бээлийн жасын туурь

**Солбицол:** N 46°22'28.9" E 106°42'15.9" Alt: 1298.

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Сүсэг бишрэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс хойш 23-24 км орчим зайд байрлах Бээлийн жасын туурь байрлана. Хожим нутгийнхан 2 суварга босгосон. Олон тооны чулуун тууриуд үлдсэн.

### **Дурсгал-28**

**Газрын нэр:** Жадамбын жасын туурь

**Солбицол:** N 46°17'37.7" E 106°59'28.8" Alt: 1280.

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Сүсэг бишрэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн хойд зүгт 27 км орчим зайд байрлах хуучин хийдийн тууриуд дээр хожим босгосон 1 суваргатай. Суваргын хойд талын хөндийг даган олон тооны хуучин тууриуд үлдсэн байна.

### **Дурсгал-29**

**Газрын нэр:** Бага Цахир уул

**Солбицол:** N 46°32'37.1" E 106°26'36.6" Alt: 1320.

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, тодорхойгүй

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, төрөл он цаг тодорхойгүй булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуй-уурхайн бүс

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бага Цахир уул хэмээх цувраа хадтай толгодууд байх ба тэрхүү толгодын эргэн тойронд олон тооны дурсгалтай. Энд дөрвөлжин булш 2, хиргисүүр 5, он цаг, төрөл тодорхойгүй 21 тооны булш.

Дундговь аймгийн Дэрэн сумын нутгаас нийт 29 дурсгалт газрын 158 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн бөгөөд эдгээрийг түүхэн үе, төрөл тус бүрээр нь дэлгэрүүлэн авч үзвэл:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 38.
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 30.
- Хүрлийн үеийн шоргоолжин булш – 3.
- Хүрэл зэвсгийн үеийн дөрөө хэлбэрийн булш – 1.
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 1.
- Хүннүгийн үеийн булш – 31.
- Түрэгийн үеийн зэл чулуу – 1.
- Монголын эзэнт гүрний үед холбогдох булш - 27
- XVIII-XIX зууны үеийн сүм хийдийн туурь – 4.
- Хадны бичээсийн дурсгал – 1.
- Түүхэн үе, он цаг нь тодорхойгүй булш оршуулгын төрлийн дурсгал – 21.

Дундговь аймгийн Дэрэн сумын 29 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 10 дурсгалт газар буюу 34.4%
- Бага эрсдэлтэй – 11 дурсгалт газар буюу 37.9%
- Дунд эрсдэлтэй – 6 дурсгалт газар буюу 20.6%
- Их эрсдэлтэй – 2 дурсгалт газар буюу 7.1%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Дэрэн сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 29 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 7 буюу 24.1 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 6 буюу 20.6%
- Байгалийн нөлөөлөл – 5 буюу 17,3%
- Аж ахуйн нөлөөлөл – 4 буюу 13,7%
- Суурьшлын бүсэд ойр – 3 буюу 10,4%
- Сүсэг бишрэл – 3 буюу 10,4%
- Вандализм– 1 буюу 3.5

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, орон нутгийн замд ойр, байгалийн нөлөөлөл гэсэн гурван нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Дэрэн сумын нутгаас илрүүлэн бүртгэсэн 158 тооны түүх, соёлын дурсгалаас шинээр 55 тооны дурсгалыг илрүүлэн бүртгэв. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал – 16
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 11
- Хүрэл зэвсгийн үеийн шоргоолжин булшны дурсгал – 3
- Хүрэл зэвсгийн үеийн дөрөө хэлбэрийн булшны дурсгал – 1
- Хүннүгийн үеийн жирийн иргэдийн булш оршуулгын дурсгал – 22
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 1
- Түрэгийн үеийн зэл чулуун дурсгал – 1.

## ЛУУС СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Хонхорын булш

**Баг:** Буянт баг

**Солбицол:** N 45°34'57.6" E 106°02'38.6" Alt: 1368

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Луус сумын төвөөс урагш хойш 20км зайд Хонхор хэмээх газар замын хажууд 3м голч бүхий 1 Монгол булш байна. Хойд дэвцэг дээр нь баруунаас зүүн тийш чиглэсэн 41 монгол булш байна.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Хөшөөн Хонхорын тахилын байгууламж

**Баг:** Буянт баг

**Солбицол:** N 45°35'33.4" E 105°58'59.5" Alt: 1398

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Хөшөө чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Луус сумын төвөөс урагш хойш 20км зайд Хөшөөн Хонхор хэмээх газарт 1ш хөшөө чулуу байна. Өндөр 3м орчим, Нүүрэн талдаа “Н” тамгатай. Хашаагаар хүрээлэн авсан байна. Сумын хамгаалалтад авсан.

### Дурсгал-3

**Газрын нэр:** Суварга хайрхны булш

**Баг:** Суварга



**Солбицол:** N 45°37'49.5" E 105°34'01.1" Alt: 1406

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе,

**Төрөл:** Дөрвөлжин булш, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын хамгаалалтад авсан.

1. Суварга хайрхны зүүн урд үзүүрт 3x2м хэмжээтэй дөрвөлжин булш байна. Баруун хашлага чулуу бусдаасаа өндөр 45см орчим, цөөн чулуун дараастай.
2. Баруун урд талдаа том чулуутай 4м голчтой Хүннү булш
3. Суварга хайрхны урд бэлд 3 зэрэгцээ булш байна. 3м голчтой, голдоо чулуун дараасгүй Хүннү булш.
4. Суварга хайрхны баруун толгойн урд 13 тооны булш байна. Мөн 60см өндөртэй хөшөө чулуу хажууд нь байна.
5. Хайрханы баруун толгойн урд бэлд замын урд талд 13ш хүннү булш байна. 5-8м голчтой жирийн иргэдийн булш оршино. Эдгээр хүннү булш нь шинээр илрүүлэн олсон болно.

#### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Дугантын жас

**Баг:** Суварга

**Солбицол:** N 45°47'47.4" E 105°31'56.5" Alt: 1440

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Суварга багийн нутаг Дугантын жас гэх хийдийн туурь байна. Нийт 13 барилгын туурь байх ба баруун хойд үзүүрийн туурийн дээр хожим суварга босгожээ. Уг газар нь жижиг уулаар хүрээлэгдсэн хөндийд оршино. Урд талдаа худагтай, баруун талдаа өвөлжөөтэй ажээ. Уг газар нь сумын хамгаалалтад байдаг.

#### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Мөхийн хүннү булш

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°48'05.4" E 105°55'04.7" Alt: 1529

**Он цаг:** Хүннүгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хүннү булш, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Мөнх уулын баруун талд хөндий дунд 11 хүннү булш, 6 Монгол булш оршино. Монгол булшны 3 нь орон нутгийн замд ойр, замын урд талдаа, Хүннү булш нь бүлгээрээ байна. 4-8м голчтой жирийн иргэдийн булш ажээ. Энэ дурсгал нь шинээр бүртгэгдэж байгаа бөгөөд цаашид нарийвчлан судлах хэрэгтэй.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Мөхийн зүүн ханан

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°50'01.4" E 105°56'01.5" Alt: 1558

**Он цаг:** Хүннүгийн үе, Хүрэл зэвсгийн үе, XVII-XX зуун

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, Хүннү булш, бичгийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Мөхийн зүүн ханангийн дунд нийт 30 булш байх ба 22 хүннү булш цогцолбор байдлаар оршино. Бусад хүрлийн үеийн хиргисүүр 1, дөрвөлжин булш 7 байна. Хүннү булшнуудын дундаж хэмжээ 5-12м голчтой. Зүүн ханангийн уг дурсгалт газрын баруун хаданд хадны хөмөг байх бөгөөд түүн дээр маанийн үсэг бичээс байна.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Мөхийн хийд

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°49'33.5" E 105°55'38.7" Alt: 1502

**Он цаг:** 18-р зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Мөхий уулын урд энгэрт 10 гаруй хийдийн туурь бүхий шавар суурьтай, чулуун өрлөгтэй хийдийн туурь байна. Урд талдаа худагтай, эргэн тойрон айл ихтэй.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Мөхийн баруун ханан

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°49'47.3" E 105°55'02.2" Alt: 1526

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Мөхийн баруун ханангийн аманд өвөлжөөний өмнө хэсэгт бүлэг булш байна. 2 хиргисүүр, 1 тахилын байгууламж, 11 дөрвөлжин булш оршино. Дөрвөлжин булшнуудын дундаж хэмжээ 2x1,5м бол хиргисүүрүүд нь 5м орчим голчтой, дугуй хүрээтэй байна.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Зээргэнт

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°47'52.8" E 105°54'06.8" Alt: 1480

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе,

**Төрөл:** Хиргисүүр, Дөрвөлжин булш, монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоносон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зээргэнт хэмээх газар нийт 21 булш орших ба 20 дөрвөлжин булш, 1 хиргисүүр байна. Дөрвөлжин булшийг урдаас хойш чиглэлтэй байрлуулсан бөгөөд голын булшнууд нь баруун хашлага чулуу харьцангуй өндөр байна. Дундаж хэмжээ 4х2м орчим байна. 1 хиргисүүр, 1 дөрвөлжин булшийг шунахайн сэдэлтэйгээр тоносон байдалтай байна. 7 монгол булш бий. Булшны хажуу дах сул чулуун дээр дүрс тэмдэг байна. Булшнуудаас хойш цувраа босоо хөшөө чулуу босгосон. Сумын хамгаалалтад авсан.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Хуруувчийн эхэн бууцны зэл чулуу

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°47'02.2" E 105°54'35.5" Alt: 1491

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Тахилын байгууламж, зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хуруувчийн эхэн бууцны хөндийд зүүн тийш чиглэсэн, нэг эгнээ 39 чулуу бүхий зэл чулуу оршино. Өмнө нь уг зэл чулууг бүртгэсэн боловч дэргэд орших олон тооны тахилын байгууламжийг бүртгээгүй байна. Бид дахин бүртгэл хийж нийт 50 гаруй хүрлийн үед холбогдох 1х2м хэмжээтэй жижиг чулуун байгууламжуудыг бүртгэн авав. Зарим нь булш байх бөгөөд он цагийг шууд тодорхойлох боломжгүй байна. Зарим булшны зүүн талд хөшөө чулуу босгосон байх нь хүрлийн үеийн дурсгал хэмээн мэдэгдэж байна. Уг газарт илүү нарийвчилсан судалгаа явуулбал дурсгалын тоо нэмэгдэх бүрэн боломжтой. Сумын хамгаалалтад авсан.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Уст улаан хад

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°37'27.6" E 105°50'18.3" Alt: 1405

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, XVII-XX зууны үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, Хүннү булш, хүрлийн үеийн хадны сийлмэл зураг, XVII-XX зууны үед холбогдох маанийн үсэг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Уст улаан хад гэх газарт 3 хүннү булш зэрэгцэн орших ба ойролцоогоор 5м голчтой жирийн иргэдийн булш байна. Түүний хойд талд 10м зайд 1 хиргисүүр байна. Уг газраас хойд зүгт 1км зайд өвөлжөөний урд худгийн хажууд 4х3м хэмжээтэй дөрвөлжин булш байна. Мөн худгийн хажуу хаданд буга, янгир, маанийн үсэг бичээс байна. Сумын хамгаалалтад авсан.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Жимгэрийн хоолой (Судай)

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°38'49.5" E 105°44'40.4" Alt: 1374

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Жимгэрийн амны эх, цагаан толгойн зүүн хойд талд дугуй хүрээтэй 1 хиргисүүр байна. 25м голчтой, 15м чулуун овоолготой, дугуй хүрээтэй. Зүүн талд 1 дагуул байгууламжтай, тоногдсон байсныг саяхан нэмж цооноглож ухсан байна.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Цохионы бууцны хиргисүүр

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°47'32.0" E 105°54'52.0" Alt: 1474

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цохионы бууцны зүүн талд 11х11м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, 4 буландаа тахилын байгууламжтай хиргисүүр бий. Сумын хамгаалалтад авсан.

Дундговь аймгийн Луус сумын нутгаас нийт 13 дурсгалт газрын 289 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 14
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 40
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 3
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал - 55
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 66
- Хөшөө чулуу - 1
- Зэл чулуу – 2
- Барилга архитектур, сүм хийдийн дурсгал – 2
- Тахилын онгон – 1
- Бичиг үсгийн дурсгал - 1
- Түүхэн үе, он цаг нь тодорхойгүй булш оршуулгын дурсгал – 114

Дундговь аймгийн Луус сумын 13 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 2 дурсгалт газар буюу 15,3%
- Бага эрсдэлтэй – 4 дурсгалт газар буюу 30,7%
- Дунд эрсдэлтэй – 1 дурсгалт газар буюу 7,6%
- Их эрсдэлтэй – 3 дурсгалт газар буюу 23%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Луус сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 13 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 4 буюу 30.7 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 3 буюу 23%
- Тоногдсон – 3 буюу 23%
- Мал шөргөөх - 3 буюу 23%

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл гэсэн нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Луус сумын нутгаас нийт 289 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн үүнээс 122 тооны дурсгалыг шинээр бүртгэн баримтуулсан. Үүнд:

- Он цаг тодорхойгүй булш оршуулгын дурсгал – 91
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 24
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 6
- Зэл чулуун дурсгал – 1

## Луус сумын нутагт байх түүх, соёлын дурсгалт газрын зарим зураг



1. Хонхорын булш



4. Дугантын жас



2. Хөшөөн Хонхорын тахилын байгууламж



5. Мөхийн хүннү булш



3. Суварга хайрхны булш



6. Мөхийн зүүн ханангийн хүннү булшны цогцолбор





7. Мөхийн хийдийн туурь



10. Хуруувчийн эхэн бууцны зэл чулуу



8. Мөхийн баруун ханангийн булш



11. Уст улаан хадны булш



9. Зээргэнтийн булш



12. Жимгэрийн хоолойн хиргисүүр

## САЙНЦАГААН СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Баянбулагийн амны булш

**Баг:** Далай

**Солбицол:** N 45°40'10.6" E 106°22'33.3" Alt: 1343

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Аймгийн төвөөс урагш 11км зайд хадтай уулын урд хэсэгт он цаг нь тодорхойгүй 11 тооны булш оршино. 3-4м голчтой, жижиг чулуун дараастай болно.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Баянбулагийн ам

**Баг:** Далай

**Солбицол:** N 45°41'45.8" E 106°21'33.6" Alt: 1353

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баянбулагийн аманд 65м голчтой дугуй хүрээтэй, 5м голч бүхий 1,6м өндөр чулуун овоолготой хиргисүүр оршино. Эргэн тойрондоо 14 тахилын тогоотой, хүрээний дотор талд 1 тахилын байгууламжтай ажээ.

### Дурсгал-3

**Газрын нэр:** Баянбулагийн ам

**Баг:** Далай

**Солбицол:** N 45°42'04.2" E 106°22'02.3" Alt: 1381

**Он цаг:** Хүннүгийн үе, тодорхойгүй

**Төрөл:** Хүннү булш, хөшөө чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Ашигт малтмалын ашиглалтын ажиллагаа

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баянбулагийн аманд нийт 34 хүннүгийн жирийн иргэдийн булш цогцолбор байдлаар оршино. Дундаж хэмжээ 5-6м. Мөн он цаг тодорхойгүй 2 булш, хүрлийн үеийн 2 хөшөө чулуу байна. Нэг хөшөө чулууны өндөр 60см бол нөгөөх нь 30см өндөртэй ажээ.

#### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Ёрвон уул

**Баг:** Далай

**Солбицол:** N 45°41'53.5" E 106°22'49.1" Alt: 1416

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ёрвон уулын өвөрт нийт 5 булш байна. 1-р булш 8м голчтой тоногдсон хиргисүүр бол 2-р булш 10м голчтой дөрвөлжин хүрээтэй, том чулуун дараастай хиргисүүр болно. 3-р булш 5м голчтой хүрээгүй хиргисүүр байна. 4-р булш 2х3м хэмжээтэй намхан хашлага чулуутай дөрвөлжин булш болно. 5-р булш сайн мэдэгдэхгүй зохион байгуулалт алдагдсан байдалтай байна. Дөрвөлжин булш бололтой.

#### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Шар хад

**Баг:** Далай

**Солбицол:** N 45°41'16.9" E 106°24'56.5" Alt: 1429

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шар хадны хамгийн урд хадтай толгойн ар тал дээр 25х25м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, баруун хойд хүрээ мэдэгдэхгүй болсон, голдоо намхан цөөн чулуун дараастай хиргисүүр байна. Түүний хажууд 15м голчтой том чулуун дараастай, хүрээгүй хиргисүүр оршино.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Шар хадны зэл чулуу

**Баг:** Далай

**Солбицол:** N 45°41'20.2" E 106°25'09.2" Alt: 1440

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Аймгийн төвөөс урагш 30км зайд Шар хадны хамгийн урд энгэрт орших өвөлжөөний урд талд 2 эгнээ 53ш зэл чулуу байх ба хамгийн өндөр нь 130см, намхан нь 20см байна. Түүнээс гадна 2 хадан дээр 2 бурхны хөргийг сийлсэн байна.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Авдрантын хүнхэр

**Баг:** Далай

**Солбицол:** N 45°41'17.6" E 106°26'24.4" Alt: 1442

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Түрэгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, хөшөө чулуу бүхий тахилын онгон дурсгал, зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Авдрантын хүнхэр гэх газрын урд хадтай хэсэгт 2 хүннү, 2 хиргисүүр, 3 дөрвөлжин булш байна. Дөрвөлжин булшны 1 нь тоногдсон байдалтай байна. Мөн 2 эгнээ 37ш зэл чулуу байх ба хойд эгнээнд нь 9 зэл чулуу байрлана. Мөн 2 босоо чулууг зэрэгцүүлэн зоосон 40см болон 80см өндөртэй 2 тахилын онгон байна. Эргэн тойронд нь 130 хүрэл болон он цаг тодорхойгүй булш байгууламжууд байна. Уг газрыг сумын хамгаалалтад авсан байна

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Их булгийн амны хиргисүүр

**Баг:** Далай

**Солбицол:** N 45°39'43.6" E 106°24'53.8" Alt: 1368

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоносон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Их булгийн амны доод үзүүрт 2 хиргисүүр байна.

1. 1-р хиргисүүр 70м голчтой дугуй хүрээтэй, 20м голчтой, 1,8м өндөр чулуун овоолготой, 17 дагуултай болно.
2. 2-р хиргисүүр 1-р дурсгалын урд талд 50м голчтой дугуй хүрээтэй, 15м голчтой, 1,5м өндөр чулуун овоолготой, 17 дагуултай байна.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Халзан цохио

**Баг:** Үйзэн

**Солбицол:** N 45°27'25.3" E 106°27'20.8" Alt: 1343

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Халзан цохио гэх хадархаг газрын дунд 2х1м хэмжээтэй тахилын онгон байна. Зүүн талын 2 үзүүрийн чулуу босоо хэвээрээ өндөр нь 1,3м орчим. Баруун талын хөшөө чулуу унасан байдалтай.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Хан-Уул

**Баг:** Үйзэн

**Солбицол:** N 45°30'34.0" E 106°33'20.3" Alt: 1417

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, Хадны зураг, Хүннү булш, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хан-Уул хэмээх хүрмэн чулуун тогтоцтой уулын урд энгэрээр олон үед холбогдох дурсгалууд оршино. Уг газар нь сумын хамгаалалтад байдаг.

1. Хиргисүүр: Уг газарт нийт 10 хиргисүүр байх ба хамгийн том нь 70м голчтой дугуй хүрээтэй, 4м голчтой чулуун овоолго бүхий хиргисүүр байна.
2. Хадны зураг: Хан уулын баруун хойд жижиг нуруун дээр 5-6 зураг байна
3. Хүннү булш: Уг гарт нийт 5 хүннү булш бүртгэсэн бөгөөд дундаж хэмжээ нь 4м байна. Галт уулын хүрмэн чулууд нэлээд ихтэй учраас намхан чулуун дараастай хүннү булшнууд зарим нь мэдэгдэхгүй болсон байна.
4. Монгол булш: Уг газарт нийтдээ 72 Монгол булш бүртгэсэн.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Ганжуурын хийд

**Баг:** Наран

**Солбицол:** N 45°42'34.5" E 105°59'18.8" Alt: 1517

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийд

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоносон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Амаржаргал уулын урд хормойд Ганжуурын хийдийн туурь бий. Одоогоор чулуун довцог туурь үлдэгдлүүд овойж хоцорсон байдалтай. Хийдийн үлдэгдэлд хөх тоосго бага сага байна. Нийт 2 хэсэг газарт бүлэг тууриуд байна. Баруун хэсэгт шавилах газар, зүүн хэсэгт хийд нь байжээ.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Амаржаргал уулын зэл чулуу

**Баг:** Наран

**Солбицол:** N 45°42'32.8" E 105°59'57.9" Alt: 1532

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Амаржаргал уулын зүүн дэвцэг дээр 100м үргэлжилсэн 100 гаруй тооны зэл чулуу байх ба 10 гаран нь унасан байдалтай байна. Уг дурсгал нь өмнө нь бүртгэгдэж байгаагүй болно.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Амаржаргал уулын булш

**Баг:** Наран

**Солбицол:** N 45°43'14.6" E 105°59'24.5" Alt: 1551

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хадны зураг, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Амаржаргал уул нь олон үеийн дурсгалыг хамрах бөгөөд аймгийн төвөөс 23км зайд оршино.

1. Хадны зураг: Амаржаргал уулын баруун овоот уулын өврийн хаданд 3 янгир байх ба нэг нь эсрэг чиглэлтэй харсан байдалтай.

2. Он цаг тодорхойгүй: Амаржаргал уулын өндөр овоотой хэсгийн урд талд 3 тооны он цаг нь тодорхойгүй цөөн чулуун дараастай булш байна.
3. Хүннү булш: Баруун овоот уулын өвөрт 4м голчтой 2 тооны хүннү булш байна. Ар талд нь 4м голчтой 1 хүннү булш байна.

#### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Суман хайрхан

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°50'34.1" E 106°33'11.6" Alt: 1335

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, Хадны зураг, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Аймгийн төвөөс зүүн хойш 25км орчим зайд тал дунд галт уулын хүрмэн чулуунаас бүтсэн ганц содон хайрхан байна. Уг хайрхны нэрийг Суман хайрхан хэмээнэ. Эргэн тойрондоо нэлээдгүй тооны булш хиргисүүрээс гадна хадны зургуудтай ажээ.

1. Хадны зураг: Суман хайрхны баруун талаар янгир, адуу, тамга тэмдгүүд болон зэрлэг амьтдын дүрслэл бий.
2. Хайрхны баруун урд, баруун хажуугаар олон тооны булш байна. Нийт 50ш булш бүртгэн авлаа. Үүнд 16 хиргисүүр, 34 монголын эзэнт гүрний үеийн булш байна.

#### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Хорины хийд

**Солбицол:** N 45°29'29.0" E 106°20'21.0" Alt: 1330

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоносон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй



**Тодорхойлолт:** 1 жижиг дуган байгаа бөгөөд дуганыг дөрвөлжин чулуун суурин дээр хөх цэнгийн тоосгоор өрж, дотор талыг 15 см шавардаж шохойдсон. Дээврийн дам нуруу нурж, ар хананы тоосго нурсан

#### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Сариг хайрхан

**Солбицол:** N 45°55'37.3" E 105°47'53.7" Alt: 1270

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сариг хайрхнаас зүүн урд зүгт 2 км орчим зайд хүрээгүй 1 хиргисүүр байна.

#### **Дурсгал-17**

**Газрын нэр:** Ар ханангийн монгол бичээс

**Солбицол:** N 45°48'77.3" E 106°48'18.8" Alt: 1280

**Он цаг:** тодорхойгүй, XVII-XX зуун

**Төрөл:** Бичиг үсгийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ар ханангийн бууцны хадны энгэрт монгол бичээс байна. Түүний хажууд нь маанийн үсэг бичээс бий.

#### **Дурсгал-18**

**Газрын нэр:** Тэвш уулын булш

**Солбицол:** N 46°00'30.2" E 105°57'20.1" Alt: 1255

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоносон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тэвш уулаас баруун урагш 2 км-т 4 хүннү булш бий. Булшнуудыг тоносон байна.

### **Дурсгал-19**

**Газрын нэр:** Бэрх уулын булш

**Солбицол:** N 46°28'20.0" E 106°24'30.0" Alt: 1295

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бэрх хайрхнаас зүүн хойш 800м орчимд 2ш хүннү булш байна. 2,5м дундаж голчтой. Намхан чулуун дараастай.

### **Дурсгал-20**

**Газрын нэр:** Сүндэв овооны булш

**Солбицол:** N 45°53'32.5" E 106°24'41.0" Alt: 1300

**Он цаг:** Хүннүгийн булш

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоносон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сүндэв овооны энгэрт 3 тооны хүннү булш байна. 1 булшийг ухаж тоносон байдалтай.

### **Дурсгал-21**

**Газрын нэр:** Өнгөт хайрхны булш

**Баг:** Үйзэн

**Солбицол:** N 45°27'43.0" E 106°23'55.0" Alt: 1324

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бэрх хайрхны зүүн байрлах хайрхныг Өнгөт хайрхан гэнэ. Урд энгэрт 4м голчтой, 5 хүннү булш, зүүн талын аманд 1 хиргисүүр байна.Үйзэн багаас зүүн урагш 5 орчим км зайтай.

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Бунхантын хөх толгойн тахилын онгон

**Солбицол:** N 45°05'51.9" E 105°55'11.6" Alt: 1288

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хөх толгойн бууцнаас зүүн тийш 800 орчим м-т нэг тахилын онгон байна. Баруунаас зүүн тийш 2 хэвтээ чулуу унасан. 1 босоо чулуу баруун хойноос зүүн урагш зүгт унасан.

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Хавцалын чулуун хэрэм

**Солбицол:** N 45°35'07.0" E 106°50'19.7" Alt: 1270

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Барилга архитектур, хэрэм

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хаалган хаднаас зүүн тийш 5-6 км-т Хавцал хэмээх газарт чулуун хэрэм байна. Зэргэлдээ 2 том хэрэм байна. Ойролцоогоор 3м өндөртэй, зүүн талын хэрэм босоо чулуунуудыг ойрхон зоосон байна.

### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Хөшөөтийн хоолойн тахилын онгон

**Солбицол:** N 45°48'34.3" E 106°48'25.4" Alt: 1288

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ар ханангийн бууцны зүүн хойно 2,6м хэмжээтэй, босоо чулуу нь унасан тахилын онгон байна.

### **Дурсгал-25**

**Газрын нэр:** Өндөр харын тахилын онгон

**Солбицол:** N 45°48'28.0" E 106°24'33.0" Alt: 1257

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Өндөр хараас баруун хойш 500м-т Хар толгойн ард. 4 босоо чулууг хавтгайгаар нийлүүлэн зоосон. Нэг чулуу нь хугарсан байдалтай.

### **Дурсгал-26**

**Газрын нэр:** Адгийн хөшөөн тахилын онгон

**Солбицол:** N 45°48'23.9" E 106°15'47.5" Alt: 1262

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоносон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Адгийн хөшөөт хэмээх газар ухагдсан тахилын онгон байна. 1,5м өндөртэй.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутгаас нийт 26 дурсгалт газрын 377 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 38
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 5
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 3
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 106
- Хүннү булш – 58
- Хөшөө чулуу - 2
- Зэл чулуу – 5
- Барилга архитектур, сүм хийдийн дурсгал – 3
- Тахилын онгон – 8
- Бичиг үсгийн дурсгал - 3
- Түүхэн үе, он цаг нь тодорхойгүй булш оршуулгын дурсгал – 146

Дундговь аймгийн Сайнцагаан сумын 26 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 4 дурсгалт газар буюу 15,3%
- Бага эрсдэлтэй – 10 дурсгалт газар буюу 38,4%
- Дунд эрсдэлтэй – 4 дурсгалт газар буюу 15,3%
- Их эрсдэлтэй – 8 дурсгалт газар буюу 30,7%-ийн үзүүлэлттэй гарч

байна.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 26 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 14 буюу 53,8 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 3 буюу 11,5%
- Тоногдсон – 6 буюу 23%
- Мал шөргөөх - 2 буюу 7,7%
- Ашигт малтмалын ашиглалтын ажиллагаа - 1 буюу 3,8%

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, тоногдсон гэсэн хоёр нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутгаас 377 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн бөгөөд үүний 287 тооны дурсгалыг шинээр бүртгэн баримтжуулав.

Үүнд:

- Он цаг тодорхойгүй булш оршуулгын дурсгал – 144
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 42
- Хөшөө чулуу – 2
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал – 17
- Хадны бичээс – 2
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 1
- Хадны зураг – 6
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 72
- Зэл чулуун дурсгал – 1

**Сайнцагаан сумын нутагт байх түүх, соёлын дурсгалт газрын зарим зураг**



1.Баянбулагийн амны булш



4.Ёрвон уулын булш



2.Баянбулагийн амны хиргисүүр



5.Шар хадны булш



3.Баянбулагийн амны хүннү булш



6. Шар хадны зэл чулуу





7. Авдрантын хүнхрийн булш



10. Хан-Уулын булш



8. Их булгийн амны хиргисүүр



11. Ганжуурын хийдийн туурь



9. Халзан цохионы булш, тахилын онгон



12. Амаржаргал уулын зэл чулуу





13. Амаржаргал уулын булш



14. Суман хайрхны булш



15. Сариг хайрхан хүн чулуун хөшөө

## САЙХАН-ОВОО СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Тамгат

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°22'03.8" E 104°00'07.6" Alt: 1347

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Суурьшлын бүс, газар олголт

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тамгат уулын баруун урд энгэрт 3,50x3,80м хэмжээтэй, дөрвөн буландаа хөшөө чулуутай, битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Тамгат

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°22'13.0" E 104°00'13.4" Alt: 1360

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тамгат уулын хадтай оройг тойроод 4 хиргисүүр байна. Эдгээр хиргисүүрүүд нь дөрвөлжин хүрээтэй, дугуй хүрээтэй, хүрээгүй гэсэн 3 төрөл байна. Дөрвөлжин хүрээтэй хиргисүүрийн нь 11x11м хэмжээтэй 4,5м голч бүхий чулуун овоолготой. Уулын оройн баруун болон баруун урд байрлах хиргисүүрүүд 5м болон 6м голчтой байна. Эдгээр хиргисүүрүүд нь бүгд тоногдсон байна.

### **Дурсгал 3**

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүү

**Баг:** Тамгат

**Солбицол:** N 45°22'13.0" E 104°00'13.4" Alt: 1360

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тамгат уулын орой дээр янгир, буга, хүн, тамга зэрэг дүрслэлүүд бүхий хадны зургууд байна. Тус тамагт уул нь Онги голын зүүн талд Замбага хайрханаас зүүн урагш оршино. Сумын төвөөс 12 км зайд оршино.

### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Баян-Өндөр

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°21'56.1" E 104°00'30.1" Alt: 1361

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл, тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн ургаш 15 км зайд байх сумын тахилагт Баян-Өндөр уулын тойроод 8ш оршуулгын дурсгал байна.

1. Баян-Өндөр хайрхны баруун талд орших нэгэн хадтай жижиг толгойн урд энгэрт дөрвөн буландаа тахилын байгууламж бүхий 15x15м дөрвөлжин хүрээтэй 10м голч бүхий хиргисүүр байна. Дараасны өндөр 1,5м өндөр, хиргисүүрийг тойроод 10 гаруй тахилын байгууламж байна.
2. 1-р дурсгалын зүүн хойд онь дээр бас нэгэн дугуй хэлбэрийн хиргисүүр байна. Хиргисүүрийн голч 6м бөгөөд тойроод 9 дагуул байгууламж байна. Энэхүү дурсгал нь тоногдсон.

3. N 45°21'54.4" E 104°01'17.3" Alt: 1903 Баян-Өндөр хайрханы урд энгэрт 11м голч бүхий дугуй хүрээтэй, 5м голч бүхий хиргисүүр. Хиргисүүрийг тойроод нэлээд хэдэн тахилын байгууламж байсан нь мэдэгдэж байна.
4. Тус хайрхны зүүн энгэрт нь байрлалтай 6м голч бүхий дугуй хэлбэрийн оршуулгын байгууламж. Уг дурсгал нь тоногдсон байна.
5. N 45°22'04.8" E 104°00'37.6" Alt: 1366 Хайрханы хойд талд байх нэгэн жижиг толгойн энгэрт зэрэгцээ байрлалтай 3 хиргисүүр байна. Эдгээр 3 хиргисүүрийн зүүн захад орших нь хэмжээний хувьд бусдаасаа нэлээд том бөгөөд 15м голч бүхий дугуй хэлбэрийн дагуул байгууламж бүхий хиргисүүр.
6. Дурсгал 5-ын баруун талд байрлана. Дөрвөн буландаа хөшөө чулуу бүхий дөрвөлжин хүрээтэй, 6м голч бүхий дугуй хэлбэрийн хиргисүүр.
7. Зэрэгцээ 3 дурсгалын баруун захад байрлана. Дөрвөн буландаа тахилын байгууламж бүхий дөрвөлжин хүрээтэй, 9м голч бүхий дугуй хэлбэрийн хиргисүүр. Хиргисүүрийн баруун, зүүн урд талуудад тус тус 2 тахилын байгууламж байна.

### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Шашир уулын энгэр

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°19'20.8" E 103°59'48.4" Alt: 1318

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр, тоногдсон.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Онгийн хийдээс урагш 3 км зайд нэгэн ягаан өндөр уул байх бөгөөд үүнийг Дунд Шашир гэнэ. Түүний зүүн энгэрт хэд хэдэн дурсгал байна.

1. Шашрын зүүн энгэрт зэргэлдээ 2 дурсгал байгаагийн хойд захад орших дурсгал нь дөрвөн буландаа тахилын байгууламж бүхий 9м голчтой дугуй хэлбэрийн хиргисүүр юм. Хиргисүүр нь урд талаараа 10 гаруй тахилын байгууламжтай.
2. Урд талд орших дурсгал нь 20м голч бүхий дугуй хүрээтэй, 10 голч бүхий дугуй хэлбэрийн хиргисүүр юм. Хиргисүүрийн зүүн талд 3 тахилын байгууламж байна. Тоногдсон.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Шашир уулын баруун тал

**Баг:** Тагт

**Солбицол:** N 45°19'05.8" E 103°59'29.6" Alt: 1332

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шашир уулын баруун талд байх 2 хиргисүүрээс баруун урд зүгт 700м зайд зэрэгцээ гурван хиргисүүр байна. Дөрвөлжин хүрээтэй 7м голч бүхий хиргисүүр. Хиргисүүрийг тойроод 10 дагуул байгууламж байна.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Ноён хүрээ

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°21'15.6" E 104°00'01.5" Alt: 1327

**Он цаг:** Он цаг тодорхойгүй

**Төрөл:** Агуй

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс урагш 15 км-т Ноён хүрэн хэмээх нэгэн хадан тогтоц бүхий өндөр уул байна. Түүний зүүн хойд талаас орж ирсэн хоёр талаараа хадтай жалга бий. Түүний хойд талд ойролцоогоор 20м урттай, 3,5 м өргөн, үүд хэсгээрээ 2м өндөр агуй бий. Агуй гол хэсгээрээ хүн мөлхөх хэмжээтэй намсаж ирээд төгсгөл хэсэгтээ 1,70м өндөр болж байна. Агуйн мухар хэсэгт нэлээд хэдэн сул чулуу байна. Энд хадны оршуулга байсан байх магадлал нэлээд өндөр байна. Нутгийн иргэд хүний яс байдаг байсан гэлцэнэ. Тус агуйн чанх урд 7м өргөнтэй хадан хөмөг байна. Хөмөгт сул чулууд нэлээд их байна.

## Дурсгал-8

**Газрын нэр:** Шашир

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°19'12.7" E 104°00'32.5" Alt: 1319

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зүүн шашир, Дунд шашир хоёрын голд 3 хиргисүүр бий.

1. 6м голч бүхий дугуй хүрээтэй, дагуур байгууламж бүхий хиргисүүр.
2. 7м голчтой дөрвөлжин хүрээтэй, 10 тахилын байгууламж бүхий хиргисүүр.
3. 19м голчтой, 2м өндөр дараастай, 10 дагуул байгууламж бүхий дугуй хүрээтэй хиргисүүр. Хойд талаар нь үерийн шуудуу байна.
4. 3 дугаартай дурсгалын зүүн урд талд 2х3м хэмжээтэй дөрвөлжин булш бий.
5. 4 дугаартай дурсгалын хажууд мөн зохион байгуулалт нь эвдэгдсэн хиргисүүр байна.

## Дурсгал-9

**Газрын нэр:** Цорж

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°20'02.2" E 103°57'31.4" Alt: 1367

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цорж уулнаас урагш нэгэн жижиг ягаан толгойн урд болон зүүн энгэрт 5 хиргисүүр, 1 дөрвөлжин булш, байна.

1. Урд энгэрт байх 4 хиргисүүр нь ямар нэгэн хүрээ байхгүй. Эдгээр 4 хиргисүүрүүд нь дунджаар 9м голчтой байна.

2. Зүүн энгэрт 2,5х3м хэмжээтэй дөрвөлжин булш бий. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
3. Зүүн хойд онь дээр дөрвөн буландаа тахилын байгууламж бүхий дөрвөлжин хүрээтэй, 7м голчтой хиргисүүр. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
4. Цорж уулаас урагш 100м л зайд 3х2м хэмжээтэй дөрвөлжин булш бий. Тоногдсон байдалтай байна.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Замбага хайрхны Хүннү булш

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°23'14.2" E 103°58'41.5" Alt: 1300

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс урагш 10 орчим км-т Онги голын зүүн бие, Замбага хайрхны урд энгэрийг дагаад цагариг хэлбэрийн 60 гаруй хүннү булш байна. Эдгээр дурсгал нь хамгийн том нь 5м голчтой, дунд нь 2,50м голчтой, жижиг нь 1м голчтой байна.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Шаазан хотын туурь

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°40'21.1" E 103°40'49.0" Alt: 1387

**Он цаг:** Дундад зууны үе

**Төрөл:** Эртний хотын туурь

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 30 орчим км-т Онгийн голын баруун цутгалан Харганын голын эрэг дээр Шаазан хотын туурь бий. Эндээс паалантай, паалангүй шаазангийн хагархай элдэв шавар ваарны үлдэгдэл ихээр олддог. Мөн эн

Боржин чулуун баганын суур 2ш байдаг. Нэг суурь нь голоороо хуваагдсан, нэг нь бүтэн байдаг. Бүтэн суурь нь 66х66х33см хэмжээтэй бөгөөд түүн дээр 32см голчтой дугуй ханын суурийг товойлгосон. Тал байдалтай суурь чулуун 66х30х35см хэмжээтэй байна. Нутгийн иргэд уг туурийг Өгөдэй хааны өвлийн ордон хэмээн нэрийднэ. Анх Х.Пэрлэй олж илрүүлсэн байна.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Сэнжит хад

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°25'58.3" E 103°55'249.8" Alt: 1296

**Он цаг:** Он цаг тодорхойгүй

**Төрөл:** Байгалийн өвөрмөгц тогтоц бүхий газар

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урагш 3,5 км зайд сэнжит хад нэртэй байгалийн өвөрмөгц тогтоц бүхий хад байна. Тус хад Онги голын хойд эрэг дээр нэгэн шаварлаг хад бүхий жижиг уулын орой дээр байна.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Зараа хайрхны тахилын онгон

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°38'04.8" E 103°53'05.0" Alt: 1352

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зараа хайрхны зүүн урд 800 орчим м-т хоёр хөшөө чулуу бүхий тахилын онгон байна. Босоо байдал хөшөө чулууны хэмжээ 2,55х50х55м хэмжээтэй бол хэвтээ байдалтай хөшөө чулууны хэмжээ 2,25х55х10см хэмжээтэй байна.

### **Дурсгал-14**



**Газрын нэр:** Зараа хайрхан булш, хиргисүүр, хадны зураг

**Баг:** Мааньт баг

**Солбицол:** N 45°38'40.7" E 103°52'26.3" Alt: 1377

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс хойш 22 км-т Зараа хэмээх орой дээгүүрээ хад асаг бүхий хойноос урагш сунаж тогтсон хайрхан юм. Тус хайрхны үргэлжлэл Бүүрцэг хэмээх тэгш оройтой уул байна. Тус уулын орой дээрээс гурван аймгийн нутаг харагдана. Зараа хайрхны хойд талаар Домбонгын говь, зүүн урд талаар Шалангийн говь үргэлжилнэ. Зүүн талдаа Галт хайрхан, баруун талд нь их, бага, дунд Султ хэмээх газрууд байна. Тус Зараа хайрхныг тойроод 140 хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр, дөрвөлжин булш, хадны зургийн дурсгалууд байна.

### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Зээргэнт

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 45°43'46.3" E 104°18'16.5" Alt: 1407

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн тийш 45 км-т Зээргэнэ хэмээх жижиг нурууны зүүн урд талд нэгэн тахилын онгон бий. 1.50x45x40 см хэмжээтэй.

### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Онгийн хийд

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°19'12.7" E 104°00'32.5" Alt: 1319

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс урагш 15 км-т Онгийн голын эрэг дагуу Уулын хийд, голын хийдийн туурь бий.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутгаас нийт 16 дурсгалт газрын 241 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 100
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 73.
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 2.
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 60.
- Агуй – 1
- Эртний хот – 1
- Сүм хийд, барилга архитектурын дурсгал – 1
- Тахилын онгон – 2
- Байгалийн өвөрмөгц тогтоц бүхий газар – 1

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын 16 дурсгалт газрын нийт 241 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 5 дурсгалт газар буюу 31.25%
- Бага эрсдэлтэй – 5 дурсгалт газар буюу 31.25%
- Дунд эрсдэлтэй – 5 дурсгалт газар буюу 31.25%
- Их эрсдэлтэй – 1 дурсгалт газар буюу 14.28 %-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 16 дурсгалт газрын 241 дурсгалын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 1 буюу 14.28 %
- Суурьшлын бүс, газар олголт-1 буюу 6.25%
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 1 буюу 6.25%
- Байгалийн нөлөөлөл – 8 буюу 50%
- Тоногдсон – 2 буюу 12.5%
- Вандализм– 1 буюу 6.25%
- Мал шөргөөх- 2 буюу 12,5%

Хамгийн гол хүчин зүйлс нь Мал шөргөөх, байгалийн хүчин зүйл, тоногдсон гэсэн гурван нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутгаас нийт 241 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүтгэсэн бөгөөд үүнээс 23 тооны дурсгал шинээр илрүүлэв. Үүнд

- Монголын эзэнт гүрний үеийн булш-1
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр дурсгал 15
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал 4
- Агуй- 1
- Хадны зургийн дурсгал- 1

## Сайхан-Овоо сумын нутагт байх түүх, соёлын дурсгалт газрын зарим зураг



1. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Тамгат уулын хадны зураг.



4. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Шашрын хиргисүүр.




2. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Ноён хүрээний агуй.



5. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Зүүн шаширын хиргисүүр.



3. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Дунд шашир уулын хиргисүүр.



6. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Зараа хайрхны босоо хөшөө нэрт  
тахилын онгон.





7. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Баян-Өндөрийн хиргисүүр.



8. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Зээргэнтийн тахилын онгон.



9. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.

Зараа хайрханы цогцолбор дурсгал.



7. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Онгийн хийд.



8. Дундговь аймгийн Сайхан-Овоо сум.  
Тамагтын хиргисүүр.

## ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүү

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°26'53.8" E 105°55'23.6" Alt: 1302

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, XVII-XX зуун

**Төрөл:** Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг, XVII-XX зууны үеийн маанийн үсэг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Суурьшлын бүс, газар олголт

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэл уулын Зүүн билүүний аманд урагш харсан 5х3м хэмжээтэй хаданд морьтой хүн, янгир, могой болон маанийн үсэг бичээс байна.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүү

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°26'52.9" E 105°55'19.5" Alt: 1297

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэл уулын Зүүн билүүний голын хөндийд 8х5м хэмжээтэй дөрвөлжин булш оршино. Давхар хашлага чулуутай, голын хашлага чулуу тодорхой харагдаж байгаа боловч гадна талын зарим хэсгийн хашлага чулууг тараасан байдалтай байна.

### Дурсгал-3

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүүний хөндий

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°26'52.9" E 105°55'19.5" Alt: 1297

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэл уулын Зүүн билүүний голын хөндийд дурсгал-2-оос баруун урагш 10м зайд 4м радиус бүхий, хүрээгүй хиргисүүр, цагариг хэлбэрийн булш байна. Он цагийн хувьд хүрэл зэвсгийн үед хамаарна.

#### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүү

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°26'52.7" E 105°55'29.7" Alt: 1298

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:**

3. Дэл уулын Зүүн билүүний голын хойд хаданд урагш харсан 5м өндөр 4м өргөн хавтгай хаданд янгир, морьтой хүн, буга зэрэг амьтдыг дүрсэлжээ.
4. Уг дурсгалын доод талд цувраа 5 хавтгай чулуу босгож тавин дээр нь зураг сийлжээ. 2 дахь хавтгай чулуун дээр эр, эм адууг унаганы хамт дүрсэлсэн нь сонирхолтой байна.

#### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүүний Адгийн ус

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°25'38.2" E 105°55'53.7" Alt: 1275

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг, бичиг үсэг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зүүн билүүний Адгийн ус гэх газар үеийн сайрын баруун хаданд 2 газарт Хятад ханз бичээс, нэг газарт янгир болон тамга сийлсэн байна. Хятад бичээсийг он цагийг тодорхойлох боломжгүй байна. Янгир болон тамганы дүрслэл нь хүрэл зэвсгийн үед хамаарна.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Дэл уул, Баруун билүү

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°26'31.1" E 105°51'56.5" Alt: 1303

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, XVII-XX зуун

**Төрөл:** Хадны сийлмэл зураг, Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэл уулын Баруун билүүний хийд нь нийт 10 туурь бүхий шавар болон чулуун байгууламжтай. Хийдийн тууриуд нэлээд нурсан байдалтай байна. Уулын баруун аманд зүүн тийш харсан байдалтай орших ба тухайн үедээ томоохон хийдийн нэг байсан нь ойлгомжтой байна. Зүүн талаар жижиг гол урсах ба нэлээд нуугдмал, жижиг уулсаар хүрээлэгдсэн байна. Хийдийн баруун хадаар хүрлийн үеийн хадны зураг болон XVII-XX зууны үеийн маанийн үсэг бичээс нэлээд их байх ба ихэвчлэн янгир, буга зэрэг зэрлэг амьтдын дүрслэл тохиолдоно.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүүний адаг

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°25'42.7" E 105°51'59.6" Alt: 1269

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх



**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэл уулын Баруун билүүний адагт голын сайрын зүүн дэнж дээр цувраа 7 тооны дөрвөлжин булш оршино. Дундаж нь 8х4м хэмжээтэй, зарим хэсгийн чулуун хашлага нурсан байдалтай байна.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Дэл уул, 32 хүнт

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°27'11.7" E 105°53'09.2" Alt: 1355

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:**

1. Дэл уулын Зүүн билүүнд 4х4м хэмжээтэй 60см өндөртэй, 15см зузаантай хашлага чулуу бүхий дөрвөлжин булш оршино. Булшны зүүн хашлага дээр эр, эм 2 том буга, хашлага чулууны дээд талын хэсэгт 32 хүнийг цувраа байдлаар дүрсэлсэн байна. Уг булшнаас зүүн тийш 4м зайд хөшөө чулуу байх ба өндөр нь 50см, 40см, өргөн 15см зузаантай болно. Уг хөшөө чулууны нүүрэн талд дүрслэл байх ба мэдэгдэхгүй болон бүдгэрчээ. Ар талдаа эмжээртэй, баруун талдаа онгин тамгатай байна.
2. 32 хүнт гэх дөрвөлжин булшны хойд хаданд янгир, буга, адууг дүрсэлсэн байна. Түүний дээд талд 3 янгир, 2 үнэгийг сийлмэл аргаар дүрсэлжээ.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Ханангийн хяр

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°27'23.3" E 105°56'28.3" Alt: 1285

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Ханангийн хярын амны урагш харсан налуу хаданд бүлэг амьтдын дүрс байна. Янгир, буга, адуу, гэх мэт. Мөн нэг хаданд тэрэг дүрсэлсэн байх ба нэлээд том хэмжээтэй ажээ. Тэргэнд хоёр адуу хөллөсөн байдалтай нэг хүнийг дүрсэлжээ. Он цагийн хувьд Хүрэл зэвсгийн үед хамаарах сийлмэл зураг болно.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүүн, Онгоцон

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°28'32.8" E 105°54'03.6" Alt: 1339

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:**

1. 3х3м хэмжээтэй дөрвөн булангийн хашлага чулуу 50см орчим өндөр дөрвөлжин булш болно.
2. 2х2м хэмжээтэй 30см өндөр хашлага чулуу бүхий дөрвөлжин булш
3. 1х1м хэмжээтэй 20см өндөр хашлага чулуу бүхий дөрвөлжин булш
4. 3х3м хэмжээтэй дөрвөн булангийн хашлага чулуу 30см орчим өндөр дөрвөлжин булш болно.
5. 1-р дөрвөлжин булшны баруун хашлага чулууны гадна талын доод хэсэгт 23 хүн цувраа байдалтайгаар дүрсэлсэн байх бөгөөд зарим хэсэг нь элсний доор орсон байна. Зургийн хадгалалт муу, маш бүдгэрсэн байдалтай.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүүн, Онгоцон

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°28'30.1" E 105°54'28.6" Alt: 1345

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, хөшөө чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:**

1. Онгоцон гэх газар 3х2м хэмжээтэй 70см хашлага чулуу бүхий дөрвөлжин булш байна. Булшны зүүн талд 5м орчим зайд 20см өндөр, 10см зузаан, 40см өргөн хөшөө чулуутай. Хөшөө чулуунд ямар нэгэн дүрслэл байхгүй.
2. 1-р дурсгалын урд талд 1х1м хэмжээтэй 20см хашлага чулуу бүхий дөрвөлжин булш байна. Булшны зүүн талд 5м орчим зайд 15см өндөр, 10см зузаан, 30см өргөн хөшөө чулуутай. Хөшөө чулуунд ямар нэгэн дүрслэл байхгүй.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүүн, Баруун шивээ

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°28'04.5" E 105°57'09.3" Alt: 1307

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэл уулын Зүүн билүүний Баруун шивээ гэх газарт 3 хэсэг хаданд Бар, янгир, хүн, унагатай адууг дүрсэлжээ.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Дэл уул, Зүүн билүүн, Ханангийн дэрс

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°27'31.4" E 105°56'41.1" Alt: 1306

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хангийн дэрс хэмээх газарт нэлээд таруу хадны зургууд байна. Янгир, адуу, буга, тэрэг, зэрлэг амьтад, болон нэгэн хаданд зураасан хэлбэрээр зурсан 3 тооны монгол гэр байна.

#### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Өлзийтийн хуудас

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°27'07.4" E 105°58'31.5" Alt: 1304

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Аж ахуйн нөлөөлөл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэл уулын Өлзийтийн хуудас гэх газарт бүлэг хадны зураг оршино. Сонирхолтой дүрслэлүүд болох бар, зэрлэг амьтад, тэрэг, мөн тамга тэмдгүүд байна. Хүний буруутай үйл ажиллагаанаас болж нэлээдгүй сүйдсэн байдалтай.

#### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Чулуун сүм

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°20'10.4" E 106°01'52.9" Alt: 1208

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тагт багийн нутаг, Хөнжлийн уулын ард, Дэл уулын өвөрт 14x14м хэмжээтэй, 3-4м өндөр, 60см зузаан өрлөгтэй, дөрвөлжин чулуун байшин байна. Эргэн тойрон жижиг хийдийн туурь байсан ул мөртэй, хүрэн бор ваарны хагархай элбэг олдож байв. Он цагийг нарийн тодорхойлох боломжгүй бөгөөд нутгийнхны ярьж буйгаар хуучны 18-р зууны жасын туурь байсан гэнэ.

## Дурсгал-16

**Газрын нэр:** Морьтын хиргисүүр

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°16'42.8" E 105°59'37.1" Alt: 1306

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тагт багийн нутаг Дэл, Хөнжлийн уулын голд хааш хаашаа харуйц сайтай жижиг толгод дээр 10м радиус бүхий 1,3м өндөр чулуун овоолготой хүрээгүй хиргисүүр оршино.

## Дурсгал-17

**Газрын нэр:** Далай хийд

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°12'42.0" E 106°03'10.2" Alt: 1335

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоносон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тагт багийн нутаг Хөнжлийн уулын урд Өмнөговь аймгийн Манлай сумын хилийн зааг дээр Далай хийд хэмээх газар бий. Хуучнаар Хуралтын хийд гэх ажээ. Тус газар 10 гаруй байшинтай томоохон хийдийн нэг байсан бөгөөд мөнх туурийг доош нь ухаж тоносон байдалтай. Уг газар нь нилээд өндөрлөг газар орших бөгөөд голоор нь үерийн сайрын жалгатай ба 2 талаар нь хийдийн тууриуд байрлана. Шар болон хөх тоосгон өрлөгтэй хуучны хийдийн нэг болно. Уг газар өмнө судалгаа хийгдээгүй бөгөөд дэл уулнаас урагш 50 орчим км зайтай ажээ.

### **Дурсгал-18**

**Газрын нэр:** Дэл уулын Зүүн шивээгийн бууц

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°27'58.8" E 105°57'32.9" Alt: 1297

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тагт багийн нутаг Дэл уулын Зүүн шивээгийн бууцны ар хаданд ганц ширхэг хас тэмдэг байх бөгөөд түүний урд 1x1м хэмжээтэй жижиг тахилын байгууламжтай.

### **Дурсгал-19**

**Газрын нэр:** Цагаан толгой, Замын сүүж

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°34'41.8" E 106°04'21.1" Alt: 1224

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоносон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Тагт багийн нутаг Цагаан суваргаас зүүн тийш 20 орчим км зайд зүүн тийш харсан уулын аманд 3 тооны хиргисүүр байсныг орчин цагт механизм ашиглан тоножээ. Маш том том чулуунуудтай, гүнзгий ухсан байдалтай байна. Одоогоор булш байсан гэх ул мөргүй, уул уурхайн олборлолт явуулсан мэт харагдана.

### **Дурсгал-20**

**Газрын нэр:** Муруй цагаан сүүж

**Баг:** Тагт

**Солбицол:** N 44°36'27.1" E 106°12'24.2" Alt: 1171

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Муруй цагаан сүүж уулын баруун өвөрт зүүн урдаас баруун хойш чиглэсэн байдалтай 10 тооны дөрвөлжин булш байна. Түүний урд дэвцэг дээр 2 тооны булшийг механизм ашиглан тоносон байдалтай.

### **Дурсгал-21**

**Газрын нэр:** Талын жас

**Баг:** Буянт

**Солбицол:** N 44°47'41.0" E 106°50'58.9" Alt: 1060

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Буянт багийн нутаг Өлзийт сумаас зүүн урагш 50км зайд Талын ус гэх газарт Талын жас хэмээх хийдийн туурь оршино. Нийт 7 байшингийн туурь байх ба голд байрлах туурь бүтэн шахуу хадгалагдан үлджээ. Уг туурь нь 10x10м хэмжээтэй, 2,5м өндөр, шар шавран байшин болно. Дээд хэсгээрээ нурж эвдэрсэн байдалтай. Бусад туурь нь зөвхөн суурь нь үлдсэн байна.

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Хөтлийн булш, Баруун өөш

**Баг:** Буянт

**Солбицол:** N 44°41'32.6" E 106°57'55.6" Alt: 1061

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Шоргоолжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:**

1. Буянт багийн нутаг Баруун өөш гэх газрын үзүүрт 2 ширхэг булш оршино. 2,5х2,5м хэмжээтэй, баруун хойд хэсгийн хашлага өндөр хөшөө чулуутай дөрвөлжин булш.
2. 1-р дурсгалын чанх хойно 4,5х2,5м хэмжээтэй намхан чулуун дараастай шоргоолжин булш оршино.

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Зүүн өөш

**Баг:** Буянт

**Солбицол:** N 44°41'32.9" E 107°00'40.3" Alt: 1038

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замын ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Буянт багийн нутаг Зүүн өөш гэх газарт 2х2м хэмжээтэй, зүүн талын хашлага бүтэн бусад талын хашлага унасан байдалтай дөрвөлжин булш байна..

### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Хөтлийн хийд

**Баг:** Буянт

**Солбицол:** N 44°40'39.4" E 107°01'35.6" Alt: 1053

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Буянт багийн нутаг Хөтөлийн усны урд аманд, уулын өвөр талдаа 3 хэсэг газарт хийдийн туурь байна. Уг туурь нь энэ хавийн хамгийн том хийд байсан бөгөөд 25 орчим барилгатай, харьцангуй сайн хадгалагдан үлдсэн тууриуд байна. Төв



хэсгийн барилгын тууриуд нь 30м орчим урдаас хойш сунаж тогтсон залгаа байх ажээ. Олон өрөө тасалгаатай. Хийдийн тууриуд нь шар шавран тоосгон өрлөгүүдтэй болно.

### **Дурсгал-25**

**Газрын нэр:** Сайн билүүн

**Баг:** Дэрт-2

**Солбицол:** N 44°39'35.4" E 106°43'09.1" Alt: 1158

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэрт-2 багийн нутаг Сайн билүүн гэх хуудаслаг цагаан занар чулуутай 3 хэсэг таран байрласан хад оршино. Уг газарт маш олон хадны зургууд байх ба бүх цаг үеийн бичээснүүд байна. Энэхүү газар урьд өмнө бүртгэгдэж байгаагүй бөгөөд зургуудын болон бичээсний хувьд маш их муудсан, сүүл үед бичигдсэн Монгол, Төвөд бичээснүүдээс бусад нь бүдгэрч устах аюулд орсон. Эрт үеийн олон мөр бүхий Монгол бичгээс гадна хүрэл зэвсгийн үеийн хадны сонирхолтой зургууд олон байна.

### **Дурсгал-26**

**Газрын нэр:** Цагаан хадны хийд

**Баг:** Буянт

**Солбицол:** N 44°57'40.6" E 106°21'58.5" Alt: 1255

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Өлзийт сумын төвөөс зүүн тийш 5км зайд 12 барилгын туурь бүхий хийд оршино. Зөвхөн суурь нь мэдэгдэх бөгөөд ямар нэгэн өрлөг ажиглагдахгүй байна.

### **Дурсгал-27**

**Газрын нэр:** Цагаан хад

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°02'30.2" E 106°25'47.2" Alt: 1277

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Өлзийт сумаас 15км зайд Гурвансайхан сум орох замд, баруунаас зүүн тийш чиглэсэн 6ш Хүннү булш оршино. Уг газар нь өмнө нь бүртгэгдэж байгаагүй бөгөөд 4-10м голчтой харилцан адилгүй хэмжээтэй 5 булш нь цувраа байрлалтай 1 булш нь урд нь байрлажээ. Эдгээр булшнуудаас бидний дугаарласны 5-р булшийг тоносон байдалтай байна.

### **Дурсгал-28**

**Газрын нэр:** Хар тойром

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°15'14.5" E 106°29'51.4" Alt: 1261

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хар тойром гэх газар зам дагуу 2,5м голтой чулуун хүрээгүй хиргисүүр оршино.

### **Дурсгал-29**

**Газрын нэр:** Хар тойром

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°15'44.5" E 106°29'45.5" Alt: 1256

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Шоргоолжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хар тойром гэх газар уул уурхайн ашиглалтын талбайн ойролцоо уулын урд энгэрт 2,5х2м хэмжээтэй жижиг шоргоолжин булш оршино.

### **Дурсгал-30**

**Газрын нэр:** Хар тойром

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°15'44.5" E 106°29'45.5" Alt: 1256

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хар тойром гэх газар уул уурхайн ашиглалтын талбайн ойролцоо уулын урд энгэрт Дурсгал-29-аас зүүн талд 20м голчтой том чулуун дараас бүхий хиргисүүр оршино.

### **Дурсгал-31**

**Газрын нэр:** Хар тойром

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°19'41.2" E 106°32'22.8" Alt: 1199

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, хадны зураг, Хүннү булш, Монголын эзэнт гүрний үеийн булш, тахилын байгууламж

**Эрсдэлийн хүчин зүйл:** Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Үнст худгийн уурхайн талбайтай залгаа Далан, Бага ноён, Бойбор, Таван хар, Өгөөмөр зэрэг галт уулын гаралтай хүрмэн чулуун бөмбөгөр уулс бий. Тал дээр байрлах эдгээр уулс нь хар өнгөтэй учир содон харагдана. Эдгээр уулсын ойролцоо 128 дурсгал байх ба бүх цаг үед хамаарна.

### **Дурсгал-32**

**Газрын нэр:** Үнст худаг

**Баг:** Буянт

**Солбицол:** N 45°19'40.3" E 106°32'39.4" Alt: 1203

**Он цаг:** Неолит, Хүннүгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Чулуун зэвсгийн дурсгал, Хүннү булш, Монголын эзэнт гүрний үеийн булш, тахилын байгууламж

**Эрсдэлийн хүчин зүйл:** Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Үнст худгийн уурхайн талбайтай залгаа Ноён уулын зүүн хормойд 6 хүннү булш, 4 монгол булш, 1 он цаг тодорхойгүй булш байна. Мөн уулын эргэн тойрноос неолитын үеийн чулуун зэвсгийн ялтас, залтас, үлдэц ихээр олдож байгаа нь шинэ чулуун зэвсгийн бууц суурин байсныг илтгэнэ.

Дундговь аймгийн Өлзийт сумын нутгаас нийт 32 дурсгалт газрын 213 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Чулуун зэвсгийн бууц - 1
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 36
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 49
- Хүрэл зэвсгийн үеийн шоргоолжин булш - 2
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 17
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 24
- Хүннүгийн үеийн булш – 52
- Хөшөө чулуу - 1
- Сүм хийд, барилга архитектурын дурсгал – 6
- Тахилын онгон – 2
- Бичиг үсгийн дурсгал - 3

- Түүхэн үе, он цаг нь тодорхойгүй булш оршуулгын дурсгал – 20

Дундговь аймгийн Өлзийт сумын 32 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 7 дурсгалт газар буюу 21,9%
- Бага эрсдэлтэй – 7 дурсгалт газар буюу 21,9%
- Дунд эрсдэлтэй – 9 дурсгалт газар буюу 28,1%
- Их эрсдэлтэй – 9 дурсгалт газар буюу 28,1%-ийн үзүүлэлттэй гарч

байна.

Дундговь аймгийн Өлзийт сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 32 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:


- Эзэнгүйдэл – 8 буюу 24,2 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 10 буюу 33,3%
- Тоногдсон – 2 буюу 6%
- Мал шөргөөх - 5 буюу 15,1%
- Ашигт малтмалын ашиглалтын ажиллагаа - 4 буюу 12,1%
- Вандализм – 1 буюу 3%
- Суурьшлын бүс, газар олголт - 1 буюу 3%
- Аж ахуйн нөлөөлөл – 1 буюу 3%

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, Орон нутгийн чанартай замд ойр, мал шөргөөх гэсэн гурван нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Өлзийт сумын нутгаас илрүүлэн бүртгэсэн 213 тооны түүх, соёлын дурсгалаас 148 тооны дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр – 2
- Хадны бичээс -1
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 10
- Хадны зургийн дурсгал – 7
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 72
- Хүрэл зэвсгийн үеийн шоргоолжин булшны дурсгал – 1
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 54
- Он цаг тодорхойгүй булш оршуулгын дурсгал – 1.

## Өлзийт сумын нутагт байх түүх, соёлын дурсгалт газрын зарим зураг



1. Дэл уул, Зүүн билүүний хадны зураг



4. Дэл уул, Зүүн билүүний булш



2. Дэл уул, Зүүн билүүний булш



5. Дэл уул, Зүүн билүүний хадны зураг



3. Дэл уул, Зүүн билүүний булш



6. Дэл уул, Зүүн билүүний хадны зураг, ханз бичээс





7. Дэл уул, Баруун билүүний хийдийн туурь



11.Ханангийн хяр



8. Дэл уул, Баруун билүүний адаг



12.Дэл уул, Зүүн билүүн, Онгоцон



9. Дэл уул, 32 хүнт  
10.



13.Дэл уул, Зүүн билүүн, Онгоцон дөрвөлжин  
булш





14. Дэл уул, Зүүн билүүн, Баруун шивээ



17. Чулуун сүм



15. Дэл уул, Зүүн билүүн, Ханангийн дэрс



18. Морьтын хиргисүүр



16. Өлзийтийн хуудас



19. Далай хийдийн туурь





20. Дэл уулын Зүүн шивээгийн бууц



23.Талын жас



21.Цагаан толгой, Замын сүүжний тоногдсон хиргисүүр



24.Хөтлийн булш, Баруун өөш



22.Муруй цагаан сүүжний булш



25.Зүүн өөш



26.Хөтлийн хийд



28.Цагаан хадны хийдийн туурь



27.Сайн билүүн



29.Цагаан хадны хүннү булш

## ӨНДӨРШИЛ СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Хүр нүдэн-1

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°25'56.7" E 107°59'25.6" Alt: 1094

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хүр нүдэн хэмээх газрын энгэрт байрлах зэл чулуун дурсгал. 11 тооны чулууг зүүнээс баруун тийш чиглүүлсэн 1 эгнээ зэл чулуу дурсгал байна. Шинээр бүртгэсэн. Жижиг намхан чулуудаас бүрдэнэ.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Хүр нүдэн-2

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°26'09.0" E 107°59'54.0" Alt: 1093

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хүр нүдэнгийн энгэрт байх дурсгал-1-ээс зүүн тийш 1 км орчим зайд байрлах 2 эгнээ зэл чулуун дурсгал. Хойд талын эгнээ нь 10 босоо цувраа чулуутай бөгөөд 6 болон 7, 9-р чулуутай зэрэгцээ жижиг чулууг зэрэгцүүлэн босносон байна. Урд талын эгнээ 23 тооны чулууг 50 гаруй метр зайд босгож цувуулан тавьсан зэл булуун дурсгал байна.



### Дурсгал-3

**Газрын нэр:** Хөх дөрөлж

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°21'34.0" E 108°05'04.0" Alt: 1090

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хөх Дөрөлжийн баруун урд энгэрт байрлах цагираг хэлбэрийн чулуун дараастай Хүннүгийн үеийн жирийн иргэдийн булштай дурсгалт газар. 5 тооны булш оршуулгын дурсгал байна. Шинээр илрүүлэн бүртгэсэн.

### Дурсгал-4

**Газрын нэр:** Улаан хуц хайрхан

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°13'32.8" E 108°14'11.0" Alt: 1163

**Он цаг:** Хүннүгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хүннү булш, Монголын үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун тийш 5 орчим км зайд байх Улаан хуц хайрхны энгэрт байх цагираг хэлбэрийн чулуун дараастай бүлэг булштай дурсгалт газар. Нийт 8 тооны булш оршуулгын дурсгал байхаас 6 тооны хүннү булш нэг газарт бүлэг хэлбэрээр оршино. Хүннү булшнаас зүүн тийш жалгын эхэн дээр 2 тооны Монголын эзэнт гүрний үеийн булш байна.

### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Ханангийн овоо

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°14'57.4" E 108°13'39.6" Alt: 1170

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Орон нутгийн замд ойр, Тонуулчид

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун тийш 6-7км орчим зайд Ханангийн овооны урд энгэрт байрлах цагираг хэлбэрийн чулуун дараастай бүлэг булштай дурсгалтай газар. Хүннүгийн үеийн жирийн иргэдийн бүлэгт хамаарах 11 тооны булш оршуулгын дурсгал байна. Хамгийн баруун талын нэгэн булшыг саяхан тонуулчид тонож ухсан. Энэ бүлэг дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Бөхтийн цагаан хад

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°13'28.3" E 108°15'34.0" Alt: 1175

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш,

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун тийш 3-4км орчим байх Бөхтийн цагаан хад хэмээх орой дээрээ том хадан тогтоцтой цагаан өнгийн хадан чулуутай уулын энгэрт байрлах том том чулуугаар цагираг хэлбэрийн чулуун дараас үйлдсэн Хүннүгийн үеийн 3 тооны булштай дурсгалт газар. 1-р булш 3м голчтой, 2-р булш 5м голчтой, 3-р булш 5м голчтой баруун дээд талаас нь дугаарлан бүртгэсэн.

## Дурсгал-7

**Газрын нэр:** Улаан хуц-2

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°13'08.1" E 108°13'15.1" Alt: 1151

**Он цаг:** Хүннүгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хүннү булш, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Улаан хуц хайрханы энгэр бэлээр орших бүлэг дурсгалууд

- N 45°13'08.1" E 108°13'15.1" Alt: 1151. Улаан хуц хайрханы зүүн энгэрт байх 3 тооны Хүннү булштай дурсгалт газар
- N 45°12'54.6" E 108°12'57.9" Alt: 1135. Урд энгэрийн Монголын эзэнт гүрний үеийн булштай дурсгалт газар нийт 10 тооны булш оршуулгын дурсгал байна.
- N 45°13'08.4" E 108°12'56.3" Alt: 1154. Зүүн энгэрт орших 6 тооны Монголын эзэнт гүрний үеийн 6 тооны булш оршуулгын дурсгалтай газар.

## Дурсгал-8

**Газрын нэр:** Аврах уулын зүүн хөндий

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°13'33.6" E 108°03'02.0" Alt: 1074

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, байгаль, мал амьтны нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Аврах хайрханаас зүүн тийш 2 км орчим зайд томоохон хөндий байх бөгөөд хөндийд байх жижиг хадан тогтоцын урд энгэрт орших гадаад зохин байгуулалт эвдэгдсэн цөөн тооны чулуун дараасаар танигдах дөрвөлжин булшны дурсгал. Уг нэг дөрвөлжин булшыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Аврах уулын зүүн хойд ар

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°13'42.8" E 108°01'51.0" Alt: 1086

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Тахилгын байгууламж

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Аврах уулын зүүн хойд ар дээр чандмалан босгосон 3 босоо чулуун байгууламж. Он цаг, төрөл хэлбэр нь тодорхойгүй тахилын зориулалттай бололтой.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Аврахын хийд-Далай хийдийн туурь

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°13'37.5" E 108°01'45.4" Alt: 1079

**Он цаг:** XVII-XX зуун, 1771 онд байгуулагдсан

**Төрөл:** Сүм хийд, барилга архитектурын байгууламж

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Орон нутгийн замд ойр, Сүсэг бишрэл, мал шөргөөх, тонуулчид ухах гэх мэт олон хүчин зүйлс нөлөөлсөн

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Аврахийн хийд хэмээн уулын нэрээр нутгийнхан нэрлэнэ. Гэхдээ албан ёсны сурвалж нэр нь Далай хийдийн туурь 1771 онд Аврах уулын Улаан овоо хэмээх тахилгатай овоот уулын урд энгэрт байрлах олон тооны сүм хийдийн чулуун болон тоосгон тууриудтай. Улаан овоог одоо ч нутгийнхан тахилга үйлддэг. Хийдийн туурин дээр хөх зөн, шатаагүй тоосго, чулуун туйртай. Хагас дутуу нурсан нэг барилгын үлдэлтэй байна.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Аврахын хийдийн баруун толгод

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°13'35.0" E 108°00'56.3" Alt: 1080

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Аврахийн хийдээс баруун тийш 1 км орчим зайд жижиг ухаа толгодын дунд орших цагираг хэлбэрийн чулуун дараастай Хүннү булш байна. 9 метр голчтой чулуун дараастай. Уг дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Дэлгэр овоо

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°09'55.0" E 107°55'23.0" Alt: 1072

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэлгэр овооны зүүн урд бэлд байх 16 тооны чулууг 57 метр газар цувруулан зэллэн босгосон.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Шар хад

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°16'21.1" E 107°59'11.5" Alt: 1175

**Он цаг:** Хүннүгийн үе, Түрэгийн үе



**Төрөл:** Хүннү булш, Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шар хадны баруун хойд талын хүрэн хадан толгойн энгэрт 2 тооны Хүннү булш байна. Түүнээс зүүн урд 27 чулууг 65 метр газарт зэллэн зоосон зэл чулуун дурсгал байна.

- N 45°16'19.8" E 107°59'11.1" Alt: 1175. 5,2м голчтой цагираг хэлбэрийн чулуун дараастай Хүннү булш.
- N 45°16'19.0" E 107°59'08.2" Alt: 1179. 3,5м голчтой цагираг хэлбэрийн чулуун дараастай Хүннү булш.
- N 45°16'21.1" E 107°59'11.5" Alt: 1175. Зэл чулуун дурсгал

#### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Элст

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°14'24.3" E 107°58'51.9" Alt: 1109

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, тонуулчидын ул мөр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шар өндрийн баруун талын Баруун Өндөрийн энгэр газрыг Элст хэмээн нэрлэх бөгөөд уг газарт 6 тооны Хүннү булш байна. 1-р булш 5,2 метр голчтой, 2-р булш тоногдсон, 6м голчтой чулуун дараастай. 3-р булш 7,3м голчтой хамгийн том чулуун дарсаатай булш, 4-р булш 4,5м голчтой, 5-р булш 4м голчтой тоногдсон байдалтай, 6-р булш 4м голчтой чулуун дараастай.

#### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Элст-2

**Баг:** Цог

**Солбилцол:** N 45°14'24.6" E 107°58'52.3" Alt: 1109

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Орон нутгийн замд ойр, Байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Элстийн дурсгалаас урд зүгт 1км гаруй зайд дэрстэй хөндийд байрлах 3 тооны Хүннү булштай дурсгалт газар. 3 булш нь нэг дор бүлгээр орших бол нэг нь арай зайдуу дэрс хотгорт байрлах аж. Энэхүү 4 булш оршуулгын дусгалыг шинээр илрүүлэн бүртгэв.

### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Хүрэн Дэл

**Солбилцол:** N 45°07'59.3" E 108°14'29.2" Alt: 1112

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хүрэн Дэл хэмээх дээрээ овоотой жижиг толгойн энгэрт байрлах 4 тооны булш оршуулгын дурсгалтай газар. Цагираг хэлбэрийн чулуун дараас үйлдсэн. Газрын хамгийн доод талаас дээш нь дугаарлан бүртгэсэн. 1-р булш 4,3м голчтой, 2-р булш 4,2м голчтой, 3-р булш 5м голчтой, 4-р булш 5,2м голчтой чулуун дараастай. Хүрэн Дэлийн хар хадан толгойн ар бэлд мөн нэг тооны Хүннү булш байна. N 45°08'15.6" E 108°14'23.0" Alt: 1116. 6м голчтой цагираг хэлбэрийн чулуун дараастай. Энд нийт 5 тооны булш оршуулгын дурсгал байна.

### **Дурсгал-17**

**Газрын нэр:** Хүнгэнээ

**Солбилцол:** N 45°07'20.3" E 108°16'31.6" Alt: 1111

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хүнгэнээгийн энгэрт байрлах 17 тооны чулууг зэллэн 60 орчим метр зайд баруунаас зүүн тийш цувруулан зэллэн зоосон.

### **Дурсгал-18**

**Газрын нэр:** Тас хайрхан

**Солбилцол:** N 45°07'41.1" E 108°24'48.0" Alt: 1079

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булшны дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, тонуулчдын ул мөр, мал амьтан шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урд зүгт 15 км зайд байх Тас хайрханы урд энгэрийн жижиг толгодын энгэр бэл, ав өврөөр олон тооны дөрвөлжин булшны дурсгал байх бөгөөд зарим нь тоногдсон нийт тодорхой мэдэгдэж байгаагаар 17 тооны дөрвөлжин булш байна.

### **Дурсгал-19**

**Газрын нэр:** Бумбагар

**Солбилцол:** N 45°13'29.9" E 108°18'20.2" Alt: 1169

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн тийш 1км зайд байх Бумбагар хэмээх газарт тодорхой мэдэгдэж байгаагаар 14 тооны чулуун цувуулан 50 гаруй метр зайд зэллэн зоосон дурсгалт газар юм.

### **Дурсгал-20**

**Газрын нэр:** Эхэн Хөх

**Солбилцол:** N 45°26'33.0" E 108°23'53.0" Alt: 1170

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Хадны зураг, бичээсийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн хойш 30 орчим км зайд байх Эхэн хөх амны зүүн талын хадтай толгойн урд энгэр, зүүн хажуу, оройгоор нь хадны налуу хавтгай дээр олон тооны маанийн үсэг, тамга тэмдэг, монгол бичиг, 2 хэсэг газар морь дүрсэлсэн байна.

### **Дурсгал-21**

**Газрын нэр:** Хөтөл хад

**Солбилцол:** N 45°28'40.7" E 108°18'36.0" Alt: 1214

**Он цаг:** Тодорхойгүй /Хүрэл, Хүннү, Түрэг гэх мэт олон үед хамаарах боломжтой/

**Төрөл:** Хадны зураг, бичээсийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс хойш 27км зайд, сумын төвөөс Чойр явах замын хойд талын Хөтөд хэмээх олон тооны мөлхөө хөх хадтай газарт тамга тэмдэг болон маанийн үсэг дүрслэгдсэн. Хадны онцлог байгалийн нөлөөлөөс болж зураг бүдгэрсэн. Мөн хаднууд жижиг намхан, мөлхөө тул мал амьтны нөлөөлөөр устаж бүтгэрэх эрсдэлтэй дурсгалт газар юм.

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Хөтөл толгод

**Солбилцол:** N 45°29'48.6" E 108°18'05.0" Alt: 1198

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хөтөлийн хаднаас баруун хойш 2км орчим зайд толгодын дундах хадан тогтоцтой толгойн урд энгэрт нийт тодорхой мэдэгдэж байгаа 33 тооны чулууг

баруун урдаас зүүн хойш 100 гаруй метр зайд цувруулан зэллэн зоосон тэгэхдээ зарим чулуудыг зэрэгцүүлэн 2 болон 3 чулууг хамтад нь босгосон байна.

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Хараат уул

**Солбилцол:** N 45°40'30.9" E 108°31'02.4" Alt: 1165

**Он цаг:** Палеолит, Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зосон зураг, Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хараатын уурхайн хашаа болон хашааны гадна зүүн талаараа хүрэл зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булштай. Мөн хашааны зүүн талын хадны энгэрт зосон зургийн дурсгалтай дурсгалт газар. Энд зосон зургийн дурсгалт газар нэг, дөрвөлжин булшны дурсгал 11 тооны дурсгал байна.

- N 45°40'30.9" E 108°31'02.4" Alt: 1165. Хараатын сүүл толгойн зосон зургийн дурсгал
- N 45°40'30.6" E 108°31'01.8" Alt: 1166. Зосон зурагтай хадны урд бэлд байх дөрвөлжин булшны дурсгалт газар 2 тооны дарвалжин булш байна. Нэг нь тоногдож хэмжээ зохион байгуулалт тодорхой бус болсон. Нэг нь 6м X 3,5м хэмжээтэй
- N 45°40'33.5" E 108°30'58.5" Alt: 1160. Хараатын уурхайн хашаан дотор 8 тооны дөрвөлжин булшны дурсгал байна. Мөн хашааны гадна зүүн урд буланд 1 тооны дөрвөлжин булш байна.

### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Мухар булаг

**Солбилцол:** N 45°39'52" E 108°29'19" Alt: 1165

**Он цаг:** Палеолит, Түрэгийн үе

**Төрөл:** Чулуун зэвсгийн дурсгал, Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Уурхайн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Мухар булаг хэмээх Сумын төвөөс зүүн хойш 50 гаруй км зайд орших булгийн хойд овооны энгэр бэлээр чулуун зэвсгийн үлдэцтэй. Овооны урд энгэрт зэл чулуун дурсгалтай газар юм.

Дундговь аймгийн Өндөршил сумын нутгаас нийт 24 дурсгалт газрын 105 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Чулуун зэвсгийн дурсгалт газар – 1.
- Хадны зосон зургийн дурсгал - 1
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 29.
- Хадны сийлмэл зураг – 1
- Хадны бичээсийн дурсгал – 1.
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал - 18
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 44.
- Сүм хийд, барилга архитектурын төрлийн дурсгал – 1.
- Зэл чулуун дурсгал – 8.
- Он цаг, төрөл тодорхойгүй дурсгал – 1.

Дундговь аймгийн Өндөршил сумын нутгаас нийт 24 газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 11 дурсгалт газар буюу 45.8%
- Бага эрсдэлтэй – 3 дурсгалт газар буюу 14.15%
- Дунд эрсдэлтэй – 7 дурсгалт газар буюу 25.9%
- Их эрсдэлтэй – 3 дурсгалт газар буюу 14.15%ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Өндөршил сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 24 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 9 буюу 37.5 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 6 буюу 25%
- Байгалийн нөлөөлөл – 4 буюу 16.6%
- Тоногдсон – 4 буюу 16.6%
- Сүсэг бишрэл– 1 буюу 4.3 %

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, орон нутгийн замд ойр, тонуулчид, байгалийн нөлөө гэсэн нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Өндөршил сумын нутгаас 105 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн бөгөөд үүний 19 тооны дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэсэн. Үүнд: Хүннү булш 17, дөрвөлжин булшны дурсгал 1, зэл чулуун дурсгал 1-ийг шинээр илрүүлэн бүртгэв.

## ХУЛД СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Булаг хайрхан

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 45°14'44.6" E 105°35'58.3" Alt: 1326

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр. Тоногдсон.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хулд сумаас зүүн хойш ойролцоогоор 4 км зайд хойноос урагш сунаж тогтсон Булаг хэмээх нутгийн шүтлэгт хайрхан байна. Уг Булаг хайрхны баруун урд энгэрт зэргэлдээ 2 дурсгал байна.

1. Дурсгал 1 нь засмал замаас 1км зайтай 13,50м голчтой хүрээгүй дугуй хэлбэрийн хиргисүүр юм. дараасны өндөр ойролцоогоор 1м өндөр. Хиргисүүрийг гол хэсгээс тоносон байна.
2. Дурсгал нэгийн урд 4м зайд 10м голчтой танилын байгууламж бүхий хиргисүүр. Гол хэсэгт 1,6м хэмжээтэй тонуулчдын нүх үлдсэн байна.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Булаг хайрхан

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 44°15'02.5" E 105°36'31.5" Alt: 1311

**Он цаг:** Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Булаг хайрхны зүүн хойд энгэрт 8 битүү чулуун дараас бүхий монгол булш байна. Уг дурсгалуудын 2 талаар үерийн шуудуу байх бөгөөд зарим дурсгал үерийн шуудуутай ойр байна. Эдгээр дурсгал хоорондын зай 1,5-2 м юм.



1. 6м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
2. 2,80м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
3. 2,90м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
4. 2,40м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
5. 3,65м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
6. 4,10м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
7. 2,80м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
8. 3,90м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.

### **Дурсгал-3**

**Газрын нэр:** Булаг хайрхан

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 45°14'59.7" E 105°36'31.4" Alt: 1341

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе,

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Булаг хайрхны зүүн энгэрт зэрэгцээ 10 дурсгал байна. Эдгээр нь битүү чулуун дараас бүхий 4 монгол булш, 1 хиргисүүр, 5 дөрвөлжин булш байна.

1. 3,50м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
2. 3,20м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
3. 3,25м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
4. 3,50м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш.
5. Эдгээр 4 дурсгалаас урагш 100м зайд 9,80м голчтой том чулуун дараас бүхий хиргисүүр. Зүүн болон зүүн хойд, зүүн урд талууддаа нийт 10 тахилын байгууламж байна. Тахилын байгууламжууд нь дунджаар 2,75м голчтой байна.
6. 5 дугаар дурсгалаас зүүн урагш 100м зайд 8х3,45м хэжээтэй дөрвөлжин булш. Дараас чулууд нэлээд сарнисан байдалтай байна.
7. 2,60х3,70м хэмжээтэй дөрвөлжин булш
8. 2,65х2,68м хэмжээтэй дөрвөлжин булш
9. Дөрвөн буландаа хөшөө чулуу бүхий 2,40х3м хэмжээтэй дөрвөлжин булш.
10. 3,10х3,30м хэмжээтэй дөрвөлжин булш

#### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Өвөлжөө хошууны бууц

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 45°14'06.1" E 105°38'52.9" Alt: 1341

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, Монголын эзэнт гүрний булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Өвөлжөө хошууны бууц хэмээх нэгэн хадтай жижиг уулын энгэрт нэгэн өвөлжөө байна. Уг өвөлжөөг тойроод цөөвтөр дурсгал байна.

1. Тус өвөлжөөнөөс урагш ойролцоогоор 800 зайд 10,30м голч бүхий хиргисүүр байна. Дараасын өндөр 1,50м хэмжээтэй. Хиргисүүрийн чанх урд 2,60м голчтой дугуй хэлбэрийн тахилын байгууламж байна. Хиргисүүр тоногдсон. Эдгээр дурсгал нь орон нутгийн замтай нэлээд ойр байна.
2. Хиргисүүрээс зүүн тийш ойролцоогоор 700 зайд зэргэлдээ 4 дурсгал байна. Баруун захын дурсгал нь 1,50м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш байна.
3. 1,30м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш байна.
4. 1,50м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш байна.
5. 2м голчтой битүү чулуун дараас бүхий монгол булш байна.

#### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Лусын хийдийн туурь

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 45°14'34.6" E 105°42'08.0" Alt: 1274

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн зүгт 12 орчим км, Бэлхнэгийн эргийн урд энгэрт Луусын хийдийн туурь байна.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Үйзэнгийн цохио

**Солбицол:** N 45°13'06.3" E 105°57'48.2" Alt: 1254

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шувуутай хийд явах зам дагуу Үйзэнгийн цохион хойд талд 5м голчтой цагариг хэлбэрийн Хүннү булш байна. Уг дурсгалын дараас чулуу эвдэгдээгүй байна.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Шувуутайн хийдийн туурь

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 45°12'25.9" E 105°59'24.7" Alt: 1230

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн тийш 34 км-т Шувуутай хайрхны баруун хойд хөндийд шувуутай хийдийн туурь бий. Хийд урд Сангийн-Овоо, Баруун талаар Үйзэнгийн цохио оршино.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Шарангадын бууц

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 45°09'39.6" E 105°59'31.3" Alt: 1200

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Шоргоолжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шарангадын агуйн зүүн урд Шарангадын бууцны хэмээх нэгэн бууц байна. Түүний урд хөлд дөрвөлжин булш, шоргоолжин булш 2 зэрэгцэн оршиж байна.

1. Дөрвөлжин булш нь 5,45х3 м хэмжээтэй, дөрвөн буландаа хөшөө чулуу бүхий дөрвөлжин булш юм. дөрвөлжин булшны голд тонуулчдын үлдээсэн 1,7м гүн нүх үлдсэн байна.
2. Дөрвөлжин булштай зэргэлдээ 5,40х3,30м хэмжээтэй шоргоолжин булш байна. Уг дурсгалын 2 талаар үерийн шуудуу байна.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Шарангадын агуй

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 45°09'48.7" E 105°59'16.1" Alt: 1228

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Агуйн бичээс

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урагш 40 орчим км-т Шарангад уулын Нүхэнгийн агуй байна. Агуйн урт 12 м, 2 м өргөн. Агуйн дотор хар бэхээр бичсэн монгол, түвд олон бичээс бий.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Шарангад

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 45°09'37.6" E 105°59'07.8" Alt: 1201

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Шарангад уулын энгэрт зэргэлдээ 2 дурсгал бий.

1. 4,40x4,60м хэмжээтэй дөрвөлжин булш байна. Дөрвөлжин булшний голд 2x2м хэмжээтэй тонуулчидын нүх үлдсэн байна.
2. 4,20x2,80м хэмжээтэй дөрвөлжин булш. Тонуулчид тоносон.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Хавтгай

**Баг:** Шувуутай баг

**Солбилцол:** N 45°09'09.1" E 105°56'12.1" Alt: 1203

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:**

Хавтгай хэмээх төмөрлөг бүхий хар уулын урд болон баруун хойд энгэрт зэргэлдээ 2 дөрвөлжин булш бий. Хавтгай хэмээх уулын баруун урд Үйзэнгийн ус хэмээх нэгэн жижиг нуур байна.

1. N 45°09'09.1" E 105°56'12.1" Alt: 1203 Уулын урд энгэр 2,70x2,70м хэмжээтэй дөрвөлжин булш. Тоногдсон.
2. N 45°09'26.3" E 105°55'47.0" Alt: 1209 Уулын баруун хойд энгэрт 3,60x2,70м хэмжээтэй дөрвөлжин булш. Тоногдсон.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Ширээт хайрхан

**Баг:** Шувуутай баг

**Солбицол:** N 44°09'36.3" E 105°51'47.7" Alt: 1245

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Үйзэнгийн усны хойд талд Ширээт хайрхан оршино. Ширээт хайрхны урд энгэр 2 дөрвөлжин булш бий.

1. 2,90x3,10м хэмжээтэй уулын том чулуудаар хүрээлэн үйлдсэн дөрвөлжин булш. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.
2. N 44°09'36.2" E 105°51'48.0" Alt: 1244. 2,10x2,30м хэмжээтэй дөрвөлжин булш. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Олдохын хийдийн туурь

**Баг:** 2-р баг

**Солбицол:** N 44°49'06.1" E 105°22'38.0" Alt: 1200

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун урагш 50 орчим км-т Олдохын усны урд Олдохын хийдийн туурь бий. Энд гудмалсан олон барилгын нурсан үлдэгдэл, түүхий болон хөх тоосго, барилгын вааран чимэглэлийн хагархай, ахуй сав суулганы хэсэг хөглөрнө.

### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Хулд уул

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°11'47.0" E 105°23'57.4" Alt: 1592

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хулд уулын зүүн урд, Улаан хадны ар зоонд 1 хиргисүүр, 1 дөрвөлжин булш байна. Улаан хадны баруун урд болон урд талаар Тээгийн хяр, баруун хойд талд Хулд уул оршино.

1. Улаан хадны ар зоонд 22x20м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, дөрвөн буландаа 2,70м голч бүхий тахилын байгууламжтай, 13,30м голчтой хиргисүүр бий. Дараасны өндөр 1,5м. Хиргисүүрийн чанх урд талд 3,30м голчтой тахилын байгууламж байхаас гадна мөн баруун болон зүүн талд тус тус 1 тахилын байгууламж байна. Хиргисүүр тоногдсон байдалтай.
2. N 45°11'47.4" E 105°23'57.2" Alt: 1593. Хиргисүүрийн чанх хойд талд 6.80x3.60м хэмжээтэй дөрвөлжин булш бий. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.

### **Дурсгал-15**

**Газрын нэр:** Хулд уул

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°11'49.9" E 105°22'47.7" Alt: 1514

**Он цаг:** Он цаг тодорхойгүй

**Төрөл:** Агуй

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хулд уулын баруун урд Зараа хадны урд талд 3,60м урт 1,7м өргөн агуй байна. Агуй нь дотроо 2 салаалсан байна. Нутгийн иргэдийн хэлж буйгаар энд хадны оршуулга байсан, хүний толгойн яс, эмээл зэрэг эд өлгийн зүйл гарч байсан гэлцэнэ. Агуйн амсар хэсэгт агуйн амсырыг хааж байсан болов уу гэлтэй хавтай сул чулууд их байна.

### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Баруун хөх тээг

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°09'06.1" E 105°26'46.0" Alt: 1412

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баруун хөх тээг хэмээх хадтай хөх уулын урд энгэрт 1 хүннү булш, 1 дөрвөлжин булш байна. Баруун хөх тээгийн зүүн урд Баясгалант хайрхан, хойд талд нь Цагаан толгой хэмээх цагаан чулуутай өндөр уул байна.

1. 3х3,50 хэмжээ дөрвөн буландаа хөшөө чулуу бүхий дөрвөлжин булш байна. Тус дөрвөлжин булшны голд тонуулчдын ул мөр үлдсэн байна.
2. Дөрвөлжин булшны урд талд зэргэлдээ 2,79м голчтой хүннү булш бий. Хүрээ чулуу нэлээд эвдэгдсэн байна.

### **Дурсгал-17**

**Газрын нэр:** Зүүн хөх тээг

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°09'06.6" E 105°26'36.4" Alt: 1413

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зүүн хөх тээгийн урд энгэрт 4 дөрвөлжин булш, 1 хиргисүүр бий. Эдгээр дурсгалыг баруун талаас нь 1 гэж дугаарлав.

1. Эдгээр дурсгалын хамгийн баруун талд нь байрлах бөгөөд 3,70х2,10м хэмжээтэй дөрвөлжин булш бий. Дурсгалын хүрээ чулууд бага зэрэг элсэнд дарагдсан байдалтай байна.
2. 1-р дурсгалтай зэрэгцээ байрлах 2,70х2,30м хэмжээтэй дөрвөлжин булш бий. Дараас болон хүрээ чулууд баг зэрэг мэдэгдэж байна.
3. 4,10х2,50м хэмжээтэй дөрвөлжин булш.
4. 3,80х3,70м хэмжээтэй дөрвөлжин булш. Элсэнд дарагдаж мэдэгдэхгүй болсон байна.
5. Эдгээр дөрвөлжин булшны зүүн урд захад 6,65м голчтой, 1,50м өндөр дараас бүхий хиргисүүр бий. Хиргисүүрийн зохион байгуулалт сайн байна.



## Дурсгал 18

**Газрын нэр:** Бага цагаан овоо

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°09'04.2" E 105°29'22.0" Alt: 1379

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баясгалант хайрхны урд Бага цагаан овоо хэмээх нэгэн цагаан чулуу бүхий овоо байна. Түүний энгэрт нэгэн хиргисүүр бий. 30м голчтой дугуй хүрээтэй, 1,5-2м өндөр чулуун дараастай, 8,20м голчтой хиргисүүр бий. Хиргисүүрийн голд тонуулчдын ул мөр үлдсэн байна.

## Дурсгал-19

**Газрын нэр:** Цагаан жирим

**Баг:** Уулын 3-р баг

**Солбилцол:** N 45°09'24.7" E 105°27'38.2" Alt: 1416

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл, тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цагаан жирим хэмээх уулын урд зэргэлдээ 2 хиргисүүр байна. Эдгээр 2 дурсгалын зүүн талаас нь эхлэн дугаарлав.

1. 12x12м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, 10м голч бүхий дугуй хиргисүүр. Хиргисүүрийг зүүн хойд тал руу нь сэтлэн тоносон байна. Хиргисүүрийн урд талд 6, баруун урд талд 5, зүүн урд талд 2 тахилын байгууламж байна. Тахилын байгууламжийн хэмжээ ойролцоогоор 1,5-2 м голчтой байна.
2. 14x14м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, 12м голчтой хиргисүүр. Хиргисүүрийн баруун урд 5, зүүн урд 4, урд талд нь 1 тахилын байгууламжтай. Тахилын

байгууламж ойролцоогоор 1,5-2м хэмжээтэй. Зарим талын байгууламжийг тоносон байдалтай байна.

### **Дурсгал-20**

**Газрын нэр:** Балжавын бууц

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°10'19.9" E 105°26'40.6" Alt: 1477

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Балжавын бууц хэмээх газар зэргэлдээ хүрээгүй 2 хиргисүүр байна. Уг дурсгалыг баруун талаас нь эхлэн дугаарлав.

1. 9м голч бүхий хүрээгүй дугуй хэлбэрийн хиргисүүр. Зохион байгуулалт бага зэрэг эвдэгдсэн байдалтай байна.
2. 8,50м голчтой дугуй хэлбэрийн хиргисүүр. Хиргисүүрийн гол хэсэгт хонхойж, зохион байгуулалт эвдэгдсэн байна.

### **Дурсгал-21**

**Газрын нэр:** Ацат хүрэн

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°10'10.8" E 105°29'02.8" Alt: 1409

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Жирмийн цагаан уулнаа зүүн тийш ойролцоогоор 2км зайд Ацат хүрэн уулын зүүн урд энгэр хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүр, дөрвөлжин булшны бүлэг дурсгал бий. Эдгээр дурсгалыг баруун талаас нь дугаарлан тодорхойлолт үйлдэв.

1. 17м голчтой, 1,5м өндөр дараас бүхий хиргисүүр байна. Зүүн урд талдаа 2м голч бүхий 5 тахилын байгууламжтай. Дурсгалын зохион байгуулалт маш сайн мэдэгдэж байна.
2. N 45°10'11.8" E 105°29'05.2" Alt: 1405. Хэмжээний хувьд нэлээд том 47х50м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, дөрвөн буландаа тахилын байгууламжтай, голын дугуй чулуун овоолго нь 15м голчтой. Хиргисүүрийн голын дугуй овоолгын зүүн талд 11м урт 8м өргөн үүдэвчтэй байгаа нь ихээхэн сонирхол татаж байна. Үүдэвчний бол хиргисүүрийн гол хэсгээс тонуулчид тоносон байна. Хиргисүүрийн урд талдаа 9, баруун талдаа 1, хойд талдаа 6 зүүн талдаа 16 тахилын байгууламж бүхий хиргисүүр юм. Тахилын байгууламжийн голч дунджаар 2,5м байна. Эдгээр тахилын байгууламжуудын гадна талаар тойроод мөн 50 гаруй тахилын байгууламж байна.
3. N 45°10'14.8" E 105°29'03.8" Alt: 1413. 2 дугаартай дурсгалын чанх хойд талд 11м голч бүхий хиргисүүр бий. Хиргисүүрийн зүүн урд талд нь 3,5м голч бүхий тахилын байгууламж байна. Дурсгалын зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
4. N 45°10'15.8" E 105°29'04.6" Alt: 1411. 40х25м хэмжээтэй 1.5м өргөн дөрвөлжин хүрээ байна. Гэхдээ уг хүрээний голд ямар нэгэн байгууламж байхгүй байх бөгөөд баруун хойд талд 10м голч бүхий дугуй хэлбэрийн байгууламж бий. Эдгээрийн тойроод 10 гаруй тахилын байгууламж байна. Тахилын байгууламжийн заримынх нь зохион байгуулалт сайн мэдэгдэхгүй байна. Хүрээний зүүн болон баруун талд бага зэрэг газар тасарсан байгаа нь зүүн болон баруун талдаа хаалгатай мэт сэтгэгдэл төрүүлж байна. Тасархайн захыг том чулуугаар тусгаарлаж өгсөн байгаа нь ямар нэгэн зохион байгуулалт байгааг илтгэж байгаа юм.
5. N 45°10'19.8" E 105°29'01.9" Alt: 1423. 4 дугаартай дурсгалын хойд талд хадан дунд байрлах 7 голч бүхийн хиргисүүр. Хүрээ болон дагуул байгууламж байхгүй байна.
6. N 45°10'18.8" E 105°29'04.0" Alt: 1417 байрлалтай. 10м голч бүхий хиргисүүрийн дурсгал. Хүрээ болон дагуул байгууламж байхгүй байна.

7. N 45°10'19.8" E 105°28'45.9" Alt: 1427 байрлалтай. 4x2,60м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш.
8. N 45°10'21.7" E 105°28'42.9" Alt: 1422 байрлалтай. 7 дугаартай дурсгалын чанх хойд талд 25м голчтой дугуй хүрээтэй 15м голч бүхий хиргисүүр бий. Хиргисүүрийн тойроод 10 гаруй тахилын байгууламж байна. Хиргисүүрийн хойд талаас н сэтлэн тоносон байдалтай байна.
9. N 45°10'16.0" E 105°28'46.4" Alt: 1432 байрлалтай. Ацат хүрэн уулын хойд талд онь дээр 15м голчтой хиргисүүр бий. Хиргисүүрийн урд талаас нь сэтлэн тоносон байдалтай байна.
10. 9 дугаартай дурсгалын чанх урд талд 5 голч бүхий хиргисүүр бий. Хиргисүүрийн голд 2,5м голч бүхий тонуулчдын ул мөр үдсэн байна.
11. N 45°10'18.4" E 105°29'10.3" Alt: 1407 байрлалтай. Ацат хүрэн уулын бүлэг дурсгалаас чанх зүүн тийн 500 зайд хиргисүүр болон дөрвөлжин булшны бүлэг дурсгал байна. Бид эдгээр дурсгалын Ацат хүрэн уулын бүлэг дурсгалд хамруулан бүртгэв. Дурсгалыг хойд талаас нь дугаарлан тодорхойлолт үйлдсэн болно. Эдгээр дурсгалыг сумын засаг даргын захирамжаар хамгаалалтад авсан байна. 20x20м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, 14м голчтой хиргисүүр бий. Хиргисүүрийн тойроод 1,5м голч бүхий 11 тахилын байгууламж байна.
12. N 45°10'32.6" E 105°29'29.0" Alt: 1414. 2,80x2,80м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш. Дурсгал гол хэсгээрээ тоногдсон байна.
13. N 45°10'32.3" E 105°29'21.1" Alt: 1415. 12 дугаартай дурсгалтай зэрэгцээ дөрвөн буландаа хөшөө чулуу бүхий 3,80x6м хэмжээтэй дөрвөлжин булш юм. Энд эгнүүлэн тавьсан 3 дөрвөлжин булш байх бөгөөд дараас чулууд таран нийлсэн байдалтай байна.
14. 13 дугаартай дурсгалтай зэрэгцээ байрлах 1,80x5м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш.
15. 14 дугаартай дурсгалтай зэрэгцээ байрлах 2x5м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш.
16. 13 дугаартай дурсгалын чанх урд талд 2,40x2,40м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.

17. 16 дугаартай дурсгалын чанх урд талд 2,40х3,10м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
18. N 45°10'31.7" E 105°29'21.7" Alt: 1414. 17 дугаартай дурсгалтай зэрэгцээ байрлах уг дурсгал нь хагас дугуй хэлбэрийн дурсгал юм. Хагас дугуйн урт 6 м хэмжээтэй. Бусад зохион байгуулалт нь сайн мэдэгдэхгүй байна.
19. 18 дугаартай дурсгалтай зэрэгцээ байрлах 5,20х4,30м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
20. N 45°10'31.3" E 105°29'22.2" Alt: 1412. 18 дугаартай дурсгалын чанх баруун талд байрлалтай 3,40х2,80м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш. Дурсгалын баруун талд янгирын дүрслэл бүхий зурагтай хөшөө чулуу байна.
21. N 45°10'30.9" E 105°29'22.3" Alt: 1410. Дурсгал 21,22,23,24 эдгээр нь зэрэгцсэн байдалтай дурсгалууд юм. Дараас чулууд нийлж сарнисан тул зохион байгуулалт сайн мэдэгдэхгүй байна. Эдгээрэй 21дугаартай дурсгал нь хэмжээний хувь бусдаасаа арай жижиг 1,80х2,50м хэмжээтэй байна. Бусад дурсгал нь 5,30х5,30м хэмжээтэй байна. Эдгээр зэрэгцээ 4 дөрвөлжин булшны зүүн талаар 7ш хөшөө чулуу бүхий зэл чулуу байна.
22. N 45°10'30.6" E 105°29'22.5" Alt: 1409. Дээрх зэрэгцээ дурсгалуудаас бага зэрэг зайдуу дөрвөн буландаа хөшөө чулуу бүхий 3,10х4,30м хэмжээтэй дөрвөлжин булш. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.
23. N 45°10'30.3" E 105°29'22.5" Alt: 1412. 3х2,3м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш. Дөрвөн буландаа жижиг хөшөө чулуутай.
24. 23 дугаартай дурсгалтай зэрэгцээ 4,20х3,30м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш. Хөшөө чулуу байхгүй байна.
25. 24 дугаартай дурсгалтай зэрэгцээ 2,20х3,60м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш. Хөшөө чулуутай. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.
26. 25 дугаартай дурсгалын чанх урд зэрэгцээ 2,90х4,80м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш. Хөшөө чулуутай. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.
27. 26 дугаартай дурсгалтай зэрэгцээ 5,80х3,80м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш.

28.27 дугаартай дурсгалтай зэрэгцээ 3,40x3,60м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш.

29.28 дугаартай дурсгалын чанх хойд талд 16м голчтой хиргисүүр бий. Хиргисүүрийн тойроод 16 тахилын байгууламж байна. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.

30. N 45°10'26.4" E 105°29'26.5" Alt: 1414. Дөрвөн буландаа тахилын байгууламж бүхий 18x18м хэмжээтэй, 13м голч бүхий хиргисүүр. Дараасны өндөр ойролцоогоор 1,5м өндөр. Хиргисүүрийг тойроод 12 тахилын байгууламж байна.

31. 30 дугаартай дурсгалын чанх хойд талд 2,30x2м хэмжээтэй битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш.

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Голын хар

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°13'12.6" E 105°30'35.0" Alt: 1397

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Хөшөө чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Голын хард 70x120x26м хэмжээтэй боржин чулуугаар үйлдсэн түрэгийн үед холбогдох хөшөө чулуу байна. Хөшөө чулууны гадна талаар илүү ямар нэгэн хүрээ, сул чулуу гэх мэт зүйл байхгүй байна.

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Баазын хиргисүүр

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°14'52.0" E 105°27'0.06" Alt: 1412

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баруун болон зүүн талаараа шаргал ухаатай тал дээр нэгэн хиргисүүр байна. Нутгийн иргэд үүнийг баазын хиргисүүр хэмээн нэрлэнэ. 10м голчтой, урдаа болон зүүн талдаа нэг нэг тахилын байгууламж бүхий хиргисүүр юм. Хиргисүүрт тонуулчдын ул мөр үлдсэн болон ажиглагдаж байна.

#### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Арангын хиргисүүр

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°12'49.2" E 105°27'30.0" Alt: 1470

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Үнэгт уулаас урагш 5км зайд Аранга уулын хойд талд 15м голч бүхий хиргисүүр бий. Хиргисүүрт тонуулчдын ул мөр үлдсэн байна.

#### **Дурсгал-25**

**Газрын нэр:** Хөдөөгийн улаан

**Баг:** Уулын 3-р баг

**Солбицол:** N 45°15'47.5" E 105°25'44.7" Alt: 1381

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хөдөөгийн улаан уулын зүүн талд нэгэн хиргисүүр бий. 15м голчтой, зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.

### **Дурсгал-26**

**Газрын нэр:** Саалийн зэл чулуу

**Баг:** Бүлээн баг

**Солбицол:** N 45°17'44.9" E 105°15'58.2" Alt: 1390

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 30 орчим км-т Саалийн чулуу гэх газрын өргөргийн дагуу 800 м үргэлжилсэн хоёр эгнээ зэл чулууд бий.

### **Дурсгал-27**

**Газрын нэр:** Хярын гурван жирим

**Баг:** Бүлээн

**Солбицол:** N 45°22'17.1" E 105°13'48.2" Alt: 1441

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 50 орчим км-т Хярын гурван жирим хэмээх намхан шар цохион дунд 22 тооны цагариг хэлбэрийн хүннү булш байна. Эдгээр булшнуудын том нь 15м голчтой, дунд нь 6м голчтой, жижиг нь 1м голчтой байна. Элсэрхэн жижиг хойлоод байгаа тул зарим дурсгалын зохион байгуулалт элсэнд дарагдсан байна.

### **Дурсгал-28**

**Газрын нэр:** Хэвтүүлийн хийд

**Баг:** Бүлээн баг

**Солбицол:** N 45°25'54.9" E 105°13'35.4" Alt: 1389



**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга, сүм хийд

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Гурван жирмийн нурууны хойд талд хэвтүүлийн хийд бий. Хэвтүүлийн хийдийг тойроод нэлээд хэдэн өвөлжөө, хаваржаа байна. Хийдийн туурь хөх болон шар шавран тоосгоны хэсгүүд хөглөрч байна.

### **Дурсгал-29**

**Газрын нэр:** Саалийн чулуу

**Баг:** Бүлээн

**Солбицол:** N 45°26'04.0" E 105°16'39.3" Alt: 1344

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Зэл чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мөл шөргөөр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хойноос урагш чиглэлтэй зэл чулуу. 100 орчим метр үлгэлжлнэ. Уг зэл чулууны урд талд нэгэн жижиг тойром байна.

### **Дурсгал-30**

**Газрын нэр:** Торхтын тахилын онгон

**Баг:** Бүлээн баг

**Солбицол:** N 45°29'40.5" E 105°14'00.4" Alt: 1378

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Торхтын тахилын онгон нь урт 2м, өргөн 50см, зузаан 40см хэмжээтэй юм. Нэг хашлаг чулуу мэдэгдэж байгаа бөгөөд урт нь 120см, өргөн нь 25см хэмжээ юм. Энэхүү тахилын онгон нь элсэнд нэлээн дарагдсан тул хашлага чулууд мэдэгдэхгүй байна.

### **Дурсгал-31**

**Газрын нэр:** Дуулгат сэrvэнгийн хиргисүүр

**Баг:** Бүлээн баг

**Солбицол:** N 45°25'58.9" E 105°08'42.24" Alt: 1347

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе,

**Төрөл:** Хиргисүүр, хөшөө чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 47 орчим км-т Сүүлт уулнаас хойш Дуулгат сэrvэнгийн урд энгэрт голдоо хөшөө чулуу, хиргисүүрийн дурсгалууд бий.

1. Хиргисүүр нь 26м голчтой, дөрвөлжин хүрээтэй. Хиргисүүрийн тойроод 9 тахилын байгууламж байна.
2. 2 хөшөө чулуу байх бөгөөд хэвтэй байдалтай хөшөө чулуу нь 2,70м өндөр 40см өргөн, 35см зузаан, босоо хөшөө чулуу нь 1,50м өндөр, 45 см өргөн, 30см зузаантай юм. Босоо хөшөө чулууны хашлага чулууд үл ялиг мэдэгдэж байна.
3. 2 дугаартай дурсгалын чанх урд талд 22 дагуул тахилын байгууламж бүхий 18м голчтой хиргисүүр бий. Хиргисүүрийн чанх урд тал 2 хөшөө чулуу байх бөгөөд нэг нь унасан байдалтай байна.

### **Дурсгал-32**

**Газрын нэр:** Сүүлт уул

**Баг:** Бүлээн

**Солбицол:** N 45°24'53.7" E 105°07'01.6" Alt: 1317

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сүүлт уулын баруун хойд энгэрт Мэнгэтийн хийдээс ойролцоогоор 3 км-т хэсэг бударгана дунд 2 цагариг хэлбэрийн хүннү булш байна. Энэхүү 2 дурсгал нь 6м голчтой. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.

### **Дурсгал-33**

**Газрын нэр:** Мэнгэтийн хийдийн туурь

**Баг:** Бүлээн баг

**Солбицол:** N 45°25'48.7" E 105°06'00.0" Alt: 1314

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун хойш 42 орчим км-т Мэнгэтийн улаан нуурын зүүн хойд талд Мэнгэтийн хийдийн туурь бий. Энэхүү хийдийн туурийн жил бүр Эрдэнэдалай, Хулд, Дэлгэрхангай зэрэг сумд нийлэн тахидаг.

Дундговь аймгийн Хулд сумын нутгаас нийт 33 дурсгалт газрын 126 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 26.
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 41.
- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 4.
- Хүрэл зэвсгийн үеийн шоргоолжин булш- 1
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал - 16
- Хүннү булш – 25.
- Түрэгийн үеийн зэл чулуу – 2.
- Түрэгийн үеийн тахилгын онгон – 3.
- XVIII-XIX зууны үеийн сүм хийдийн туурь – 5.
- Хадны бичээсийн дурсгал – 1.
- Агуй-1
- Түүхэн үе, он цаг нь тодорхойгүй булш оршуулгын төрлийн дурсгал – 1.

Дундговь аймгийн Хулд сумын 33 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 4 дурсгалт газар буюу 12.12%
- Бага эрсдэлтэй – 15 дурсгалт газар буюу 45.45%
- Дунд эрсдэлтэй – 2 дурсгалт газар буюу 6.06%
- Их эрсдэлтэй – 12 дурсгалт газар буюу 36.36%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Хулд сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 33 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 6 буюу 18.18 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 3 буюу 9.09%
- Байгалийн нөлөөлөл – 8 буюу 24.24%
- Мал, амьтны нөлөөлөл – 4 буюу 12.12%
- Тоногдсон – 12 буюу 36.36%

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл, байгалийн хүчин зүйл, тоногдсон гэсэн гурван нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Хулд сумын нутгаас нийт 33 дурсгалт газрын 126 тооны түүх, соёлын дурсгалаас 12 дурсгалт газраас 23 тооны дурсгал шинээр илрүүлэв. Үүнд:

- Монголын эзэнт гүрний үед холбогдох булш - 4
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр - 7
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш - 6
- Хүрэл зэвсгийн үеийн шоргоолжин булш - 1
- Хүннү булш – 4
- Зэл чулуун дурсгал - 1

## Хулд сумын нутагт байх түүх, соёлын дурсгалт газрын зарим зураг



1. Дундговь аймгийн Хулд сум. Луусын хийдийн туурь



4. Дундговь аймгийн Хулд сум. Өвөлжөө хошууны бууцны хиргисүүр.



2. Дундговь аймгийн Хулд сум. Булаг хайрхны монгол булш



5. Дундговь аймгийн Хулд сум. Шарангадын бууцны дөрвөлжин булш.



3. Дундговь аймгийн Хулд сум. Булаг хайрхны монгол булш.



6. Дундговь аймгийн Хулд сум. Шувуутай хийдийн туурь.





7. Дундговь аймгийн Хулд сум. Хулд уулын хиргисүүр.



9. Дундговь аймгийн Хулд сум. Ацат хүрний цогцолбор дурсгал.



8. Дундговь аймгийн Хулд сум. Ацат хүрний цогцолбор дурсгал.



9. Дундговь аймгийн Хулд сум. Үйзэнгийн цохионы хүннү булш.

## ЦАГААНДЭЛГЭР СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Ханангийн бууц

**Солбицол:** N 48°15'58" E 107°48'43" Alt: 1291

**Он цаг:** Тодорхойгүй үе

**Төрөл:** Зосон болон сийлмэл бичээс

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс урд зүгт 20 орчим км газарт Ханангийн бууцны арын хаданд улаан зосоор бичсэн мөн сийлсэн маанийн үсэг бичээс байна.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Түрүү хайрхны булш

**Солбицол:** N 46°15'37,73" E 107°53'40,26" Alt: 1305

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урагш 26 км орчим зайд Түрүү хайрхан хэмээх газарт уулын эргэн тойрон 4 тооны хиргисүүр, 5 дөрвөлжин булш, 19 Хүннү булштай дурсгалт газар юм. Нийт 28 тооны дурсгал байна.

- N 46°15'37,73" E 107°53'40,26". Дугуй хүрээтэй хиргисүүр, хиргисүүрийн хүрээ 46 м голчтой, голын овгор чулуун дараас 11 м голчтой.
- N 46°15'57,02" E 107°51'50,39". Дугуй хүрээтэй хиргисүүр, хүрээний голч 33 метр, голын овгор чулуун дараас 9 метр голчтой. Тодорхой мэдэгдэж байгаа 7 тооны дагуултай.
- N 46°16'03,37" E 107°51'53,96". Дугуй хүрээтэй хиргисүүр, хүрээний голч 31 метр, голын овгор чулуун дараас 11 метр голчтой. Тодорхой мэдэгдэж байгаа 5 тооны дагуултай.
- N 46°15'51,31" E 107°53'19,29". Дөрвөлжин булшны бүлэг дурсгал.

- N 46°15'50,07" E 107°53'06,71". Дугуй хүрээтэй хиргисүүр, хүрээний голч 12 метр, голын овгор чулуун дараас 9 метр голчтой.
- N 46°15'50,00" E 107°53'11,65". Бүлэг дурсгалтай нийт 19 тооны булштай. Түрүү хайрханы урд энгэрт байна.

### **Дурсгал-3**

**Газрын нэр:** Шар шороотын Хөшөөт

**Солбицол:** N 46°19'16" E 107°56'05" Alt: 1285

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал амьтны нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урд зүгт 25 орчим км зайд Шар шороотын бууцнаас зүүн хойш Хөшөөт гэх газарт дэрстэй хөндийд нилээд эвдэгдэж сүйдсэн тахилын онгон байна. Баруун урд талдаа жижиг босоо чулуутай.

### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Хутаг хайрхан

**Солбицол:** N 46°21'52,22" E 108°10'4,29" Alt: 1287

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урд зүгт 40 гаруй км зайд Хутаг хайрхан хэмээх уул байна. Хутаг хайрханы энгэр бэлээр 62 дөрвөлжин булш, мөн 2 тооны хиргисүүр бүхий дурсгалт газар.

### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Тулга Жас

**Солбицол:** N 46°29'58,94" E 107°51'59,91" Alt: 1289



**Он цаг:** XVII-XIX

**Төрөл:** Сүм хийд, барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Сүсэг, эзэнгүйдэл, орон нутгийн зам дагуу

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баян уулын урд, сумын төвөөс зүүн хойш 20 гаруй км газар Ажирхайн хонхор хэмээх газарт байх Тулга Жасын туйр байна.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Цагаандэлгэр сумын хийд

**Солбицол:** N 46°24'45,34" E 107°38'09,79" Alt: 1291

**Он цаг:** XVII-XX

**Төрөл:** Сүм хийд, барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Сүсэг

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвд байрлалтай гадуураа ногоон төмөр хашаатай, дотроо 1 дугантай.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Хөх өндөр

**Солбицол:** N 46°24'55" E 107°40'29" Alt: 1294

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Түрэгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, Хиргисүүр, Хүннү булш, Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн тийш 2 орчим км-т дөрвөлжин булш 18, хиргисүүр 3, хөх өндрөөс зүүн тийш 1 км орчимд 10 тооны Хүннү булшны дурсгал байна. Мөн хоёр эгнээ зэл чулуун дурсгалтай газар юм.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Бортрогийн хэрэм-/Бат-Оригийн хэрэм/

**Солбицол:** N 46°35'40,75" E 107°58'52,50" Alt: 1285

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Хэрэм

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн хойш 40 орчим км-т Бортрог хэмээх газарт хүрмэн чулуун хэрмийн туйр байна. Хэрэм нь 4 талдаа хаалгатай баруун урд талдаа дотор талдаа цонжтой. 4 тал нь гадагшаа цүлхэгэр, 100м X 130м хэмжээтэй.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Чулуут шанд

**Солбицол:** N 45°46'07" E 107°00'57" Alt: 1279

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Хадны бичээс/Түвд/

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, байгалийн нөлөө

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Чулуут шандны бууцнаас хойш 800 орчим м-т цагаан толгойн энгэрт Түвд маанийн бичээс байна.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Адуун чулуу

**Солбицол:** N 46°29'00,45" E 108°09'02,61" Alt: 1275

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн тийш 40 гаруй км зайд Адуун чулууны урд үзүүрт 7 тооны дөрвөлжин булштай дурсгалт газар.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Цагаан эрэг

**Солбицол:** N 46°16'58,81" E 107°49'26,27" Alt: 1280

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Хүн чулуу

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, байгалийн нөлөө, мал амьтан

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цагаан эргийн адагт зэрэгцээ байрлах 2 хүн чулуу хөшөө байна. Өндөр хүн чулуу нь унасан, жижиг хүн чулууны толгой хэсгээс цуурч унасан гадуурх хашаа эвдэрсэн. Гадуураа тахилын чулуун хашлага байсан бололтой чулуунуудтай.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Мушгиа зандан ширээ-/Баруун Чойрын хийд/

**Солбицол:** N 46°14'52,07" E 108°07'28,87" Alt: 1280

**Он цаг:** XVII-XX

**Төрөл:** Сүм хийд, барилга архитектурын дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Орон нутгийн зам, сүсэг

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урд зүгт 42 км зайд Мушгиа зандан ширээ хэмээх газарт Баруун Чойрын хийдийн үлдэгдэлд шороон довцогууд болон чулуун өрлөг туйрууд үлдэж хоцорсон. Хийдийн туйрин дээр 1 суварга, хүрд шинээр баригдсан. 1754-1988 он гэсэн бичигтэй төмөр суурьтай дотроос чулуу дүүргэсэн сувраг байна. 1990 онд суваргыг бүтээсэн байна.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Тоодог уул

**Солбицол:** N 46°21'20,03" E 107°52'29,15" Alt: 1293

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Орон нутгийн замд ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урд зүгт 20 орчим км зайд Тоодог уулын зүүн хойд бэлд 10 дөрвөлжин булш, 1 хиргисүүр байна.

#### **Дурсгал-14**

**Газрын нэр:** Дэлгэр/Уурхайн талбай/

**Солбицол:** N 46°37'07,9" E 107°52'38,5" Alt: 1293

**Он цаг:** Тодорхойгүй

**Төрөл:** Булш оршуулгын дурсгал, Зэл чулуун дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл, Аж ахуй, уурхайн талбайн бүс

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дэлгэр хэмээх нэртэй уурхайн талбайн бүсэд байх 26 тооны дурсгал, түүний нэг нь зэл чулуун дурсгал, 25 нь он цаг төрөл, хэлбэр нь тодорхойгүй булш оршуулгын дурсгал байна.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутгаас нийт 14 дурсгалт газрын 177 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 10.
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 102.
- Хадны бичээс маанийн үсэг – 2.
- Хүннү булш – 29.
- Түрэгийн үеийн зэл чулуу – 2.
- Түрэгийн үеийн тахилгын онгон – 1.
- Түрэгийн үеийн хүн чулуун хөшөө - 2
- Сүм хийд, барилга архитектур, хэрэм – 4
- Он цаг, төрөл тодорхойгүй булш оршуулгын дурсгал – 25 .

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын 14 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 5 дурсгалт газар буюу 35.7%
- Бага эрсдэлтэй – 5 дурсгалт газар буюу 35.7%
- Дунд эрсдэлтэй – 2 дурсгалт газар буюу 14.2%
- Их эрсдэлтэй – 2 дурсгалт газар буюу 14.2%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 14 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 8 буюу 53.8 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 2 буюу 15.4%
- Байгалийн нөлөөлөл – 2 буюу 15.4%
- Мал, амьтны нөлөөлөл – 2 буюу 15.4%

Хамгийн гол хүчин зүйлс нь эзэнгүйдэл байгаа нь харагдаж байна.

## ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛУУД

### Дурсгал-1

**Газрын нэр:** Алгийн бууц

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°47'57.0" E 105°58'30.2" Alt: 1391

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс урагш 22 км зайд Алгийн бууц хэмээх жижиг элс, дэрс бүхий хөндийд 35 тооны цагариг хэлбэрийн булш байна. Эдгээр нь хэмжээний хувьд харилцан адилгүй бөгөөд зарим дурсгалын дараас чулууд элсэнд зарагдсан байна. Зохион байгуулалт нь мэдэгдэж байгаа 35 дурсгал байгаа бөгөөд элсэнд дарагдаж мэдэгдэхгүй болсон нэлээд дурсгал байж болохоор байна. Том 7м голчтой, Дунд 5м голчтой, жижиг нь 2м голчтой байна.

### Дурсгал-2

**Газрын нэр:** Зараа толгой

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°43'14.0" E 104°48'14.9" Alt: 1476

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Зараа толгойн зүүн урд болон урд энгэрээр нийт 15 цагариг хэлбэрийн Хүннү булш байна.

1. N 45°43'14.0" E 104°48'14.9" Alt: 1476 Зүүн урд энгэрт хэмжээний хувьд жижиг цагариг хэлбэрийн 2 булш байна. 4.7 м голчтой, 3.40м голчтой. Эдгээр

дурсгалын дараас чулуунд элсэнд дарагдан зарим хэсгээр мэдэгдэхгүй болсон байна.

2. N 45°43'30.5" E 104°48'33.8" Alt: 1475 Зараа толгой урд энгэрт 13 цагариг хэлбэрийн Хүннү булш байна. Эдгээрийн хэмжээ харилцан адилгүй байх бөгөөд том нь 7м голчтой, дунд нь 4м голчтой, жижиг нь 2м голчтой байна. Эдгээр дурсгал нь элсэнд дарагдсаны улмаас зарим нэгийн нь зохион байгуулалт мэдэгдэхгүй болсон байна.

### **Дурсгал 3**

**Баг:** Улаан тээг

**Солбицол:** N 45°39'41.8" E 104°48'09.5" Alt: 1368

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Улаан тээгийн урд энгэрт 5м голч бүхий цагариг хэлбэрийн Хүннү булш байна. Булш тоногдсон.

### **Дурсгал-4**

**Газрын нэр:** Цавчирын хийд

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°39'40.9" E 104°47'11.8" Alt: 1359

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Эрдэнэдалай сумын төвөөс урагш 22 км орчимд цавчирын хийд бий.

### **Дурсгал-5**

**Газрын нэр:** Цавчирын хийдийн хиргисүүр

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°39'45.8" E 104°47'14.1" Alt: 1365

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм, тоногдсон.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй.

**Тодорхойлолт:** Цавчирын хийдийн хойд тал зэрэгцэн нэгэн хиргисүүр байна. Хиргисүүр нь 1 дагуул байгууламжтай, 10 м голч бүхийн цагариг дугуй хэлбэрийн хиргисүүр. Нутгийн хүний хэлж байгаагаар хиргисүүрийг 2 жилийн өмнө тонуулчид тоносон байна.

### **Дурсгал-6**

**Газрын нэр:** Цагаан цохио

**Баг:** 1-р баг

**Солбилцол:** N 45°40'02.8" E 104°36'31,4" Alt: 1380

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм, тоногдсон.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цагаан цохионы энгэрт 18 цагираг хэлбэрийн хүннү булш байна. Эдгээр дурсгалууд нь хэмжээний хувьд харилцан адилгүй бөгөөд төв хэсэг байх дурсгал нь бусдаасаа хэмжээний хувьд том байх бөгөөд 11м голчтой. Бусад нь түүнийг тойрсон байдалтай байна.

### **Дурсгал-7**

**Газрын нэр:** Хадан таримал

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°40'34.3" E 104°46'33.1" Alt: 1413

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Дөрвөлжин булш, Хүннү булш



**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хадан таримлын өвөлжөөний баруун урд хаяанд 4 хиргисүүр, 2 хүннү булш, 1 хөшөө чулуу бүхий дөрвөлжин булш байна. Цагариг хэлбэрийн хүннү булшны хэмжээ нь хоёулаа адил 4 м голчтой байна. Хиргисүүрийн хэмжээ нь 4-6м голчтой дугуй хэлбэрийн хиргисүүр юм. Дөрвөлжин булш нь машин замд өртөн зохион байгуулалт нь бага зэрэг мэдэгдэж байна. Хөшөө чулуу нь 70x45x20м хэмжээтэй.

### **Дурсгал-8**

**Газрын нэр:** Бичигт хад

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°40'21.8" E 105°47'51.5" Alt: 1413

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг, тамга

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хайлааст хэмээх улаан хадтай цохионы энгэрт нэгэн жижиг толгой байх бөгөөд түүний орой дээр хоёр хэсэг жижиг ургаа хад байна. Энэхүү 2 хадны урд талын хадан дээр хөндөлтэй туухай, онги, холбоо онги, цэгтэй онги зэрэг тамгууд дүрсэлсэн байна. Хадны урд нүүрэнд үл мэдэх дүрслэлүүд байна.

### **Дурсгал-9**

**Газрын нэр:** Хайлааст

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°40'28.5" E 104°47'47.3" Alt: 1407

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хайлаастын урд энгэрт 4 хиргисүүр байна. Уг хиргисүүр нь дугуй хүрээтэй хиргисүүр юм. Том 11м голчтой, Дунд нь 9м голчтой, жижиг нь 6м голчтой байна. Эдгээр 4 хиргисүүр нь тоногдсон байдалтай байна.

### **Дурсгал-10**

**Газрын нэр:** Рашаантын бичигт хад

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°41'11.9" E 104°48'16.6" Alt: 1438

**Гэрэл зургийн дугаар:**

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Бичгийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Рашаантын өвөлжөөний зүүн талд нэгэн худаг байх бөгөөд үүнийг рашаан хэмээн нэрлэнэ. Сахрын өвчинд их сайн. Тус худгийн хойд хаданд түвд маанийн үсэг бичсэн байна.

### **Дурсгал-11**

**Газрын нэр:** Бурхантын хонд

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°41'12.6" E 104°44'17.1" Alt: 1383

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Рашаантын бичигт хадны баруун хойд баруунаас зүүн тийш үргэлжилсэн ягаан хадтай цохионы төгсгөл хэсгийн аманд нэгэн чулуу хороо байна. Уг чулуун хорооны баруун урд хадтай жижиг толгой байх бөгөөд түүний энгэрт 2 хиргисүүр, 7 дөрвөлжин булш байна.

1. Дөрвөлжин булшнууд нь дөрвөн буландаа хөшөө чулуутай 2х2м, 3х2м, 1х1м хэмжээтэй байна.
2. Хиргисүүр нь дөрвөлжин хүрээтэй, 6м голч бүхий дугуй хэлбэрийн хиргисүүр, ямар нэгэн хүрээгүй 7м голч бүхий хиргисүүрүүд байна.

### **Дурсгал-12**

**Газрын нэр:** Бурхан шар хад

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°40'55.1" E 104°44'38.8" Alt: 1390

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш, хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл, тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Бурхан шар уулын энгэрт болон тойроод 7 хиргисүүр, 10 дөрвөлжин булш байна. Хиргисүүрүүд нь дөрвөлжин хүрээтэй дагуул байгууламж бүхий хиргисүүрүүд юм. Мөн ямар нэгэн хүрээ байхгүй дугуй хэлбэрийн хиргисүүрүүд ч байна. Дөрвөлжин булшнууд нь хэмжээний хувьд харилцан адилгүй 4,50х2,50м, 2х2м, 3х2м, 2х2м хэмжээтэй байна. Эдгээр дурсгалууд нь элсэнд дарагдсан тул зохион байгуулалт нь тодорхой мэдэгдэхгүй байна. Мөн зарим дурсгал нь тоногдсон.

### **Дурсгал-13**

**Газрын нэр:** Хөх хурууны хях

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°44'15.0" E 104°37'37.8" Alt: 1430

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хөх хурууны хярын баруун урд 4,30м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш байна. Дурсгалын зохион байгуулалт маш сайн мэдэгдэж байна.

## Дурсгал-14

**Газрын нэр:** Хар чулуут

**Баг:** 2-р баг Өнгөт

**Солбицол:** N 45°54'17.3" E 104°35'24.3" Alt: 1406

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг, дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм, тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Үнэгт хайрхны зүүн талын нуруунд Хар чулуутай хэмээх хар хэсэг хад байна. Тэр хадан дунд нэгэн айлын өвөлжөө байна. Өвөлжөөг тойроод дөрвөлжин булш хадны зураг нэлээд байна.

1. Өвөлжөөний тойрсон хаднуудад янгир, зээр, үнэг, адуу, хүн зэрэг амьтадын дүрс бүхий зурагнуудтай. Зурагнууд дээр давхарлаж зурсан байна.
2. Өвөлжөөний зүүн талд 3 дөрвөлжин булш байна. Дөрвөлжин булшнууд тоногдсон тул зохион байгуулалт эвдэгдсэн байна. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байгаа 1 дөрвөлжин булшны хэмжээ нь 1,7х2,50м хэмжээтэй байна.
3. Өвөлжөөнөөс баруун тийш 50м зайд 12 дөрвөлжин булш байна. Нимгэн хавтгай чулуудыг босгон хайрцаглаж үйлдсэн. Хэмжээний хувьд харилцан адилгүй. Эдгээр дөрвөлжин булшнууд дунд сонирхол татсан нэг дурсгал нь хамгийн баруун захад нь байх 6,30х3,20м хэмжээтэй дөрвөлжин булш юм. Хашлага чулуун дээр янгир, зээр, морь зэрэг амьтадыг дүрсэлсэн байна. Бусад дөрвөлжин булшнуудын хэмжээ дунджаар 4х3,10м хэмжээтэй. Хамгийн жижиг нь 1х1м хэмжээтэй байна.
4. Эдгээр 12 дөрвөлжин булшны хад хаданд янгир, зээр, хүн зэрэг амьтадын дүрс бүхий зурагнууд байна. Зурган дээр давхарлаж зурсан байдалтай байна.

## Дурсгал 15

**Газрын нэр:** Бага хайрхан

**Баг:** 2-р баг. Өнгөт.

**Солбицол:** N 46°00'49.8" E 104°33'21.9" Alt: 1311

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе,

**Төрөл:** Хиргисүүр, дөрвөлжин булш, хадны зураг, Хүннү булш.

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Үнэгт хайрхны зүүн урд тусдаа байх хайрхныг Бага хайрхан хэмээн нэрлэнэ. Тус хайрхныг тойроод хиргисүүр, дөрвөлжин булш, цагариг хэлбэрийн хүннү булш, мэр сэр хадны зургууд байна.

1. Хадны зурагт янгир, буга, хүн, морь зэрэг амьтдыг дүрсэлсэн байна. Зурган дээр давхарлаж зурсан байна. Дүрслэлийн хувьд нар, салхинд элэгдэн нэлээд бүдгэрсэн байна.
2. Бага хайрхны тойроод 9 хиргисүүр байна. Хиргисүүрүүд нь дугуй, дөрвөлжин хүрээтэй болон хүрээгүй гэсэн 3 төрлийн хэлбэртэй байна. Эдгээр бүгд тахилын байгууламжтай. Эдгээр хиргисүүрүүд дотроос хамгийн том нь 20х20м хэмжээ бүхий дөрвөлжин хүрээтэй, 10 тахилын байгууламжтай 9 голчтой хиргисүүр байна. Дурсгалууд сайн хадгалагдаж үлдсэн байна.
3. 5,50м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш 1 байна. Дурсгалын зохион байгуулалт эвдэгдээгүй сайн хадгалагдаж үлдсэн байна.
4. Цагариг хэлбэрийн хүннү булштай зэрэгцээ 2 дөрвөлжин булш байна. 3х2м, 4х2,5м хэмжээтэй. Зохион байгуулалт сайн мэдэгдэж байна.

#### **Дурсгал-16**

**Газрын нэр:** Үнэгт хайрхан

**Баг:** 2-р баг. Өнгөт.

**Солбицол:** N 46°01'16.2" E 104°33'08.1" Alt: 1301

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, XVII-XX зуун

**Төрөл:** Хиргисүүр, хадны зураг, дөрвөлжин булш, бичээс.

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Үнэгт хайрхныг тойроод маш олон тооны дурсгал байна. Үнэгт хайрхны тойроод 30 гаруй хиргисүүр, 20 гаруй дөрвөлжин булш байна. Үнэгт хайрхан энгэрт нэгэн өвөлжөө байх бөгөөд түүнийг тойроод маш олон зураг байна. Зурагт янгир, зээр, үнэг, чоно, луу, хүн, морь, тамга зэрэг маш баялаг дүрслэлүүд байна. Мөн хожуу үед бичсэн түвд бичээсүүд ч байна. Зарим зургийн давхарлан зурж ихэд гэмтээсэн байна. Үнэгт хайрхны хойд талд Халзан хэмээх нэгэн өндөр уул байх ба түүний энгэрээр мөн 20 гаруй хиргисүүр, 1 цагариг хэлбэрийн хүннү булш байна. Тухайн дурсгалууд маш сайн хадгалагдаж үлдсэн байна.

## Дурсгал-17

**Газрын нэр:** Баянхошуу

**Баг:** 2-р баг. Өнгөт

**Солбицол:** N 46°00'39.0" E 104°28'19.0" Alt: 1299

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе, Монголын эзэнт гүрний үе

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү булш, Монголын эзэнт гүрний үеийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм, байгалийн хүчин зүйл.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй.

**Тодорхойлолт:** Баян хошуу уулын урд энгэрээр хиргисүүр, цагариг хэлбэрийн хүннү булш болон монгол булшнууд нэлээд байна.

1. Баянхошуу уулын урд энгэрт 30 голч бүхийн дугуй хүрээтэй хиргисүүр байна. Хиргисүүрийн зүүн урд энгэрт 1,20м голчтой 4 тахилын байгууламж байна. Хиргисүүрийн гол хэсгээс тоносон байдалтай байна.
2. Тус хиргисүүрээс баруун тийш уулийн энгэрийг дагаад 10 гаруй дурсгал байна. Үүнд монгол булш 2 байна. Эдгээр булшнууд нь хоёулаа 5м голч бүхий битүү чулуун дараастай дугуй хэлбэрийн булшнууд юм. Хиргисүүр 3 байна. Эдгээр нь дунджаар 5м голч бүхий дугуй хүрээтэй 4,5м голчтой байна. Цагариг хэлбэрийн хүннү булш 6 байх бөгөөд эдгээр дунджаар 4м голчтой байна.

## Дурсгал-18

**Газрын нэр:** Цагаан цохио

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°40'02.8" E 104°36'31,4" Alt: 1380

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Вандализм, тоногдсон.

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Цагаан цохионы энгэрт 18 цагариг хэлбэрийн хүннү булш байна. Эдгээр дурсгалууд нь хэмжээний хувьд харилцан адилгүй бөгөөд төв хэсэг байх

дурсгал нь бусдаасаа хэмжээний хувьд том байх бөгөөд 11м голчтой. Бусад нь түүнийг тойрсон байдалтай байна.

### **Дурсгал-19**

**Газрын нэр:** Хадан таримлын хадны зураг

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 46°06'53.3" E 104°24'42.7" Alt: 1472

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хадны зураг

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Нутгийн шүтлэгт Хайрхан хэмээх уулаас баруун хойш нэгэн жижиг хадан цохионд янгир, зээр зэрэг амьтадыг дүрсэлсэн байна. Нар салхинд дүрслэл нэлээд бүдгэрсэн байна.

### **Дурсгал-20**

**Газрын нэр:** Хайрханы хиргисүүр

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 46°06'49.3" E 104°24'41.7" Alt: 1470

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Хиргисүүр

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дурсгал 19-өөс урагш 8м голчтой хиргисүүр бий. Хиргисүүр нь 1,5м хэмжээтэй 4 тахилын байгууламжтай. Тонуулчдын ул мөр үлдсэн байна.

### **Дурсгал-21**

**Газрын нэр:** Хайрханы тахилын онгон

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 46°06'27.7" E 104°28'03.7" Alt: 1361

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хайрхан хэмээх хадтай 2 өндөр уулын зүүн урд нэгэн тахилын онгон байна. Хөшөө чулуу нь 1,50х50х25см хэмжээтэй.

### **Дурсгал-22**

**Газрын нэр:** Өнгөт

**Баг:** Өнгөт баг

**Солбицол:** N 45°09'56.7" E 104°37'20.1" Alt: 1455

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Орон нутгийн замтай ойр

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Өнгөтийн рашааны зүүн хойно, бригадын төвийн хойд талд нэгэн жижиг аманд 11 тооны цагариг хэлбэрийн хүннү булш байна. Эдгээр хүннү булшны хамгийн том нь 8м голчтой, дунд нь 5м голчтой, жижиг нь 4 м голчтой байна.

### **Дурсгал-23**

**Газрын нэр:** Өнгөт

**Баг:** Өнгөт баг

**Солбицол:** N 46°11'58.9" E 104°37'17.2" Alt: 1544

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй



**Тодорхойлолт:** Өнгөтийн рашаанаас зүүн хойш 4 орчим км-т нэгэн хөшөө чулуу байна. 65x35x25 см хэмжээтэй. Уг хөшөөний хашлага чулуу үл ялиг мэдэгдэж байна. Хашлага чулууны хэмжээ 60x25x10см юм.

#### **Дурсгал-24**

**Газрын нэр:** Баян уулын зүүн энгэр

**Баг:** Өнгөт баг

**Солбицол:** N 46°07'33.0" E 104°44'38.1" Alt: 1413

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баян уулын зүүн урд энгэрт 11 тооны цагариг хэлбэрийн хүннү булш байна. Зарим дурсгалыг үер дайрч зохион байгуулалтыг нь нэлээд эвдсэн байна. Эдгээр дурсгалууд нь ойролцоогоор 5м голчтой.

#### **Дурсгал-25**

**Газрын нэр:** Баян уулын зүүн толгод

**Баг:** Өнгөт баг

**Солбицол:** N 46°07'44.3" E 104°45'40.8" Alt: 1426

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Дунд эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Дурсгал 24-өөс зүүн тийш 3 орчим км-т 35 тооны цагариг хэлбэрийн хүннү булш байна. Эдгээр дурсгалыг үер дайрч зохион байгуулалтыг нь эвдсэн. Мөн 3 булшыг нь тонуулчид тоносон байна. Хамгийн том нь 8м голчтой, дунд нь 6м голчтой, жижиг нь 4м голчтой байна.

### **Дурсгал-26**

**Газрын нэр:** Хөшөөн хар

**Баг:** Өнгөт баг

**Солбилцол:** N 46°15'19.7" E 104°37'11.7" Alt: 1468

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хурдангийн овооноос зүүн ургаш Хөшөөн харийн тахилын онгон бий. Хөшөө чулууны өндөр 1м, өргөн нь 45см, зузаан нь 30 см байна. Хашлага чулуу 1. 75x25x20см, 2. 80x35x10см, 3. 85x20x15см, 50x25x5см тус ту хэмжээтэй.

### **Дурсгал 27**

**Газрын нэр:** Шургуулын ам

**Баг:** Өнгөт баг

**Солбицол:** N 45°59'30.2" E 104°54'07.8" Alt: 1385

**Он цаг:** Хүннүгийн үе

**Төрөл:** Цагираг хэлбэрийн булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Хурдны хүрэн овооноос зүүн урагш 4 км-т Шургуулын ам хэмээх хадан хавцал байна. Хавцалын баруун эрэг дээр 7 цагариг хэлбэрийн хүннү булш байна. Эдгээр цагариг хэлбэрийн булшны зохион байгуулалт сайн мэдэгдэж байна. 3-4м голчтой юм.

### **Дурсгал-28**

**Газрын нэр:** Харц хатны булш

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°59'30.2" E 104°54'07.8" Alt: 1385

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе

**Төрөл:** Дөрвөлжин булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс баруун тийш 4 км-т 4х3м хэмжээтэй, дөрвөн буландаа хөшөө чулуутай, битүү чулуун дараас бүхий дөрвөлжин булш.

### **Дурсгал-29**

**Газрын нэр:** Сангийн хийд

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 46°00'24.0" E 104°56'59.0" Alt: 1367

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Маш бага эрсдэлтэй.

**Тодорхойлолт:** Эрдэнэдалай сумын төвд хуучны Сангийн далай хийдийн түүхийг хадгалан үлдсэн ганц цогчин дуган бий.

### **Дурсгал-30**

**Газрын нэр:** Үнстийн хийд

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°46'09.3" E 105°14'03.3" Alt: 1350

**Он цаг:** XVII-XX зуун

**Төрөл:** Барилга архитектур, сүм хийдийн дурсгал

**Эрсдэлийн хүчин зүйл:** Эзэнгүйдэл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй.

**Тодорхойлолт:** Сумын төвөөс зүүн урагш 35 орчим км, Цагаан-Овоо уулын хойд хөндийд Үнстийн хийдийн туурийн үлдэгдэл бий.

### **Дурсгал-31**

**Газрын нэр:** Баян улаан уулын баруун урд энгэр

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°45'13.9" E 104°15'09.9" Alt: 1367

**Он цаг:** Он цаг тодорхойгүй

**Төрөл:** Дугуй хэлбэрийн

**Эрсдэлийн хүчин зүйл:** Тоногдсон

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Их эрсдэлтэй.

**Тодорхойлолт:** Баян улаан уулын баруун урд энгэрт он цаг нь тодорхойгүй 25 тооны дурсгал байна. Энэхүү дурсгал хэмжээ жижиг 1,5-2м голчтой дугуй хэлбэрийн дурсгал юм.

### **Дурсгал-32**

**Газрын нэр:** Баян улаан уулын урд энгэрийн булш

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°45'04.3" E 105°15'44,4" Alt: 1354

**Он цаг:** Хүрэл зэвсгийн үе, Хүннүгийн үе

**Төрөл:** Хиргисүүр, Хүннү булш

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баян улаан уулын урд энгэрт 17x14 хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, хүрээний өргөн 1м, голын шороон овоолго 4,5 м голчтой. Чанх урд талдаа 2,5м үүдэвчтэй, зүүн хойд талдаа 7 ш дагуул байгууламж бүхий хиргисүүрийн дурсгал байна. Зүүн хойд талд 7м голчтой цагариг хэлбэрийн хүннү булш байна. Мөн түүнийг тойроод эмх замбараагүй хэд хэдэн байгууламж байна. 1x1 хэмжээтэй.

### **Дурсгал-33**

**Газрын нэр:** Баян улаан уул

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°45'04.3" E 105°15'44,4" Alt: 1354

**Он цаг:** Он цаг тодорхойгүй

**Төрөл:** Тодорхойгүй

**Эрсдэлийн хүчин зүйл:** Байгалийн хүчин зүйл

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Баян улаан уулын урд энгэрт 4-5м голчтой дугуй хэлбэрийн чулуун овоолгууд байна. Он цаг тодорхойгүй.

### **Дурсгал-34**

**Газрын нэр:** Баян улаан уулын зүүн хөтөл, Хадан таримлын тахилын онгон

**Баг:** 1-р баг

**Солбицол:** N 45°45'24.9" E 105°16'16.9" Alt: 1392

**Он цаг:** Түрэгийн үе

**Төрөл:** Тахилын онгон

**Эрсдэлийн хүчин зүйл:** Мал шөргөөх

**Дурсгалт газрын эрсдэлийн үнэлгээ:** Бага эрсдэлтэй

**Тодорхойлолт:** Сумын төвөөс урагш 37 км-т Баян улаан уулын зүүн хөтөл дээр голдоо хөшөө чулуутай 1 тахилын онгон байна. Хөшөөний өндөр нь 1,60м, өргөн нь. дээд талаараа 35 см, дунд талаараа 45см, доод талаараа 50 см.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутгаас нийт 34 дурсгалт газрын 327 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэсэн. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн төрлийн дурсгал – 83
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 53.

- Хүрлийн үеийн хадны сийлмэл зураг – 4.
- Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгын дурсгал – 2
- Барилга архитектур, сүм хийдийн дурсгал – 4
- Түрэгийн тахилын онгон – 3
- Бичиг үсгийн дурсгал – 1
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 150.
- Эртний бичээс – 1
- Түүхэн үе, он цаг нь тодорхойгүй булш оршуулгын төрлийн дурсгал – 26.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын 34 дурсгалт газрыг эрсдэлийн үзүүлэлтээр нь тодорхойлоход:

- Маш бага эрсдэлтэй – 6 дурсгалт газар буюу 17.64%
- Бага эрсдэлтэй – 10 дурсгалт газар буюу 29.41%
- Дунд эрсдэлтэй – 7 дурсгалт газар буюу 20.58%
- Их эрсдэлтэй – 11 дурсгалт газар буюу 32.35%-ийн үзүүлэлттэй гарч байна.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутгаас илрүүлэн уг судалгаанд бүртгэгдсэн нийт 34 дурсгалт газрын эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулахад:

- Эзэнгүйдэл – 3 буюу 8.83 %
- Орон нутгийн чанартай замд ойр байрлах – 2 буюу 5.88%
- Байгалийн нөлөөлөл – 12 буюу 35.29%
- Тоногдсон – 3 буюу 8.85%
- Вандализм 7 буюу 20.58%
- Мал шөргөөх 6 буюу 17.64%

Хамгийн гол хүчин зүйлс нь вандализм, мал шөргөөх, байгалийн гэсэн гурван нөлөөлөл байгаа нь харагдаж байна.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутгаас нийт 34 дурсгалт газрын 327 тооны түүх, соёлын дурсгалаас 15 дурсгалт газраас 128 тооны дурсгал шинээр илрүүлэв. Үүнд:

- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал- 4

- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал- 18
- Хадны бичээсийн дурсгалт газар - 1
- Хүннүгийн үеийн жирийн иргэдийн булшны дурсгал - 100
- Түрэгийн үеийн тахилын онгон - 1

## Эрдэнэдалай сумын нутагт байх түүх, соёлын дурсгалт газрын зарим зураг



Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Харц хатны булш.



Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Үнстийн хийд.



Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Цавчирын хийд.



Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Үнэгт хайрхны хадны зураг.



Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Үнстийн хийд.




Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Үнэгт хайрхны хиргисүүр.





Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Хадан таримлын тахилын онгон.



Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Шургуулын амны хүннү булш.



Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Хөшөөн харын тахилын онгон.



Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Сангийн хийд.



Дундговь аймгийн Эрдэнэдалай сум. Сангийн хийд.

## 18. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТОВЧ ТАЙЛАН, ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг/Хавсралт-.. үз/ ШУСС-2020/33 тоот гэрээний 2 дугаар хавсралтаар баталгаажуулагдан хэрэгждэг бөгөөд төслийн хэрэгжилтийн явцыг жил бүр хоёр үе 3 үе шаттайгаар шалгадаг. Үүнд:

- Төслийн хагас жилийн хэрэгжилтийн явцын тайлан, мониторинг болон санхүүгийн тайланг тухайн оны 6 сарын 1-ны дотор авдаг.
- Тухайн төслийн хэрэгжилт, үр дүн явцын талаар хэрэгжүүлж буй байгууллага дээр /ШУТИС/ “ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ” тусгай комисс ажиллаж шийдвэрээ гаргадаг. Тухайн оны 12 сард
- Төслийн хэрэгжилтийн бүтэн жилийн тайлан, мониторинг болон санхүүгийн тайланг дараа оны 2 сарын 1-ны дотор ШУТСангийн тухайн Салбарын судалгаа, мониторинг хариуцсан мэргэжилтэн болон санхүү дээр хүлээлгэн өгдөг.

Манай төслийн судалгааны баг төслийн хэрэгжилтийн явцын монитронг болон санхүүгийн тайланг жил бүр холбогдох байгууллагад гаргаж өгч байсан.

Энэхүү төслийн 2021-2022 оны 2 жилийн хэрэгжилтийн талаар төслийн эцсийн үр дүн, тайлангийн талаар ШУТИС дээр 2022 оны 12 сарын 20-ны хэрэгжилт, үр дүн явцын талаарх “ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ” тусгай комисс ажиллаж шийдвэрээ гаргасан/Төслийн хяналтын шинжилгээний комиссын хурлын хөтөлбөр болон түүнтэй холбогдох шийдвэрийг /Хавсралт-5 үз/ гаргасан.

Төслийн үр дүнгийн даалгаврыг “Дундговь аймгийн нутаг дахь, түүх соёлын дурсгал” нэртэй суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх 2020 оны 5 сарын 19-ны өдрийн ШуСС-2020/33 дугаар гэрээний 1 дүгээр хавсралтаар баталгаажуулсан.

### ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР

д/д	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэл	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа /он, сар/
1	Дундговь аймгийн нутаг дэвсгэрт буй нүүдэлчдийн түүх, археологийн холбогдолт шинэ дурсгалуудыг илрүүлэх судалгаа шинжилгээний ажлыг хийж, мэдээллийн санг арвижуулж, эртний дурсгалын сан хөмрөгийг баяжуулж, хадгалалт, хамгаалалт хийх боломж <u>бүрдэнэ.</u>	2	Дундговь аймгийн түүх, археологийн дурсгалын мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвийн мэдээллийн баазад бүртгэлжүүлнэ Эрдэм шинжилгээний өгүүлэл /Их сургууль болон ШУА-АХ-ийн сэтгүүл/	2021 он 12 сар

2	Экспертийн судалгаа хийгдэж, хээрийн судалгааны эрдэм шинжилгээний тайланг жил бүр гаргаж, ШУТИС-ийн Археологи-Угсаатны зүйн экспедицийн гар бичмэлийн санд болон санхүүжүүлэгч талд шилжүүлнэ	2	Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлнэ.	2021 он 12 сар
3	Дундговь аймгийн нутаг дэвсгэрт буй түүх, археологийн хөдлөх болон үл хөдлөх дурсгалын нэгдсэн бүртгэл бий болгоно	1	Дундговь аймгийн Түүх, археологийн дурсгалын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан	2021 он 12 сар
4	Дундговь аймгийн 15 сумдын нутаг дахь түүх, археологийн дурсгалын талаар сум тус бүрээр тухайлсан сэдэвчилсэн "Дундговь аймаг: түүх, соёлын дурсгалын судалгаа" лавлах гарна.	1	Дундговь аймаг: түүх, соёлын дурсгалын судалгаа" сэдэвчилсэн лавлах ном. /20х.х-100ш, оюуны өмчийн гэрчилгээ/	2021 он 12 сар
5	Төслийн эцсийн тайлан бичиж захиалагч, санхүүжүүлэгчид хүлээлгэн өгч акт үйлдэх	1	Төслийн тайлан	2021 он 12 сар

### Үр дүнгийн даалгавар түүний гүйцэтгэлийн тайлбар:

“Дундговь аймгийн нутаг дахь, түүх соёлын дурсгал” нэртэй суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ 2020 оны 5 сарын 19-ны өдөр байгуулагдсан бөгөөд 2020, 2021 онуудад хэрэгжих төлөвлөгөөтэй байсан боловч ковидийн нөхцөл байдлын улмаас санхүүжилт 1 жил зогссон. Тиймээс уг төсөл 2021, 2022 онуудад хэрэгжсэн болно. Бид төслийн үр дүнгийн даалгаварт дээрх 5 үр дүнг тусгаж өгсөн бөгөөд гүйцэтгэлийг дараах байдлаар тайлбарлав. Үүнд:

1. Дундговь аймгийн түүх, археологийн дурсгалын мэдээллийг Соёлын өвийн үндэсний төвийн мэдээллийн баазад бүртгэлжүүлнэ. Эрдэм шинжилгээний өгүүлэл /Их сургууль болон ШУА-АХ-ийн сэтгүүл/. 100% биелүүлсэн. Соёлын өвийн үндэсний төвд жил бүрийн судалгаагаар илэрсэн дурсгалын мэдээллийг өгөхөөс гадна МОНГОЛЫН АРХЕОЛОГИ-2021, 2022 оны 2 удаагийн эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд 2 өгүүлэл, ДУНДГОВЬ СУДЛАЛ-2021, 2022 эрдэм шинжилгээний 2 удаагийн хурлын эмхэтгэлд 4 өгүүлэл хэвлүүлсэн/Хавсралт-6 үз/.
2. Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлнэ. Бүрэн хэрэгжүүлсэн 100%. МОНГОЛЫН АРХЕОЛОГИ-2021, 2022 оны 2 удаагийн эрдэм шинжилгээний

хуралд 2 илтгэл, ДУНДГОВЬ СУДЛАЛ-2021, 2022 эрдэм шинжилгээний 2 удаагийн хуралд 4 илтгэл хэлэлцүүлсэн нь эдүгээ хурлын эмхэтгэлд хэвлэгдэн гарсан/Хавсралт-7 үз/.

3. Дундговь аймгийн Түүх, археологийн дурсгалын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан. Бүрэн хэрэгжүүлсэн 100%. Бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бий болгож тайлан болон гарсан. ШУТИС сургууль нь Монгол улсад археологийн судалгаа шинжилгээ хийх эрх бүхий 5 байгууллагын нэг бөгөөд жил бүрийн судалгааны ажлын тайланг дараа оны 2 сард багтаан Соёлын өвийн үндэсний төвд хүлээлгэн өгдөг/Хавсралт-8 үз/.
4. Дундговь аймаг: түүх, соёлын дурсгалын судалгаа” сэдэвчилсэн лавлах ном. /20х.х-100ш, оюуны өмчийн гэрчилгээ/. Эдүгээ хэрэгжиж байгаа. Хэрэгжилтийн хувьд 100 хувьтай байгаа бөгөөд эх бэлтгэл дууссан бөгөөд Редактор завсар хяналт хийгдэж байна. Ном бүтээл бүрэн гарсны дараа холбогдох материалыг бүрдүүлж оюуны өмчийн гэрчилгээ авахаар ажиллаж байна. Мөн лавлах бүтээл катологийн бүтэц агуулга, стандартыг ШУТИС-БуХС-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. Төслийг хэрэгжүүлэгчийн зүгээс ШУТИС-БуХС-ийн эрдмийн зөвлөлөөр төслийн эцсийн тайлан болон лавлах бүтээлийг хэлэлцүүлэн холбогдох албан бичиг, дүгнэлт, хурлын протоколын хамт ШУТСанд хүлээлгэн өгч байна.
1. Төслийн эцсийн тайлан. ШУТСанд хүлээлгэн өгөв.

## ДҮГНЭЛТ

ШУТСангийн дэмжлэгтэйгээр Дундговь аймгийн бүх сумдад (15 сум) 2 жилийн хугацаанд Түүх соёлын дурсгалын бүртгэл судалгааг хийж өмнө нь бүртгэлтэй дурсгалуудыг дахин баримтжуулахаас гадна олон үед хамаарах олон арван шинэ дурсгалуудыг нээн илрүүлж шинжлэх ухааны эргэлтэд оруулж, бүртгэл мэдээллийн дата баазыг бүрдүүлэн, фото болон видео санг бий болгож, дурсгалуудад эрсдэлийн үнэлгээ хийн, цогцоор нь судалсан нь монгол улсын хэмжээнд анхдагч боллоо.

Дундговь аймаг нь түүх соёлын бүртгэл судалгаа болон археологийн малтлага судалгаа нэлээдгүй ихээр хийгдсэн аймгийн тоонд зүй ёсоор орно. Учир нь тус бүс нутагт түүх соёлын болон байгалийн үзэмжит дурсгалаараа Монголд төдийгүй дэлхийд гайхагдахаар олон арван гайхамшигт дурсгалуудтай билээ. Дэлхийн өвд бүртгэлтэй Дэл хөнжлийн уулаас эхлүүлээд Их, Бага газрын чулуу, Сүм хөх бүрд, Дэлгэр Чойрын хийд цаашлаад Цагаан, Улаан суваргыг дурдаж болно.

Дэл уулын хадны зураг нь Монгол орноос олдсон хадны зургуудыг бодвол тархац болон дүрслэлийн хувьд нэн сонирхолтой дурсгал билээ. Өнөөдрийн байдлаар Дэл уулыг бүхэлд нь судалсан зүйл байхгүй бөгөөд судалгааны ажил одоо ч үргэлжилсээр байна. Цаашид Дундговь аймагт буй түүх соёлын дурсгалуудыг шинээр нээн илрүүлж судалгааны эргэлтэд оруулж, шинэ судалгааны хэрэглэгдэхүүнийг бий болгох шаардлага тулгарч байна.

Бидний хийсэн 2 жилийн судалгааны үр дүнд шинээр олон арван дурсгалыг илрүүлэн олж судалгааны баялаг их хэрэглэгдэхүүнийг цуглуулаад байна. Үүнд: Чулуун зэвсгийн бууц суурин, хадны зургийн нэн сонирхолтой дүрслэл бүхий дурсгалт газар, Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны цогцолбор газар, буган хөшөөд, Хүннүгийн оршуулгын цогцолбор газар, түрэгийн үеийн тахилын онгон, руни бичгийн шинэ дурсгалууд, монголын эзэнт гүрний үеийн оршуулгын цогцолбор газар зэргийг дурдаж болно.

Өлзийт сумын Дэрт 2-р багийн нутгийн Сайн билүүний хадны зургийн дурсгалт газар нь өмнө нь бүртгэгдэж байгаагүй бөгөөд хуудаслаг занар чулуунаас бүтсэн

учраас өгөршилд их орсон, дээрх зураг нь маш их балартаж бүдгэрсэн байна. Уг газарт хүрлийн үеийн сийлмэл зургаас гадна эртний Монгол бичгээр бичсэн олон мөр дурсгалууд нэлээд газарт байна. Мөн хожуу үеийн Монгол бичгээс гадна Төвөд бичээснүүд ч нэлээдгүй бий. Уг дурсгалт газрыг нэн даруй бүртгэлжүүлж хадны зураг бичээсийг яаралтай хуулж авах шаардлагатай байгаа болно.

Луус сумын Буянт багийн нутаг Мөхийн ханан уулын шинэ хүннүгийн дурсгалт газар нь мөн адил урд нь бүртгэгдэж байгаагүй бөгөөд нэг дор 50 гаруй жирийн иргэдийн булштай цогцолбор газар болно. Үүнээс улсын хамгаалалтад болон аймаг, сумын хамгаалалтад авах нэн шаардлагатай дурсгалт газрууд байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Өлзийт сумын Далай хийдийн туурь, Муруй Цагаан Сүүжийн дөрвөлжин булшны цогцолбор, Логийн Хар уулын булш хиргисүүрийн дурсгал болон шинээр илрүүлэн олсон Сайн билүүний хадны зургийн дурсгалт газрыг сумын хамгаалалтад авах, тус сумын Буянт багийн Хар тойром, Үнст Худгийн уул уурхайн ашиглалтын талбайд өртөж буй дурсгалуудыг авран хамгаалах малтлага судалгаа хийлгэх, Сайнцагаан сумын хамгаалалтад байх Авдрантын Хүнхрийн дөрвөлжин булшны цогцолбор, Хан уулын монголын үеийн булшны цогцолбор газрыг зэрэглэл ахиулж улсын хамгаалалтад, мөн сумын Суман хайрхан уулын булш хиргисүүрийн дурсгалыг сумын хамгаалалтад, Далай багийн Баянбулагийн хүннү булшны цогцолборыг улсын аймгийн хамгаалалтад авч авран хамгаалах малтлага судалгаа хийлгэх, Луус сумын Суварга хайрхны булш хиргисүүрийн дурсгал, Мөхийн зүүн ханангийн хүннү булшны цогцолбор газар, Мөхийн зүүн ханангийн шинэ хүннү булшны дурсгалт газрыг сумын хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай байна.

Түүнчлэн Гурвансайхан сумын Монгол овоо хэмээх газрын Хүннүгийн оршуулгын бүлэг дурсгал, мөн Зүүн хөх овооны Хүннүгийн бүлэг оршуулгын дурсгалт газар нь өмнө нь бүртгэгдэж байгаагүй. Түүнчлэн Өндөршил сумын Ханангийн овоо хэмээх газрын Хүннүгийн бүлэг дурсгал. Баянжаргалан сумын Баян Цогт хайрхны чулуун зэвсгийн бууц суурин бүхий дурсгалт газар болон Хүннүгийн үеийн оршуулгын дурсгалт газар нь өмнө нь бүртгэгдэж байгаагүй бөгөөд Баян Цогт хайрхны Хүннүгийн

үеийн бүлэг дурсгалт газарт үүдэвч бүхий дугуй чулуун дараастай булш илэрсэн нь уг дурсгалт газрыг Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалт газар хэмээн үзэх бүрэн үндэслэлтэй бөгөөд шинжлэх ухааны чухал агуулгатай дурсгалт газар хэмээн үзэж болно.

Мөн улсын хамгаалалтад болон аймаг, сумын хамгаалалтад авах нэн шаардлагатай дурсгалт газрууд байгааг онцлон тэмдэглэв. Үүнд:

Гурвансайхан сумын Монгол овоо Хүннүгийн дурсгалт газар, Зүүн хөх овоо Хүннүгийн бүлэг оршуулгын газар, Таван жасын туурь, Их жасын туурь, Майхан уулын хиргисүүрийн цогцолбор бүхий дурсгалт газар.

Өндөршил сумын Улаан Хуц хайрхны бүлэг дурсгалт газар, Ханангийн овоо Хүннүгийн оршуулгын дурсгалт газар. Аврахын хийдийн туурь, Тас хайрхны дөрвөлжин булшны дурсгалт газар.

Баянжаргалан сумын Баян Цогт хайрхны үе үеийн дурсгалтай бүлэг цогцолборт газар. Зараа хайрхны дурсгалт газар, Их Эрээний дурсгалт газар.

Цагаандэлгэр сумын Хутаг хайрхны дурсгалт газар, Хөх өндрийн дурсгалт газар зэрэг болно.

Түүнчлэн цаашид үргэлжлүүлэн суурин буюу малтлага судалгаа хийх саналтай байна. Үүнд: нэн тэргүүнд Баянжаргалан сумын нутгаас олдсон Баян Цогт хайрханы үе үеийн цогцолбор дурсгалтай газрыг дурдаж болно.

Хулд сумын нутагт орших Луусын хийд, Мэнгэтийн хийдийн туурь, Олдохын хийдийн туурь, Шувуутай хийдийн туурь зэрэг эдгээр хийдийн тууриудыг жил болгон шинээр тонодог дурсгалт газрыг сумын хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай байна.

Дэлгэрхангай сумын нутагт орших Хүрэн хайрханы бичээс, Тамганы овооны хадны зураг, бичигт хүрэн хадны бичээс зэрэг хадны зураг бичээсийн дурсгалууд нь бүдгэрэх мөн нутгийн иргэд дээрээс нь нэмж зурах гэх мэт эрсдэл байгааг анхаарах нь зүйтэй байна. Сайхан-Овоо сумын нутагт дахь Замбага хайрханы жирийн бүлэг

оршуулгын дурсгалыг улсын аймгийн хамгаалалтад авч авран хамгаалах малтлага судалгаа хийлгэх шаардлагатай байна.

Эрдэнэдалай сумын нутагт оршин Алгийн бууцны хүннүгийн жирийн иргэдийн бүлэг оршуулга, Цагаан цохионы энгэрийн хүннүгийн жирийн иргэдийн бүлэг оршуулга, Үнстийн хийд, Цавчирийн хийд, Үнэгт хайрхны цогцолбор дурсгалыг улс, аймгийн хамгаалалтад авч авран хамгаалах малтлага судалгаа хийлгэх шаардлагатай хэмээн үзэж байна.

Бидний судалгааны үр дүнд Дундговь аймгийн нутаг дэвсгэрээс нийт 375 дурсгалт газрын 3124 тооны түүх, соёлын дурсгалыг илрүүлэн бүртгэж баримтжуулсан бөгөөд сум тус бүрийн дурсгал бүрийг төрөл ангилал, он цаг, түүхэн үеэр нь ангилан судалж нэгтгэсэн. Мөн дурсгалт газар бүрийн эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулан судалж нэгтгэсэн. Түүнчлэн сум орон нутагт уг дурсгалын хадгалалт хамгаалалтын талаар санал, зөвлөмж гаргасан.

Дундговь аймгийн нутаг дэвсгэрээс илрүүлэн бүртгэсэн 3124 тооны түүх, соёлын дурсгалыг түүхэн он цаг, дурсгалын төрөл хэлбэрээр нь авч үзвэл:

- Чулуун зэвсгийн дурсгалт газар – 8
- Чулуун зэвсгийн үеийн зосон зургийн дурсгал – 2
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал – 541
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 567
- Хүрэл зэвсгийн үеийн шоргоолжин булшны дурсгал – 31
- Хүрэл зэвсгийн үеийн дөрөө хэлбэрийн булш – 1
- Хадны сийлмэл зураг, тамга тэмдгийн дурсгал – 48
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 924
- Түрэгийн үеийн булш – 1
- Түрэгийн тахилын онгон – 41
- Түрэгийн үеийн хүн чулуун дурсгал – 9
- Зэл чулуун дурсгал – 42
- Хадны бичиг үсгийн дурсгал – 28
- Агуй – 3



- Сүм хийд, барилга архитектурын дурсгал – 49
- Түүхэн он цаг, төрөл хэлбэр нь тодорхойгүй булш оршуулгын дурсгал – 352

Эдгээр 3124 дурсгалаас шинээр илрүүлэн бүртгэсэн 1107 дурсгал байна. Үүнд:

- Чулуун зэвсгийн дурсгалт газар – 3
- Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүрийн дурсгал – 109
- Хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны дурсгал – 87
- Хүрэл зэвсгийн үеийн шоргоолжин булшны дурсгал – 5
- Хүрэл зэвсгийн үеийн дөрөө хэлбэрийн булш – 1
- Хадны сийлмэл зураг, тамга тэмдгийн дурсгал – 16
- Хүннүгийн үеийн булш оршуулгын дурсгал – 445
- Түрэгийн үеийн булш – 1
- Түрэгийн тахилын онгон – 8
- Түрэгийн үеийн хүн чулуун дурсгал – 3
- Зэл чулуун дурсгал – 10
- Хадны бичиг үсгийн дурсгал – 7
- Агуй – 1
- Сүм хийд, барилга архитектурын дурсгал – 1
- Түүхэн он цаг, төрөл хэлбэр нь тодорхойгүй булш оршуулгын дурсгал – 256

Төслийн үр дүнд дээр бүх мэдээллийг агуулсан, цаашдын судалгааны эхлэл болох “ДУНДГОВЬ АЙМГИЙН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛ” нэртэй сэдэвчилсэн лавлах катологи хэвлэгдэхэд бэлэн болоод байгаа билээ.

## АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Амартүвшин нар, 2004 – Амартүвшин Ч., Баттулга Ц. Ханангийн бууцны бичээс. // *Studia Archeologica*. tom. XXII (II). Fasc.12. Улаанбаатар.
2. Амартүвшин нар, 2008а – Амартүвшин Ч., Жаргалан Б. Бага газрын чулуунд хийсэн хүрэл зэвсгийн түрүү үеийн булшны судалгаа. // *Studia Archaeologica*. Tom. VI (XXVI), Fasc.5. Улаанбаатар.
3. Амартүвшин нар, 2008б – Амартүвшин Ч., Хатанбаатар П. Хүрэн хондын хүннү булш. // *Studia Archaeologica*. Tom.VI (XXVI), Fasc.10. Улаанбаатар.
4. Амгалантөгс нар, 2005 – Амгалантөгс Ц., Амартүвшин Ч. Нумын наалтан дээрх сараачмал хэдэн дүрс (Хүннү булшны хэрэглэгдэхүүнээр). // *Studia Archaeologica*. Tom. III (XXIII), Fasc.5. Улаанбаатар.
5. Базылхан, 1964 - Базылхан Б. Эртний түрэг бичээстэй мутрын тэмдэг // ШУАМ, 11. Улаанбаатар.
6. Баттулга, 1998 – Баттулга Ц. Дэл уулын Баруун Билүүний II, III бичээс. // *Studia Archaeologica*. Tom. XVIII, Fasc 9. Улаанбаатар.
7. Батсүх, 2004 – Батсүх Д. Дундговь аймгийн нутгаас шинээр олдсон хүрэл эдлэлүүд. Магистрын зэрэг горилсон дипломын ажил. Монгол улсын Боловсролын Их сургууль. Улаанбаатар.
8. Баяр, 1995 – Баяр Д. Монголчуудын чулуун хөрөг. Улаанбаатар.
9. Баяр, Эрдэнэбаатар, 1989 – Баяр Д., Эрдэнэбаатар Д. МЗТСХЭ-ийн бичээс судлалын ангид 1989 онд ажилласан тайлан. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
10. Беспалов, 1951 – Беспалов Н.Д. Почвы Монгольской Народной Республики, Труды Монгольской комиссии АН СССР. Вып.41. Москва.
11. Буян нар, 1968 – Буян Ч., Чожеркапоста. Монгол-Венгерийн хамтарсан геологийн хайгуулын тайлан. Улаанбаатар.
12. Буян нар, 1969 – Буян Ч., М.Эрне. Монгол-Венгерийн хамтарсан геологийн эрэл хайгуулын үр дүнгийн тайлан. Улаанбаатар.
13. Буян нар, 1969 – Буян Ч., Сэлэмбаатар С. Геологийн эрэл хайгуулын тайлан. Улаанбаатар.
14. Дорж, Новгородова, 1975 – Дорж Д., Новгородова Э.А. Петроглифы Монголии. Улаанбаатар.
15. Дорж, Цэвээндорж, 1978 – Дорж Д., Цэвээндорж Д. Монголын палеолит. Улаанбаатар.
16. Волков, 1957 – Волков В.В. Бронзовый и ранний железный века Монголии. Улан - Батор.
17. Волков, 1963 – Волков В.В. Дундговь аймагт эртний хайгуул хийсэн тухай. // *Studia Archaeologica*. Tom. II, Fasc 6. Улаанбаатар.
18. Галдан нар, 2010 – Галдан Г., Жаргалан Б. Бага газрын чулууны хадны зураг дахь тамга тэмдгийн дүрслэл. // *Studia Archaeologica*. Tom. (IX) XXIX, fasc. 10. Тал 197-209. Улаанбаатар.

19. Гүнчинсүрэн нар, 2009 – Гүнчинсүрэн Б., Амартүвшин Ч., Болорбат Ц., Жаргалан Б., Галдан Г., Одсүрэн Д. Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил, Баянжаргалан сумдын нутаг, “Denison Mines” ХХК-ний “Хараат”, “Хайрхан” ашиглалтын талбайнуудад хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны хээрийн шинжилгээний ангийн тайлан. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
20. Лхагвасурэн, 1994 - Х. Лхагвасурэн. Средневековые погребения монголов (XII-XIV вв.). Диссертация на соискание ученой степени кандидата исторических наук. Москва. Металл ашигт малтмалын., 2004 – Металл ашигт малтмалын хүдрийн ордын I паспорт (Ордын дугаар 0101). АМХЭГ-ийн Геологийн мэдээллийн төв. Бүртгэлийн хуудас зохиосон Д.Баатар, санд оруулсан Ш.Өлзийбаяр, нэмэлт засвар хийсэн Д.Баатар. Улаанбаатар.
21. МЗТСХЭ.,1969 - МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах ангийн тайлан. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
22. МЗТСХЭ.,1970 - МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах ангийн тайлан. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
23. МЗТСХЭ.,1971 - МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах ангийн тайлан 1971.ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
24. МЗТСХЭ.,1972 - МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах ангийн тайлан 1972. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
25. МЗТСХЭ.,1973 - МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах ангийн тайлан 1973. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
26. Монгол нутаг., 1999 - Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал (сэдэвчилсэн лавлах). тал 38-39. Улаанбаатар.
27. Монгол орны., 1969 – Монгол орны физик газарзүй. Редактор Ш.Цэгмид. Улаанбаатар.
28. Монгол улсын., 2009 – Монгол улсын үндэсний атлас. ШУА-ийн Газарзүйн хүрээлэн. II хэвлэл. Ерөнхий редактор Д.Доржготов. Улаанбаатар.
29. Мөнхтулга нар, 2010 – Мөнхтулга Р., Хүрэлсүх С. Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутаг Оюут Овоо дахь “Голден Погада” ХХК-ны ашиглалтын талбайн хайгуул судалгааны ажлын тайлан. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
30. Мэнэс, 1995 – Мэнэс Г. К археологической характеристике северо восточной и западной групп каменных статуи монгольского времени (XIII-XIV вв). // Studia Archaeologica. Tomus XV, fasc. 8. Улаанбаатар.
31. Наваан, 1985 – Наваан Д. Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедицийн тайлан. Улаанбаатар.
32. Наваан, 1999 – Наваан Д. Хүннүгийн соёлын өв. Улаанбаатар.
33. Наваан, Санжмятав, 1981 – Наваан Д., Санжмятав Т. Хээрийн шинжилгээний тайлан. 1981. Улаанбаатар.
34. Окладников, 1964 – Окладников А.П. Олень золотые рога. М-Л., Окладников и др., 1977 - Окладников А.П., Дорж Д. Памятники каменного века на юге МНР // Studia Archaeologica. Tom. VII. fasc.1. Улаанбаатар.

35. Окладников, 1981 - Окладников А.П. Петроглифы Монголии. Ленинград.
36. Пэрлээ, 1951 – Пэрлээ Х. Краткое сообщение о древностях около Их Газарын чулуу. Улаанбаатар.
37. Пэрлээ, 1956 - Пэрлээ Х. XI зууны үеийн булшны үлдэц // ШУ. 12. Улаанбаатар.
38. Пэрлээ, 1961 - Х. Пэрлээ. Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон. Улаанбаатар.
39. Пэрлээ, 1963 – Пэрлээ Х. Өмнөговь, Өвөрхангай аймгуудын говь талын нутгаар эртний судлалын хайгуул хийсэн нь. // Эртний судлал, угсаатны зүйн бүтээл. Улаанбаатар.
40. Санжмятав, 1986 – Санжмятав Т. К вопросу изучения наскальных рисунков связанных с охотой у древних кочевников. ОУМЭ-ийн IV их хурал. III боть, Улаанбаатар.
41. Санжмятав, 1987 – Санжмятав Т. 1987 оны хээрийн шинжилгээний тайлан. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар
42. Санжмятав, 1988 – Санжмятав Т. 1987 оны хээрийн шинжилгээний тайлан (Дундговийн экспедици). ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
43. Санжмятав, 1995 – Санжмятав Т. Монголын хадны зураг. Улаанбаатар.
44. Сэр-Оджав нар, 1964 - Сэр-Оджав Н., Долгорсүрэн Д. Дундговь аймаг хүрлийн үед. Улаанбаатар.
45. Хатанбаатар нар, 2007 – Хатанбаатар П., Жаргалан Б., Ханичёрч В., Амартүвшин Ч. Хүннү булшнаас илэрсэн харь гаралтай олдворууд. // *Studia Archaeologica*. Том. XXIV (IV), fasc.21, тал 305-323. Улаанбаатар.
46. Хүүхэнбаатар, 2008 – Хүүхэнбаатар Д. Эх түүхээ эргэцүүлэхүй. Улаанбаатар. Цэвээндорж, 1990 – 1990 оны Монгол-Унгар-Зөвлөлтийн хамтарсан хүннүгийн дурсгал судлах ангийн тайлан. ШУА-ийн АХГБСХ. Улаанбаатар.
47. Цэвээндорж, 1999 – Цэвээндорж Д. Монголын эртний урлагийн түүх. Улаанбаатар.
48. Цэвээндорж, 2000 – Цэвээндорж Д. Бага газрын чулуу, Тарвагатай, Хүүшийн хөтөл, Баруун Хайрханы хүннү булш. // *Studia Archaeologica*. Том. XX, fasc.5. Улаанбаатар.
49. Цэвээндорж нар, 2005 – Цэвээндорж Д., Батболд Н. Дундговь аймгийн Дэл уулын Билүүний хадны зураг. Улаанбаатар.
50. Эрдэнэ нар, 2007 – Эрдэнэ Б., Амгалантөгс Ц., Нельсон Р. Бага газрын чулуунд хийсэн археологийн малтлага судалгааны зарим үр дүнгээс. // *Studia Archaeologica*. Том. (IV) XXIV, fasc. 15. тал 188-216. Улаанбаатар.
51. Nelson et al., 2007 - Albert Russell Nelson, William Honeychurch, Chunag Amartuvshin. Gobi Mortuary Site through Time: Bioarchaeology at Baga Mongol, Baga Gaz aryn chuluu. // *Current Archaeological Research in Mongolia*. Paper from the First International Conference on “Archaeological Research in Mongolia” held in Ulaanbaatar, August 19th – 23rd, 2007.
52. Honeychurch et al., 2007 - Honeychurch, W., A.R. Nelson, and Ch. Amartuvshin. Death and Social Process Among the Ancient Xiongnu of Mongolia. Invited paper given at the international conference, Xiongnu: the First Empire of the Steppes. National Museum of Korea, Seoul, December. 2007.

53. Wright et al., 2007 – Joshua Wright, Chunag Amartuvshin. “Unseen by Eye, Unheard by Ear”: The Archaeology of the Early Turks at Baga Gazaryn Chuluu, Mongolia. //Current Archaeological Research in Mongolia. Paper from the First International Conference on “Archaeological Research in Mongolia” held in Ulaanbaatar, August 19th – 23rd, 2007. 349-365.
54. Эрдэнболд нар, 2012 – Эрдэнэболд Л., Хатанбаатар Д., Бямба-Очир Ц., Ванчигдаш Ч., Болормаа С., Одбаяр З, Дундговь аймгийн Баянжаргалан сумын Нутгийн-Орд ХХК-ийн талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар.
55. Эрдэнболд нар, 2016 – Эрдэнэболд Л., Хатанбаатар Д., Бямба-Очир Ц., Ванчигдаш Ч., Болормаа С., Одбаяр З, Дундговь аймгийн Гурвансайхан сумын Очир-Ундраа ХХК-ийн талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар.
56. Бямба-Очир нар, 2021 – Бямба-Очир Ц., Бат-Эрдэнэ С, Дундговь аймгийн Баянжаргалан сумын Шохойн тал ХХК-ийн талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар.

# **ХАВСРАЛТ**

*/Төслийн тайланд холбогдох баталгаа баримт бичиг/*